



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-9
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	10-162
<hr/>	
<i>1. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2021.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/</i>	12-13
<i>2. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан. 2022.11.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/</i>	14-32
<i>3. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй танилцах асуудал</i>	32-73
<i>4. Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл: Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Эрчим хүчний зорилт болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан томоохон төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, тулгамдаж байгаа асуудлын талаар</i>	73-105
<i>5. Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, нэн яаралтай/</i>	105-162

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 02-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 40 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 09 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, Ц.Анандбазар, П.Анужин, Э.Батишугар, Д.Бат-Эрдэнэ, Г.Ганболд, Х.Ганхуяг, Ц.Даваасүрэн, Г.Дамдинням, Т.Доржханд, Б.Дэлгэрсайхан, Н.Наранбаатар, Х.Нямбаатар, Б.Пүрэвдорж, Б.Саранчимэг, Ц.Туваан, Ч.Ундрал, Н.Учрал, Ч.Хүрэлбаатар, Д.Цогтбаатар, Н.Энхболд;

Чөлөөтэй: Б.Баттөмөр, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, Ц.Сэргэлэн, Ж.Чинбүрэн;

Хоцорсон: С.Батболд – 1 цаг 04 минут, С.Ганбаатар – 07 минут, Н.Ганибал – 3 цаг 26 минут, Ж.Мөнхбат – 4 цаг 43 минут, Г.Мөнхцэцэг – 59 минут, С.Одонтуяа – 1 цаг 03 минут, Ш.Раднаасэд – 4 цаг 54 минут, Л.Энх-Амгалан – 1 цаг 28 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболороос ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор үг хэлэв.

Нэг.Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2021.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга С.Мөнхнасан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, мөн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Ч.Хишигдалай, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал, тус газрын Газрын тосны бүтээгдэхүүний хэлтсийн дарга Д.Даваабаяр, “МИАТ” ТӨХК-ийн Санхүү, удирдлагын газрын захирал Н.Цэгц, “Эрчис ойл” ТӨХК-ийн захирал З.Ширзана, менежер Х.Эрдэнэбилэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв. /10:15/

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 6
Бүгд: 40
85.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан. 2022.11.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын ахлах референт Д.Саруул, шинжээч Б.Төрбат, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, Эдийн засаг, хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга О.Одончимэг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Т.Нарантунгалаг, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хуулийн хэлтсийн дарга С.Цогтгэрэл, Батлан хамгаалах яамны Хуулийн хэлтсийн дарга Г.Энхболд, Барилга, хот байгуулалтын яамны Хуулийн хэлтсийн дарга Б.Нямдорж, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газрын Цөмийн болон цацрагийн хяналтын улсын ахлах байцаагч Э.Цэрэнчимэг, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Хууль, эрх зүй, дотоод хяналтын газрын дарга У.Халиунаа, Стандарт, хэмжил зүйн газрын дарга Б.Билгүүн, мөн газрын Захиргаа, удирдлагын газрын дарга В.Ганзориг, Цөмийн энергийн комиссын ажлын албаны дарга Г.Манлайжав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга

Д.Энхбат, Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Уг асуудлыг асуулт, хариултаар үргэлжлүүлэв.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьшаа, С.Ганбаатар, Ц.Мөнх-Оргил нарын тавьсан асуултад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Стандарт, хэмжил зүйн газрын дарга Б.Билгүүн нар хариулж, тайлбар хийв.

Төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, С.Бямбацогт нар дэмжиж, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Б.Энхбаяр, Г.Амартүвшин нар эсрэг байр суурьтай үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аудитын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Биеийн тамир, спортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын хэвлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Галын аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

тухай, Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Музейн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсролын сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ургамал хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувийн хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувиргасан амьд организмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цахим гарын үсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 16
Бүгд: 42
61.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй танилцах асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Д.Зүмбэрэлхам, нэр дэвшигч Н.Батчимэг, М.Пүрэвсүрэн, Б.Ганболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Нэр дэвшигчийн талаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Д.Зүмбэрэлхам, Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Хууль зүйн байнгын хорооны дарга Л.Мөнхбаатар нар танилцуулав.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын танилцуулга болон нэр дэвшигчээс Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Х.Болорчулуун, Ц.Мөнх-Оргил, С.Амарсайхан, Ц.Сандаг-Очир, Б.Бат-Эрдэнэ, Т.Энхтүвшин, Г.Мөнхцэцэг, Д.Ганбат, С.Ганбаатар, Ц.Идэрбат, Б.Энхбаяр, М.Оюунчимэг, Д.Сарангэрэл, Ш.Раднаасэд, Ш.Адьяа нарын тавьсан асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Д.Зүмбэрэлхам, нэр дэвшигч Н.Батчимэг, М.Пүрэвсүрэн, Б.Ганболд нар нар хариулж, тайлбар хийв.

Нэр дэвшигчийг танилцуулсан талаар Монгол Улсын Ерөнхийлөгчид албан бичгээр мэдэгдэхээр тогтов.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 17 минут үргэлжилж, 13 цаг 26 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 07 минутад эхлэв.

Дөрөв.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл: Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Эрчим хүчний зорилт болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан томоохон төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, тулгамдаж байгаа асуудлын талаар

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Насантогтох, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Мөнх-Оргил, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга Э.Түвшинчулуун, Эрчим хүчний зохицуулах хорооны Ажлын албаны дарга Б.Болор-Эрдэнэ, “Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Балжинням нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Ж.Монголжингоо нар байлцав.

Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Эрчим хүчний зорилт болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан томоохон төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, тулгамдаж байгаа асуудлын талаар мэдээлэл хийв.

Эрчим хүчний сайдын мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийн төлөөллөөс Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл үг хэлэв.

Мэдээлэлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.6-д заасны дагуу цөөнхийн төлөөллөөс Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал, О.Цогтгэрэл, Ж.Батсуурь нарын тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа 15 цаг 17 минутаас 15 цаг 20 минутад хуралдааныг даргалав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.13-д заасны дагуу Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь нарын тавьсан асуултад Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн хариулж, тайлбар хийв.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Эрчим хүчний зорилт болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан томоохон төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, тулгамдаж байгаа асуудлын талаар мэдээлэл хийлээ.

Уг асуудлыг 15 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Тав. Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, нэн яаралтай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд Г.Түвдэндорж, мөн яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга Б.Болортуяа, Ногоон хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Буяннэмэх, Хуулийн хэлтсийн дарга С.Цогтгэрэл, Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн П.Баярцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга С.Мөнхнасан, “Монголын эрх зүйн судалгаа хөгжлийн төв” төрийн бус байгууллагын хуульч Р.Лхагвабаяр, Монголын Аялал жуулчлалын холбооны хүндэт Ерөнхийлөгч, “Нью жуулчин тур” ХХК-ийн ерөнхий захирал Ш.Нэргүй нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, М.Оюунчимэг, С.Чинзориг, Б.Баярсайхан, Б.Энхбаяр, Ц.Идэрбат, Х.Булгантуяа, С.Ганбаатар, Ж.Бат-Эрдэнэ, Н.Ганибал, О.Цогтгэрэл, Ж.Батжаргал, Т.Аубакир нарын тавьсан асуултад Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, мөн яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга Б.Болортуяа, Хуулийн хэлтсийн дарга С.Цогтгэрэл, Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн П.Баярцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, “Монголын эрх зүйн судалгаа хөгжлийн төв” төрийн бус байгууллагын хуульч Р.Лхагвабаяр, Монголын Аялал жуулчлалын холбооны хүндэт Ерөнхийлөгч, “Нью жуулчин тур” ХХК-ийн ерөнхий захирал Ш.Нэргүй нар хариулж, тайлбар хийв.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Ц.Сандаг-Очир, Ж.Батжаргал, Л.Мөнхбаатар нар үг хэлэв.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлын санал хураалтыг хойшлуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Цэргийн их сургуулийн 1992 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа, Х.Нямбаатар нарын урилгаар Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг угтан иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан, Ц.Цэрэнпунцаг нарын урилгаар Завхан аймгийн Их-Уул сумын Соёлын төвийн ажилтнууд, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Л.Мөнхбаатар, Л.Энх-Амгалан нарын урилгаар Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн 1993 оны төгсөгчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 7 цаг 34 минут үргэлжилж, 76 гишүүнээс 50 гишүүн хүрэлцэн ирж, 68.8 хувийн ирцтэйгээр 18 цаг 24 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 09 минут.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. 52.0 хувьтай ирц бүрдсэн байна.

Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 02-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулна.

Нэгдүгээрт, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Зарчмын зөрүүтэй нэг саналтай. Асуулт асууж, үг хэлж дууссан байгаа.

Хоёрдугаарт, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Гуравдугаарт, Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй танилцах асуудал.

Дөрөвдүгээрт, Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт дүрэмийн төлсөн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар 14.00 цагаас Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл. Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, шинэ сэргэлтийн бодлогын эрчим хүчний зорилт болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан томоохон төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, тулгамдаж байгаа асуудлын талаар мэдээлэл сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболороос хэлэлцэх асуудалтай холбогдуулан хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргахаар зөвшөөрөл олгоно уу гэсэн ийм бичиг ирсэн байна.

Ингээд Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн үг хэлнэ.

Д.Өнөрболор: Гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе. Парламентч бидний ер нь үндсэн чиг үүрэг бол энэ цаг үеийн шаардлагад нийцсэн төгс төгөлдөр, чанартай хууль баталж байх ийм үндсэн чиг үүрэгтэй байгаа.

Нэн ялангуяа эдийн засаг агшсан, эдийн засаг маш их хүндэрсэн энэ цаг үед бидний үүрэг хариуцлага илүү өндөр байх ёстой. Гэтэл тоо гүйцээх гэж байгаа мэт дутуу дулимаг хууль баталж байгаа нь нийгэм, эдийн засгийн

дорвитой шинэчлэл хүлээсэн олны хүлээлт, зорилгод үнэхээр хүрч чадахгүйд хүрч байна гэж үзэж байна. Тухайлбал, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиар дамжуулан эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөллийг бий болгох, төсвийн ачааллыг бууруулах боломж зэргийг олноороо хүч түрсэн байдлаар үндсэндээ үгүй хийлээ.

Тэгээд улс орны нийгэм, эдийн засагт энэ онцгой ач холбогдол бүхий олон чухал хууль тогтоомж, шийдвэрийн төслийг хариуцлагатайгаар хэлэлцэн батлахын оронд бидэнд эрэмбээ хүлээж болох аар саар асуудал бид өнөөдөр цаг заваа тун ч их барж сууна. Тухайлах юм бол хүний ой тоонд, тооны машинд багтахаргүй олон их наядын энэ хохиролтой нүүрсний хулгай гэх хэргүүд, Хөгжлийн банкийг тонож дээрэмдсэн хэрэг, ЖДҮ-г залгисан, нийгмийн даатгалын сангуудыг олон зуун тэрбумаар тоологдох хохиролтой асуудлууд дээр Улсын Их Хурал дүр эсгэсэн ийм эс үйлдсэн байдалтай байна.

Тэгэхээр үр нөлөө муутай, иргэдийн амьдрал, хувийн хэвшлийн салбарт нэмэр тусгүй, бүр зарим талаараа сөрөг нөлөөтэй болж болохуйц ийм зүйлс хэлэлцэж суухын оронд бид ард иргэдийн бухимдлыг дээд зэргээр төрүүлээд байгаа энэ улс орноо дээрэмдэж тоносон асуудлуудыг Улсын Их Хурал нэн яаралтай хэлэлцэж шийдвэрлэх нийгмийн захиалга үүсээд байгааг бид анхаарах хэрэгтэй байна.

Тиймээс Хөгжлийн банк, энэ нүүрсний хулгайн хэрэг, бусад тулгамдсан асуудлуудаар холбогдох албан тушаалтнуудыг бид дуудан

ирүүлэх хэрэгтэй байна. Улсын Их Хурлын гишүүдэд ил тод мэдээлэл өгүүлэх хэрэгтэй байна. Энэ асуудлыг хэлэлцэх хэрэгтэй байна. Нээлттэй сонсгол зохион байгуулах хэрэгтэй байна гэж иргэдээ төлөөлөн сонгогдсон Улсын Их Хурлын гишүүний хувиар ингэж санал болгож байна. Бас шаардаж байна. Дарга аа.

Г.Занданшатар: Д.Өнөрболор гишүүн хурал чуулгандаа идэвхтэй оролцож бай.

Нүүрсний хулгайн асуудлаар Гочоогийн Ганболд гишүүнтэй түр хороо байгуулагдаад гэрч дуудаад, шинжээч томилоод ажлын хэсэг хуралдаад түр журам гарч байгаа. Их Хурал дээр ажлууд явж байгаа шүү дээ.

Хөгжлийн банкны асуудлаар Баттөмөрийн Энхбаяр гишүүн нээлттэй сонсгол зохион байгуулсан. Бас Хяналт шалгалтын түр хороо байгуулаад хоёр, гурван шинжээч томилоод төрийн тусгай албаны туршлагатай мөрдөгч, шинжээч томилоод ажиллуулж байгаа. Одоо бас хугацаа нь дуусахаар тэрийгээ хэлэлцүүлнэ.

Энэ ажлууд Улсын Их Хурлаас гадуур байгаа юм огт байхгүй шүү.

Харин тэр ажиллууддаа манай гишүүд идэвхтэй оролцож байх хэрэгтэй.

Одоо хэлэлцэх асуудалд орно.

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явна.

Нэг.Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2021.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Уг асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл завсарлага авсан.

Ингээд завсарлагын хугацаа дууссан байна. Ажлын хэсгийн гишүүдийг өчигдөр танилцуулсан.

Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Содномцэрэнгийн Мөнхнасан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Болдбаатарын Анхбаяр, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Чулууны Хишигдалай, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Лхамсүрэнгийн Баярмандал, тус газрын Газрын тосны бүтээгдэхүүний хэлтсийн дарга Даваахүүгийн Даваабаяр, “МИАТ” ТӨХК-ийн Санхүү, удирдлагын газрын захирал Нарангэрэлийн Цэгц, “Эрчис ойл” ТӨХК-ийн захирал Занаширын Ширзана, “Эрчис ойл” ТӨХК-ийн менежер Хүүхээгийн Эрдэнэбилэг. Ингээд протоколд тэмдэглэгдлээ.

Одоо гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан байгаа. О.Цогтгэрэл дарга завсарлага авсантай холбогдуулаад үг хэлэх үү. Дэгээрээ асуух ёстой юм байна. Завсарлагын хугацаа дууссан эсэх талаар Одонгийн Цогтгэрэл гишүүн үг хэлнэ.

О.Цогтгэрэл: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе.

Газрын тосны хууль дээр Ардчилсан нам үндсэндээ хоёр дахь

удаагаа завсарлага авсан. Яагаад гэвэл энэ хуульд үзэл санааны хувьд, үзэл баримтлалын хувьд явж байгаа зүг чигтэй зөрчилдөж байгаа олон зүйл байгаа гэж үзэж байгаа.

Төрийн өмчит аж ахуйн нэгж байгуулж бизнест оролцёе гэж байгаа. Дээрээс нь тухайн нэг салбарыг, тэр тусмаа Монгол Улс чинь өөрөө газар зүй, орон зайн хувьд, тээврийн хувьд хязгаарлагдмал болон агаарын орон зайгаа нэг улсаас, нэг компаниас илүү бүрэн дүүрэн. Албан бусаар байсан бол одоо албан ёсоор дотоодын аж ахуйн нэгж хамтран байгуулах замаар ингэж агаарын орон зайд хэт давамгай байдал олгоё гэсэн энэ олон зүйлүүд нь өөрөө бас яг бид нарын явж байгаа зүг чиг олон зүйлтэй зөрчилдөж байна гэж ингэж үзэж завсарлага авч байгаа.

Тэгээд цаашдаа ч бас яг энэ байр суурин дээр бид бүгдийн хувьд энэ байр сууриа дахин илэрхийлж байна.

Тэгээд хоёр дахь удаагийн завсарлага дуусаж байгаа учраас үргэлжлүүлэн хэлэлцээд явж таарах байх.

Г.Занданшатар: Одоо зарчмын зөрүүтэй саналын томёоллоор санал хураалт явуулна.

Зарчмын зөрүүтэй нэг санал байгаа. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэдэндамбын Цэрэнпунцаг.

Санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

Эхний санал хураалт учраас энэ бүртгэл, төстийн санал хураалт байгаа. Энэ 7 гишүүн. Ш.Адъяа, Д.Батлут, Ж.Батсуурь, С.Ганбаатар, Г.Ганбат, Б.Жаргалмаа, О.Цогтгэрэл нарын гишүүд. Энэ төстийн санал хураалт.

Одоо Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжбэ гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Ц.Цэрэнпунцаг гишүүний гаргасан саналыг.

34 гишүүн дэмжиж, 85.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна. Ц.Цэрэнпунцаг гишүүн ээ.

Энэ хууль батлагдсанаараа бид агаарын тээврийн үнэ тариф хямдарна

гэсэн хүлээлт. Ийм зорилготой энэ хуулийг нэгд баталж байгаа. Мөн бас энэ бензин, нефть бүтээгдэхүүний үнэ хямдрах чухал яриа хэлэлцээрийн үндэс гэж баталж байгаа.

Тийм учраас үүнийг их үр дүнтэй, сайн хэрэгжиж, үнийн өсөлтийн үед дизель түлш хомсдож байгаа олон асуудлыг шийднэ гэж итгэж энэ хуулийг баталж байгаа шүү. Тийм ээ.

Тэгэхдээ нөгөө талаас Одонгийн Цогтгэрэл гишүүний хэлээд байгаа хувийн хэвшлийн юмыг төр булааж авч байгаа юм шиг тийм хандлага байж болохгүй. Хууль хэрэгжүүлэхдээ хувийн хэвшлийг хохироохгүй байх тэр зарчмаа баримтлах хэрэгтэй.

Зочид танилцуулъя. Цэргийн их сургуулийн 1992 оны төгсөгчид 30 жилийн ойн дурсамж уулзалтын хүрээнд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ гэгээн дурсамж дүүрэн залуу насаа дурссан сайхан уулзалтын өдрийн мэндийг дэвшүүлээд, сайн сайхныг хүсэн ерөөе. Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс. /алга ташив/

Дараагийн асуудалд орно.

Хоёр.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Васгийн газар Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулж, 2022.11.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Ажлын хэсгийн гишүүдийг оруулъя. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулна.

Хоёр гишүүн асуулт асууж, хариулт авах байгаа. Тэгээд дараа нь санал хураалттай.

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Дашзэвэгийн Амарбаясгалан, Стандартчилал, хэмжил зүйн газрын дарга Болдбаатарын Билгүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Нэргүйн Мягмар.

Ажлын хэсгийнхнийг оруулъя. Эрчим хүчний яамны Эрчим хүчний Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Батмөнхийн Насантогтох, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Доржсүрэнгийн Саруул. Бусад улсуудыг орж ирэхээр нь танилцуулая. Д.Саруул орж ирсэн үү.

Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуулт асууна.

Ш.Адьяа: Зөвшөөрлийн тухай хуулийг 2019 онд өргөн бариад өнөөдрийг хүртэл олон сорилттой тулгарч байж өнөөдөр Их Хурлын чуулганд орж ирж байна л даа.

Энэ зөвшөөрлийн тухай асуудлыг цэгцлэх нь өнөөдөр Монголд, ялангуяа төрийн үйл ажиллагааны энэ ард иргэдийг, бизнесийг чирэгдүүлдэг, авлигал хээл хахууль, хүнд суртлыг бий болгодог өнөөдрийн гаж тогтолцоог, гаж үйлдлийг таслан зогсоох ийм тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн ийм хуулийн төсөл учраас энэ хуулийн төслийг зайлшгүй яаралтай баталж гаргах нь өнөөдөр төрийн нэр хүндийг өсгөх, иргэдэд хөнгөн шуурхай үйлчлэх, авлигал хээл хахууль, бусад хүнд суртлыг арилгахад чухал ач холбогдолтой хуулийн төсөл гэсэн ийм бодолтой байгаа. Ийм ч учраас энэ хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа юм.

Хуулийн төсөлд хуримтлагдаж ирсэн олон асуудлыг бүгдийг нь шийдэж чадаагүй ч гэсэн энэ цаг үеийн шаардлагад нийцсэн, ялангуяа өнөөдөр зөвшөөрлийн системийг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим хэлбэрээр асуудлыг шийдэх ийм эрэл хайгуулыг бий болгосон ийм зүйл байгаа нь сайшаалтай хэрэг.

Гэхдээ Монгол Улсад өнөөдөр бүх юм хуулиар явагдах ёстой. Аливаа зөвшөөрлийн систем, бусад хулгай луйвар хийдэг бүх асуудлууд чинь журмаар явж ирсэн. Журмаар явж ирсэн.

Хуулиас гадуур журам боловсруулдаг энэ асуудалд зарим нэг салбарууд дээр байсаар байна. Журмаар боловсруулдаг энэ асуудлыг ер нь байхгүй болгох боломжийг яагаад хууль санаачлах гэж оруулж ирээгүй юм бэ гэдэг ийм асуудал байна. Тухайлахад өнөөдөр Авто тээврийн үндэсний төв мэтийн ийм газрууд тэр ногоон бичиг, улс хооронд явуулах зөвшөөрөл,

компани байгуулах зөвшөөрөл, түүнчлэн шинээр компани байгуулахад тэдэн жил тээвэр хийсэн байх ёстой, тэдэн жил тээвэр хийсэн байх ёстой гэсэн ийм журмыг боловсруулж, бизнес эрхлэгчдийг дарамталдаг аливаа боломжийг нь хаадаг, өөрийнхөө хамаарал бүхий компаниуд, ашиг сонирхолтой аж ахуйн нэгжүүдийг дэмжих тогтолцоог бий болгож ирсэн асуудлууд өнөөдөр байгаа.

Энэ хуулиар биш журмаар зохицуулдаг тогтолцоог халахад, өөрчлөхөд хуулийн төсөл санаачлагчид энд ямар бодолтой байна? Энэ талаар нэг хариулт авъя.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт сайд. Хэн хариулах вэ? Нэргүйн Мягмар. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн бодлогын газрын дарга. 81.

Н.Мягмар: Ш.Адъяаа гишүүний асуултад хариулъя.

Засгийн газраас Зөвшөөрлийн хуульд нийцүүлэх зорилгоор оруулж ирсэн 89 хууль тогтоомж, нэг Улсын Их Хурлын тогтоолын төслийн хүрээнд нийтдээ 45 салбарын хуульд журам баталж зохицуулж байсан зохицуулалтыг Зөвшөөрлийн хуульд нийцүүлж хуулиар зохицуулна гэдэг агуулгаар салбарын хуулиудад нь өөрчлөлт оруулж журам батлах эрхүүдийг хассан.

Тэгээд салбарын хуулиудад нь түлхүү яг энэ журмаар зохицуулж байсан процессын шинжтэй тийм харилцаануудыг зохицуулж байсан зохицуулалтуудыг нь хууль руу нь тусгах. Бүр дэлгэрэнгүй зүйл байх

тохиолдолд стандарт мөрдөнө гэдэг ийм агуулгаар зохицуулж орж ирсэн.

Хоёрдугаарт, Улсын Их Хурлаас Зөвшөөрлийн хуулийг батлахтай холбогдуулаад 35 дугаар тогтоол гаргаж Засгийн газарт даалгасан.

Энэ тогтоолын хоёрдугаар заалтад Зөвшөөрлийн хуульд нийцүүлж зөвшөөрөл харилцааг зохицуулж байгаа Засгийн газар, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийг энэ хуульд нийцүүлэх, холбогдох арга хэмжээ авах гэдэг энэ тогтоолын хүрээнд Засгийн газраас ялангуяа Ш.Адъяаа гишүүний хэлж байгаа журамласан ийм хэм хэмжээний актуудаа хүчингүй болгож, Хууль зүй, дотоод хэргийн яаманд улсын бүртгэлээс хасуулаа гэдэг үүрэг даалгаврыг холбогдох сайд нарт нь даалгачихсан байж байгаа.

Тэгэхээр одоо энэ хууль маань 2023 оны 01 сарын 01-нээс хэрэгжээд ирэхээр журамласан журмууд хүчингүй болж хууль бол өөрөө үйлчилж эхлэх юм.

Г.Занданшатар: Зочид эхлээд танилцуулчихъя.

Цэргийн их сургуулийн 1992 оны төгсөгчид 30 жилийн ойн дурсамж уулзалтынхаа хүрээнд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Төрөлх сургууль, ачит багш, гэгээн дурсамжаа эргэн санасан энэ сайхан уулзалтын өдрийн мэндийг хүргээд Та бүхний цаашдын ажил, амьдралд чинь сайн сайхныг хүсэн ерөөе. /алга ташив/

Ширнэнбаньдын Адьшаа гишүүн тодруулж асууна. 1 минут.

Ш.Адьяа: Н.Мягмар даргаас дахиад нэг хариулт авъя.

Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын гаргасан шийдвэр, зөвшөөрөлтэй бусад орон нутгийн засаг захиргаа, түүний нэгж, удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн өөрийн удирдах байгууллагын эрх мэдэлийг Зөвшөөрлийн хуулиар тодорхой хэмжээнд хязгаарласан асуудлууд байгаа. Үүнийг хэлэлцүүлгийн явцад засаад явах юм уу, аль эсвэл цаашлаад үүнийг хууль хоорондын зөрчил, энэ асуудал чинь ингээд үргэлжлээд явах юм уу?

Өнөөдөр чинь Монгол Улс нэгдмэл улс. Гэтэл өнөөдөр бүх аймгууд нэг нэг жижиг ханлигууд шиг ийм шийдвэр гаргадаг. Энэ нь ингээд хууль хоорондын иргэдийн дунд үүний хэрэгжилт, хууль хоорондын болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага, түүнчлэн Засгийн газартаа.../минут дуусав/

Г.Занданшатар: Нэргүй Мягмар. 81.

Н.Мягмар: Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны 01 сарын 01-нээс мөрдөх хууль дээр ямар зөвшөөрлүүдийг зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд нь хэн бэ гэдгийг тусгайлан заасан. Өөрөөр хэлэх юм бол тусгай зөвшөөрлийг 249, энгийн 114 зөвшөөрлийг Зөвшөөрлийн хуульдаа заагаад өгчихсөн.

Тэгэхээр энэ зөвшөөрлийн жагсаалтад орсон зөвшөөрлийг л

зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд. Одоо жишээ нь нутгийн өөрөө удирдах байгууллагаас энэ хуульд заасан ямар зөвшөөрлийг л олго гэсэн байна тэрийг л олгоно. Түүнээс өөр бусдаар зөвшөөрлийн шинжтэй бүртгэл, лавлагаа, дүгнэлт гаргах гэдэг юм уу журамлах эрх энэ хуулиар хориглогдож байгаа.

Тэгээд энэ зарчмаараа 2023 оны 01 сарын 01-нээс нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд зөвшөөрлийн жагсаалтад тусгаснаас өөр зөвшөөрөл олгох, журамлах зүйл байхгүй болно гэж ойлгож болох юм.

Г.Занданшатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна. Дараа нь санал хураалттай.

С.Ганбаатар: Сая Д.Өнөрболор гишүүн уг нь их чухал юм хэлсэн юмсан. Яг л тоо гүйцээх гэж байгаа юм шиг ямар ч чанаргүй гурилдсан асуудлууд их байна.

Одоо энэ хууль гэхэд 89 хуульд өөрчлөлт орж байгаа шүү дээ. 89 хууль. Та нарын нэг нь ч уншаагүй байх. Би л лав үүнийг бүтэн уншиж чадсангүй. Хоёр өдөр уншлаа.

Улсын Их Хурлын даргад 2022 оны 11 сарын 21-нд өргөн барьсан гэж байгаа. Над дээр хоёр өдрийн өмнө ирсэн. Би нэг 63 хувийг нь л уншлаа. Тэгээд энэ гурилдалт. Ард түмний яг санал бодол энэ хуульд тусгагдах уу, үгүй юу. Хоёр өдөр уншиж байгаа юм. Энэ бүтэн ном. Үг болгон дээр нь хүмүүсийн амьдрал, зовлон зүдгүүр. Авлига л байгаа. Хамгийн гол нь. Энд авлигыг өөгшүүлдэг хууль. Энэ Зөвшөөрлийн хууль.

Тэгэхээр Д.Өнөрболор гишүүний хэлснээр зүгээр сонсох төдийд, сонсгол хийсэн төдийд, нэг ажлын хэсэг байгуулсан төдийд, нэг хууль баталсан төдийд нэг ийм дохио зангаагаар дохиураар Монгол Ардын намаа хол явахгүй. Зул бөхийнхөө өмнө бадамладаг шиг одоо юмандаа нэг бодитой сэтгэлээсээ анхаармаар байна.

Энэ хууль Үндсэн хуульд заасан байгаа юм. Ер нь бусад хуулиудад ч гэсэн. Хуулиар хориглосон болон хууль зөвшөөрөлтэй эрхлэхээс зааснаас бусад төрлийн үйл ажиллагааг иргэн, аж ахуйн нэгж эрхэлж болно гэж байгаа юм. Зөвшөөрөл.

Одоо 14 чиглэлээр 249 тусгай зөвшөөрөл, 12 чиглэлээр 114 энгийн зөвшөөрөл байх ёстой боловч та нар бод доо. 1600 болоод бизнес нь өргөжин тэлсэн. Ард иргэдийн нус нулимс, зовлон зүдгүүрийг зовоож байж авлига авдаг тогтолцоо энэ төр чинь зүгээр л хүн зовоож байж авлигал авдаг болсон.

Тэгээд энэ дээр стандарт бол зүгээр заавал мөрдөх бус сонгон хэрэглэхээр зохицуулчихсан байгаа. Энэ зүйлүүдийг эргэж харах цаг болсон. Гишүүд минь ээ. Нухацтай энэ рүү ормоор байна.

Захиргааны хэм хэмжээний акт буюу дүрэм журмаар асуудал шийддэг болсон. Яг Үндсэн хуулиараа бол хууль нь зөвшөөрөөгүй бол гэж хэлчихсэн байгаа шүү дээ. Хуулиар заасан. Тэгсэн одоо дүрэм журмаар Монголын ард түмнийг зөвшөөрлөөр дөнгөнд хийж зовоож байгаа.

Тэгээд нийт 89 хуульд нэмэлт, өөрчлөлт орохоор болж байгаа. Бүтэн уншсангүй ээ. Амжсангүй. Хуулийн

төслийг хоёр өдрийн өмнө авлаа. Хоёрхон асуулт л байна даа.

Аль ч зөвшөөрөл олгоход мэргэжлийн боловсон хүчинд тавих шаардлага. Энэ мэргэшсэн хүмүүс нь надад тодорхой хариулж өгөөрэй. Тавих шаардлага. Инженер, мэргэшсэн зөвлөх гэх мэтийг хуульд нарийвчлан тусгасан байна. Сайн. Тэгэхдээ Монгол оронд өнөөдөр яг мэргэшсэн нарийн боловсон хүчнээр дутмаг байгаа. Хомсдчихсон байгаа. Сая сая төгрөгөөр мэргэшсэн тусгай зөвшөөрөл, тэр зөвлөх, инженер янз бүрийн ярликуудыг бүгдийг нь худалдаж авч байгаа мэдээллүүд зөндөө байна.

Үүнийг энэ хуульд яаж хаасан бэ. Эсвэл ийм юм байхгүй гэж хэлэх гэж байна уу? Миний нэгдүгээр асуулт.

Мэргэшсэн боловсон хүчин тавих шаардлагууд дээр ямар судалгаа, дүгнэлт хийсэн бэ? Үүний цаана сүүдэрт нь мэргэжлийн мэргэшсэн үнэмлэх, гэрчилгээ, диплом олгоход авлигал байгаа тийм мэдээллүүд байгаа. Эндээс яаж сэргийлсэн бэ?

Хоёрдугаар миний асуулт. Тусгай зөвшөөрөл авахад мэргэжлийн шаардлага тавихын оронд тэр тоног төхөөрөмж, мөн тэр компанийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн чадамж, туршлагыг тэргүүнд нь тодорхойлж тавьдаг тийм зарчим, зүйл заалт энэ хуульд барьсан тал бий юу?

Одоо нэгэнт л гүүр барьчихсан, нэгэнт л тусгай тэр онцгой ажлыг нь хийчихсэн тэр туршлага нь байхад тэр аж ахуйн нэгжээс 10 ширхэг гүүрийн инженерийн диплом авчир гээд шаардахыг би буруу.../минут дуусав/

Г.Занданшатар: Эхлээд Сайнхүүгийн Ганбаатар гишүүнд нэг сануулга өгчихье.

Өнгөрсөн 7 удаагийн чуулганы та 5-ыг нь тасалчихсан байна. Тэгээд гэнэт орж ирээд цочсон юм шиг ингээд юу хэлэлцээд байна вэ гэж гайхах хэрэггүй.

Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлж стандартчилал, хуулийн хийдэл, давхцал зөрчлийг арилгах зорилгоор энэ хуулиуд орж ирж байгаа. Яаралтай. 01 сарын 01-нээс Зөвшөөрлийн тухай хууль хэлэлцэх ёстой.

Зөвшөөрлийн тухай хууль чинь таны яриад байгаа тэр хээл хахууль, авлигалыг бууруулах зорилгоор тусгай аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тоог хэд дахин бууруулж, хөнгөлж чөлөөлж байгаа. Мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагууд эрх мэдлийг нь олгож байгаа. Маш сайн тийм чөлөөт зах зээлийн зарчимд нийцсэн тийм хууль. Харин ч ард түмнийг энэ хүнд суртал хэрэглээд салгаж байгаа хуулийг хэрэгжүүлэхийн тулд үүнийг яаралтай өргөн барь гэж шаардаад шахаад Улсын Их Хурал үүнийг оруулж ирж хэлэлцэж байгаа юм.

Тэгээд хуулиа ойлгоогүй. Ядаж нэгдүгээр хуудсаа унших хэрэгтэй шүү дээ. Энд чинь Монгол Улсын Их Хурлын 2022 оны 35 дугаар тогтоолоор зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Хэмжил зүйн тухай хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэх чиглэлээр хуулийн

давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, холбогдох хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны журмын дагуу боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт Улсын Их Хурлаас даалгасан. Үүний дагуу орж ирж байгаа юм.

Хууль тогтоомжийн хуульд тэр хуулийн давхцал зөрчлийг арилгах зорилгоор хууль тус бүрийн үзэл баримтлалыг хэлэлцэхгүйгээр нэгтгэж хэлэлцэж болно гэсэн заалттай.

Ийм учраас хууль тогтоох ажилдаа хариуцлагатай хандахыг танаас хүсэж байна.

Энэ хэдэн зөвшөөрлийг хэд болгож хөнгөлсөн юм. Тодорхой хариул. Н.Мягмар дарга та ажлаа мэддэг юм бол дорвитой зөв хариулаач. Та нар тэгээд бас. Хэдэн зөвшөөрөл хэд болгосон юм. Ямар давхцал хийдэл, зөрчлийг арилгаж байгаа юм. Тодорхой хариул. 81. Н.Мягмар дарга.

Н.Мягмар: С.Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар.

Зөвшөөрлийн хуулийг 6 сард батлахдаа өмнө явж ирсэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хуулиар бий болсон. Үүний дагуу хуулийг хэтрүүлэн хэрэглэж, практик дээр бараг зөвшөөрлийн шинжтэй болчихсон ийм үйл ажиллагаа Худалдаа, аж үйлдвэрийн танхимын судалгаагаар 1400 орчим болсон байсныг Зөвшөөрлийн хуулийг батлах хүрээнд 360 гаруй болгож цөөрүүлсэн.

Энэ 360 гаруй болж цөөрүүлсэнтэй холбоотойгоор бусад

хуулиудыг энэ хуульд нийцүүлж ингэж оруулж ир гэдэг энэ үүргийг хууль тогтоогч Улсын Их Хурлаас Засгийн газарт даалгасны дагуу бид бүхэн 89 хууль тогтоомжид өөрөөр хэлэх юм Зөвшөөрлийн хуульд нийцүүлээд журам батлах ёстой байсан бол тэр журам батлах эрхийг нь хүчингүй болгох, стандартаар тодорхой мөрдөх ёстой гэсэн зүйлийг нь улам тодруулж, нийтдээ жишээ нь Зөвшөөрлийн хуульд заасан 108 тусгай зөвшөөрөл, 7 энгийн зөвшөөрөлтэй холбоотой стандартыг тусгайлан баталж, зөвшөөрөл эзэмшигч заавал мөрдөх үүрэгтэй байхаар жишээ нь Стандарт, хэмжил зүйн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуулиудад ингээд өөрчлөлт оруулж төсөл боловсруулж оруулж ирсэн.

Г.Занданшатар: Хэдийг. 1200-г 360 болгосон уу?

Н.Мягмар: Тийм. 1400 гаруйгаас.

Г.Занданшатар: С.Ганбаатар гишүүн ээ. 1400 гаруй тусгай зөвшөөрлийг 360 болгож цөөлсөн. Энгийн тусгай зөвшөөрлийг хялбаршуулсан.

Ер нь стандарт гэдэг бол тийм дэмий хууль биш. Экспорт, импорт, нийгмийн бүх харилцаанд стандарт шиг чухал юм байхгүй. арин стандартын шинэчлэл удааширч байгаа.

Ер нь тэгээд шударга журам гэдэг чинь, тэгш журам гэдэг чинь стандартаас үүсдэг шүү дээ. Дабль стандартгүй. Нэг стандарттай байхаас.

Зочид танилцуулья. Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа, Хишгээгийн Нямбаатар нарын урилгаар

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг угтан иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ эрүүл энх, хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. /алга ташив/

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн 1 минут тодруулж асууна.

С.Ганбаатар: Ноёнтой уралцвал толгойгүй, нохойтой сөргөлдвөл хормойгүй гэдэг шиг. Би Улсын Их Хурлын даргатай уг нь сөргөлдөөгүй юмсан.

Хууль 11 сарын 21-нд орж ирлээ. Хоёр өдрийн өмнө би хүлээж авлаа. Унших цагаар хомс байлаа гэдгээ хэллээ.

Тэгээд миний асуултад тодорхой сая хариулсангүй. Би тэр 1600 орчим. Би тэр юунаас нь харсан шүү. Удирдамжаас нь хараад тэр танилцуулгуудаас нь уншсан зүйлээ ярьсан.

Энэ мэргэжлийн боловсон хүчинд тавих шаардлагууд дээр практик дээр өнөөдөр энэ боловсон хүчний хомсдолд орчихсон байгаа энэ асуудал дээр тодорхой зохицуулалтуудыг хийсэн үү? Энэ практик судалгаанууд дээр тоо баримт байгаа юу? Энэ дээр мэргэшсэн боловсон хүчин хангалттай байгаа. Энэ шаардлагууд хангалттай болно гэж хариулах юм уу, эсвэл болохгүй байгаа тухайн аж ахуйн нэгжүүдийн хийсэн туршлага, тоног төхөөрөмжүүдийнх нь тэр шаардлагад

нь хангалттай байгаа гэдгээр бас энэ зарчмууд орж болох уу гэсэн.

Г.Занданшатар: 81. Н.Мягмар дарга хариулья.

Н.Мягмар: Энэ Зөвшөөрлийн хууль үндэсний аюулгүй байдал, хүний эрүүл мэнд, байгаль орчин, мөн төрийн баялаг, нийтийн өмчтэй холбоотой ийм зүйлийг хязгаартайгаар ашиглахтай холбоотой л явуулж байгаа үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл болон энгийн зөвшөөрөл олгоно гэдэг ийм зохицуулалтаар батлагдсан.

Бусад тохиолдолд иргэн, хуулийн этгээд хууль тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагааг чөлөөтэй эрхэлнэ гэж заасан.

Тийм учраас энэ Зөвшөөрлийн тухай хуульд заасан зөвшөөрөл эзэмшигчдэд тавих нийтлэг шаардлагыг энэ хуулиар заагаад өгчихсөн. Тэр зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны онцлог, төрөл, тэр эрсдэлтэй байдал энэ тэрээс нь хамаарч зайлшгүй зөвшөөрөл эзэмшигч буюу зөвшөөрөл авах гэж байгаа тэр улсуудад тавигдах шаардлага, тоног төхөөрөмж, мэргэжлийн боловсон хүчинд тавигдах шаардлага энэ тэрийг салбарынх нь хуулиудад нь тусгайлан зааж өгөх зайлшгүй шаардлагатай байгаа. /минут дуусав/

Г.Занданшатар: Цэндийн Мөнх-Оргил гишүүн асуулт асууна.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Гишүүдийг Их Хурлын удирдлагыг энэ 89 хуульд нэлээн анхаарал хандуулаач гэж хүсмээр юм байна.

С.Ганбаатар гишүүний бухимдаад байгаа ч аргагүй л дээ. Ингээд л энэ том ном ороод ирчихдэг. Тэгээд 89 хууль гэдэг чинь үндсэндээ ер нь Монгол Улсын хууль тогтоомж, эрх зүйн актуудыг орвонгоор нь эргүүлэх гэж байна шүү дээ. Нэлээн орвонгоор нь эргүүлэх гэж байна.

Жишээ нь, энэ хар даа. Бид Стандартчилал, хэмжил зүйн хуулийг өөрчлөөд олон улсын жишигт нийцүүлсэн байхгүй юу. Хуучин манайд юу гэж боддог байсан бэ гэхээр, стандарт гэхээр Засгийн газар батлаад өгчихсөн. Заавал хэрэгжүүлэх нь стандарт гээд ойлгочихсон байсан байхгүй юу.

Хорвоо ертөнц чинь өөр болчихсон шүү дээ. Хорвоо ертөнц чинь Засгийн газар батлаад өгчихсөн юм нь техникийн зохицуулалт болчихсон. Техникийн зохицуулалт. **Technical specifications**_[техникийн тодорхойлолт] гээд. Тэрийг нь заавал биелүүлнэ.

Стандарт гэдэг нь талууд сайн дураараа, хэдүүлээ техникийн зохицуулалтаас илүү бүтээгдэхүүнийхээ чанарыг сайжруулья, ноолуурынхаа чанарыг сайжруулья, махныхаа чанарыг сайжруулья гээд байгууллагууд хоорондоо тохироод хүлээн зөвшөөрөөд стандарт болгоод тэрийгээ хянаад явж байдаг юм нь сайн дурын үндсэн дээр стандарт болчихсон байхгүй юу.

Тэгээд үүнийг бол одоо жишээ нь энэ хуулиар ингээд орвонгоор нь өөрчлөөд ороод ирж байна шүү дээ. Шал өөрөө тодорхойлолт оруулаад.

Стандарт гэдэг нь “тогтоосон, сонгон хэрэглэх” гээд үндсэн агуулгыг нь үлдээнгүүтээ эсвэл “хуульд заасны

дагуу заавал дагаж мөрдөх баримт бичиг” гээд нөгөө техникийн зохицуулалттайгаар хутгачихаж байгаа байхгүй юу.

Одоо ингээд энэ стандартын хэмжил зүйн эрх зүйн зохицуулалт чинь бүр шал өөр болоод явчихлаа. Хэрэгжихээргүй болчихлоо. Энэ ингэж сууриар нь бужигнуулж болохгүй шүү дээ. Н.Мягмар аа.

Хоёрдугаарт, энэ байна шүү дээ. Би Зөвшөөрлийн хуулийг дэмжээд байгаа юм. Тэгэхдээ Зөвшөөрлийн хуульд нийцүүлж байна гэж хэлээд үндсэн хуулиудаа, гол хуулиудаа орвонгоор нь бужигнуулаад байж болохгүй ээ. Жишээ нь, сая хэдхэн хоногийн өмнө, хэдхэн сарын өмнө бид Согтууруулах ундааны хуулийг баталсан. Түүн дээрээ Ерөнхийлөгчийн Тамгын газартай, Нийслэлийн Засаг даргынхантай, аймгийн Засаг дарга нартай ярьж, Хүнс, хөдөө аж ахуйн яамныхантай ярьж, бүр тал талаас нь, үйлдвэрлэгч нартай ярьж ярьж байгаад энэ сонгон шалгаруулалт гэдэг чинь шал худлаа юм байна. Ерөөсөө дуудлага худалдаа хийе. Яадаг вэ гэхээр сонгон шалгаруулалт гэж баахан худлаа баримт бичиг цуглуулж авчхаад, тэгээд л ёстой нөгөө авлига руугаа орчхоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр зүгээр дуудлага худалдаа хийчихье. Хүн мөнгөө төлөөд зөвшөөрлөө аваг. Тэгээд хоёр жилийн дотор үйлдвэрээ бариг. Ийм юм руу шилжүүлээд оруулсан чинь буцаад л нөгөө архиныхаа хуулийг орвонгоор нь эргүүлээд л сонгон шалгаруулалт гээд л ороод ирж байгаа юм.

Хоёр сарын өмнө баталсан хуулиа, гаргасан концепцоо ингээд хоёр

сарын дараа бид буцаагаад л өөрчлөөд байх юм уу? Хууль чинь хэрэгжиж амжаагүй байна шүү дээ. Энэ арай хариуцлагагүй юм.

Зөвшөөрлийн хуулийг дэмжиж байна. Зөвшөөрлийн тоог нь цөөлөх ёстой. Авлига, хүнд сурталтай тэмцэх ёстой. Тэгэхдээ ингэж бужигнуулж биш шүү дээ.

Би зүгээр ганцхан жишээ хэлье. Одоо энэ архидан согтууруулах дээр тэр согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох гэж байгаа байхгүй юу. Тэрийг дуудлага худалдаа болгочихсон байсан юм. Тэгсэн чинь одоо байна шүү дээ, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандартын шаардлагыг дүгнэсэн стандартын хуудасны хуулбар, эрх бүхий байгууллагаас тухайн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх талаар гаргасан улсын байцаагчийн болон ажлын байрны дүгнэлт гээд.

Энэ олон юмнууд чинь хүний чинь жинхэнэ утгаараа тэр зөвшөөрлөөс чинь илүү хүн зовоогоод байгаа юм чинь энд байгаа байхгүй юу. Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл гээд нэг зөвшөөрөлтэй юм шиг мөртлөө тэрийгээ өгөхийн тулд дотроо арван хэдэн тусгай зөвшөөрөл, шаардлага.../минут дуусав/

Г.Занданшатар: Ц.Мөнх-Оргил гишүүнд сайн тайлбарлаж өгье. Нэргүйн Мягмар. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газар.

Өнөөдөр хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж байгаа шүү дээ. Хэлэлцэх эсэхийг шийдчихээд энэ дээр чинь хууль болгоноор ажиллана.

Н.Мягмар: Ц.Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя.

Стандарт хэмжил зүй, тохирлын итгэмжлэлийн үнэлгээний тухай хуульд стандартын талаарх томъёоллыг тодорхойлж ингэж оруулж ирж байгаа. Яах вэ, дэлгэрүүлээд манай Стандарт, хэмжил зүйн Б.Билгүүн дарга хариулах байх.

Бид бүхний оруулж ирж байгаа, Засгийн газрын зүгээс оруулж ирж байгаа концепцоор стандартыг зайлшгүй мөрдөх ёстой ийм зохицуулалтууд байна. Техникийн зохицуулалтаас гадна. Өөрөөр хэлэх юм бол олон хувилбартай, олон улсын болон үндэсний хэмжээний стандартууд байдаг учраас энэ тодорхой төрлийн үйл ажиллагаанууд дээр зайлшгүй стандартыг баталъя.

Үүнийгээ мөрдье өө. Тэгэхдээ энэ нь зүгээр хуулиар заавал мөрдөнө гэсэн ийм стандартыг л тодруулж оруулж ирье гэж тогтоод стандартын хүрээнд 108 тусгай зөвшөөрөл, 7 энгийн зөвшөөрөлтэй үйл ажиллагааг зайлшгүй стандарттай байх ёстой. Энэ стандартыг нь зайлшгүй зөвшөөрөл эзэмшигчид нь мөрдөх ёстой гэсэн энэ хүрээндээ боловсруулж холбогдох яамдаас нь оруулж ирж байгаа юм.

Согтууруулах ундаа, түүний эргэлтэй холбоотой асуудал дээр ер нь энэ зөвшөөрлийг дан дуудлага худалдаа гэхгүйгээр сонгон шалгаруулалтын. Өөрөөр хэлэх юм бол нэмэлт нөхцөл тавьдаг ийм арга хэлбэрүүдээ явуулбал бас байлгах ёстой гэдэг ийм асуудлыг тавьж байгаа.

Тэгээд яг согтууруулах ундаатай холбоотой зохицуулалтыг Хүнс, хөдөө аж ахуйн яамны зүгээс энэ зөвшөөрлийг эзэмшигчид тавигдах шаардлага, нөхцөлүүдийг салбарын хуульдаа илүү тодруулж оруулж ирж ингэж зохицуулалтыг нь оруулж ирж байгаа.

Г.Занданшатар: 84. Стандартыг ч тодорхойлсон юм байхгүй л дээ. Хууль дээр нь. Иодорхой хариул.

Б.Билгүүн: Ц.Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя.

Шинээр орж байгаа өөрчлөлтөд гол асуудал нь стандартыг сонгон хэрэглэх гэдэг гол концепц нь хэвээрээ үлдэж байгаа.

Заавал мөрдөх асуудал нь нөгөө тохирлын үнэлгээний баталгаажуулалтад заавал хамрагдах бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт гэж Засгийн газраас баталсан жагсаалт байгаа. Энэ дээр орсон бүтээгдэхүүнүүдийг баталгаажуулахын тулд эдгээр стандартуудыг заавал мөрдөх ёстой юм гэдэг гол концепцыг оруулж байгаа юм.

Энэхүү 291 дүгээр тогтоол дээр орсон бараа бүтээгдэхүүний гол шаардлага нь юу вэ гэхээр хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болохуйц бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг стандартад заавал нийцүүлэх ёстой гэдэг юм Засгийн газрын тогтоолоор батлагдсан ийм жагсаалт байгаа юм. Энд хамаарах стандартуудыг заавал мөрдүүлье гэдэг тухай л асуудлыг тусгаж оруулсан юм.

Г.Занданшатар: Гүйцээгээд тодорхой хариулаач.

Ер нь зөвшөөрлийн тоог 1200, 1400-аас 360 болгож цөөрүүлэхдээ нөгөө талаас төрийн үүргийг сулруулж болохгүй. Хүний эрүүл мэнд, амь настай холбоотой, согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, согтууруулах ундаа энэ тэрийн зөвшөөрөл, стандартыг заавал мөрдөнө гэж. Түүндээ л нийцүүлж байгаа гэж хэлээд байна шүү дээ.

Та сүүлд асуулт авсан. Одоо болсон. Та өчигдөр хуралдаан оролцоогүй. Та 3 удаа хоцорсон, 1 удаа тасалсан байна. Өнгөрсөн сарын хурлаар. Өчигдрийн хуралдаан дээр үг аваагүй байна. Байхгүй байсан байна. Хуралдаа сууцгааж бай.

1 минут. Тодорхой хуультай холбоотой л юм асуу. Ц.Мөнх-Оргил гишүүн 1 минут.

Ц.Мөнх-Оргил: Намайг ер нь хуультай холбоогүй юм асууж байхыг та мэдэхгүй байх шүү. Г.Занданшатар дарга аа.

Стандарт гэж энэ Стандарт, хэмжил зүйн хуулийн 4.1.2 дээрээ тодорхойлчихсон юм. Техникийн зохицуулалт гээд тодорхойлчихсон юм. Энэ хоёроос гадна стандарт, техникийн үзүүлэлт, техникийн шаардлага, тэгээд техникийн зохицуулалт гээд энэ тусдаа юмнууд байхгүй юу.

Заавал биелүүлдэг стандарт гэдэг чинь техникийн зохицуулалт болчхож байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл ингээд нөгөө суурь ойлголтуудаа хооронд нь хутгаад байхаар чинь наад хууль чинь яаж хэрэгжих юм бэ.

Энэ 2017 оны хуулийг Б.Билгүүн ээ, чи надад заагаад байх юм байхгүй. Би энэ хуулийг чинь өөрөө батлуулсан юм. Наад яриад байгаа Засгийн газрын тогтоолыг чинь би бас батлахад нь оролцсон юм.

Одоо та нар энэ стандарт, хэмжил зүйн суурь зохицуулалтыг бүгдийг нь устгаж байна. За юу. Байхгүй болгож байна.

Тэгээд ингээд хуулиа мэдэхгүй нөхдүүд орж ирээд цоо шинэ юм хийж байгаа юм шиг юм яриад Монгол Улсад үйлчлээд болоод.../минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Та нар хариулж чадахгүй мэдэхгүй, ажлаа мэдэхгүй үнэнээ хэлээд хуулиа буцааж татаж ав. Ийм бужигнуулчихсан юм хийчихсэн юм бол. Хариулж чадахгүй юм. Тийм юм байхгүй, ийм юм байхгүй. 84.

Б.Билгүүн: Ц.Мөнх-Оргил гишүүний асуултад тодруулга хийе.

Техникийн зохицуулалтаар зохицуулж байгаа асуудлууд бий. Техникийн зохицуулалтыг Монгол Улсад Засгийн газар баталж байгаа. Стандарт, хэмжил зүйн газар стандартуудаа баталж байгаа.

Тухайн салбарт заавал мөрдөхөөр стандартыг оруулж ирж байгаа нь түрүүн дурдаж байгаа хүний эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой стандартууд, түүн дотроо яг энэ Засгийн газраас баталсан жагсаалтад орсон бараа, бүтээгдэхүүнтэй холбоотой стандартуудыг л тодорхой зааж өгч байгаа.

Г.Занданшатар: Ингээд хуулиа тайлбарлаж хамгаалж хэлж чадахгүй бол энэ хуулийг унагаах юм уу, буцаана шүү.

Зохицуулалт байхгүй. Ажлаа мэддэггүй улсууд юм байна гэж үзээд бид буцаахаас өөр замгүй боллоо.

Одоо дэмжсэн, дэмжээгүй үг хэлээд тэгээд хэрвээ дэмжигдэхгүй бол энэ хууль буцлаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүн байна уу?

Батгөмөрийн Энхбаяр.
Ганибалын Амартүвшин гишүүнээр тасаллаа. Цэндийн Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Зөвшөөрлийн хуулийг бид дэмжиж байгаа.

Тэрийг эсэргүүцээд байгаа юм байхгүй. Хэн ч гэсэн бизнесээ жижиг, дунд, том гэлтгүй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдээ дэмжээд төрийн хүнд суртлаас багасгая л гэж бодож байгаа шүү дээ.

Тэгэхдээ тэр Зөвшөөрлийн хуулиа хэрэгжүүлэх нэрээр ингээд 89 хуулиа бужигнуулаад хэдхэн сарын өмнө баталсан хуулиа концепоор нь өөрчлөөд. Стандарт, хэмжил зүй гэдэг чинь өнөөдөр Монгол Улсын энэ үйлдвэрлэл, үйлчилгээ, хүнсний аюулгүй байдал, бүтээгдэхүүн үйлчилгээний аюулгүй байдал, бүх юмыг зохицуулж байгаа техникийн хууль байхгүй юу. Энд ямар нэгэн улс төр байхгүй. Мэргэжлийн хууль.

Тэгээд эд нарыгаа ингээд Зөвшөөрлийн хуультай нийцүүлж байна гээд эрх зүйн суурь бааз дэвсгэрээ

ингээд бужигнуулчихаж болохгүй шүү дээ.

Бид та нарт хууль баталж өгөөд Засгийн газрыг хууль хэрэгжүүл гэдэг л шаардлага тавьж байгаа шүү дээ. Түүнээс хоёр сарын өмнө баталчихсан хуулийг биш юм байна, дуудлага худалдаа биш юм байна, дуудлага худалдаанаас гадна бид заавал сонгон шалгаруулалт хийх ёстой юм байна гээд оруулаад ир гэж хэлээгүй шүү дээ.

Хэрэгжүүлж эхлээгүй. Та нар ер нь Засгийн газар хууль хэрэгжүүлэх үүрэгтэй гэдгээ ойлгодог юм уу, эсвэл Улсын Их Хурлын хуулийг нь засаад одоо энэ биш байна. Ерөөсөө хоёр сарын өмнө баталсан хууль чинь биш байна. Одоо бид нар шал өөр концепц хийх ёстой гээд ингээд оруулаад ирэх ёстой гэж бодоод байгаа юм уу.

Үүнийгээ дахиж янзалж оруулж ирсэн нь зөв байх.

Г.Занданшатар: Нэг дэмжихгүй үг хэллээ. Батгөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Би Ц.Мөнх-Оргил гишүүны зарчмын саналтай бас санал нэг болоод явчихлаа шүү.

Энэ яах вэ танилцах боломж, хугацаа давчуу байсан учраас бас нэг их сайн үзэж чадаагүй. Сая бас ингээд үзээд байсан чинь. Бид Зөвшөөрлийн хууль. Би энэ Зөвшөөрлийн хуулийн ажлын хэсэгт ажилласан юм.

Тэгээд чуулганы хэлэлцүүлгийн шатанд хоёр асуудлаар бас зарчмын байр суурь илэрхийлээд байсан юм. Тэр нь газрын зөвшөөрөл, ашигт малтмалын

зөвшөөрөл хоёрыг нь Зөвшөөрлийн хуулиар зохицуулахгүй.

Газрын зөвшөөрлийн асуудлыг газрын багц хуулиар л зохицуулна. Ашигт малтмалын зөвшөөрлийн асуудлыг зөвхөн Ашигт малтмалын хуулиар зохицуулна.

Энэ хоёр дээр зарчмын ялгаатай буюу Зөвшөөрлийн хуульд заасан тэр дуудлага худалдааны аргыг ганцхан хэрэглэж болохгүй. Тухайлбал, газар дээр. Тэгвэл одоо энэ хамгийн цөөхөн хүн амтай, хамгийн том газар нутагтай гэхчээ энэ чинь өнгөтэй мөнгөтэй хүн л авна шүү дээ. Дуудлага худалдаагаар газраа олговол.

Тэгээд энэ дагасан Газрын хууль ороод ирсэн байна л даа. Одоо бид нар чинь өчигдөр Газрын багц хуулийн хэлэлцэх эсэхийг нь шийдээд дэмжчихсэн. Өчигдөр. Дөнгөж өчигдөр.

Тэгсэн чинь үүнийг дагасан газрынх нь хуульд оруулж байгаа өөрчлөлт нь ба дахиад Газрын хуультайгаа тэнцэхүйц ийм бараг арван хэдэн хуудас. Бүр том хууль ороод ирсэн байна.

Энэ хуульд нь юу байна вэ гээд тэгэхээр нөгөө дуудлага худалдааны асуудлуудаа зохицуулаад явчхаж. Өчигдөр бид нарын хэлэлцэх эсэхийг шийдсэн газрын багц хуулиар болбол газар олгох зөвшөөрлийг ямар зарчмаар шийдэх вэ гэдэг дээр концепц нь бас яг энэ зөвхөн дуудлага худалдаагаар олгох ийм концепц байхгүй.

Тэгэхээр энэ Засгийн газраас орж ирж байгаа хоёр, гурван өдрийн давтамжтай зайтай орж ирж байгаа хуулийн концепцуудыг нийцэл, үзэл

баримтлалын зөрүүг аягүй сайн нягтлахгүй бол болохгүй юм байна.

Ашигт малтмалын хууль дээр бас нэлээн том өөрчлөлт ороод ирсэн юм байна шүү дээ. Энэ чинь. Бас бараг арваад хуудас шахуу юм байх шиг байна. Үүнийг бас нэлээн сайн үзмээр юм шиг байна. Энэ лицензийн зөвшөөрлүүд яаж явах гэж байгаа юм бол.

Эсвэл Засгийн газар чинь нэг юм өөрчилж санаачилчих гээд байдаг.

Ер нь үүнийг дагалдуулаад янз янзын юмнуудаа оруулаад явчихъя гээд энэ зөвшөөрөлтэйгөө яг хуультайгаа холбоогүй юмнууд өргөн барьчихсан юм биш байгаа гэсэн бас би зүгээр таамаг ярьж байгаа шүү. Би уншиж чадаагүй учраас. Тийм юм байна уу, үгүй юу?

Тийм учраас үүний нийтлэлийг нэлээн сайн үзэж байж ярихгүй бол болохгүй л санагдаад явчихлаа.

Г.Занданшатар: Ганибалын Амартүвшин гишүүн.

Г.Амартүвшин: Баярлалаа. Би Зөвшөөрлийн тухай хуулийн ажлын хэсэгт өөрөө гишүүн болоод ажилласан.

Энэ бол маш том дэвшилттэй тийм өөрчлөлт болсон. 1400 гаруй зөвшөөрлийг бид тоог нь бууруулаад хүнд суртлыг нь бид цэгцлээд их зөв юм болсон. Гэхдээ одоо жишээлбэл Банкны тухай хуулийг үүгээр ингээд засах гэж байна л даа. Бүхэл бүтэн хэсэг нэмж байна.

Банкны тухай хуулийг бид юу болж баталж байлаа. 7, 8 жил гацсан тэр

хуулийг бөөн хэрүүл маргаан болж элдвээр хэлүүлж байгаад бид орж ирсэн шүү дээ. Арай гэж байж баталсан. Тэгээд одоо хавсралт мэтээр Банкны тухай хуулийг ингээд өөрчлөж болохгүй шүү дээ.

Банкны тухай хууль чинь тусгай зөвшөөрөлтэй. Энэ бол Монголын эдийн засгийн маш том нөлөө үзүүлдэг салбар шүү дээ. Үүнийг бид зүгээр хавсралт мэтээр Стандартчлалын тухай хуулийг өөрчилж байна гэсэн нэрийн доор Банкны тухай хуулиа ингэж хөндөж болохгүй. Маш олон том том хуулиуд энэ дээр ингээд хавсралтаар ороод ирчихсэн байна л даа.

Тэгэхээр ийм байдлаар бид энэ хуулийг ерөөсөө цаашаа явуулж хэлэлцэх ямар ч боломж байхгүй.

Тийм болохоор би энэ хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжихгүй байна.

Г.Занданшатар: Гурав дэмжихгүй үг хэлсэн. Одоо зөвхөн дэмжсэн гишүүн үг хэлэх болсон.

Сайнбуянгийн Амарсайхан гишүүн. Сандагийн Бямбацогт гишүүнээр тасаллаа.

С.Амарсайхан: Энэ стандартыг заавал дагаж мөрддөг байх тухай асуудлыг л ярьж байгаа юм.

Техникийн зохицуулалт гэж бий. Тэгэхдээ техникийн зохицуулалт нь стандарт юм уу, эсвэл зүгээр техникийн шаардлага юм уу гэдэг нь ч ялгагдахаа байчихсан. Ард иргэд, аж ахуйн нэгжээсээ эхлээд төрийн байгууллага, төсвийн байгууллагууд нь хүртэл үүнийгээ дагаж мөрддөггүй ийм байдал байгаа учраас өнөөдөр гараад бид энэ

гудамжны түгжрэл, явган хүний замаасаа эхлээд авто замын асуудал, айл өрхийн барилга, байгууламж, энэ бараа, бүтээгдэхүүний чанар, стандарт, аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдал, эм, эмийн хэрэгслийн аюулгүй байдал гээд бүх зүйл эрсдэлд орчихсон.

Стандарт сонголт юм байна гээд тусгачихсан учраас дуртай нь үүнийг хэрэгжүүлдэг, дургүй нь хэрэгжүүлдэггүй. Үзэмжийн болчихсон.

Ийм учраас энэ Зөвшөөрлийн тухай хуулиас эхлээд энэ стандартыг бид зайлшгүй дагаж мөрддөг болъё гэж. Асар том хөгжил ярьдаг, хардаг. Маш том бодлого ярьдаг, боловсруулдаг. Түүнийг хэрэгжүүлдэг гүүр нь болсон стандарт өнөөдөр мартагдсан учраас бүх зүйл Монгол Улсад эмх цэгцгүй, эрэмбэ дараагүй, эзэнгүй, ажил нь эзэнгүй, эзэн нь хариуцлагагүй, хариуцлага нь стандартгүй ийм явж ирсэн байгаа юм.

Тийм учраас энэ хуульд тусгай зөвшөөрөл эзэмшдэг эзэмшиг ч бай, эсвэл аливаа нэгэн үйл ажиллагаа явуулж байгаа бол зайлшгүй стандартыг хууль мэт даган мөрддөг байна гэж ийм зохицуулалтыг тусгаж өгч байж бид дараа дараагийн асуудлуудаа цэгцлэхгүй бол болохгүй ийм асуудал байгаа юм. Эрхэм хурлын дарга аа.

Тийм учраас энэ асуудлыг ойлгож, зөв талаас нь харахгүй бол бид өмнө нь ийм хууль баталчихсан юм. Техникийн зохицуулалт байгаа юм. Тэр нь сонголтоор байдаг юм гээд сайн дурын үзэмжийн асуудал болчихсон.

Мэргэжлийн хяналтын байгууллагын асуудал байгаа. Очоод шаардлага тавьдаг, хяналт тавьдаг.

Болохгүй байна, бүтэхгүй байна гэдэг. Гэтэл өөрөө хяналт нь стандартгүй болчихсон учраас хяналт тавьж байгаа байгууллага нь хэнийг яаж хянахаа ч мэдэхээ больчихсон, хяналт нь үзэмжийн болчихсон, хариуцлага нь ч үзэмжийн болчихсон, эргээд хариуцлага шаардах гэхээр хэнээс юуг шаардахаа мэдэхээ больчихсон ийм асуудал байгаа юм.

Тийм учраас энэ стандартыг улс орон даяар бүх нийтийн үйл хэрэг болгоё. Тэгээд энэ алхдаг гишгэдэг, гудамж талбайгаасаа эхлээд амьдардаг, суудаг орон сууц, ажил төрөл, төрийн албанаас эхлээд хүртэл төрийн үйлчилгээг стандартжуулах, хариуцлагажуулах, бүр цаашлах юм бол өдөр тутмын хэрэглээний аюулгүй байдал, хэрэглээний соёл, тэгээд энэ стандартын соёлыг түгээх хүрээнд энэ асуудлыг шийдье гэж ингэж энэ өөрчлөлтийг оруулж ирж байгаа юм. Ажлын хэсэг ажилласан. 10 дугаар сарын 05-ны өдөр Засгийн газарт танилцуулсан.

Стандарт, хэмжил зүйн газрын үйл ажиллагааг сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эргээд хууль эрх зүйн уялдаа холбоог хангахтай холбоотой асуудал байгаа.

Цаашдаа бид эргээд бүр энэ техникийн тохирлын үнэлгээ гэдэг зохицуулалт гэдгээ ч гэсэн эргэж харах ёстой. Стандарт гэж байгаа бол нэг л үг хэлээр ярьдаг хөгжлийн нэг хэлтэй байхгүй бол стандарт ч юм шиг, тохирлын үнэлгээ ч юм шиг, техникийн зохицуулалт гээд ингээд бантанг нь хутгаад хаячихсан ийм хуулиудыг л цэгцэлье гэж ингэж асуудал ярьж байгаа юм.

Тийм учраас үүнийг манай гишүүд дэмжиж, энэ стандартгүйгээр бид цаашаа сайн сайхан амьдрал, сайн сайхан өөрчлөлт, тэгээд бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний нэг түвшин нэг, шаардлагыг бий болгох тийм орчин нөхцөл бүрдэхгүй шүү гэдгийг Та бүхэн маань ойлгож энэ асуудлыг дэмжиж өгөхийг хүсье.

Г.Занданшатар: Сандангийн Бямбацогт гишүүн.

Дараа нь санал хураалттай. Гишүүд чуулганы танхимд цуглаарай. Санал хураалт явуулна.

С.Бямбацогт: Энэ хуулийн төслийг хэлэлцэхэд дэмжиж байгаа юм.

Яагаад гэвэл бид Зөвшөөрлийн тухай хуулийг батлах гэж нэлээн болсон. 2001 онд аж ахуйн үйл ажиллагааны Зөвшөөрлийн тухай хууль гэж анх батлагдсан. Хэрэгжиж эхэлсэн цагаасаа хойш үндсэндээ гарын үсгээ үнэлж төрийн албан тушаалтнууд үндсэндээ шан харамж авдаг, хүнд суртал гаргадаг, авлигал авдаг үндсэн эх үүсвэр нь болсон. Үүнийг шийдэх гэж олон жил ярьсан. Олон жил.

Ингээд 2016 оноос хойш үндсэндээ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан. 2019 онд хууль өргөн барьсан. 2019 онд өргөн барьсан хуулийг хэлэлцэж батлах гэж 2022 онд баталсан.

2022 онд батлахдаа Зөвшөөрлийн тухай хуулийг хэрэгжүүлэх Зөвшөөрлийн тухай хуульд бусад хуулиудыг нийцүүлэх үндсэндээ энэ хүнд суртал, авлига, шан харамж авдаг асуудлаас салгах төрийн албан хаагчдыг. Энэ хуулийг хэрэгжүүлье.

Хэрэгжүүлэхдээ Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлж бусад хууль тогтоомжийг өөрчлөөрэй. Хуулиудын давхардал, хийдэл зөрчилгүй болгоорой гэдэг үүргийг Улсын Их Хурлаас Засгийн газарт өгсөн. Өгсөн.

Тэгээд үүнийг л хэрэгжүүлж болно. Их Хуралд Засгийн газар хуулийн төсөл өргөн барьсан. Энэ хуулийг хэлэлцэж байж, баталж байж 2023 оны 01 сарын 01-нээс Зөвшөөрлийн тухай хууль маань хэрэгжиж эхлэх юм.

Тэр 1400 тусгай зөвшөөрөл чинь 360 орчим болж цөөрөх юм. Зөвшөөрлийг давсан авлигал хээл хахууль авдаг, гарын үсгээ үнэлдэг явдал цэгцрэх юм. Хэрвээ энэ хуулийг дэмжихгүй уначих юм бол үндсэндээ дахиад л нөгөө хээл хахууль авдаг 1400 тус тусгай зөвшөөрөл чинь хэвээрээ, гарын үсгийн үнэлдэг байдал чинь хэвээрээ үлдэх юм.

Тийм болохоор гишүүд энэ талаас нь хараач ээ. Үнэхээр асуудалтай байж болно. Асуудалтай байх юм бол хэлэлцэх эсэхийг нь шийдчихээд анхны хэлэлцүүлгийн явцад засаад сайжруулаад өөрчлөөд явах бололцоо нь Их Хуралд байгаа. Их Хурлын бүрэн эрх юм. Энэ асуудал бол. Тийм болохоор Зөвшөөрлийн хуулиа хэрэгжүүлэхийн тулд энэ хуулийн төслийг дэмжиж, яаралтай Зөвшөөрлийн хуулийг хүнд сурталаас салгах энэ асуудлыг шийдэх хэрэгтэй байгаа юм. Тийм болохоор гишүүдийг дэмжиж өгөөч ээ гэж хүсэж байна.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглая. Асуулт, хариулт, үг хэлэх цаг

дууссан. Одоо санал хураалтын цаг болж байна. Гишүүн чуулганы танхимд цуглая.

Зочид танилцуулья. Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын Баярсайхан, Цэдэндамбын Цэрэнпунцаг нарын урилгаар Завхан аймгийн Их-Уул сумын Соёлын төвийн ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхний ажил хөдөлмөр, ард түмнээ соён гэгээрүүлэх их үйлсэд өндөр амжилтыг хүсэн ерөөе. /алга ташив/

Н.Мягмар дарга аа. Та хэдэд олон удаа болж байгаа. Гишүүдийн хэлж байгаа шүүмжлэлд зүйтэй, анхаарах зүйл зөндөө байна.

Хуулийн төслийн чанарт анхаарах хэрэгтэй байна гэж би өчигдөр сануулж хэлсэн. Хууль санаачлагч түүхий дутмаг төслөө Улсын Их Хурал учрыг нь олно гээд парламентын босго давуулаад шийддэг байдлаа зогсоо гэж хэлсэн. Эрдэмтэн судлаачид, иргэдэд салбар салбарынхаа саналыг сайн авч шүүсийг нь шахаж байж оруулж ирж бай гэж хэлсэн.

Та нарын өргөн барьсан 80 заалттай төсөл 90 өөрчлөлт орж батлагдаж байна.

Одоо Төмөр замын тухай хууль бүх заалт нь шинэчлэгдэж орох гэж байна. Үүнийг татаж аваад дахиж ярихгүй бол. Тийм ээ. Манай ажлын хэсэг Ж.Бат-Эрдэнэ гишүүн, манай Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ажилласан.

Энэ хууль дээр ч гэсэн Зөвшөөрлийн тухай хуульд заасан шүү дээ. Үндсэн концепц нь төрийн нийтийн өмчийг ашиглах харилцааг Зөвшөөрлийн хуулиар зохицуулахгүй гэж. Төрийн нийтийн өмч чинь Үндсэн хуулиараа Монгол Улсын иргэнд өмчлүүлснээс бусад газар газрын хэвлийн баялаг орж байгаа шүү дээ.

Тэгээд энэ дотор ингээд Газрын хууль ороод ирчихсэн гээд энэ газрын багц хууль хэлэлцэж байхад давхцуулаад ороод ирдэг чинь энэ Батгөмөр Энхбаяр гишүүний хэлж байгаа зөв. Ц.Мөнх-Оргил гишүүн тэр стандартчилал, техникийн зохицуулалт хоёрын ялгааг хэлчих гэж байхад ялгааг нь хэлэхгүй байна шүү дээ.

Стандарт сонгон хэрэглэх, заавал дагах баримт бичиг гээд хоёулангийн зэрэг хэрэглэхээр чинь үүнийг чинь хууль хоёр ацтай байж болдоггүй шүү дээ.

Ц.Мөнх-Оргил гишүүн бол заавал сонгон хэрэглэх стандарт байх ёстой гээд байна шүү дээ. Гэх мэтчилэн ингээд олон асуудлууд байна.

Тэгэхдээ манай эрхэм гишүүд анхааран болгоож хэлэлцэх эсэхийг нь шийдээд янзлаад явахгүй бол Зөвшөөрлийн хууль 12 сарын 31-н өнгөрөөд 01 сарын 01-нээс хэрэгжих ёстой.

Сая С.Бямбацогт гишүүний хэлээд байгаа шиг нөгөө 1600 зөвшөөрлийг чинь 360 болгох асуудал чинь энэ хуулиар цэгцлэгдэх ёстой. Тэгэхгүй бол хуучин хуулиараа Зөвшөөрлийн хууль хэрэгжихгүй үлдэх гээд байна. Ингээд Улсын Их Хурлыг ийм ацан шалаанд ингээд дандаа

оруулж байгаа ийм байдлууд үүсэж байгаа нь аль алиных нь хэлж байгаа саналыг харгалзан үзэхээс өөр аргагүй.

Манай Сайнбуянгийн Амарсайхан гишүүн хэлээд байна. Стандарт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан байшин барилгын стандартаас авхуулаад энэ замын халтираа гулгаа, энэ зам харгуй түгжрэл ямар байна. Энэ бүхэн чинь эцсийн дүндээ үүнтэй бас холбогдоно. Ийм асуудал ихтэй боловч одоо бас хэлэлцэх эсэхийг нь шийдвэрлээд дэмжээд, тэгээд ажлын хэсэг байгуулаад хууль тус бүрээр нь хэлэлцээд зарим хуулиудыг тэр Газрын тухай хууль, ашигт малтмалтай холбоотой хууль, тэр стандартчилал, техникийн зохицуулалттай хууль дээрээ анзаарах юмнууд байвал засаж янзална гэж үзээд нэлээн том ажлын хэсэг гаргаж янзлаад, тэгээд энэ 12 сардаа нэлээн шахуу ажиллаж батлах зорилт тавибал ямар вэ.

Тэгэхгүй бол С.Амарсайхан сайд аа, энэ хууль чинь дэмжигдэхгүй буцах гээд байна. Буцах юм бол ахиад орж ирнэ. Тэгээд энэ танхим энэ тэртэй ахиад хууль тус бүрээр нь ярилцъя.

Тэр согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих хуульд орж өөрчилж байгаа чинь техникийн зохицуулалт, шаардлагууд нэмэгдчихээд байна гээд Ц.Мөнх-Оргил гишүүн хэлээд байна бас.

Ингээд санал хураалт явуулъя. Дэмжээд ажиллах л шаардлага. Гишүүд үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авто тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аудитын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Биений тамир, спортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын хэвлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Галын аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,

Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кадастрын зураглал, газрын кадастрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Музейн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсролын сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архиан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ургамал хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үйлдвэр, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот суурины

ус хангамж ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувийн хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувиргасан амьд организмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цахим гарын үсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон Генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Гишүүд, олон нийт бас нэг зүйлийг онцлон анхаарахыг хүсье. Нэг их олон хууль өөрчлөөд ингээд багцалж байгаа юм шиг харагдаж магадгүй.

Тэгэхдээ бид Зөвшөөрлийн тухай хууль дээр илүү либерал чөлөөт зөвшөөрөл аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх орчин бүрдүүлэх зорилгоор зөвхөн Зөвшөөрлийн хуулиар л зөвшөөрөл олгоно.

Төрийн нийтийн өмчөөс бусад бүх харилцааг заавал зөвшөөрлийн хуулиар зохицуулна гээд тэгчихсэн учраас өмнө нь хууль болгон дээр нөгөө зөвшөөрлийн харилцаа зөвшөөрөл авна, зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл авна гээд байсан юмнуудыг бас янзлах, стандартчилах ийм нөхцөлүүд үүссэн учраас энэ олон хуульд зэрэг өөрчлөлт орж байгаа юм шүү.

01 сарын 01-нээс Зөвшөөрлийн тухай хууль үйлчилж, аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, энгийн зөвшөөрлийг илүү хялбаршуулах зорилготой хууль маань хууль зүйн техникийн хувьд ингээд гарчихсан нь бас том өөрчлөлт, реформ хийгдэж байгаа л хэрэг юм байгаа юм. Тэгэхдээ реформ, өөрчлөлт хялбар байдаггүй.

Тийм учраас энэ бүхнийг ойлгохыг хүсье. Ингээд санал хураалт явуулна. Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал

Гурав. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй танилцах асуудал

Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй танилцах асуудлыг хэлэлцэнэ.

Нэр дэвшигчийн талаарх танилцуулгыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Дорждамбын Зүмбэрэлхам танилцуулна.

хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Эдийн засгийн либералчлалын л том реформын процесс. Дотор нь зөндөө алдаа оноо юм байхыг бас үгүйсгэхгүй байна.

61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гишүүдийн олонх нь төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

Эдийн засгийн байнгын хороо яам, Худалдаа, аж үйлдвэрийн танхим, яг хүнсний холбоо, хүнсний чиглэл, Газрын хуулийг. Газрын хуулийг газрын багц хуультайгаа тустай хэлэлцэх нь зүйтэй. Хууль тус бүрээр нь бараг ажлын хэсэг байгуулж хянан үзэх шаардлагатай юм байна.

Ингээд Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийн асуудалд орно.

Ажлын хэсэг, нэр дэвшигчдийг оруулж ирье. Манай Хууль зүйн байнгын хорооны дарга Лхагвын Мөнхбаатар гишүүн бас нээлттэй сонголт зохион байгуулж, нэр дэвшигчидтэй танилцах асуудлыг олон нийтийн оролцоотой их сайн зохион байгуулсан байгаа.

Л.Мөнхбаатар дарга маань анхныхаа нээлттэй сонсголыг зохион байгуулсан. Одоо цаашдаа энэ нүүрс, банк санхүү, энэ олон тулгамдсан асуудлуудаар нээлттэй сонсголуудыг сайн зохион байгуулж хэвших хэрэгтэй. Олон түмэндээ мэдээлж хэвших хэрэгтэй.

Шүүгч нар маань яасан бэ? Нэр дэвшигчдийн талаарх танилцуулгыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Дорждамбын Зүмбэрэллхам танилцуулна. Индэрт урьж байна.

Д.Зүмбэрэллхам: Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд Та бүхний энэ өглөөний амгаланг эрье.

Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчийг Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч томилно гэж, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт Ерөнхий зөвлөл, Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулснаар томилуулах саналыг Ерөнхийлөгчид хүргүүлнэ гэж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 104 дүгээр зүйлийн 104.2 дахь хэсэгт нэр дэвшигчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Хууль зүйн байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд танилцуулна гэж тус тус заасан.

Үүний дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай

хуулийн 104 дүгээр зүйлийн 104.2 дахь хэсэгт заасныг баримтлан Улсын дээд шүүхийн шүүгчийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн сул орон тооны сонгон шалгаруулалтад нэгдүгээрт эрэмбэлэгдсэн нэр дэвшигч Мөнхөөгийн Пүрэвсүрэн, дараа нь эрэмбэлэгдсэн Бадамдоогийн Ганболд Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын шүүгчийн сул орон тооны сонгон шалгаруулалтад нэгдүгээрт эрэмбэлэгдсэн Нэргүйн Батчимэг нарыг Монгол Улсын Их Хуралд танилцуулж байна.

Ингээд нэр дэвшигчийг дарааллын дагуу танилцуулъя.

Монгол Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Мөнхөөгийн Пүрэвсүрэнгийн танилцуулгыг хийе.

Мөнхөөгийн Пүрэвсүрэн нь 1982 онд Өвөрхангай аймагт төрсөн. 40 настай. Эрэгтэй. Ам бүл 4. 1989-1998 онд Хэнтий аймгийн Хэрлэн сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, 1998-2003 онд “Их Засаг” сургуульд эрх зүйч бакалавраар төгссөн. 2011-2014 онд “Их Засаг” их сургууль, Хууль зүйн сургуульд магистрын зэрэг хамгаалсан. Эрх зүйч мэргэжилтэй.

2003-2004 онд “Улаанбаатар даатгал” компанид хуулийн зөвлөх, 2004 онд Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүхэд шүүгчийн туслах, Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, 2004-2007 онд Улсын дээд шүүхэд шүүгчийн туслах шинжээч, 2007-2012 онд Өвөрхангай аймаг дахь Сум дундын нэгдүгээр шүүхийн шүүгч, 2012 онд Говьсүмбэр аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, 2012-2013 онд Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, 2013-2015 онд

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн шүүгч, 2015 оноос хойш Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчээр ажиллаж байна.

Нэр дэвшигч М.Пүрэвсүрэн төрийн албанд 18 жил ажилласан. Шүүгчээр 14 жил 10 сар ажилласан. Үүнээс давж заалдах шатны шүүгчээр 10 жил ажиллаж байгаа нэр дэвшигч байна.

Нэр дэвшигчийн хуульд заасан шалгуур хангасан байдлын талаар танилцуулъя.

Нэр дэвшигч М.Пүрэвсүрэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан хяналтын шатны шүүхийн шүүгчид тавих болзол, шаардлагыг дараах байдлаар хангаж байна.

Нэгдүгээрт, хууль зүйн дээд боловсролтой байх гэсэн шалгуур байгаа. Энэ дээр хууль зүйн дээд боловсрол эзэмшсэн, магистрын зэрэг хамгаалсан талаар түрүүн танилцуулсан.

Хоёрт нь, 35 нас хүрсэн байх ёстой. 40 настай нэр дэвшигч маань.

Гуравт нь, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй гэдгийг Цагдаагийн ерөнхий газрын лавлагаагаар баталгаажиж байгаа.

Дөрөвт нь, шүүгчид нэр дэвших үед яллагч, яллагдагчаар татагдаж байгаагүй гэдгийг прокурорын лавлагаагаар магадалсан.

Тавд нь, шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүй болохыг тогтоосон эрх бүхий эмнэлгийн мэргэшсэн эмчийн магадлагаатай байх гэдэг талаар энэ мэргэшсэн байгууллагын дүгнэлтээр баталгаажуулсан.

Зургаад нь, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх гэдгийг Монголын Хуульчдын холбооны магадлагаагаар баталгаажуулсан.

Долоод нь, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх гэж байгаа.

М.Пүрэвсүрэн шүүгчээр нийт 14 жил 10 сар ажилласан байгаа.

Гуравт нь, сонгон шалгаруулалтад тэнцсэн байдлын талаар Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт заасны дагуу шүүгчид нэр дэвшигчээс авсан шалгалтад М.Пүрэвсүрэн нь хууль зүйн мэдлэг чадварын шалгалт, мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалт нийлээд нийтдээ 81.41 оноо авч сонгон шалгаруулалтад тэнцсэн хоёр нэр дэвшигчээс нэгдүгээрт эрэмбэлэгдсэн байгаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн хуралдаанаас шийдсэний дагуу Монгол Улсын Их Хуралд нэр дэвшигчийг танилцуулж байна.

Дараа нь Монгол Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Бадамдоогийн Ганболдын танилцуулга.

Бадамдоогийн Ганболд нь 1978 онд Улаанбаатар хотод төрсөн. 44 настай. Эрэгтэй. Ам бүл 4. 1980-1996

онд 34 дүгээр сургуулийг бүрэн дунд боловсролтой төгссөн.

1996-2000 онд “Их Засаг” хууль зүйн дээд сургуулийг бакалавраар төгссөн. 2000-2001 онд хууль зүйн “Их Засаг” их сургуульд хууль зүйн ухааны магистрын зэрэг хамгаалсан. Эрх зүйч мэргэжилтэй. 2000-2004 онд “Их Засаг” хууль зүйн дээд сургуульд багш, 2006-2008 онд “Халх журам” хууль зүйн дээд сургуульд багш, 2008-2014 онд “Түшээ” дээд сургуульд багш, 2006 оноос Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгчөөр ажиллаж байна.

Нэр дэвшигч Б.Ганболд нь өмгөөлөгчөөр нийтдээ 16 жил ажилласан туршлагатай хүн байна.

Шалгуур хангасан байдлын талаар хууль зүйн дээд боловсролтой, магистрын зэрэгтэй гэдгийг түрүүнд танилцуулсан.

35 нас хүрсэн байх ёстой. Одоо 44 настай. Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй. Шүүгчид нэр дэвших үед яллагдагчаар татагдаж байгаагүй. Шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүй болохыг холбогдох байгууллагын магадлагаагаар баталгаажуулсан.

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй гэдгийг Монголын Хуульчдын холбоо баталгаажуулсан. Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх гэж байгаа. Нийтдээ өмгөөлөгчөөр 16 жил ажилласан туршлагатай хүн байна.

Энэ Б.Ганболд нэр дэвшигч бол Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт заасны дагуу шүүгчид нэр дэвшигчдээс

авсан шалгалтад нийтдээ 72.6 оноо авч, сонгон шалгаруулалтад тэнцсэн хоёр нэр дэвшигчийн хоёрдугаарт эрэмбэлэгдсэн байгаа.

Ингээд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шийдвэрийн дагуу нэр дэвшигч Бадамдоогийн Ганболдыг танилцууллаа.

Дараачийн нэр дэвшигч Монгол Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Нэргүйн Батчимэг байна.

Нэргүйн Батчимэг нь 1975 онд Дорноговь аймагт төрсөн. 47 настай. Эмэгтэй. Ам бүл 4. 1983-1993 онд Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян багийн 10 жилийн сургуульд суралцаж, бүрэн дунд боловсролтой төгссөн.

1993-1997 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч бакалавраар төгссөн. 2011-2018 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуульд Хууль зүйн ухааны магистрын зэрэг хамгаалсан. Эрх зүйч мэргэжилтэй.

1998-2001 онд Дорноговь аймаг дахь сум дундын хоёрдугаар шүүхэд туслах шүүгч, 2001-2010 онд Дорноговь аймаг дахь сум дундын нэгдүгээр шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгч, 2010-2013 онд онд Дорноговь аймгийн шүүхийн шүүгч, 2013-2015 онд Иргэний хэргийн давж заалдах шатны хоёрдугаар шүүхийн шүүгч, 2015-2016 онд Говьсүмбэр, Дорноговь аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, 2016 онд Дорноговь аймгийн Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчээр тус тус ажилласан.

Нэр дэвшигч Батчимэг нь төрийн албанд 24 жил 4 сар нийтдээ ажилласнаас шүүгчээр 21 жил 4 сар ажиллаж байгаа хүн байна.

Давж заалдах шатны шүүгчээр 12 жил ажилласан. Хуульд заасан шалгуур хангасан байдлын талаар хууль зүйн дээд боловсролтой. Магистрын зэрэгтэй гэдгийг түрүүнд танилцуулсан.

35 нас хүрсэн байх ёстой. Одоо 47 настай. Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй. Шүүгчид нэр дэвших үед яллагдагчаар татагдаж байгаагүй. Шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүй болохыг холбогдох байгууллагууд баталгаажуулсан.

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх ёстой. Энэ талаар Монголын Хуульчдын холбоо магадлагаа гаргасан. Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх ёстой. Нийтдээ Батчимэг шүүгчээр 24 жил 4 сар ажилласан туршлагатай хүн байна.

Сонгон шалгаруулалтад тэнцсэн байдлын талаар нийт оноо 80 оноо авч, сонгон шалгаруулалтад тэнцсэн нэр дэвшигчдээс нэгдүгээрт эрэмбэлэгдсэн ийм нэр дэвшигч байна.

Ингээд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шийдвэрийн дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Их Хуралд эдгээр нэр дэвшигчийг танилцуулж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Одоо Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Лхагвын Мөнхбаатар танилцуулна.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 01/14/50 тоот албан бичгээр Улсын дээд шүүхийн шүүгчид Нэргүйн Батчимэгийг мөн өдрийн 01/14/59 тоот албан бичгээр Улсын дээд шүүхийн шүүгчид Бадамаагийн Ганболдыг, мөн өдрийн 01/14/60 тоот албан бичгээр Улсын дээд шүүхийн шүүгчид Мөнхөөгийн Пүрэвсүрэнг нэр дэвшүүлэн Монгол Улсын шүүхийн тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу Улсын Их Хуралд танилцуулахаар ирүүлсэн.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт Улсын Их Хурал, Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчдээ Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 104 дүгээр зүйлд заасан журмын дагуу танилцана гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 104 дүгээр зүйлд заасан журмын дагуу Хууль зүйн байнгын хорооны 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 18 дугаар тогтоолоор Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоож, сонсголыг 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгууллаа.

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт Байнгын, дэд хорооны гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь оролцоноор тухайн сонсголыг хүчинтэйд тооцно гэж заасан

бөгөөд нэр дэвшигчийн сонголд Хууль зүйн байнгын хорооны дарга Л.Мөнхбаатар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяшаа, Э.Бат-Амгалан, Х.Нямбаатар, Ц.Сандаг-Очир, Ж.Сүхбаатар, Б.Пүрэвдорж, Б.Энхбаяр, Б.Энх-Амгалан нар оролцож хуульд заасан шаардлагыг хангасан болно.

Нэр дэвшигчийн сонголын зарыг 20 хоногийн турш олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй хүргэсэн бөгөөд сонголд П.Бадамрагчаа, Б.Батдэлгэр, Э.Баярхүү, П.Мягмарсүрэн, Б.Төрболд нар оролцогчоор оролцсон бол Б.Үүрийнтуяа ажиглагчаар хуралдсан болно.

Сонголыг парламентын цахим хуудсаар шууд дамжуулан олон нийтэд хүргэсэн бөгөөд цахимаар 92 хүн үзэж, байр сууриа илэрхийлсэн бөгөөд сонголд 4 цагийн турш үргэлжилсэн.

Хууль зүйн байнгын хорооны 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанд Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Д.Зүмбэрэлхамд танилцуулсан бол нэр дэвшигчтэй хийсэн сонголын тайланг Хууль зүйн байнгын хорооны дарга Л.Мөнхбаатар танилцуулсан болно.

Дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг нэр дэвшигчдээс урьд өмнө нөлөөллийн мэдүүлэг бөгж байсан эсэх болон шүүгчийн хараат бус байдлыг хэрхэн хангаж ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр шүүхийн шинэчлэлийн хүрээнд Улсын Дээд шүүх тодорхой тохиолдолд хэрэг маргааныг хяналтын журмаар хянан шийдвэрлэх болсонтой холбоотой зарим хэрэг давж заалдах шатны шүүхэд

эцэслэн шийдвэрлэх нөхцөл бүрдсэн хуулийн зохицуулалтын талаар нэр дэвшигчдээс асуулт асууж, хариулт авч, мөн Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Монгол Улсын шүүхийн тухай хуульд зааснаар шүүх хэрэг, маргааныг хэрхэн шийдвэрлэсэн тухай хуулиар хамгаалагдсан нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарахаас бусад мэдээллийг нийтэд мэдээлэх, иргэдийг мэдээллээр хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг тайлбарлах зорилгоор шүүхийн шийдвэрийг олон нийтэд ойлгомжтой байдлаар мэдээлэх заалт хэрэгжихгүй байгаа талаар онцолж, хуулийн зохицуулалтыг нэг мөр хэрэгжүүлж анхаарч ажиллах талаар үг хэлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Нэргүйн Батчимэг, Бадамдоогийн Ганболд, Мөнхөөгийн Пүрэвсүрэн нарыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 104 дүгээр зүйлд заасан журмын дагуу Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулсан болно.

Г.Занданшатар: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Дорждамбын Зүмбэрэлхам, Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Нэргүйн Батчимэг 24 жил шүүгчээр ажилласан. МУИС төгссөн хүн байна. Улсын дээд шүүхийн шүүгч нэр дэвшигч Бадамдоогийн Ганболд 18 жил шүүх салбарт ажилласан “Их Засаг” дээд сургууль төгссөн хүн байна.

Б.Ганболд нь өмгөөлөгч, шүүгчээр ажиллаж байгаагүй. “Их Засаг” дээд сургууль төгссөн хүн байна. Мөнхөөгийн Пүрэвсүрэн Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч. “Их Засаг” дээд сургууль төгссөн. 18 жил шүүхийн салбарт ажиллаж байгаа юм байна.

Ажлын хэсгийг танилцууллаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга болон нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Баттөмөрийн Энхбаяр. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүнээр тасаллаа. Даваажанцангийн Сарангэрэл гишүүнийг нэмж оруулаад тасаллаа.

Одонгийн Цогтэрэл гишүүн асуулт асууна.

О.Цогтгэрэл: Дээд шүүхийн ерөнхий шүүгчид нэр дэвшигчдийн танилцуулгыг харж байна. Энд заавал тодруулах ёстой зүйлс байгаад байна.

Ер нь Дээд шүүхийн ерөнхий шүүгч гэдэг чинь ер нь энэ өөрөө тийм практик хэрэг маргаан гэхээсээ илүүтэйгээр энд хуулийн зөв хэрэглээ, хууль хоорондын зөрчил гээд онолын жигд чигтэй тийм онолын суурь, тийм өндөр хэмжээний бэлтгэгдсэн байдал, өөрөө Дээд шүүхийн ерөнхий шүүгчдэд тавигдах ёстой томоохон шаардлагыг нь нэг гэж, жишээ нь би хувьдаа бодож байна л даа.

Тэгэхээр энэ Дээд шүүхийн ерөнхий шүүгч гэдэг чинь энэ өөр тийм практик хэрэг маргаан гэхээсээ илүүтэйгээр энд хуулийн зөв хэрэглээ, хуулийн хоорондын зөрчил гээд онолын чигтэй, тийм онолын суурь одоо тийм

өндөр хэмжээний бэлтгэгдсэн байдал өөрөө Дээд шүүхийн ерөнхий шүүгчид тавигдах ёстой томоохон шаардлагын нэг гэж одоо жишээ нь би бол хувьдаа бодож байна л даа.

Энэ онолын чиг баримжаа гэдэг чинь судалгаа хийсэн судлаач байх, бас олон улсын хэвлэл болоод бусад зүйлүүдэд материал хэвлүүлсэн байх гээд тэр онолын чиг баримжааг чинь хэмждэг өөрийнх нь хэмжүүр үзүүлэлтүүдтэй.

Тэгэхээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргаас асуух гээд байна л даа. Яг одоо Дээд шүүхийн ерөнхий шүүгчид тавих шаардлага дотор эдгээр шаардлагуудаас байна уу? Энэ онолын чиг баримжаа болоод онолын талаар бэлтгэгдсэн байдлыг энэ шалгуур үзүүлэлтэд яаж байдаг юм? Тэгээд эдгээр шүүгчид болоод ер нь Дээд шүүхийн ерөнхий шүүгч нарт энэ талаараа хэр зэрэг бэлтгэгдсэн гэж та үздэг вэ? Одоо яг ингээд энэ материал энэ тодруулга, энэ танилцуулгын хүрээнд харахад үнэхээр тэр талын зүйл харагдахгүй байгаад байна л даа. Тэгээд тодруулж асууж байна.

Гурван нэр дэвшигчээс бас үүнийг товчхон хариулаач ээ гэж. Та нар яг саяын хэлдэг практик хэрэг маргаан гэхээсээ урьдаар онолын талд илүү бэлтгэгдсэн байх ёстой. Та нар энэ онолын чиглэлээр өөрсдийгөө яг хэр зэрэг бэлтгэгдсэн гэж үздэг вэ? Судалгааны ажил болоод олон зүйлүүд дээр хийсэн бүтээсэн зүйлүүдээсээ танилцуулаач ээ?

Тэгээд энэ дээр зайлшгүй энэ нэг ийм томоохон гүнзгий мэргэжлийн шинжтэй байгууллагын хувьд та нар салбартаа хүлээн зөвшөөрөгдөх,

салбартаа энэ чиглэлээрээ хүлээн зөвшөөрөгдөх гэдэг чинь өөрөө ингээд цааш цаашдаа асар их том зүйлээ.

Тэгэхээр саяын тэр шаардлага болоод энэ онолын чиг баримжаа гэдэг зүйлүүд дээр нэлээн тийм дэлгэрүүлж хэлж өгөөч ээ.

Г.Занданшатар:

Д.Зүмбэрэлхам дарга хариулья.

Д.Зүмбэрэлхам: О.Цогтгэрэл гишүүний асуултад хариулья.

Ер нь үндсэн 7 шалгуур байгаа учраас 7 шалгуурын талаар би түрүүнд танилцуулга хийсэн.

Ер нь Монгол Улсын шүүхийн тухай хууль дээр дараах шаардлагын аль нэгийг хангасан байна гээд шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан, прокурор, эсвэл өмгөөлөгчөөр дагнан 10-аас доошгүй жил ажилласан, магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн их дээд сургуульд 10-аас доошгүй жил багшилсан гэсэн ийм үндсэн шалгуурууд байгаад байгаа юм.

Ер нь онолын өндөр мэдлэгтэй байх ёстой. Үүнийгээ практиктай сайн холбож чаддаг, ур чадвартай байх ёстой гэдэгтэй санал нэг байгаа. Энэ талаар үндсэндээ нэр дэвшигчдийн сонгон шалгаруулах шалгалтад энэ талаар одоо энэ ур чадварыг нь шалгах, онолын мэдлэгийг нь шалгах энэ шалгууруудыг оноо өгч дүгнэх ийм юугаар үндсэн сонгон шалгаруулалтын явцад энэ агуулга орсон. Үүгээрээ оноожоод ингээд гараад ирсэн нэр дэвшигчид байгаа гэдгийг нэгд хэлье.

Хоёрт, энэ нэр дэвшигчид гурвуулаа эрх зүйн магистрын зэрэгтэй. Шат шатандаа олон жил чиглэл чиглэлээрээ ажилласан. Ялангуяа энэ Б.Ганболд нэр дэвшигчийн хувьд 13, 14 жил их дээд сургуулиудад багшилсан юм билээ. Нэлээд хэдэн бүтээлтэй хүн байна лээ.

Бусад хоёр нэр дэвшигчийн хувьд ч гэсэн бас судалгааны өгүүлэл энэ тэр эрдэм шинжилгээний хэвлэл сэтгүүлүүдэд нийтлүүлсэн ийм байдал шалгалтын явцад харагдаж байсан. Тэгээд өөрсдөө бас энэ талаараа тодруулж танилцуулах байх. Баярлалаа.

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун гишүүн. Байж байгаарай. Нэр дэвшигчид хариулья. М.Пүрэвсүрэн.

М.Пүрэвсүрэн: Та бүхний энэ өдрийн мэндийг хүргэе. О.Цогтгэрэл гишүүний асуултад хариулья.

Онолын мэдлэг бол шүүн таслах ажиллагаанд хамгийн чухал асуудал. Тэгээд энэ онолын мэдлэгийг ажлын туршлагаар баяжуулж, үүнийг мэргэшил болгож, ур чадвар болгож ингэж хэрэглэх нь шүүгчдийн өмнө тавигддаг мэргэжлийн шаардлага юм.

Миний хувьд эрүүгийн эрх зүйн сургагч багшаар бэлтгэгдсэн. Мөн санхүүгийн гэмт хэрэг болон мөнгө угаах терроризмтой тэмцэх энэ чиглэлээр тогтмол сургалтад хамрагдаж бэлтгэгдсэн байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Бадамдоогийн Ганболд.

Б.Ганболд: Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлэе.

О.Цогтгэрэл гишүүн асуулт асууж байна. Баярлалаа. О.Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын дээд шүүх онолын чиглэлтэй байх гэдэг тал дээр тантай санал нэг байна. Миний хувьд багш, судлаачаар олон жил ажилласан. Онолын хувьд өөрийгөө зохих түвшинд бэлтгэгдсэн гэж үзэж байгаа.

Тийм ч учраас одоогийн байдлаар 22 номын зохиогч. Ялангуяа эрүүгийн эрх зүй, эрүүгийн процесс, криминологи болон гэмт хэрэг зүйлчлэлийн онол гэсэн судалгааны бүтээлүүдийг бичиж туурвисан байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Одоо Хаянгаагийн Болорчулуун гишүүн асууна. Учлаарай. Байж байгаарай. Н.Батчимэг. Нэргүйн Батчимэг.

Н.Батчимэг: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Миний хувьд шүүгч хүн бол онолын мэдлэггүйгээр холбогдох хэрэг маргаанд хуулийг хэрэглэх боломжгүй. Энэ утгаараа шүүгч нар онолын мэдлэгээ байнга дээшлүүлж, хэрэг маргаан шийдвэрлэх болгондоо тухайн холбогдох онол, үзэл баримтлал, зарчмыг судалж мэдлэгээ хөгжүүлж байдаг.

Миний хувьд 2013-2017 онд шүүгчдийг худалдааны эрх зүйн чиглэлээр сургах төсөлд хамрагдаж сургагч багшаар бэлтгэгдэн ажиллаж, мөн шүүгч нарт зориулсан сургалтын гарын авлага боловсруулж сургалтад хэрэглэсэн байгаа.

Мөн Монгол Улсын Их Сургуулиас гаргадаг Эрх зүй сэтгүүлд

судалгааны өгүүллүүд бичиж хэвлүүлж байсан ийм байгаа.

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун гишүүн.

Х.Болорчулуун: Манай Монгол Улсын шүүх үнэхээр ард түмний итгэлийг алдаж алдаж ирсэн, ажиллаж байсан гэдгийг Та бүхэн мэдэж байгаа.

Үнэхээр том хэргэм цолтой шүүгч нараасаа авхуулаад Дээд шүүхийн шүүгч нар нь авлигал, аливаа болох бүтэхгүй юманд холбогдоод л. Энэ бол эртний түүх биш шүү дээ. Саяхных.

Тэгэхээр Дээд шүүхийн шүүгч нарыг үнэхээр сайн асууж шалгааж тавих нь Их Хурлын бүрэн эрх. Яах вэ, та бүхэн ярьж байна. Онолын мэдлэг, төгссөн сургууль, магистр гээд л сайхан сайхан сургууль төгссөн л байна. Гэхдээ ерөнхийдөө хүний шударга зан байдал гэдэг өвлөгдөж ирсэн, удамшиж ирдэг л дээ. Ямар ч сургууль төгсөөд тэр шударга зан байдлыг өөрчлөх тийм нөхцөлгүй байдаг гэж үздэг.

Тэгэхээр би юу хэлэх гээд байна вэ гэхээр зөв хүмүүс л төрөлхийн удмын шударга, зөв хүмүүс Дээд шүүхэд ажиллаасай, ороосой л гэж хүсэж байна. Тэгж байж олон түмний итгэлийг авна. Хүний ажил амьдралтай холбоотой эцсийн алхыг, сүүлийн алхыг Дээд шүүх цохидог.

Тийм учраас маш хариуцлагатай ийм хүмүүс сонгож байх ёстой. Би орон нутагт ажилласан энэ гурван шүүгчээс тэр Дорноговьд ажиллаж байсан, насаараа ажилласан, хөдөө орон нутагт. Энэ шүүгчтэй ярих юм байхгүй. Бас хүнийг өмгөөллийн төлөө өмгөөлж

насаараа ажилласан энэ шүүгчид нэр дэвшиж байгаа хүнтэй яриад байх юм байхгүй.

Харин тэр нийслэлийн шүүхэд 14 жил шүүхээр ажиллаад 10 жил нь давж заалдах шатны нийслэлийн шүүхэд ажилласан юм байна. Энэ Мөнхөөгийн Пүрэвсүрэн гэж хүн.

Би энэ хүнийг болох болохгүй юманд бага л холбогдсон байгаасай л гэж залбирч байна даа. Нийслэлийн шүүх дээр бүх л асуудал дамжиж явагддаг. Өнгөтэй мөнгөтэй мөнгөний эрхшээлд шүүх нугарч байсан гашуун түүх бишгүй байгаа. Нэг л компанийн хэргийг хэлэхэд 10 жил шүүгээд зарим эзний холбогдогч нь нас бараад энэ жил шийдэгдэж байх жишээтэй. Энэ байдал танай нийслэлийн шүүхээр л ороод гарсан. Иймэрхүү асуудалд холбогдож байгаагүй гэсэн баталгаа ер нь байна уу?

Би тэр Мөнхөөгийн Пүрэвсүрэн дээр л асуултын тэмдэг тавихаар байна. Үнэхээр шударга цаашаа ажиллана гэсэн баталгаа байна уу л гэж асуумаар байна.

Г.Занданшатар: 82.
Мөнхөөгийн Пүрэвсүрэн.

М.Пүрэвсүрэн: Х.Болорчулуун гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр хар бараан янз бүрийн асуудалд холбогдож байсан уу гэж байна. Тэгэхээр би шүүгчээр томилогдож ажилласнаас хойш шүүгчийн ёс зүйн ямар нэгэн асуудалд холбогдож байгаагүй. Өнөөдрийн байдлаар ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой ямар нэгэн шийтгэл хүлээж байгаагүй. Баярлалаа.

Г.Занданшатар: Энэ асуулт, үг нэг. Танилцах асуудал учраас нэмэлт байхгүй. Асуулт, үг нэг явах юм билээ. Ингээд Цэндийн Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Д.Зүмбэрэллхам дарга минь ний нуугүй л хэлье дээ. Олон жил бие биенийгээ мэдэх юм. Сэтгэл дундуур байна.

Хууль батлагдсанаас хойш одоо бараг анхны Дээд шүүхийн шүүгч нарыг Шүүхийн ерөнхий зөвлөл оруулж ирж байх шиг байна. Тэгээд таны ажлын үр дүн шүү дээ. Одоо ингээд энэ гурван нэр дэвшигч орж ирж байгаа нь.

Тэгээд гурван нэр дэвшигч гурвууланд нь би жоохон сэтгэл дундуур байна. Намтар түүхийг нь харахад. Туршлагатай л хоёр шүүгч байна л даа. Тэгэхдээ яг Дээд шүүхийн шүүгч хийхээр хэмжээний саяын О.Цогтгэрэл гишүүний асуугаад байгаа шиг одоо манай хяналтын шатны шүүгч нь онолын шүүх болчихсон шүү дээ.

Тэр хэмжээний практик нь байлаа гэж бодоход яг онолын мэдлэг туршлага нь байна уу?

Тэгээд бид өөрсдөө хуулиа буруу хийсэнтэй л бас холбоотой байна л даа. Их Хурал өөр дээрээ бас буруугаа авах ёстой юм байна. Жишээ нь, Б.Ганболд нэр дэвшигч дээр нэг ч өдөр шүүгчээр ажиллаагүй хүнийг л бид Дээд шүүхийн шүүгчээр нэр дэвшээд ороод ирэх бололцоог нь бүрдүүлчихсэн л байгаа байхгүй юу. Тэгээд прокуророор, эсвэл өмгөөлөгчөөр дагнаж 10 жил ажилласан, 10-аас доошгүй жил ажилласан байх ёстой гээд. Тэгээд Б.Ганболд нэр дэвшигч бол жишээ нь Д.Зүмбэрэллхам дарга аа, Б.Ганболд нэр

дэвшигч бол. Би хүнийг нь, гурвуулыг нь хэний ч мэдэхгүй. Зүгээр намтарыг нь уншаад л харахад.

Яг өмгөөлөгчөөр 10 жил дагнаж ажиллаагүй л байна шүү дээ. Гол ажил нь багшилж л байсан байна. 2014 оноос хойш юу хийсэн нь тодорхойгүй юм байна. Энэ чинь бараг 10 жил, 8 жил энэ хүн хаана юу хийж явсан юм. 2006-2008 онд “Халх журам” дээд сургуульд багшилсан байна. 2009-2014 онд “Түшээ” дээд сургуульд багшилсан байна. Энэ хоёр сургууль чинь хоёулаа байхгүй болчихоо биз дээ.

Тэгээд бид та санаж байна уу, үгүй юу. Тэр хурлын протокол эд нарыг олж үзэх юм уу. Эсвэл хуульдаа бид өөрчлөлт оруулаад засах юм уу. Энэ чинь багшилна гэдэг чинь зүгээр багш гэж бид анх хуулийн төсөл дээрээ хууль батлахдаа яриагүй шүү дээ. Бид их дээд сургуулийн эрх зүйн профессор гэж бүр ярьсан шүү дээ. Профессор. Багш, профессор хоёрын хооронд чинь зарчмын зөрүү байна шүү дээ.

Тэгээд тэр эд нарыг харах ёстой байсан юм биш үү. Энэ арай л. Ялангуяа Б.Ганболд нэр дэвшигчийн хувьд Дээд шүүхийн шүүгч болоод очиход Б.Ганболд минь, одоо чи минь өөрийгөө бэлэн гэж бодож байна уу? Өмгөөлөгчөөр ажиллах, шүүгчээр ажиллах, тэгээд зүгээр шүүгчээр ажиллах, Дээд шүүхийн шүүгчээр ажиллах чинь шал зарчмын өөр юмнууд байгаа шүү дээ.

Тэгээд ийм хариуцлагатай юм дээр чи минь очоод өөрийгөө бэлэн байна гэж бодож байна уу?

Д.Зүмбэрэллхам аа, чи одоо энэ хүмүүс ингээд одоо яг Дээд шүүхийн

шүүгч хийхэд бэлэн гэж итгэл үнэмшил байна уу? Чамд. Жишээ нь, Б.Ганболдын хувьд асууя л даа.

Чи өөрөө итгэл үнэмшил болж байж оруулж ирж байх ёстой шүү дээ. Тэгээд энэ дээр чинь мэдлэг чадвар, ёс зүй гэж бид хуульд хэлж өгсөн шүү дээ. Мэдлэг нь байж болно. Б.Ганболдын хувьд жишээ нь. Чадвар нь байна уу? Дээд шүүхийн шүүгч хийх чадвар нь байна уу?

Нөгөө хоёр нь шүүгч хийж байсан юм байна гэж бодоод чадвар нь байж. Гурвууланд нь ёс зүй байгаа гэж би итгэж байна. Үүнийг л та нар чинь задалж хууль хэрэглэж байх ёстой шүү дээ. Д.Зүмбэрэллхам аа. Шалгаж байх ёстой. Чадвар нь байна уу? Жишээ нь, энэ хүн одоо яг хэрэг уншиж үзсэн юм уу? Хэрэг уншаад яг гаргалгаа гаргаж байгаа тэр чадварыг нь судалж үзсэн юм уу, Та нар. Эсвэл зүгээр одоо нэг олон сонголттой асуултаар шалгалт авчхаад л, тэгээд л төдөн оноо авчихлаа, хоёроор ороод ирлээ. Энэ хүнийг сонгочихъё гээд оруулаад ирчихэв үү.

Г.Занданшатар: Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Д.Зүмбэрэллхам. 83.

Д.Зүмбэрэллхам: Ц.Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя.

Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүхийн сонгон шалгаруулалт хоёр дахь удаагаа явагдаад хоёр дахь удаагаа энэ танилцуулж орж ирж байгаа. Эхнийх дээр нь хоёр нэр дэвшигчийг танилцуулсан, томилсон. Одоо бол гурван нэр дэвшигч ингээд танилцуулагдаж байна. Энэ гурван нэр дэвшигчээр үндсэндээ Улсын дээд шүүхэд байгаа сул орон тоо үндсэндээ

нөхөгдөх юм. Нэг дэх, хоёр дахь гэдэг дээр ийм хариулт байна.

Хоёрдугаарт, энэ Улсын дээд шүүх бол манай улсын хамгийн дээд шатны шүүх, онолын шүүх гэдэг талаас нь бид Улсын дээд шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтад тусгай даалгавар бэлтгэдэг. Энэ тусгай даалгаварт онолын болон практикийн шийдвэр боловсруулах, бодлого бодох, гаргалгаа гаргах бүх энэ юунуудыг маш нууцлалтайгаар даалгавар болгож оруулаад, тэгээд үүнийг хэрхэн шийдвэрлэсэн, ур чадвар нь ямар байгаа юм, шүүхийн шийдвэрийг яг бодит байдлаар боловсруулсан байдал нь ямар байна вэ гэх мэтийн олон талын шалгуураар нь оноо тавьж ингэж гаргаж ирдэг. Тэгээд энэ талын юуг энэ дээр ийм байх ёстой гэдэгтэй би 100 хувь санал нэг байна.

Тэгээд ингээд энэ оноож байгаад гарч ирээд эрэмбэлэгдээд, ингээд эхний байранд гараад ирчихсэн хүмүүсээ нэр дэвшүүлж явуулж байгаа. Нэр дэвшүүлж, танилцуулж томилуулах асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөл шийдвэрлэж байгаа. Урьд нь бол ингэж эрэмбэлдэггүй. Хаанаас нь ч хамаагүй нэр дэвшүүлээд ингээд томилдог байсан энэ практик энэ Шүүхийн тухай хуулиар ингэж эрэмбээр нь нэр дэвшүүлнэ гэдэг асуудлыг шийдвэрлэсэн нь маш зүйтэй болсон гэж бодож байгаа. Энэ бол биднээс ч шалтгаалахгүйгээр эрэмбээр хэн нь гарч ирнэ вэ, тэр хүн нь нэр дэвшигдээд ингээд явж байгаа.

Тийм учраас Ц.Мөнх-Оргил гишүүний саяын асуудаг энэ агуулга бол бид нарын шалгалтад орж байгаа гэдгийг би бас тайлбарлаж хэлмээр байна.

Дараачийн дугаарт энэ улсуудын тайлбар танилцуулга юмнуудыг аваад хүмүүсээс одоо ингээд асууж сураглаж явдаг. Ингээд д алдаа дутагдал байна уу гэдгийг сайтар олон хоног тавьж байж энэ хүний талаар ямар мэдээлэл ирэх нь вэ гэдгийг шалгадаг. Тэгээд энэ бүхний эцэст энэ нэр дэвшигч болгоныг нэг бүрчлэн Шүүхийн ерөнхий зөвлөл дээр танилцдаг. Ингээд олон талаас нь үзэж байж нэр дэвшүүлдэг.

Тэгээд өнөөдөр Та бүхэнд танилцуулж байгаа энэ гурван нэр дэвшигчийн хувьд хэрвээ томилогдоод ажиллах юм бол аль алинд нь онолын болон практикийн мэдлэг дутахгүй, мэдлэг, ур чадвар дутахгүй байх гэдэгтэй би итгэл үнэмшилтэй байгаа.

Дараачийн дугаарт нь өмгөөлөгчөөр нэг ч удаа ажиллаж байгаагүй гэдэг нь. Шүүгчээр нэг ч удаа ажиллаж байгаагүй гэдэг нь үнэн. Анх удаа энэ Шүүхийн тухай хуульд өмгөөлөгчөөр дагнан 10 жил ажилласан, прокуророор дагнан 10 жил ажилласан, шүүгчээр дагнан 10 жил ажилласан бол одоо ингээд дараачийн шатны шүүгчид нэр дэвшиж болно гэдэг ийм шалгуур орж ирсний үндсэн дээр энэ бол эхний удаагийн яг энэ хуулийн дагуу эхний удаа дагнан өмгөөлөгчөөр ажилласан ийм нэр дэвшигч орж ирж байгаа.

Бид бас нягталж үзсэн. Энэ өмгөөлөгчөөр ажилласан хугацаануудыг нягталж үзсэн. Их дээд сургуулиудад багшилж байхдаа өмгөөлөгчөөр ажиллаад явсан байна лээ.

Тэгээд ер нь их дээд сургуулиудын багш нар өмгөөлөгчөөр ажиллаад л явдаг юм байна. Тэгээд энэ талыг нь нягталж үзсэн. Яг

өмгөөлөгчөөр ажилласан хугацааны хувьд зөрүү гарахгүй.

Г.Занданшатар: Сайнбуянгийн Амарсайхан гишүүн асуулт асууна, үг хэлнэ.

С.Амарсайхан: Ер нь Шүүхийн тухай хууль батлагдаж байхад энд давах болон дээд шатны шүүхэд шүүгчээр ажиллах хүмүүсийг ямар шалгууртай байх вэ гэдэг дээр нэлээн саналууд хэлж байсан.

Харамсалтай нь одоо бид өөр зарчим барьж хуулиа баталсан. Өөрөөр хэлбэл хуульч бол хэн ч байж болно гэдэг. Одоо нэгэнт өөрсдөө хуулиа баталчихаад тэгээд хууль хэрэгжүүл гэж байгаа хүмүүс баталсан хуулиа өөрсдөө хэрэгжүүлэхээс өөр яах вэ. Одоо тэгээд мянга шүүмжлээд хэрэггүй шүү дээ.

Би ч одоо бас нэлээн хэлж байсан учраас үүнийг хэлж байгаа юм. Болж байгаа юм уу, энэ заалт чинь. Зарчимд нийцэх юм уу. Шүүгчээр ажиллаагүй хүмүүс тэр дундаа давах болон дээд шатны шүүхэд ажиллаад хүний хувь заяатай холбоотой амь амьдралтай холбоотой эмзэг шийдвэрүүдийг гаргана. Туршлага дутах асуудлууд гарна. Үүнийгээ гишүүд сайн бодсон юм байгаа биз дээ гэж анх хууль баталж байхад хуулийн үг, үсэг, заалт дээр хатуу байр суурьтай байсан. Харамсалтай нь тэгээд шийдэгдсэн учраас одоо бид хуулиа барихаас өөр аргагүй ийм нөхцөл байдалд байгаа. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, шүүгчид нэр дэвшиж байгаа ер нь шүүхийнхэн анхаарах хэрэгтэй байгаа юм.

Энэ Монгол Улсын Шүүхийн тухай хуульд зааснаар шүүх хэрэг, маргааныг хэрхэн шийдвэрлэсэн тухай хуулиар хамгаалагдсан нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарахаас бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэх гэж заасан байдаг. Гэтэл өнөөдөр шүүгчид, шүүх байгууллагууд үзэмжээрээ асуудалд ханддаг. Өөрөөр хэлбэл тогтсон дүрэмгүйгээр, нэг бол бүх шүүхийн шийдвэрийг тэр чигт нь нийтэд ил болгодог. Эсвэл ил болгодоггүй.

Тэгэхээр энэ шүүхийн шийдвэрийг ил болгодог асуудлаа эргэж харахгүй бол хохирогч, хариуцагчийн хооронд хэлсэн ярьсан үнэн худал нь мэдэгдэхгүй мэдүүлгүүд бүгд олон нийтэд ил болдог. Хохирогч давхар хохирдог. Өөрөөр хэлэх юм бол хариуцагчийн нотолгоогүй, баталгаагүй мэдүүлэг тэр чигээрээ олон нийтийн өмнө гардаг. Хохирогчийн эсрэг мэдүүлж байгаа, өгч байгаа.

Гэрийн хаягаасаа эхлээд төрсөн он, сар, үр хүүхдүүд, хэрэг болсон газар гэдэг юм уу, бүх нарийн зүйлүүд гардаг. Энэ ийм байж болохгүй. Хувь хүний хуулиар хамгаалагдсан нууц гэж бий. Эмзэг мэдээллүүд гэж байна. Харин хэрхэн шүүх шийдвэрлэсэн юм. Ямар замаар шийдвэрлэсэн юм. Ямар ял оноосон юм гэдэг нь товчхон мэдээллүүд байх ёстой. Түүнээс биш бүх мэдээллийг ил гаргаад тавьчихдаг. Энэ бол нөгөө шударга хүний эрхийг хамгаалдаг нийгэм биш шүү гэдгийг хэлье.

Тийм учраас энэ дээр Шүүхийн ерөнхий зөвлөл онцгой анхаарч, цаашид энэ хохирогч хариуцагчийн мэдээллийг гаргахдаа энэ дээр нэлээн сайн нухацтай үзэх хэрэгтэй.

Гуравдугаарт, тэгээд нэр дэвшигчдэд бас одоо нэгэнт ороод ирсэн. Амжилт хүсье.

Хуулиа барьж, энэ шүүх шинэчлэлийн процессыг эрчимжүүлэхэд хувь хүний болон албаны зүгээс хариуцлагатай, идэвх санаачилгатай, зарчмаа барьж, энэ шүүхийн шинэчлэлийн процессыг дорвитой хийхэд дорвитойхон шиг хувь нэмэр оруулж ажиллаарай гэдгийг хүсье.

Г.Занданшатар: Үг хэллээ. Тэгэхдээ энэ нийгэмд бас буруу ойлголт олон нийтэд өгч олохгүй байх. Хэн ч хамаагүй томилогдож болохоор хуульчилсан юм шиг. Хуулийн буруу гэж үзэхээсээ өмнө хууль хэрэгжүүлж байгаа энэ Шүүхийн ерөнхий зөвлөл, дарга нар энэ сонгон шалгаруулалт. Шилж олох гэж байгаа шүү дээ. Үндсэн хуульд шилж олох гэж орсон шүү.

Шилж олох ажлыг хангалтгүй явуулсан байна л гэж хэлбэл зохино. Хэн ч байж болно гэж заагаагүй. Хуульд. 10 жил өмгөөлөгчөөр, багшаар дагнан ажилласан. Онолын шүүх болсон шүү дээ. Гуравны нэг нь, гуравны хоёр шүүгч байна. Гуравны нэг нь байж болно гэж байгаа юм.

Энэ зөвхөн шүүгч дотроосоо биш. Бас нэг эргэлтэд орж тэр дотроо ялзарч өмхийрөөд байж болзошгүй учраас эргэлтэд оруулж байх, цус сэлбэж байх зорилгоор өмгөөлөгчөөр ажилласан хүний эрх талаасаа. Багшаар ажилласан онолын шүүгч нарыг бэлтгэх зорилгоор дагнан 10 жил ажилласан хүнийг яг тэр чигээрээ мэргэшсэн хүмүүсийг шилж олох ёстой.

Энэ бол Д.Зүмбэрэллхам даргын буруу гэж ярина уу гэхээс биш хуулийн буруу гэж би үзэхгүй. Баталсан хуулиа бид зөв тайлбарлаж байхгүй бол үүнийг тэгээд хэрэгжээд нэг ч жил болоогүй хуулиа үгүйсгээд байж таарахгүй.

Дараагийнх нь гишүүн Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир:
Д.Зүмбэрэллхам даргаас асууя.

Аливаа зүйл хоёр талтай. Өнгөрсөн жил батлагдсан Шүүхийн хуулийн шинэчилсэн найруулгын үр дүнд хуулийн үр дүнд өнөөдөр бас энэ гурван нэр дэвшигч ингээд хэлэлцэгдэж нийтийн сонголын хүрээнд, сонгон шалгаруулалтын хүрээнд ингэж, өөрсдөө бас эр зориг гаргаж, санал хүсэлтээ өгч ингэж орж ирж Улсын дээд шүүхэд өөрсдийн мэдлэг боловсролоо, ажилласан туршлагаар ажиллая гэж ингэж орж ирж байгаа гэж ойлгож байгаа. Сайн тал нь.

Нөгөө тал нь Улсын дээд шүүхийн шүүгч нар чинь одоо нэг мэдэхэд дандаа прокуроруудаас, аль эсвэл өмгөөлөгч нараас бүрдчихсэн явж байх вий дээ. Одоо ер нь Улсын дээд шүүхийн тэр 25 хүний хэд нь шүүгч биш хүмүүс өнөөдөр ажиллаж байна вэ? Өнөөдөр энэ гурван хүний нэг нь гэхэд л шүүгчээр нэг ч жил ажиллаагүй, өмгөөлөгч хийж байсан ийм хүн орж ирж байгаа.

Тэгээд цаашдаа ийм байдлаар сонгон шалгаруулалт хийсэн гээд ингээд эрэмбэлж оруулж ирсэн гээд байвал тэр эрэмбэ дээр асуудал байна уу, үгүй юу? Өнөөдөр энд орж ирж байгаа эрүүгийн танхим дээр өрсөлдөж байгаа хоёр хүн чинь гуравхан хүн

өрсөлдөөд л хоёр нь орж ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр 10 хүн өрсөлдөхөөс 2 хүн орж ирэх, 3 хүн өрсөлдөхөөс 2 хүн орж ирэх гэдэг чинь ялгаатай байна. Ялгаатай байна. Хэдийгээр өрсөлдөж эрэмбэлэгдэж орж ирж байгаа боловч.

Тийм учраас цаашдаа энэ олон шүүгч нарыг өөрсдийгөө сорих, өөрсдийнхөө мэдлэг боловсролыг дээшлүүлэх, энэ Дээд шүүхэд ажиллах ийм тал дээрээ тэр бололцоо, боломж хэр байна вэ? Үүнийг юу гэж үзэж байна вэ? Энэ улсын дээд шүүгч нар чинь давахын шатныхаа шүүгч нарын олон жил ажилласан туршлагатай шүүгч нарын тэр хууль хэрэглээ, онолын талын юмнуудыг нь хянах улсууд шүү дээ. Гэтэл одоо нэг ч жил шүүгчээр ажиллаагүй улсуудын одоо тэгээд Улсын дээд шүүх дээр нь гарч суучаад олон жил ажилласан давхан шатны шүүгч нарын дэнсэлсэн хэргийг хянаад сууж байна гэхээр одоо бас миний хувьд л лав ой тоонд буухгүй л байгаа юм. Үүнийг Д.Зүмбэрэллхам дарга юу гэж бодож байна вэ?

Магадгүй бас сайн талаас нь харъя гэвэл энэ Улсын дээд шүүхийн энэ шүүгч нар дотор шинэ шинэчлэл хийгдэж, салхи сэвэлзэж, олон жил бугшсан хараат байсан энэ асуудлуудыг шинэчилж сайжруулахын төлөө хийгдэж, шинэ хүмүүс орж ирж байна гэж ингэж сайн талаас нь харвал ийм тал байна. Энэ дээр Д.Зүмбэрэллхам дарга юу гэж үзэж байна вэ гэдгийг нэгт хэлье.

Хоёр дахь асуудал. Д.Зүмбэрэллхам дарга аа, өмнөх Ерөнхийлөгчийн үед энэ нэг 10 гаруй шүүгч нарын асуудлыг эрхийг түдгэлзүүлсэн асуудал байгаа. Өнөөдөр

хүртэл хэвээрээ байж байгаа. Энэ улсуудын эрх хохироод явж байгаа. Энэ улсууд ажлаа хийж чадахгүй, нөгөө ажилласан сарынхаа 70 хувийн цалингаар цалинжаад явж байгаа гэсэн ийм мэдээлэлтэй байгаа. Тэгээд эхнээсээ зарим нь тэтгэврийн насанд хүрээд тэтгэвэрт гарч байх шиг байна. Ингээд 10 гаруй жил үндсэндээ хохироод явж байна. Энэ асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөл юу гэж үзэж байгаа вэ? Ямар ч шалтгаан нь тодорхойгүй байдлаар шүүгчийн эрхийг нь түдгэлзүүлчихсэн шүү дээ. Өмнөх Ерөнхийлөгчийн үед. Энэ асуудлыг та бүхэн юу гэж авч үзэж байгаа вэ? Энэ асуудлаар ярилцаж байгаа зүйл байна уу? Энэ асуудлуудыг одоо ингээд энэ 10 гаруй хүмүүс хүний тоо нь цөөн гээд эрх нь зөрчигджээ гээд. Энэ чинь өөрөө шүүгч нар шүү дээ. Санал гомдол гаргасан хүн байна уу? Энэ эрхээ сэргээлэх үүднээс. Шүүхийн ерөнхий зөвлөлд хандсан шүүгч нар байна уу? Энэ асуудал дээр. Ийм хоёр асуултад хариулт өгөөч ээ.

Г.Занданшатар:

Д.Зүмбэрэллхам дарга бэлдэж байгаарай.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн, Лхагвын Мөнхбаатар, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан нарын урилгаар Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн 1993 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, гэгээн дурсамж, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Тэгээд энэ шинэ хуулийн дагуу нээлттэй сонголыг манай Лхагвын Мөнхбаатар гишүүн сайн боломжийн хэмжээнд зохион байгуулсан. Тэгэхдээ тэр “шилж олох” гэдэг нэг үг байгаа. Багш нараас С.Нарангэрэл академич шиг ч юм уу. Тийм хүмүүсийг шилж олох ёстой, үүрэгтэй нь Шүүхийн ерөнхий зөвлөл шүү дээ. Тийм ээ. Үүнийг цаашдаа.

Тэгээд энэ гурван хүн чинь гурвуулаа Дээд шүүгчийн шүүгчээр томилогдох юм уу? Энэ гурваас чинь нэг нь л Ерөнхийлөгч томилно биз дээ. Тийм ээ. Шинэ хуулийн дагуу чинь. Тэр энэ тэрээ тодорхой хариулаад. Гурвуулаа томилогдохгүй байж болно гэж бодож байна би. Тийм. Энэ танилцуулгыг ч үндэслээд юм уу.

Д.Зүмбэрэллхам дарга хариулья.
83.

Д.Зүмбэрэллхам: Дээд шүүхэд эрүүгийн шүүгчийн хоёр орон тоон дээр хоёр нэр дэвшигч байгаа. Иргэний нэг сул орон тоон дээр нэг нэр дэвшигч байгаа. Хэрвээ томилбол одоо гурвуулаа томилогдох ийм бололцоотой гэж.

Нэгдүгээрт, Улсын дээд шүүхэд шүүгч болон шүүгч бус гишүүдийн хувь хэмжээ байгаа гэж. Энэ Дээд шүүх дээр гарч байгаа сул орон тоо болгон дээр сонгон шалгаруулалт зарлахдаа энэ хувь хэмжээг эхэлж судалж байж барьж байгаа.

Тийм учраас одоогоор Улсын дээд шүүх дээр энэ хувь хэмжээ хадгалагдаж явж байгаа. Бид үүнийг анхаарлын төвд байлгаж байгаа гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Яг тодорхой хэлчих. Байгаа юм уу, байхгүй юм уу? Хэд байгаа юм. Байгаа бол.

Д.Зүмбэрэллхам: Гуравны нэг нь шүүгч бус гишүүн байгаа. Гуравны хоёр нь шүүгч нь шүүгч гишүүд. Ерөөсөө л шүүгч байж байгаад юу яасан гишүүд байгаа.

Г.Занданшатар: Дан шүүгч гишүүд байгаа шүү дээ. Одоо.

Д.Зүмбэрэллхам: Тийм.

Г.Занданшатар: Гуравны нэг нь шүүгч биш байж болно гэж хуульд байгаа юм.

Д.Зүмбэрэллхам: Тийм. Тэр нь их дээд сургуулиудаас юу яасан. Одоо тэгээд өмгөөлөгчөөр энэ тэр ажиллаж байгаад ирсэн тийм шүүгчид. Өмгөөлөгчөөр бол дан өмгөөлөгчөөр ажиллаж байсан хүн бол одоо л яаж байна л даа. Улсын дээд шүүхэд хэд хэдэн ерөөсөө шүүгчээр ажиллаж байгаагүй, их дээд сургуульд багшилж байгаад тэр шалгуураар орж ирсэн хэд хэдэн гишүүд байгаа шүү дээ. Ер нь бол. Тийм.

Яг өнөөдөр шүүгчээр ерөөсөө огт ажиллаж байгаагүй хүн гэнэтхэн Улсын дээд шүүхэд орж ирж байгаа бас биш юм гэдгийг би бас тодруулж хэлэхийг хүсэж байна.

Тэр нэг ч шүүхэд ажиллаж байгаагүй хүн гэдэг дээр би сая юу хэлчихлээ. Ер нь олон улсын жишиг бол энэ өмгөөлөгчдөөс л шүүгч болдог шүү дээ. Ер нь бол. Lawyer гээд.

Тэгээд энэ өмгөөлөгч гэдэг хүн чинь шүүх хуралдааны танхимд л шүүн

таслах ажиллагааны яг үндсэн оролцогч болоод ингээд бүх насаараа л тэр шүүх хуралдааны танхимд л сууж байдаг. Тэгээд л энэ жишгээр нь олон улсын жишиг ч гэлээ гэсэн энэ өмгөөлөгчдөөс л шүүгч болгодог ийм жишиг байдаг. Тэгээд энэ жишгийг хууль болгоод гараад ирчихлээ гэж бодоод бид тэгж итгээд одоо сонгон шалгаруулалт явуулаад ингээд ороод ирэхээр энэ биш байна гээд ингээд байхаар би бас гайхаад л байна.

Тэр түдгэлзүүлсэн 10 гаруй шүүгчийн түдгэлзүүлээд эднээс энэ түдгэлзүүлсэн шүүгчдээс гэм буруу нь нотлогдоод шийтгэгдсэн шүүгчид бий. Шийтгэгдсэн. Бусад нь бол шүүхээр ороод бас цагаандаад ажлаа хийж байгаа улсууд бий. Одоо хоёр, гурван шүүгчийн асуудал прокурор дээр байна. Түдгэлзээтэй. Бид одоо энэ хүмүүсийн асуудал хэт удлаа. Одоо нэг бол нэг талд нь гаргаж шийдэж өгөөч ээ. Оронд нь одоо ингээд сонгон шалгаруулалт зарлаад хүн томилж болохгүй юм. Ачааллыг нь төлөвлөж зохицуулах бололцоогүй байна гэдэг юуг байнга явуулж байгаа. Прокурорын байгууллага одоогоор шийдэгдэх бололцоо байхгүй байна. Хугацаа сунгуулаад ингээд ажиллаж байгаа гэсэн ийм хариу өгөөд байгаа.

Энэ дээр би Ц.Сандаг-Очир гишүүнийг санаа зовж асууж байгаа гэдгийг би ойлгож байна. Шүүхийн ерөнхий зөвлөл ч гэлээ гэсэн энэ дээр ажиллаж байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар:

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би гурван зүйл хэлээд орхиё.

Энэ орж ирж байгаа шүүгч нарын хувьд сонгон шалгаруулалт, энэ Байнгын хороо, тэгээд Шүүхийн ерөнхий зөвлөл хууль номынхоо дагуу оруулж ирж байгаа улсууд байгаа байлгүй дээ гэж.

Тэгээд хамгийн гол нь би асуух гээд байгаа юм бол энэ нөгөө боловсон хүчин, хүний нөөцийнхөө асуудлыг энэ хуулийн салбарт боловсон хүчин бэлтгэж байгаа энэ их дээд сургуулиуд хувийн болон төрийн өмчийн их дээд сургуулиудтайгаа яаж ажиллаж байгаа юм бэ? Эндээс чинь л хүмүүс гарч ирж байгаа шүү дээ.

Хуучин тогтолцооны үед чинь Нийгмийн аюулаас хамгаалах яамны боловсон хүчнийг шилж сонгох энэ ажил чинь бүр ерөнхий боловсролын сургуулиас. Одоо мань мэтийг чинь 8 дугаар анги төгсөөд л шилж сонгож, бүр удам угшлаар нь ингэж авч байсан шүү дээ.

Тэгээд энэ талынх нь юм ямар байдаг юм гэдэг нэг ийм асуудал байгаа юм. Тэгэхгүй бол энэ уг үндэснээс нь асуудлыг авч үзэхгүй бол болмооргүй юм шиг ийм юм ойлгогдоод байгаа юм.

Тэгээд бид энэ шүүхийн асуудалд хөндлөнгөөс оролцохгүй. Бүрэн итгэлтэй л бид явж байсан л даа. Олон ч энэ Их Хурлаар шүүгч нар томилогдож байсан. Гэтэл сүүлд нь хэрэг асуудалд орооцолдож байгаа байдал бол одоо бүр сүүлдээ хэрээс хэтэрлээ шүү дээ. Хулгай, дээрэм, бүр зохион байгуулалттайгаар энэ хувийн өмчийн компанийг, лиценз, зөвшөөрлийг нь, элдэв туухай юмыг нь хууль хяналтын байгууллага, шүүхийн оролцоотойгоор дээрэмдсэн, тоносон тухай асуудал ингээд яригдаад байдаг.

Энэ Засгийн газар нийгэмд шударга ёс тогтооно гээд шударга ёсны хувьсгал хийнэ гээд олон асуудлуудыг гаргаж тавиад ингээд нөгөөдөх нь замхарчихдаг. Тэр нь аль шат нь завхраад байна вэ гэхээр зэрэг хууль хяналтын байгууллага шүүхийн шатанд л энэ замхраад байдаг. Зарим нь арваад жил сунжирдаг. 30, 40 удаа шүүх хурлыг нь хийдэггүй. Тэгээд шүүхийн шийдвэр гаргахаараа зэрэг ашиг сонирхлын зөрчилтэй, шударга бус ийм шийдвэр гаргасан ийм асуудлууд байна шүү дээ.

Одоо төсөл тендерээр энэ концесстой холбоотой асуудал гэхэд тэрийг нь цуцлаад, үүний дараа нөгөө компани нь шүүхээр асуудлаа явуулж шийдүүлээд, тэгээд эцэстээ юу гарч байна вэ гэхээр зэрэг нөгөө анх төсөвт өртгөөсөө нэг дахин нугалснаар нөгөөдхийг нь хийх тухай асуудал шүүхээр шийдвэрлэгдсэн. Тэгээд л тэрийгээ аваад л ингээд л улс хохироод явж байгаа ийм жишээнүүд байна шүү дээ.

Одоо Эрдэнэтийн 49-тэй холбоотой асуудал байна, ЖДҮ-тэй холбоотой асуудал байна, энэ олон сангуудын асуудал байна, Хөгжлийн банктэй холбоотой асуудал. Одоо сүүлд босоод ирсэн энэ нүүрсний хулгайтай холбоотой асуудлууд байна.

Томоохон асуудлуудыг гаргаад ирдэг. Тэгээд л ингээд замхарчихдаг ийм нэг нөхцөл байдал байх юм. Энэ дээр яах вэ?

Сүүлд нь нэг асуух юм бол би энэ хууль шүүхийн байгууллагад ажиллаж байгаа улсууд ашиг сонирхлын зөрчлөөс ангид, энэ тансаг хэрэглээнээс

ангид, энэ төрдөө өргөсөн тангарагтаа үнэнч ингэж л ажиллах ёстой л гэж би бол ингэж ойлгодог хүн л дээ. Нийгэм бол тэгж ойлгодоггүй юм байна лээ. Би прокурорыг томилогдоход энэ тухай асуудлыг хөндөж яриад тэр коментуудыг харж байх юм бол ерөөсөө огт өөр ойлголттой юм байна лээ шүү дээ.

Тэгэхээр энэ хүмүүсийн танилцуулга дээрээс л энэ хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбоотой юм огт байхгүй байгаад байх юм.

Тэгэхээр энэ хүмүүс чинь ямар ашиг сонирхлын зөрчил гаргах вэ? Хөрөнгө орлого нь байна уу? Энэ олж байгаа орлогоосоо давсан хэрэглээтэй байх юм бол үүнийгээ тайлбарлаж чадахгүй бол буцааж улсад тушаадаг энэ хууль эрх зүйн зохицуулалтыг бий болгох тухай асуудлыг бид ярьж байна шүү дээ.

Г.Занданшатар:

Д.Зүмбэрэллхам дарга хариулъя. 83.

Д.Зүмбэрэллхам:

Хүний нөөцийн судалгааны хувьд бид шүүгч сонгон шалгаруулж байгаа байдал эртнээс урьдчилаад. Ер нь шүүгч нарын хувийн хэрэг бид нарт байдаг л даа. Шүүхийн ерөнхий зөвлөл дээр байдаг. Шүүгч нарынхаа хувийн хэргийг үзээд судлаад ингээд байж л байдаг.

Яг сонгон шалгаруулалттай холбоотой асуудал болохоор урьдчилаад ингээд судалчихсан хүмүүсээ оруулж ирдэггүй. Яг үнэндээ. Үүнийг нээлттэй зарладаг. Тэрэнд бүх одоо ингээд орё гэсэн улсууд хүрч ирдэг. Тэгээд бүртгүүлсэн улсууд дээр судалгаа явуулаад, сонгон

шалгаруулалтыг нь ил тод явуулаад ингээд л шийдвэрлэж байгаа.

Тэгээд энэ шийдвэрлэх явцад судалгааны тийм хувийн хэрэг бүрдүүлээд нөгөө хүнийхээ алдаа дутагдал гаргаж байсан уу, ёс суртахууны хувьд ямар байсан бэ энэ тэр гээд л бид нар хэрэндээ л ерөөсөө хууль дээр заасан бүх л шалгууруудыг яаж шалгаж болох тэр бололцоогоор нь шалгаад, тэгээд хүн нэг бүр дээр нэр дэвшигч дээр яриад, тэгээд энэ хүнийг ийм байдлаар сонгон шалгаруулалтад оруулах уу, яах вэ гэдгийг шийдээд ингээд явж байгаа.

Ер нь судалгааны хувьд ингэж явж байгаа. Тэр хэрэг замхардаг асуудал бол энэ шүүн таслах ажиллагааны асуудал байна.

Ер нь нэр дэвшигчдийн хувьд яг тангарагтаа үнэнч ажиллах ёстой. Энэ бол шүүхийн хамгийн гол асуудал энэ байх ёстой. Бид энэ дээр Шүүхийн ерөнхий зөвлөл захиргааны байгууллагын хувьд шүүгч рүүгээ хандсан энэ ёс зүйн сургалт, тэгээд энэ гарч байгаа алдаа дутагдлын талаар тухай тухайн үед нь шүүхүүдэд мэдэгдэж сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх энэ чиглэлийн ажлуудыг л бид хийж байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Танилцуулга дээр тодруулга байхгүй юм байна. Асуулт, үг нэг юм байна.

Төмөртогоогийн Энхтүвшин гишүүн.

Т.Энхтүвшин: Д.Зүмбэрэллхам даргаас асууя.

Энэ шүүгчийн ачаалал маш их бий. Ачаалалтай ажиллаж байгаа. Энэ шүүхийн ачааллыг бууруулах талаар иргэдийн шүүхээр шүүлгэх эрхийг хөндөхгүйгээр ачааллыг бууруулах талаар ер нь ямар ажил зохион байгуулж байгаа вэ? Шүүхийн бус журмаар хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тогтолцоог сайжруулах, түлхүү хэрэглэх, хэрэг, маргааныг аль болох шүүхийн өмнөх шатанд шийдвэрлэх тогтолцоог сайжруулах тал дээр ер нь ямар ажил зохион байгуулж байгаа юм бэ гэдэг дээр нэг асуулт асууя.

Хоёр дахь асуудал байж байна. Энэ захиргааны хэрэг, иргэний хэрэг гээд хоёр шатны шүүх байж байгаа. Тэгээд ойлгомжтой энэ албан тушаалаасаа буусан ч гэдэг юм уу, ажлаас чөлөөлөгдсөн ч гэдэг юм уу, эсвэл нэг эд хөрөнгийн маргаантай хүмүүс шүүх дээр их олон сар, жилээр явах юм. Нэг ойлгомжтой хэрэг дээр. Тухайлбал, нэг ажлаас халагдсан хүн одоо гурван шатны шүүхээр яваад бараг жил 6 сар явж байх шиг байна. Нэг эд хөрөнгийн маргаантай холбоотой ойлгомжтой, бараг анх шатны одоо тэр шүүхээрээ дахиж юу гэдэг юм давж заалдахгүйгээр шийдвэр гаргачих бололцоотой юман дээр л хүртэл одоо ингээд л бас л жил 6 сар л одоо ингээд л явах юм. Нэг хүнийг залхаан цээрлүүлж байгаа юм шиг шүүхээр хүнийг эр зоригийг мохоож байгаа юм шиг ийм үзэгдлүүд энэ шүүх дээр байгаад байна. Та энэ дээр ямар бодолтой байдаг юм?

Ойлгомжтой юм дээр л дахиад л дараагийн шатны шүүх дээд шат, хяналтын шат нь ч тэр, одоо ямар шат байдаг юм хамаг цаг хугацаагаа л барах юм.

Тийм учраас энэ гаргаж байгаа шийдвэрүүдээ бас нэг дахин давж заалдахгүй ч гэдэг юм уу, ойлгомжтой юм дээр цаг хугацааг нь хожчихсон, наашлуулсан тийм шийдвэрүүдийг гаргаж байвал илүү их үр дүнтэй юм болов уу гэсэн ийм бодолтой байж байна. Энэ дээр та ер нь ямар бодолтой байдаг юм бэ гээд.

Тэгээд орж ирж байгаа гурван шүүгчийг дэмжиж байна. Шударга ажиллаарай Та бүхэн маань. Ёс зүйтэй байгаарай. Шүүгчийн нэр хүнд, шүүхийн байгууллагын нэр хүндийг дээшлүүлж ажиллаарай гэж хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Үг хэллээ. Тийм ээ. Асуулт. Д.Зүмбэрэллхам дарга хариулья.

Д.Зүмбэрэллхам: Шүүгчийн ачааллын талаар асуулаа. Т.Энхтүвшин гишүүний асуултад хариулья.

Шүүгчийн ажлын ачаалал янз бүр байна. Орон нутагт зарим газар нь гайгүй байна. Одоо Сүхбаатар дүүрэг, Хан-Уул дүүрэг энэ тэр гээд ялангуяа иргэний хэрэг энэ тэр дээр хэт их ачаалалтай байна.

Тэнд хэт их ачаалал нь яаж үүсэж байна вэ гэвэл Улсын Их Хурлын баталсан 42 дугаар тогтоол бий. Тэр дээр одоо яг тэр шүүх дээр 15, 16, 17 шүүгчтэй гээд ингээд тавьчихдаг. Улсын Их Хурлын тогтоол учраас тэрнээс илүү шүүгч ажиллуулж болдоггүй. Тогтоол зөрчих гээд байдаг. Тэгээд энэ ачааллыг тэнцүүлэх нэг арга нь бол энэ 42 дугаар тогтоол дээр нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал мөн юм байна гээд бид судлаад Улсын Их

Хуралд өчигдөр бичиг төлөвлөөд явуулсан.

Тэгээд энэ асуудлыг Улсын Их Хурал дээр ерөнхийдөө шүүх байгуулах асуудлаас өмнө нэн даруй шийдүүлмээр ийм асуудал байгаа юм. Тэгээд үүнийг Улсын Их Хурал маань бидэнд хурдан шийдээд өгвөл шүүх байгуулах асуудал хүртэл одоо бид нар энэ ачааллаа зохицуулах ийм боломжтой болох юм байна гэж ингэж харж байгаа. Нэгд.

Хоёрт, бид энэ шүүгч нарын ажлын ачаалал, шүүх, шүүх дээр нь шүүх шүүгч дээр нь бүр ажлын зураг авалт хийгээд ингээд ажлын ачааллыг судлаад тогтоочихсон байгаа.

Тийм учраас одоо энэ шүүх байгуулах асуудалтай зэрэгцүүлээд энэ ажлын ачааллыг тэнцүүлэх ийм суурь судалгаа нь бэлэн болчихсон учраас энэ асуудлыг шийдэх гээд ингээд олон талаас нь харж үзэж шийдэх ийм бололцоо бүрдэж байгаа гэдгийг би танилцуулья.

Тэгээд тэр эрүү, захиргааны хэрэг дээр зарим жижиг маргааныг хурдан шийдмээр байна. Дахиж авч үзэхгүй, нэгмөсөн ингээд шууд эцсийн шийдвэр болгочихмоор байна энэ тэр гэдэг асуудал бол бас яригддаг. Энэ бол ерөнхийдөө энэ процессын хуулиудын дагуу нэгд шийдэх ёстой шийдэл гаргах ёстой асуудлууд байдаг.

Хоёрдугаарт, энэ шүүх байгуулах асуудлыг юу яахад дагаж шийдэж болмоор зарим зүйлүүд байдаг. Бид энэ талаар судалгаа хийж байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн.

Г.Мөнхцэцэг: Шүүхийн ерөнхий зөвлөлд нэр дэвшигчид орж ирж байна. Тэр тусмаа энэ дотор бас эмэгтэй хүн орж ирж байгаад би бас их олзуурхаж байна.

Ер нь танилцуулгуудтай нь танилцлаа. Хууль зүйн байнгын хороо бас нээлттэй сонголт хийж та бүгдийн асуулт хариултаар нэлээн чамбайруулсан гэж ингэж харж байгаа.

Тэгэхээр Н.Батчимэг шүүгчийн хувьд анхан шатандаа, дунд шатандаа ажиллаж байсан. Энэ салбартаа 24 жил ажиллачихсан. Тэр тусмаа хөдөө орон нутагт ажиллаад нэлээн туршлага хуримтлуулсан гэж харж байгаа. Эмэгтэй хүнийх нь хувьд ер нь сайн дэмжиж байгаа юм.

Тэгэхээр бас нэг онцгойлж асуух асуулт байна.

Ер нь энэ шүүгчийн хараат бус байдлыг хангах тал дээр нийгэм бас нэлээд их тийм хүлээлттэй байдаг. Тэгэхээр ер нь шүүгчээр ажиллаж байсан та бүхний хувьд ийм нөлөөллийн мэдүүлэг гээд ийм мэдүүлгийг авдаг. Тэгээд үүнийг бөглөж байсан удаа байна уу, үгүй юу?

Хоёрдугаарт, шүүхийн салбар, тэр тусмаа энэ хууль хүчний салбарт ажиллаж байгаа эмэгтэйчүүд маш их, одоо бараг хоёр, гурав, дөрөв дахин ийм ачаалалтай ажилладаг. Тэгэхээр эмэгтэй шүүгчид маань хэдэн хувийг нь эзэлж байна вэ?

Ер нь энэ салбарт ажиллаж байгаа эмэгтэй шүүгчдийн нийгмийн хамгаалал, цаашид ажиллах орчин нөхцөл гээд ингээд олон зүйл дээр бид

анхаарч ажиллах ёстой гэж ингэж боддог.

Тэгэхээр энэ чиглэлээр манай шүүх ер нь ямар судалгаа явуулдаг юм бэ? Энэ дээр хариулт авъя гэж асуулт тавьж байна. Тэгээд нэр дэвшигчдийг дэмжиж байгаагаа илэрхийлье.

Г.Занданшатар: Хэн хариулах юм? Сая ч гэсэн нөлөөллийн шинж чанар. Ингээд Дорноговь аймгаас сонгогдсон гишүүн. Хэн хариулах юм. Нөлөөллийн мэдүүлэг авсан уу? 87.

Н.Батчимэг: Г.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Шүүгчийн хараат бусаар ажиллах, хөндлөнгийн байр суурьтай байх, төвийг сахисан байр суурийг илэрхийлнэ гэдэг шүүгч бол энэ хараат бусаар ажиллах гэдэг өөрөө их өргөн хүрээтэй ойлголт.

Энэ дундаа шүүгч хараат бусаар ажиллаж байгаа шүүгчийн хувьд яг гаргаж байгаа шийдвэрээс нь энэ хүнийг үнэхээр хараат бус ажиллаж байна уу, үгүй юу гэдгийг харах боломжтой. Шийдвэр нь хууль ёсны бөгөөд үндэслэлтэй гарч байж хараат бусаар ажиллаж байна уу, үгүй юу гэдгийг тодорхойлж харах боломжтой болох байх.

Үүнээс гадна миний хувьд 24 дэх жилдээ шүүхийн байгууллага, 21 жил шүүгчээр ажиллаж байгаа. Энэ утгаараа энэ хараат бусаар ажиллах, хөндлөнгийн байр суурьтай байх, төвийг сахисан энэ зан төлөвийг өдий хорин хэдэн жил өөртөө төлөвшүүлж ажиллаж байгаа гэж боддог.

Нөлөөллийн мэдүүлэг одоогоор нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн нөлөөллийн мэдүүлэг байхгүй байна.

Ер нь би эмэгтэй шүүгчдийн талаар судалгаа юм уу, тоон үзүүлэлтийг нь сайн мэдэхгүй байна. Зүгээр миний бодож байгаагаар ерөнхийдөө шүүгчдийн 60 хувь нь юм уу, ямар ч байсан арай илүү хувь нь эмэгтэй шүүгчид байгаа байх.

Тэгээд эмэгтэй шүүгчдийн хувьд. Ер нь шүүгчийн ажил хуульд захирагдаж ажиллана. Тэр утгаараа ёс зүйн нэлээн хатуу өндөр шаардлагууд тавигддаг гэдэг утгаараа бид нийгмийн харилцаанд оролцохдоо хязгаарлагдмал гэсэн энэ байдал нь эмэгтэй шүүгчдийн хувьд бид адилхан л эх хүн, ээж хүн, эмэгтэй хүн.

Тийм учраас үр хүүхдээ хүмүүжүүлэх, сургах тийм ээ, айл гэрийн эзэгтэй байх энэ асуудал бол бас байна. Гэхдээ бид нийгмийн харилцаанд орохдоо тодорхой хуульд заасан ёс зүйн шаардлагын үүднээс оролцдог учраас бас энэ эрх нь хязгаарлагдмал хэрэгждэг. Гэхдээ нэгэнт шүүгч гэдэг энэ албан тушаалд томилогдож энэ төрийн албыг хашиж байгаа учраас энэ ёс зүйн хэм хэмжээг дагаж ажиллах нь зүйтэй байдаг.

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Ер нь гурван засаглалын нэг хараат бусаар ажиллах ёстой л доо. Улсын дээд шүүх.

Тэгээд анхан шатны шүүхийн шийдвэрийг ч өөрчилж л байдаг, давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг ч

өөрчилж л байдаг ийм л газар л даа. Улсын дээд шүүх бол.

Тэгээд энэ шүүхэд итгэх итгэл байхгүй болчихсон. Одоо хараат бусаар ажиллана гэдэгт эргэлзэж байна. Би бол. Энэ гурван нөхрийг оруулж ирсэн байдал. Тэр хуулийн ч гэсэн шаардлага хангахгүй хууль байсан юм байна. Шилж сонгож байгаа байгууллага нь ч олигтой шилж сонгоогүй юм байна. Энэ цөөхөн хүн л өрсөлдсөн л юм байна л даа.

Тэгээд сая Харвард төгссөн хүн хэлж л байна. Тэгээд хэр олон хүн өрсөлдөөд байгаа юм? Яагаад одоо ийм шаардлага хангасан улсууд орж ирэхгүй байна. Энэ талаар одоо манай Шүүхийн ерөнхий зөвлөл юу гэж бодож байна. Цалин мөнгө нь болохгүй байна уу, эсвэл нэг намыг нь ч юм уу, нэг компанийн ч юм уу, нэг хүний хувийн шүүгч нар л орж ирэх гээд байгаа юм биш үү.

Ардчилсан намыг, бүлгийг энд хэвийн ажиллах бололцоог нь байхгүй болгосон. Бараг сандлынхаа нэг хөлийг тайрч өгөөд л тамга хийж өгөөд байдаг юм шиг байгаа юм.

Тэгээд одоо сүүлийн хэдэн сар Ардчилсан намын бүлэг бүр ирц нь хангагдаж хуралдаж чадахгүй байгаа. Нам нь бүлгээ тараачихсан гэж ярьж байгаа. Тэгээд тоглоомын хэдэн хүмүүс ингэж суулгачхаад л ингэж хэлэлцэж байгаа юм шиг. Улсын дээд шүүх биш болгож байна л даа.

Энэ хувийн сургуулиуд сайн нь сайн л байдаг байх. Гэхдээ ихэнх нь Монгол Ардын намын дарга нарын сургуулиуд байдаг. Тэгээд үүнийг төгссөн улсууд орж ирсэн юм байна.

Нэг аймгаасаа ерөөсөө гарч үзээгүй шүүгч орж ирж байна. Бас л нэг хүний хамааралтай л байх гэж ойлгож байна. Үүнийгээ өөрөө юу гэж бодож байгаа вэ?

Харин энэ өмгөөлөгч залуу чинь харин өмгөөлөгчөөр олон жил ажилласан юм байна. Энэ харин зүгээр ажиллачих болов уу гэж бодож байна.

Энэ шүүхээр яваад л 40 саяар торгууль аваад л авлигачид гарч байгаа шүү дээ. Ийм байхад гадаадын хөрөнгө оруулалт энэ тэр орж ирэхгүй ээ. Энэ шүүхэд чинь итгэхгүй байна шүү дээ. Хэрэг маргаанаа тэнд зөв зүйтэй шийдвэрлүүлнэ гэдэгт итгэхгүй байгаа.

Тийм учраас гадаадын хөрөнгө оруулалт орж ирэхгүй байгаа. Тухайлбал, одоо өнөөдөр Улсын Их Хурлын 76 гишүүн бол яг адилхан эрхтэй. Хэн ч хэнээсээ илүү биш. Үүнийг нь алдагдуулчихсан.

Одоо бүх амьтан тэгш эрхтэй, нэг амьтан нь илүү эрхтэй гэдэг шиг л. Сая Д.Өнөрболор гишүүн, С.Ганбаатар гишүүн хоёр ярьж байхад л араас нь тэгээд л тайлбар хийж л байдаг. Үгүй ээ, энэ хүмүүс чинь үг хэлэх, асуулт асуух эрхээ ард түмнээсээ л авсан шүү дээ.

Нөгөө талаар одоо энэ сайд нар давхар дээлтэй болоод 100 хонож байгаа байх. 3 сар гаруй болчихсон. Одоо тэгээд баахан коммент хэлдэг араас нь. Нэг гишүүн асуусны дараа. Бас л илүү эрх эдэлж байгаа. Тэгээд тайлбар тавьдаг.

Нэг иймэрхүү л янзтай болчихоод байна л даа. Энэ улс орон. Тэгээд Монгол Улсын Их Сургууль төгссөн

хүмүүс чинь шаардлага хангадаггүй болчихсон юм уу? Хувийн дээд сургууль чинь босго оноо нь бага байдаг юм уу? Яадаг юм? Би тэгж л ойлгосон шүү дээ.

Тэгээд Улсын дээд шүүхэд хамгийн шаардлага хангасан хамгийн сайн хүмүүс орох ёстой.

Г.Занданшатар: Танд Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчидтэйгээ танилцах асуудал хэлэлцэж байгаа гэдгийг нэг сануулаад хэлчихье. Хариулах юм байвал Д.Зүмбэрэлхам дарга хариулья.

Д.Зүмбэрэлхам: Д.Ганбат гишүүний асуултад хариулья.

Тэгээд цөөхөн хүн өрсөлдсөн гэж байна. Олон хүн өрсөлдөөгүй.

Ер нь Улсын дээд шүүхийн шүүгчийн өрсөлдөөн бол цөөхөн хүний дунд болох шинжтэй юм байна. Аливаа өрсөлдөөн чөлөөтэй байх ёстой. Бид тэр хоног хугацааг нь бариад зарлах ёстой. Тэнд ирсэн улсуудаас нь сонгон шалгаруулах ёстой. Хаа нэг газраас бид шилдэг хуульчийг шилж олох ёстой гээд уриад, тэгээд хөтлөөд хүрч ирээд одоо ингээд энэ шалгалтад орооч ээ гэж хэлэх ийм боломж ерөөсөө байхгүй. Яг л чөлөөтэйгөөр зарлаад л, чөлөөтэйгөөр хэн орж ирж өрсөлдөөнд ордог юм. Тэр улсуудаас нь сонгон шалгаруулалт явуулахаас өөр арга байхгүй.

Энэ арга замыг шүүхийн хуулиар маш тодорхой зааж өгсөн. Тэр хүрээнд нь явуулж байгаа гэдгийг би хэлмээр байна.

Тийм учраас өрсөлдөөн цөөхөн хүний дунд явагдсан уу, олон хүний

дунд явагдсан уу гэдэг асуудал бол мэдээж олон хүний дунд явагдвал чанартай л болох байх. Цөөхөн хүний дунд явагдсан гэдгээрээ энэ чанар буураад одоо ингээд чанаргүй нэр дэвшигчид орж ирж байна гэдэгтэй би санал нэгдмээргүй байгаа юм.

Дараа нь тэр аймгаасаа гарч үзээгүй хүн одоо ингээд нэр дэвшигч орж ирж байна гэдэг дээр бид хаа хаанаа анхаармаар юм шиг байгаа юм. Ер нь яахаараа аймгийн давж заалдахад байсан хүн меритээр одоо ингээд Улсын дээд шүүхэд орж ирж ажиллаж болохгүй гэж.

Ер нь энэ чинь бараг дэмжигдмээр юм биш үү гэж. Би үүнийг дэмжмээр юм биш үү гэж бодмоор. Мерит зарчим гэдэг чинь бүгд л хот хөдөөнийхөнд адилхан үйлчлэх ёстой гэж би өөрөө төрийн албанд ажилласан, энэ мерит гэж их олон жил ярьсан учраас би үүнийг меритээрээ явж байгаа юм болов уу гэж би хараад байгаа юм.

Тэгээд ер нь энэ сонгон шалгаруулалтын дүнгээр хэдийгээр бид яг бодлого бариад ингээд төлөөлөл төлөөлөл гэж байгаагүй ч гэлээ гэсэн яг л одоо энэ Шүүхийн тухай хууль дээр яг заасан тэр бүрэлдэхүүнээс энэ Улаанбаатарын давахаас, орон нутгийн давахаас, тэгээд өмгөөлөгчөөр дагнасан төлөөллөөс энэ тэр гээд ингээд бүрдчихэж байгаа юм.

Тэгээд л энэ сонгон шалгаруулалтыг хуулийн дагуу явуулсны үр дүнд л ингэж гарч байгаа юм.

Г.Занданшатар: Д.Ганбат гишүүн хариултаа авлаа. Их Хурлын дарга бол хуралдаан зохион байгуулах,

хуулийн дагуу зохион байгуулах, хуулийг хэлэлцүүлэх үүрэгтэй.

Тэгээд хуулийн дагуу бас ирц зарлах үүрэгтэй. Дашдондогийн Ганбат гишүүн өнгөрсөн 11 дүгээр сард 7 удаа хуралдаан болсноос нэг удаа оролцоогүй, 4 удаа хоцорсон байна. Хуралдаандаа идэвхтэй оролцож байхыг сануулж байна.

Одоо Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

С.Ганбаатар: Миний хувьд хууль шүүхтэй холбоотой юм бага ярьдаг. Мэддэг юм дээрээ би цочсон юм шиг ярьдаг. Нийгмийн асуудал, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, хөдөлмөрийн асуудал, төсөв, тэгээд уул уурхайтай холбоотой юм. Гэхдээ энэ дээр асуулт байна. Хэд хэдэн асуулт байна.

Нэгдүгээрт, ер нь шүүхийн тогтолцоонд маш олон шударга мэргэжилдээ үнэнч, мэргэжлийнхээ төлөө олон шүүх, прокурор ажиллаж байгаа. Олон хууль хүчний хүмүүс ажиллаж байгаа. Үнэн. Тэрийг хүлээн зөвшөөрнө. Гэхдээ шүүхийн тогтолцоо нэлэнхүйдээ Монголын ард түмэн үнэхээр гутарч байна. Та нар байна шүү дээ. Улсын Их Хурлын 76 гишүүд биднийг ард түмэн сонгодог. Та нарыг сонгодоггүй.

Монголоор дүүрэн хулгай. Оюу Толгойн шаариг бөмбөлгийн хулгай, тэр баяжмалын гэрээний хулгай, Эрдэнэтийн баяжмалын тухай хулгай, Оюу Толгойн тухай 20 жил ярилаа. Шүүх таг. Та нараас ичсэндээ Швейцарын шүүх дүгнэлт гаргаж эхэлж байгаа шүү дээ. Та нараас ичсэндээ олон улсын шүүх ажиллаж эхэлж байгаа. Та

нар ажилладаггүй учраас Монголын ард иргэд, сэтгүүлчид, Улсын Их Хурлын гишүүд бид өөрсдөө та нарын өмнөөс ажлыг нь хийдэг.

Миний нэгдүгээр асуулт. Ийм мундаг ухаантай царайтай ийм гоё хүмүүс томилогдож сонгогдож байгаа юм байна. Та нар яг энэ саяын миний ярьсан зүйл дээр яаж үр дүн гаргах вэ? Яаж өөрчлөлт гаргах вэ? Монголын ард түмэн ядуудаа ажилгүйдээ бухимдаж байгаа. Тэгэхдээ шударга бус байдалд бүр их бухимдаж байгаа. Бүр гутарч байгаа. Энэ дээр яаж үр дүн гарах вэ?

Өнөөдөр та нар яг ард иргэдийн сонгогдсон гишүүд бид яг энэ зовлонг мэдэрдэг байхгүй юу. Биднийг чинь ерөөсөө л хариуцлага тооцооч ээ л гэж ярьдаг. Монголоор дүүрэн нүүрсний хулгай, Хөгжлийн банкны хулгай. Хариуцлага тооцооч ээ. Тооцдог, шоронд хийдэг, шийдвэр гаргадаг та нар таг. Та нар бол хам хэрэгтнүүд болдог. Бидний ойлголтоор та нар хам хэрэгтнүүд.

Энэ нэрээ яаж цэвэрлэх вэ? Өнөөдрийн нүүрсний хулгай, тэр Гаалийн Б.Асралт гээд дарга хэлсэн шүү дээ. Хоёр удаа хэлсэн. Тэр түр хорооны хурал дээр. Би хоёр удаа энэ хууль, хүчний байгууллагад би энэ хулгайн тухай мэдэгдсэн. Материалаа явуулсан. 10 гаруй жил болчихлоо. Таг. Та нар энэ хам хулгайн асуудал дээр ямар үр дүн гаргах вэ? Нүүрсний асуудал дээр. Хөгжлийн банкны асуудал дээр. Нэгдүгээр миний асуулт.

Хоёрдугаар асуулт. Ер нь хуульгүй, шүүхгүй юм шиг талд бэлчиж байгаа мал шиг ийм ширэнгийн хууль шиг ийм улс орныг яаж буцааж эвэнд нь оруулах вэ? Одоо улс төрчдөд танилтай,

шүүхэд танилтай хүмүүс жижгээ, багыгаа, чадал буурайгаа идэж уудаг ширэнгийн хууль Монголд үйлчилж байна. Энэ дээр яаж үр дүн гарах вэ? Та нарт ямар санаа бодол байгаа бол? Зүгээр шүү дээ. С.Ганбаатар аа, чи буруу ойлгоод байна гэж байвал хэлээрэй. Эсвэл тийм ээ. Үүнийг би ийм ийм зохицуулалтаар ингэж өөрчилнө гэвэл бас хэлээд өгөөрэй. Бөөрөнхийлбөл муухай даа. Ард иргэд үүнийг сонсохыг хүсэж байгаа болов уу.

Хоёрдугаарт, шударга шүүгч нар их байгаа гэдгийг би хэлсэн. Зүгээр улс төрчидтэй нийлсэн тэдний захиалгаар. Тэр Ардчилсан намын тамга тэмдгийн тухай ярьж байна. Муухай харагдаж байна. Бөөлжис цугтаж байна. Энэ асуудал дээр энэ улс төрчдөөс хараат бус байдал та нар дээр энэ шүүх, прокурор, энэ хүчний байгууллагууд дээр гайгүй болох болов уу? Ямар арга зам байдаг юм бол?

Ард иргэд үүнийг л тодруулж асуудаг. Одоо сая НҮБ-ын шинжээч хүрч ирээд дүгнэлт гаргасан шүү дээ. Шүүх тогтолцоо чинь дампуурчихсан байна. Та нар дээр 98 хувь нь шүүхийн шийдвэргүйгээр хүмүүс.../минут дуусав/

Г.Занданшатар: Гурван асуултад хариулна. Яаж хариулах билээ? Нэр дэвшигчдээс асуусан. Тийм ээ. Бүгдээрээ нэг бүрчлэн хариулъя.

Тэгээд манай Баттөмөрийн Энхбаяр гишүүн бол бас тэр Хөгжлийн банк энэ тэрээр нээлттэй сонгогдсон зохион байгуулах ажил зохион байгуулж байгаа. Бас энэ нэр дэвшигчийн танилцах сонголыг бусад улсад бол Америк, Солонгос улсуудад “**НОТЛОХ СОНГОЛ**” гэж. Ерөнхийлөгчид нь

томилдог боловч томилгоог “нотлох сонсгол”, “баталгаажуулах сонсголууд” гэж хийдэг. Тэр талаар бас хуульд өөрчлөлт оруулъя энэ тэр гээд санаачлаад явж байгаа.

Тэр нүүрсний хулгай, Хөгжлийн банкны олон асуудлуудаар энэ Түр хороод нээлттэй сонсгол зохион байгуулж байгаа. Тэрэнд манай С.Ганбаатар гишүүд өөрсдөө их сайн идэвхтэй оролцож байх хэрэгтэй шүү. За юу.

Ингээд Д.Зүмбэрэллхам дор хариулъя.

Д.Зүмбэрэллхам: С.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Нийгэмд шударга ёс үйлчлэх ёстой. Шүүгч хараат бус байх ёстой. Олон нийтийн итгэлийг хүлээх ёстой гэдэг дээр С.Ганбаатар гишүүнтэй 100 хувь мэдээж санал нэгдэнэ.

Шүүх бол хөгжлийнхөө үе шатуудыг дамжаад л явж байгаа. 2019 онд Үндсэн хуулийн 49 дүгээр зүйл дээр өөрчлөлт орсонтой холбогдуулаад 2021 онд Шүүхийн тухай хуулийг шинэчилж баталсан. Энэ Шүүхийн тухай Улсын Их Хурлын баталсан энэ хууль бол энэ шүүхийн шинэтгэлийн нэг үе шатыг эхлүүлсэн гэж би хувьдаа бодож байгаа юм.

Яагаад би ингэж бодож байгаа юм гэхээр ер нь Шүүхийн тухай хуулийг хэрэгжүүлэх гэхээр хуучин зохицуулалт, хуучин арга барил, хуучин сэтгэлгээгээр энэ хуулийг хэрэгжүүлж болохгүй юм билээ.

Тийм учраас бид их олон дүрэм журмуудыг баталж байгаа. Хэрэгжүүлэх

гэж оролдож байгаа. Шүүхийн ерөнхий зөвлөл бүрдээд нэг жил болж байна. Энэ хууль хэрэгжээд бас нэг л жил болж байна. Тэгээд бид үр дүнг нь харах хугацаа хараахан болоогүй байна.

Ер нь энэ хууль жоохон тогтвортой хэрэгжээд жоохон цаг хугацаа өнгөрөхөд ер нь шүүхийн тогтолцоо, үйл ажиллагаа, тэгээд тэр олон нийтэд нээлттэй болох, олон нийтийн итгэлийг хүлээх олон зүйл дээр эргэлт гарах байх гэж би тийм өөдрөг бодолтойгоор бид ийм бодлого, итгэл үнэмшилтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа гэдгийг илтгэж хэлье.

Нүүрсний хулгай, одоо энэ Хөгжлийн банкны асуудал энэ тэр гээд энэ бол одоогоор шүүх дээр ирсэн юм уу, ирээгүй юм уу. Би бас сайн мэдэхгүй байна. Тэгэхдээ миний мэдэж байгаа юм бол үндсэндээ энэ бол нийгмийн дуулиан болсон энэ асуудалд шүүх нийгмийн сэтгэл зүйд автаж болохгүй. Зөвхөн хуульд заасан байдлаар хараат бусаар энэ асуудлыг шийдэх ёстой гэдгийг л их сайн мэдэж байна.

Ингэж чадах юм бол үнэхээр шүүх шударга ажиллаж байна гэдгийг харуулах ёстой. Манай шүүх энэ дээр хичээж ажиллах ёстой. Шударга ажиллах ёстой гэдэгтэй С.Ганбаатар гишүүнтэй санал нэг байна. Баярлалаа.

С.Одонтуяа: Нэр дэвшигч Н.Батчимэгээс эхлэх үү. Нэргүйн Батчимэг хариулъя.

Н.Батчимэг: С.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Нүүрсний асуудал Хөгжлийн банкны хэргийн талаар байр суурь гэж байх шиг байна. Энэ талаар яг миний

хувьд тодорхой ийм байр суурийг илэрхийлэх боломжгүй. Шүүгч нэгэнт эрүүгийн хэрэг юм уу, иргэний хэрэг юм уу, ямар нэгэн байдлаар хэрэг, маргаан хянан шийдвэрлэж байгаа тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуульд заасан журмын дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагддаг. Шүүгч гагцхүү хуульд захирагдаж хэрэг, маргааныг төвийг согсог хараат бус байдлаар шийдвэрлэх үүрэгтэй байдаг.

Тэгэхээр энэ дээр ямар ч байсан шүүгч хүний хувьд шударга байх ёстой, шударга ёсыг сахих ёстой гэдэгтэй мөн адил санал нэг байна.

Дараагийн асуулт бол ёс зүйн шаардлагын хувьд шүүгчид тавигдаж байгаа ёс зүйн шаардлага, шүүгчдийн ёс зүйн асуудал мэдээж чухал асуудал. Шүүхийн тухай хууль шинэчлэгдэж батлагдсанаар ер нь шүүгчийг ёс зүйн хувьд тавигдах шаардлагыг нэлээн өндөр тавьсан. Шаардлагаас гадна энэ ёс зүйн хувьд шалгаж байгаа энэ сорил шалгалт, сонгон шалгаруулж байгаа энэ шалгаруулалт нэлээн боловсронгуй, илүү тэр хүний ёс зүй, суурь хүмүүжил энэ тал руу нь илүү ингэж тавигдаж байгаа учраас шүүгчдэд тавигдаж байгаа энэ ёс зүйн шаардлага өндөрсөж ингэж явж байгаа гэж ойлгож байгаа.

Улс төрчдөөс хараат бус байх тал дээр энэ шүүхэд тавигддаг хамгийн чухал шүүх хараат бус байх, шүүгч бие даасан байх шаардлагын юм гол чухал нэг шаардлага байдаг. Миний хувьд ямар нэгэн тийм улс төрчидтэй харилцаа холбоо ийм юм байхгүй байгаа.

С.Одонтуяа: Дараагийн нэр дэвшигч Бадамдоогийн Ганболд хариулъя.

Б.Ганболд: С.Ганбаатар гишүүн асуулт тавилаа. Баярлалаа. Асуултад хариулъя.

Ард түмэн шүүхэд итгэх итгэлгүй байгаа. Хараат бус байх, шударга байх, улс төрөөс хараат бус байх, хам эрхтэн болохгүй байх гэсэн олон шаардлагуудыг тавьж байгаа явдалтай санал нэг байна.

Би шүүхийн системээс гадна шүүн таслах үйл ажиллагааг эрхлээгүй учраас бусад хэрэг маргааны талаар болон шүүхийн нэр хүндийн асуудлаар байр сууриа илэрхийлэх нь боломжгүй байна.

Харин хувь хуульчийнхаа хувьд Монгол Улсын дээд шүүхийг илүү онолын шинжтэй шүүх байх нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байдаг. Хэрвээ энэ тал руугаа эрх зүйн хөгжилт хийгдэх юм бол таны ярьж байгаа олон асуудал дээр бид бас зөв зохистой гарцтай болж чадна гэдэгтээ итгэлтэй байна. Баярлалаа.

С.Одонтуяа: Одоо Мөнхөөгийн Пүрэвсүрэн нэр дэвшигч хариулъя.

М.Пүрэвсүрэн: С.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Шүүхийн нэр хүнд өөрөө олон нийтийн итгэл дээр тогтож байдаг. Тэгээд олон нийтийн итгэлийг хүлээснээр энэ ямар үр дагавартай юм бэ гэхээр эцсийн зорилго бол хууль дээдлэх зарчмын энэ хэрэгжилт, үр нөлөөнд нөлөөлөх ийм ач холбогдолтой.

Тэгээд шүүх яаж олон нийтийн итгэлийг хүлээх вэ. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод, нээлттэй явагдах ёстой. Хүнийг шударгаар шүүлгэх эрхийг хангах. Ингээд гаргаж байгаа шийдвэр нь хуульд нийцсэн, нотлох баримтад тулгуурласан ийм үйл ажиллагаагаар олон нийтийн итгэлийг хүлээж авна.

Миний хувьд улс төрөөс ямар нэгэн хараат байдал байхгүй. Тодорхой нэг эрүүгийн хэрэг, тухайлах юм бол нүүрсний хулгай, Хөгжлийн банкны асуудлаар энд шүүхээр шийдвэрлэгдээгүй асуудлууд учраас байр суурь хэлэх нь Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлээр хориглосон зохицуулалтад хамаарч байгаа. Баярлалаа.

С.Одонтуяа: Дэгээд тодруулга байхгүй байгаа. Одоо Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуултаа асууя.

Ц.Идэрбат: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Ард иргэдийн дунд шүүх засаглалын нэр хүнд ямар байх нь энэ шүүхээс гарч байгаа шийдвэр, олон юмнаас шалтгаална. Одоо бол яг иргэдийн ид бухимдаж байгаа асуудал бол энэ улс орноо тонон дээрэмдсэн гэж яригдаад байгаа энэ олон асуудал дээр шүүх ер нь ямархуу байр суурьтай байх юм бэ гэдэг дээр нэлээн хатуу хяналттай байгаа гэж би ойлгож байгаа.

Ер нь одоо энэ хүн төрөлхтний хамгийн адгийн зүйл бол улс орноо тонон дээрэмдэх зүйл юм гэж их сэтгэгч Гегель гэдэг хүн хэлсэн байдаг юм билээ.

Тэгээд манай дээр жишээ нь Эрдэнэтийн 49 хувь гээд л 2016 оноос яригдсан. Өнөөдөр 6 жил болж байна. Энэ асуудал таг. Хөгжлийн банкны асуудлууд таг. Тэгээд Ерөнхий сайд нь хүртэл Засгийн газрын тэргүүн нь энэ хууль бус хулгай дээрэмтэй тэмцэхээ илэрхийлээд шүтэл үлээгээд асуудлуудыг гаргаж тавиад, мөрдөх байгууллагууд нь үүнийг шалгаад эцэслээд ингээд хууль хяналтын дараагийн шатны байгууллагууд руу очдог. Эндээс эхлээд л ард иргэдийн дунд олон жил болдог нөгөө хүлээлтүүд нь эхэлдэг. Энэ болгон бас шүүхийн нэр хүндтэй би холбоотой болов уу гэж боддог юм. Жишээ нь, Хөгжлийн банкн дээр гэхэд өнөөдөр 18 удаа шүүх хурал нь хойшлоод энэ хүн зээлээ төлөх ёстой. 200 тэрбум төгрөгөө төлөхгүйгээр гадаадад гараад явчихсан. Магадгүй 18 биш хоёр, гурван удаа хойшлоод энэ шүүх хурал болсон бол энэ 200 тэрбум төгрөг өнөөдөр төлөгдчихсөн байхыг ч үгүйсгэхгүй ийм л юм байгаа юм.

Тэгэхээр энэ болгон чинь ард түмний уурыг хүргээд, ундууцлыг хүргээд. Магадгүй та бүхний яриад байгаа энэ шүүх засаглалын нэр хүндэд чинь сөргөөр нөлөөлөөд байгаа юм гэдгийг би хэлье гэж ингэж бодож байгаа юм.

Саяхан Хууль зүйн сайд Х.Нямбаатар нэлээн дэлгэрэнгүй юм ярьсан. Гадаадын хөрөнгө оруулагчдыг бас луйвардсан барьсантай холбогдуулаад. Хилийн хоригтой байгаа хүнийг нэг шүүгч хилийн хоригийг нь цуцлаад маргааш нь гарангуут дахиад хэлээ хоригийг нь сэргээчихдэг гэж байгаа юм.

Тэгээд иймэрхүү зүйлүүд байгаад байгаа учраас ард иргэд энэ шүүх засаглалд итгэх итгэл нэлээн муудаад байгаа юм шүү гэдгийг би зориуд энэ Дээд шүүхийн гурван шүүгч томилогдох гэж байгаатай, танилцуулагдаж байгаатай холбогдуулаад хэлье. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга байгаа учраас хэлье гэж ингэж бодож байгаа юм.

Энэ ганц миний үг биш. Энэ бол яг хөдөө орон нутагт ард иргэдтэй уулзаад ярьж байхад энэ хууль хяналтын байгууллагаас шалгагдсан хэргүүд чинь өнөөдрийг хүртэл яагаад шийдэгдэхгүй байгаа юм бэ.

Сая С.Ганбаатар гишүүн ярьж байна. Хариуцлага тооцооч ээ гэдэг зүйлийг энэ гишүүн, энэ 76 гишүүн болгонд л энэ ард иргэд дайж байгаа, хэлж байгаа, харж байгаа.

Тэгээд өнөөдөр ямар ч үр дүн байхгүй байгаад энэ шүүхийн засаглалын нэр хүнд байгаа шүү. Өчигдөр хоёрхон хоногийн өмнө би Хэнтий аймгаас Жаргалтхаан суманд тэгээд л үйлчилгээний газраар ороход амьдрал хэцүү байна. Гэхдээ энэ амьдрал хэцүү байгааг бид даваад гарч чадна. Гагцхүү энэ олон түмний боломжийг хулгайлсан энэ олон хэргүүд шүүхээр хурдан шийдэгдээсэй билээ гээд захын үйлчилгээний ажилтан эмэгтэй надад хэлээд зогсож байх жишээтэй.

Тийм учраас энд би бас хэлэх ёстой хүмүүс нь байгаа учраас хэлж байгаа гэж ингэж бодож байна.

Би нэг асуулт асууя. Одоо сая Д.Зүмбэрэлхам дарга шүүхийн ачааллуудыг багасгахад Улсын Их

Хурлын 48 дугаар тогтоол гэсэн байх. Ингээд саад болж байна. Үүнийг засаж залруулаад явах юм бол шүүхийн ачааллыг зохицуулаад байх боломжтой гэж хэлж байгаатай адилхан энэ шүүхийг 18 удаа хойшлуулдаг энэ процессыг одоо зогсоох ямар бололцоо байгаа юм бэ. 18 гэдэг чинь арай хэтэрхий байна шүү дээ. Нэгдүгээрт.

Энэ дээр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүх дээр ийм дутагдал гараад байгаа учраас 18 удаа хойшилж байгаа. Үүнийг Улсын Их Хурлаас засаад өгөөч ээ гэдэг ийм саналаа оруулж ирээч ээ гэж би хүсэх гээд байгаа юм.

Дараагийнх нь, одоо ингээд энэ цалин мөнгөтэй холбоотой. Олон хүмүүс, ялангуяа хөдөө орон нутагт ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүд олон хүний цалин мөнгийг өгөхгүй алга болдог. Эцэст нь шүүхдэх болдог. Шүүхдэнэ гэхээр жил гаруйн процесс явах болдог. Энэ Улаанбаатар хотод байгаа компаниудад тухайн харьяа дүүргүүдэд нь гомдлоо гаргах болдог гээд олон хүн ингэж чадахгүйгээсээ болоод хохироод байгаа юм.

Тэгэхээр энэ дээр ч гэсэн удахгүй Улсын Их Хурлаар энэ тендерийн хууль орж ирнэ. Шинэчилсэн найруулга. Энэ дээр энэ цалин мөнгөтэй холбоотой асуудлуудыг ярихад шүүхийн процессын асуудал.../минут дуусав/

С.Одонтуяа: Сүүлийн асуултад нэр дэвшигчид товч хариулья. Н.Батчимэгээс эхэлье. Нэр дэвшигч Н.Батчимэг.

Н.Батчимэг: Ц.Идэрбат гишүүний асуултад хариулья.

Ц.Идэрбат гишүүн энэ шүүх хуралдаан хойшлуулж байгаа эрх зүйн зохицуулалтын талаар ярьж ярилаа.

Шүүх хуралдаан хойшлуулах талаар энэ шүүхийн практик болон хуулиас харахад шүүх хуралдаан хойшлуулах зохицуулалт эрүүгийн хэргийн хувьд өмгөөлөх эрхээр хангах, хэрэг материалтай танилцах гэх мэтчилэн эрхийг нь хангах үүднээс хэргийн оролцогчдын өөрсдийн хүсэлтээр шүүх хуралдааныг хойшлуулдаг.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед шинээр нотлох баримт гаргах, мөн өмгөөлүүлэх эрхийг хангах, хавтаст хэргийн материалтай танилцах гэх мэтчилэн энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрхийг нь хангах зохицуулалттай холбоотойгоор ингээд шүүх хуралдааныг хойшлуулах зохицуулалтууд байдаг.

Тэгэхээр энэ шүүх хуралдааныг хойшлуулаад байгаа нь энэ хуульд заасан журмын дагуу явагдах ёстой.

Ер нь шүүхээс болон шүүгчээс шалтгаалж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хойшлогдох, шүүх хуралдаан хойшлогдох, хэрэг хянан шийдвэрлэх нь удаашрах ийм тохиолдол гарах ёсгүй.

Дараа нь энэ гомдол гаргах ажиллагааны талаар мөн Ц.Идэрбат гишүүн асуулаа. Гомдол гаргах энэ ажиллагаа бол шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашралтай байна гээд. Шинэ шүүхийн тухай хуулиар нэг дэвшилттэй зүйл нь юу байсан бэ гэхээр хуульд заасан яг зөвшөөрөгдсөн үндэслэлээр Улсын дээд шүүхэд гомдол гаргах. Улсын дээд

шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор хэргийг давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хянах гэсэн энэ зохицуулалт орж ирснээр харин энэ иргэдийг чирэгдүүлэхгүй байх, хэрэг ингэж олон дахин олон шүүх дамжиж явахгүй байх, энд энэ зохицуулалтууд бас ийм ач холбогдолтой гэж үзэж байгаа.

С.Одонтуяа: Дараа нь 87 дугаар микрофон. Бадамдоогийн Ганболд нэр дэвшигч хариулъя.

Б.Ганболд: Баярлалаа. Ц.Идэрбат гишүүний асуултад хариулъя.

Шүүхээс гарч байгаа шийдвэр бол цаг хугацаа хийгээд хөрөнгө мөнгөний хувьд нэлээд асуудал тавьдаг. Үүнийг өмгөөлөгчөөр олон жил ажиллаж байх хугацаанд мэддэг. Таны хэлж байгаа энэ олон шалтгаануудыг, ялангуяа ард иргэд үнэхээр их амсдаг. Хаа байсан хол газраас зардал чирэгдэл болоод ирдэг. Ирэнгүүт нь шүүх хуралдаан нь хойшилчихдог. Нөгөө хохирсон хүмүүс хохирлоо авъя гэхээр хуралдаан нь болж өгдөггүй. Тэгээд миний мэдэж байгаа практикаар. Түрүүн ч бас нэг Их Хурлын гишүүн хэллээ. 40 удаа хойшилж байгаа гэж.

Ийм хойшилж байгаа шалтгаанууд байдгаас болоод хүндрэлтэй олон асуудал үүсдэг. Үүнийг шүүхийн бус журмаар хурдан хугацаанд шийдвэрлэх, олон улсын жишиг практикийг харах юм бол хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх процессын ажиллагааны тусламжтайгаар энэ асуудлыг шийдвэрлэдэг.

Яваандаа энэ байдлууд манай хууль тогтоомжид тусгалаа олоод ирвэл энэ асуудал зөв зүйтэй голдиролдоо орно гэдэгт итгэлтэй байна. Баярлалаа.

С.Одонтуяа: Мөнхөөгийн Пүрэвсүрэн нэр дэвшигч хариулъя.

М.Пүрэвсүрэн: Ц.Идэрбат гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр тодорхой нэг хэрэг дээр жишээ татаж энэ удаа дараа хойшилсон гэдэг асуудалд ёс зүйн үүднээс хариулт өгөхгүйгээр одоо яг хууль тогтоомжийн хүрээнд, процессын хуулийн зохицуулалтын хүрээнд, мөн практик шаардлага гэсэн энэ хоёр талаас нь хариулт өгье.

Тэгэхээр Захиргааны болон Эрүүгийн процессын хуульд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг гэсэн ийм процесс байгаа. Энэ процессоор хамгийн гол үзэл санаа нь энэ шүүх хуралдааныг шалтгаангүйгээр хойшлуулахгүйн тулд талуудын санал хүсэлт, байр суурийг сонсож хурлыг товлодог. Энэ нь өөрөө дараагийн шүүх хуралдаан хойшлохгүй байх урьдчилсан нөхцөл болж байгаа.

Хоёр дахь хуулиар олгогдсон боломж юу байна гэхээр шүүх хуралдааныг удаа дараа шалтгаангүй хойшлуулж байгаа тохиолдолд томилолтын өмгөөлөгч хойшлуулаад, тэр нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд санаатай саад учруулж байна гэсэн итгэл үнэмшил шүүгчид тогтох юм бол өмгөөлөх эрхийг нь томилолтын өмгөөлөгчөөр хангаж ингэж тухайн хэргийг хэлэлцэн шийдвэрлэх ийм боломж бас хуулиар нээлттэй байдаг.

Практикийн талаас нь хэлэх юм бол сая КОВИД-ын нөхцөл байдал, олон оролцогчтой энэ хэргүүд дээр хуралдаан их удаан хойшилж байсан ийм практикууд гарч байсан. Энэ бол тухайн шүүгч болон хэргийн оролцогчоос шалтгаалахгүй энэ цар тахлын нөхцөл байдал байсан юм шүү гэдгийг хэлье. Баярлалаа.

С.Одонтуяа: Одоо Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуулт асууна.

Б.Энхбаяр: Монгол Улсын дээд шүүхийн шүүгчдэд нэр дэвшигчдийг Шүүхийн ерөнхий зөвлөл шилж сонгон шалгаруулан Улсын Их Хурал танилцаж, Монгол Улсын Ерөнхийлөгч томилдог.

Улсын Их Хурал танилцаж байгаа нь энэ томилгооны эрхэд оролцож санал хураалт явагддаг гэдэг асуудал биш. Ард түмний төлөөллийн дээд байгууллага гэх утгаар Та бүхний талаар асуултаараа дамжуулж ард түмэндээ Монгол Улсын шүүх засаглалын оройн дээдэд ямар хүмүүс шалгарч, ямар хүмүүс томилогдох гэж байна вэ гэдгийг танилцуулж байгаа ийм хэлбэр юм.

Миний хувьд хоёр асуулт байна. Д.Зүмбэрэлхам даргаас.

Энэ шүүгчдийн сонгон шалгаруулалт хэзээ зарлагдаж зохион байгуулагдсан бэ? Энэ зарлагдаж зохион байгуулагдахын өмнө нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн хуульчдаас шүүгчдийг шилж сонгох ажлыг, шалгалт авах ажлыг хариуцдаг Ай Ти хэлтсийн даргыг та өөрчилсөн гэсэн ийм мэдээлэл байна. Тэгэхээр энэ үнэн үү? Олон гишүүд зарим нэр дэвшигчдэд голонгуй хандаж байна.

Тийм учраас би энэ асуултыг асууж байгаа юм.

Хоёр дахь асуулт нь, ер нь нэр дэвшигчтэй холбоотойгоор шүүх засаглалд хөндлөнгөөс нь нөлөөлөхгүй гэдэг утгаар асуулт асууя гэсэн бодол байгаагүй. Тэгэхдээ гишүүдийн асуултад хариулт өгч байгаа байдлаас үүдээд хоёр асуултыг нэр дэвшигч Б.Ганболдоос асуумаар санагдлаа.

Та түрүүн нэг гишүүний асуултад хариулахдаа 22 ном бичсэн гэж хэллээ. Тэгээд би бол Б.Чимид багш, С.Нарангэрэл багшийг ч 20 ном бичсэн гэж сонсоогүй.

Ер нь яах вэ, бүх номыг уншдаг, мэддэг байх алба мэдээж жишээлбэл надад байхгүй л дээ. Тэгэхдээ би нөгөө таны бичсэн номыг сайн мэдэхгүй байгаад байна. Хуулийн шинжлэх ухааны салбартаа хүлээн зөвшөөрөгдөхийн нэг үндэслэл легитив[хууль ёсны] байдлын үндсэн нь мэдээж энэ судалгаа шинжилгээний ажил.

Тэгэхээр та энэ 22 номоо нэг дурдаад хэлээд өгөөч. Ямар номууд бичсэн бэ?

Хоёрдугаарт, гишүүдийн асуултад хариулж байгаа байдлаас харахад Б.Ганболд нэр дэвшигч жоохон халилтай тийм харгиа яриатай байна шүү.

Одоо уянгын халил гэж хэлэхэд хаашаа юм. Тийм их халил ихтэй байна шүү. Шүүгч хүнд ялангуяа ийм халил, сэтгэл хөдлөл ийм зан байдал байх ёсгүй байдаг юм шүү.

Тэгээд онолын их суурьтай учраас орж ирсэн гэж байгаа учраас нэг онолын асуулт байна. Эрүүгийн хэрэг дээр “хэргийн бодит байдлыг тогтоох”, “хэргийн бодит үнэн”-ийг тогтоох гэж хоёр ялгаатай онолын ойлголт байдаг.

Тэгэхээр манай эрүүгийн хууль тогтоомж дээр энэ хоёрын алиныг нь хэрэглэж нутагшуулсан бэ? Энэ ойлголт ер нь ямар ялгаатай вэ? Хэргийн бодит байдлыг тогтоох, хэргийн бодит үнэнийг тогтоох.

С.Одонтуяа: Нэр дэвшигчид хариулья. Хэн эхлэх вэ? Б.Ганболд нэр дэвшигч хариулья.

Б.Ганболд: Баярлалаа. Б.Энхбаяр гишүүн асуулт асуулаа. Асуултад хариулья.

Хоёр асуулт байна. Нэгдүгээрт, 2000 онд сургууль төгсөөд түүнээсээ хойш эрдэм судалгааны ажил хийхэд шамдан суралцаж ирсэн. Тэр оноос эхэлж өнөөдрийн он хүртэл жилд нэг бүтээл гаргаж амждаг. Энэ дагуу жил болгон ном бичиж нийтийн бүтээл болгож ирсэн.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, Монгол Улсын эрүүгийн эрх зүй, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй, Эрх зүйн онол, Криминологи, Гэмт хэрэг зүйлчлэлийн онол, Нотлох баримтын онол, Эрх зүй судлал. Түүнчлэн Өршөөлийн эрх зүй зэрэг нийт 22 бүтээлийг бичиж нийтийн бүтээл болгосон байдаг юм.

Энэ миний багшлах болон эрдэм судалгааны ажил хийж байгаа үр дүнтэй минь холбоотой гэж ойлгодог.

Тийм учраас багш хийж байсан, өмгөөлөл хийж байсан энэ үйл явцынхаа үр дүнд олсон.

Б.Энхбаяр гишүүний хэлж байгаа тэр халилтай ярих, сэтгэл хөдөлж эмоци гаргах иймэрхүү байдлууд байхыг үгүйсгэхгүй. Энэ дээр би дараа нь онцгой анхаарна. Төвийг сахисан шүүгч болж хэрвээ томилогдсон тохиолдолд төвийг сахисан ийм байр сууринаас асуудалд хандах болно гэж өөрийгөө үзэж байна.

Ром, Германы эрх зүйн тогтолцоотой орон, эсвэл Англи-Саксоны эрх зүйн тогтолцоотой орон хоёрын ялгаанаас үүдэж энэ онолын асуудал гарч байгаа юм.

“Эрүүгийн хэргийн бодит байдлыг тогтоох”, эсвэл “эрүүгийн хэргийн үнэн бодит байдлыг тогтоох” гэсэн зарчмын шинжтэй асуудал энэ онолын хүрээнд яригддаг.

Одоогийн дагаж мөрдөж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “хэргийн бодит үнэнийг тогтоох” гэсэн зарчмыг авч үзсэн байгаа. Энэ зарчмын хүрээнд мэтгэлцэх зарчим нэг талдаа байх. Нөгөө талд хэргийн оролцогчид эрүүгийн хэргийн бодит үнэн байдлыг өмгөөлөх болон яллах талуудын мэтгэлцээний үр дүн дээр тогтооно гэсэн эрх зүйн зохицуулалтынхаа хувьд орж ирж хэлбэршиж байна. Энэ яваандаа илүү их төгөлдөржинө гэдэгтээ итгэлтэй байна. Баярлалаа.

С.Одонтуяа: Баярлалаа. Одоо Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууя.

М.Оюунчимэг: Миний эхний асуулт Д.Зүмбэрэллхам даргаас асуумаар байна.

Энэ өөрөө хүний нөөцтэй холбоотой асуудал. Түүрүүн Б.Энхбаяр гишүүн яг хэлж байна л даа. Одоо энд орж ирж байгаа гурван хүнийг харахад нэг нь Монгол Улсын Их Сургууль, Н.Батчимэг, нөгөө хоёр нь хувийн хуулийн сургууль төгссөн байна. Мэдээж салбартаа удаан хугацаанд сайн ажиллаж байгаа байх л даа.

Энэ хувь хүмүүсийн тухайд нь биш. Ер нь сонгон шалгаруулалтад хэчнээн шүүгч оролцсон, хэчнээн хүн оролцсон бэ? Энэ хүмүүсийн одоо яг боловсон хүчин, төгссөн сургууль, мэдлэг боловсрол юугаараа энэ гурван хүн маань шалгараад ингээд нээлттэй сонсголоор өнөөдөр Улсын Их Хурал дээр орж ирж байгаа юм бол оо? Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч.

Ер нь энэ шүүгчдийн маань шүүх засаглал гэдэг бол маш хариуцлагатай ийм байгууллага.

Тэгэхээр хүний нөөц тал дээр жоохон асуудал тулгарч байна уу, эсвэл хангалттай байгаа юу? Боловсон хүчний чадавх гэдэг өөрөө маш чухал асуудал.

Тийм учраас Д.Зүмбэрэллхам дарга та энэ сонгон шалгаруулалтад орсон хүмүүсийн ажилласан байдал, төгссөн сургууль, эзэмшсэн мэргэжил, гадаад, дотоодод мастерын зэрэг хамгаалсан, олон улсад туршлагатай ажиллаж байсан, энэ тэр бол өөрөө өнөөдөр маш чухал үзүүлэлт л дээ.

Тэгэхээр энэ тал дээр манай энэ систем маань хэр хүний нөөцтэй байна вэ? Чадварлаг боловсон хүчин ямар

байна вэ? Аль ямар сургуулиудад бэлтгэгддэг вэ? Энэ дээр та нэг хариулт өгөөч. Нэгдүгээрт.

Хоёрт нь, түрүүн хэлж байна л даа. Үнэхээр шүүх засаглалын оройн дээд буюу Дээд шүүхийн шүүгч Та бүхэн маань нэр дэвшээд орж ирж байна. Сонгон шалгаруулалт дээр ялаад ингээд орж ирж байгаа учраас маш хариуцлагатай хүмүүс маань орж ирж байна гэж би харж байгаа.

Түрүүн бас нэг нь хэлж байна. М.Пүрэвсүрэн маань хэлж байна л даа. КОВИД-ын үед олон шүүх хурал хойшлогдсон асуудлууд гарсан гээд. КОВИД болоогүй байхад. Би нэг жишээ хэлье. Одоо “Эрэл” компанийн асуудал гэж байгаа.

2015, 2016 оноос хойш өнөөдрийг хүртэл энэ компани гэр хорооллын дахин төлөвлөлтөд ороод тэнд зөвшөөрөл авчхаад нэг хадаас ч хөдөлгөөгүй, нэг хүрз ч ухаагүй. Гэтэл одоо тэнд хэдэн зуун мянган хүн энэ компаниас болоод ажиллагаа нь явдаггүй хохироод байж байна.

Тэгээд нийслэлээс, Барилга, хот байгуулалтын яамнаас үүнийг цуцлаач ээ. Хууль зөрчөөд одоо өнөөдрийг хүртэл үйл ажиллагаа явуулаагүй учраас эрлийг цуцалъя гэдэг шүүх хурал нь дандаа хойшлогддог. Эсвэл дандаа энэ компанийн талд гардаг.

Сая Хөгжлийн банк дээр өчнөөн өртэй гээд л тэглээ. Тэгээд энэ асуудал нь бас шүүх дээр очоод хойшлогдчихсон. Нөгөөдөх нь хаана байгаа нь ч бүү мэд. Бүр асуудал нь ноцтой байгаад байхад. Тэгээд ямар хүмүүс нь ингэж шүүх дээрээ илүү юм байгаад байдаг юм.

Тэгэхээр энэ шүүх засаглал маань мөнгөний өмнө яагаад ингэж өвдөг сөхрөөд байна? Энэ авлигад өртөмтгий учраас ингээд байна уу? Эсвэл улс төрийн нөлөөлөл их байгаад байна уу? Би гурван нэр дэвшиж орж ирж байгаа хүмүүсээс энд хариулт өгөөч гэж хэлмээр байна. Ганцхан кэйсийг жишээ болгоод хэлж байгаа юм шүү.

Гэтэл энэ маш олон хүнийг хохироогоод байна. Өнөөдөр ингээд Чингэлтэй дүүрэг жишээлбэл телевиз хавийн тэр газрыг тэр чигээр нь нөгөө дахин төлөвлөлтөд орно гээд авчихсан. Тэгээд өнөөдөр нэг ч ажил хийгээгүй. Иргэд тэнд бухимдаад. Үүнийг цуцлаад өгөөч гэдэг. Тэгээд яасан. Шүүх дээр дандаа гацдаг. Эсвэл шүүх дээр нөгөөдөх нь бүр олон зөрчил гаргачихсан энэ компанийн талд гараад өнөөдөр хүртэл яваад байдаг. Хаана байна нөгөө шударга ёс. Тийм ээ. Уг нь шударга ёсыг тогтоох хүмүүс маань та нар шүү дээ.

Тэгээд иймэрхүү зөрчлүүд их байгаад байгаа юм. Тэгээд энэ дээр би эхлээд хариулт авъя гэж бодож байна. Тэр саяын боловсон хүчин, сонгон шалгаруулалттай холбоотой асуудал дээр Д.Зүмбэрэллхам дарга та маш тодорхой, үнэн зөв хариулт өгөөрэй. Танд бас улс төрийн нөлөөлөл орсон уу, үгүй юу? Та түрүүн ямар ч нөлөөлөл ороогүй гээд хэлж байна лээ л дээ.

Гэхдээ үнэхээр шалгараад гараад ирсэн бол дэмжиж байна.

С.Одонтуяа: Д.Зүмбэрэллхам дарга хариулахдаа М.Оюунчимэг гишүүний асуулт. Түрүүн уучлаарай

Б.Энхбаяр гишүүн бас танаас сонгон шалгаруулалтын талаар асуусан.

Мөн Мэдээлэл, технологийн даргын талаар асуусан. Та энэ асуултуудад дэлгэрэнгүй хариулаад дараа нь нэр дэвшигчид хариулъя.

83 дугаар микрофон.
Д.Зүмбэрэлхам дарга.

Д.Зүмбэрэлхам: Түрүүн Б.Энхбаяр гишүүний асуултад би хариулах байсан юм. Тэгээд М.Оюунчимэг гишүүн бас дахиад давтаад асуусан учраас би хамт хариулчихъя.

Мэдээлэл, технологийн газар гэж байгаа юм. Манайд. Шүүхийн ерөнхий зөвлөлд. Тэгээд энэ Мэдээлэл, технологийн дарга нь одоо бол Д.Хатанболд гэж хүн байгаа.

Энэ Д.Хатанболд нэлээд эрт томилогдсон байх. Манай ажлын алба томилсон. Энэ бүх сонгон шалгаруулалтын үед л энэ хүн байсан. Ерөнхийдөө сүүлд явагдсан.

Одоо бид бүрдээд гурван удаа сонгон шалгаруулалт явагдаж байна. Гурван удаад гурвууланд нь байсан байх. Яг одоо энэ шалгалтын өмнө тэр Ай Ти-гийн хариуцсан дарга солигдсон гэдэг бол энэ үндэсгүй. Тийм юм болоогүй. Үндэсгүй ч юу байх вэ. Ер нь тийм юм болоогүй. Ямар нэгэн хүн энэ дээр солигдоогүй гэдгийг би баталгаатай хэлье. Нэгд.

Хоёрт, бид нарын энэ сонгон шалгаруулалтын оноо Ай Ти-гээс шалтгаалж өөрчлөгдөх боломжгүйгээр бид зохион байгуулж байгаа гэдгийг хэлье.

Гуравт нь, бид нарын сонгон шалгаруулалт онолын мэдлэг, ёс зүй, зан төлөвийн шалгалт. Тэгээд ур чадварын шалгалт, яг практик, кэйсийг шийдэж байгаа асуудал энэ тэр гээд ер нь шүүгчийг сонгон шалгаруулж, яг өөрийнх нь үнэлэмжээр дээр доор нь эрэмбэлж, юугаар нь эрэмбэлж болох юм гэдэг хууль дээр заасан бүх шалгуураар нь шалгаж байгаа.

Тийм учраас өнөөдрийн Та бүхэнд танилцуулж байгаа энэ гурван нэр дэвшигч хуульд заасан бүх шалгууруудаар оноожуулаад, яг эрэмбээрээ гарч ирж байгаа юм гэдгийг би бүр баталгаатай тайлбарлаж хэлье.

Хоёрдугаарт, өнөөдрийн хуульч мэргэжилтэй, эрх зүйч мэргэжилтэй хүний нөөцийн асуудал, өнөөдрийн эрх зүйн боловсролын тогтолцоо өнөөдөр манайд ямар байгаа вэ, яаж явж ирсэн яг тэр хүрээнд л байгаа. Яг тэр хүрээнд л байгаа.

Тэгээд улсын сургууль, хувийн сургууль энэ тэр ингээд хувийн хэвшлийн боловсролын сургуулиудыг дээр доор нь оруулж, МУИС-ийнх дээр бол 3 оноо илүү тавья. Дараа нь хувийн сургууль төгссөн бол 1 оноо тавья ч гэдэг юм уу тэгж үзэх ерөөсөө боломж байхгүй.

Өнөөдөр их сургууль их сургуулиараа, дээд сургууль бол дээд сургуулиараа ижил тэнцүү эрхтэй. Яах вэ, одоо ингээд хүмүүсийн үнэлэмжээр янз бүр байдаг байж болох байх. Бид тэгж үнэлэх боломж байхгүй учраас бүх л дээд сургууль, их сургууль төгссөн тэр үнэлэмжүүдийг тэнцүү авч үздэг гэдгийг би тайлбарлаж хэлье гэж бодож байна. Баярлалаа.

С.Одонтуяа: Одоо нэр дэвшигч Нэргүйн Батчимэг хариулъя.

Д.Зүмбэрэллхам: Би нэг зүйл дээр нэмээд хэлчих үү. Түрүүн олон дахиж гарч ирсэн учраас. Тэр хэргийг их олон удаа хойшлуулдаг гэдэг дээр манай шүүгч гишүүд тайлбарлаад л байна. Үндэслэл байдаг юм шиг байна.

Ер нь би процессын багш хүний хувьд энэ ер нь энэ процессын хуулиудад л ер нь шалтгаан нь байдаг байх гэж бас бодоод байгаа шүү.

Яагаад гэвэл тэрийг үндэслэлгүйгээр хойшлуулаад, санаатайгаар хэргийг хойшоо хаяад байгаа бол тэр шүүгчийг буруутгаад шийтгэхчиг ерөөсөө маш амархан. Тэр чинь нэг гэмт хэрэг үйлдсэн байна, нэг бол ёс зүй зөрчсөн байна.

Ингээд нэг үндэслэлтэй болоод л тэр чинь хойшоо байгаад. Тэр үндэслэл нь хуульд байдаг учраас тэр одоо ямар нэгэн шалтгаан гарч ирэхээр хойшлуулахаас өөр арга замгүй байдалтай. Тийм байдлаар хуульчилчихсан тийм байж магадгүй учраас энэ дээр.../минут дуусав/

С.Одонтуяа: Одоо нэр дэвшигч Нэргүйн Батчимэг хариулъя.

Н.Батчимэг: М.Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

М.Оюунчимэг гишүүн энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа, хэргийн энэ хугацаа удаашруулж байгаа асуудлын шалтгаан, нөхцөлийн талаар ярьж байна. Түрүүн би Ц.Идэрбат гишүүний асуултад хариулахдаа энэ хугацааны талаарх

хуулийн зохицуулалт, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын талаар мөн товч хэлсэн.

Ер нь иргэний хэргийг 60 хоногийн дотор шийдвэрлэх ёстой. Энэ хугацааг шүүгчдийн зөвлөгөөнөөр тодорхой үндэслэл байвал нэг удаа 30 хоногоор сунгах ийм хугацааны зохицуулалтууд байгаад байгаа. Энэ хугацаанаас хэтрүүлж хэрэг хянан шийдвэрлэж байгаа нь шүүх хуулийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг явуулах ёстой.

Шүүх, шүүгчээс шалтгаалж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хугацаа удаашрах ёсгүй гэдэг дээр би саналаа, өөрийнхөө тайлбараа хэлж байна.

Тодорхой яг тэр нөгөө асуусан хэргийн талаар бол ёс зүйн шаардлагын үүднээс хэлэх боломжгүй байгаа. Тэгээд яг шийдвэрлэсэн шүүгч нь биш учраас хугацаа сунгасан, хугацаа удааширсан шалтгаан нөхцөлийнх нь талаар мэдээлэл байхгүй байна. Тийм.

С.Одонтуяа: Одоо Бадамдоогийн Ганболд нэр дэвшигч Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Хариулсан хүмүүс микрофоноо унтраачихаарай.

Б.Ганболд: Асуулт асуусан явдалд баярлалаа. М.Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

Миний хувьд шүүн таслах ажиллагаа эрхлээгүй учраас өнгө мөнгө, улс төрийн нөлөө, шүүн таслах ажиллагаанд хэрхэн яаж байгаа талаар тодорхой хэлж чадахгүй байна.

Өмгөөллийн үйл ажиллагаа хийж байх явцад үйлчлүүлэгч нар багшлах

ажиллагаа хийж байх явцад багш нар оюутнууд иймэрхүү асуудлыг асууж бид тодорхой кэйс дээр яах вэ гэхээрээ ярилцдаг ийм талууд байдаг байсан.

Улс төрийн нөлөөнд автахгүй байх, өнгө мөнгөний нөлөөнд орохгүй байх гэдэг шүүгч хүний хувьд зайлшгүй баримтлах ёстой асуудал.

Тийм учраас хэрэв би Улсын дээд шүүхийн шүүгчээр томилогдвол энэ байдал дээр онцгой анхаарч ажиллана. Итгэлтэй байж болно гэж танд хэлмээр байна. Баярлалаа.

С.Одонтуяа: Одоо Мөнхөөгийн Пүрэвсүрэн нэр дэвшигч хариулья.

М.Пүрэвсүрэн: М.Оюунчимэг гишүүний асуултад хариулья.

Гишүүн тодорхой нэг тохиолдол дээр жишээ татаж хэргийн хугацаа алддаг, хуралдаан хойшлуулдаг, шүүх хуралдаан удаа дараа хойшилдог энэ асуудлыг хөндөж байна.

Тэгэхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа сунжрах, шүүх хуралдаан удаа дараа хойшлох энэ асуудлууд бол хүний шударгаар шүүлгэх эрхийг зөрчсөн зөрчил юм.

Тэгэхээр би түрүүн гишүүний асуултад хариулахдаа энэ зөрчлийг яаж багасгах вэ, хууль зүйн ямар боломж байна вэ гэдэг талаар тодорхой хариулчихсан байгаа. Яг тэр тодорхой жишээн дээр ёс зүйн хувьд хариулт өгөх боломжгүй байна. Баярлалаа.

С.Одонтуяа: Одоо Даваажанцангийн Сарангэрэл гишүүн асуулт асууя.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Нэргүй овогтой Батчимэг, Бадамдоо овогтой Ганболд, Мөнхөө овогтой Пүрэвсүрэн нарын намтар, ажилласан байдлын мэдээллийг энэ танилцуулгаас авсан.

Энэ гурван хүн бол гурвуулаа сонгон шалгаруулалтад орсон. Дээгүүр оноо авсан. Нийтийн сонголд мөн оролцсон. Тэр үед янз бүрийн сөрөг мэдээлэл ирээгүй. Хууль зүйн байнгын хороогоор дэмжигдээд нэр дэвшээд орж ирж байгаа гурван нэр дэвшигч байна.

Манай зарим гишүүдийн зүгээс бас би болгоомжгүй үг хэллэг хэрэглэж байна гэж бодож байна. Тэр дотоод гадаад, хувь хувьсгалын сургуулийн ийм ялгаварлан гадуурхалт гаргаж болохгүй. Би Д.Зүмбэрэлхам даргын хэлж байгаатай санал нэг байна.

Түүнээс гадна нэг аймгаас хальж үзээгүй хүн байна, хаана ажиллаж байгаа нь мэдэгдэхгүй гэх мэтчилэнгийн ийм болгоомжгүй үг мэдээллийг олон нийтэд өгөх нь би буруу гэж бодож байна. Яагаад гэвэл энэ намтрыг уншихад манай гурван нэр дэвшигч төрд хорь гаруй жил ажиллачихсан, хорь хүртэл жил ажиллачихсан. Ялангуяа салбартаа 16-аас 24 жил ажилласан ийм гурван нэр дэвшигч байна. Ялангуяа Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчдэд тавих шалгууруудыг гурвуулаа биелүүлсэн байна.

Тийм учраас энэ хүмүүс тэр Дээд шүүхийн шүүгчээр томилогдоод шийдвэр гаргана. Иргэдийн зүгээс хүндэтгэлгүй хандах, шийдвэрт нь эргэлзэх ийм мэдээллийг намтар, ажилласан байдалтай нь гүйцэд

танилцалгүйгээр ийм мэдээлэл өгөх нь би буруу гэж ингэж үзэж байгаа юм.

Тийм учраас би тухайлбал та гурвынхаа энэ намтар, ажилласан байдлыг хараад, танилцаад, ямар ч байсан энэ шүүхийн салбарт нэлээн шинэчлэл авчрах, салхи оруулах ид насны ийм гурван залуу орж ирж байгаа юм байна. Өөрчлөлтөд өөрсдийнхөө хувь нэмрийг оруулах байх гэж ингэж итгэж байна.

Манай Н.Батчимэг нэр дэвшигчийн хувьд Дорноговь аймагт анхан шатны шүүгчээс авхуулаад ажиллачихсан. Өнөөдрийн түвшинд хүрсэн их туршлагатай ийм шүүгч байна. Нөгөө хоёрыг нь ч гэсэн би дутуу үнэлэх юм алга.

Тийм учраас бид энэ гурван нэр дэвшигчээ сайхан дэмжээд, харин хамгийн гол нь би өөрийнхөө зүгээс энэ иргэд шүүхэд итгэхгүй байгаа, шүүх чирэгдэлтэй байгаа, асуудалд удаан хандаж байгаа, цаг хугацаа алдаж байгаа энэ гол зүйлүүдэд анхаарлаа хандуулаад тодорхой хэмжээний өөрчлөлтүүд хийгээд дараа нь Их Хурал дээр орж ирэх ийм боломжууд Та бүхэн гарна байх.

Тэгэхэд энэ зүйлүүдээ хийгээд сууж байх тэр сайхан өдөр ирнэ байх гэж ингэж бодож гурван нэр дэвшигчдээ амжилт хүсэж байна. Та бүхэн маань шүүхийн шинэчлэлд хувь нэмэр оруулах, энэ салбарт олон жил ажилласан ийм гурван нэр дэвшигч байна гэж бүрэн дүүрэн дэмжиж байгаагаа илэрхийлж байна. Амжилт хүсье. Залуусаа.

С.Одонтуяа: Баярлалаа. Д.Сарангэрэл гишүүн нэр дэвшигчдэд амжилт хүсэж дэмжсэн үг хэллээ.

Одоо Шатарбалын Раднаасэд гишүүн асуултаа асууя.

Ш.Раднаасэд: Би нэр дэвшигч нартай холбоотой ярих юм алга. Тэгээд шалгуураараа шалгагдаад гарч ирж байгаа байлгүй.

Ерөнхий зөвлөлд хэлэхэд. Одоо дахиж шүүгчээр 10-аас доош жил ажиллаагүй хүн Дээд шүүх рүү орж ирэх зайгүй болж байгаа шүү.

Нийт Дээд шүүхийн шүүх бүрэлдэхүүний гуравны хоёроос гуравны нэг нь багш болон өмгөөлөгчөөр ажиллаж байсан хүмүүс байж болохоор заасан.

Өнөөдөр томилогдож байгаа хэн билээ? Б.Ганболд билүү. Б.Ганболдоор ингээд 8 дахь хүн чинь дуусаж байгаа. Үүнийг та баримтлах ёстой болов уу гэж бодож байна.

Хоёр дахь юм нь. Өмнөх юугаар би бас ярьж байсан. Дээд шүүхийн юун дээр. Энэ 55 нас хүрсэн, 30-аас доошгүй жил шүүгчээр ажилласан энэ тэтгэвэрт гарах хүмүүсээ яагаад гаргахгүй байлгаад байгаа юм бэ? Д.Зүмбэрэлхам дарга аа.

Энэ хүмүүсээ тэтгэвэрт нь гаргаад энэ шүүхийн хуулийг анх хийхэд чинь ерөөсөө л энэ бугширсан юмыг чинь өөрчлөхийн тулд шинэчлэл хөдөлгөөн цус сэлгэдэг энэ байдлыг нь зайлшгүй хийе. Тэр хараат бус байдлыг нь хангуулъя. Ашиг сонирхлын зөрчилтэй байдлыг нь болиулъя.

Мэдүүлэг өгдөг больё. Ашиг сонирхлын.

Энд тэнд уулзсан ч гэсэн ийм хүнтэй уулзлаа шүү гэж мэдэгддэг байя. Үүнийг нь ёс зүйтэй нь уяж, энэ ажлын хариуцлагатай нь уясан. Өөрөө шүүгч, нөхөр нь өмгөөлөгч, хүүхэд нь прокурор ч гэдэг юм уу ингээд нэг ийм байдлыг чинь засах гэж л энэ рүү явсан шүү дээ. Энэ байдал ч өнөөдөр засрахгүй ингээд хууль нэг жилийн хугацаанд явж байна. Одоо хорь гаруй шүүгч нар байх ёстой. Ажиллаж л байгаа. Үүнийг яагаад санаачлагч та нар хийхгүй байгаа юм.

Хоёрдугаарт, цаашдаа энэ нэр дэвшигчтэй холбоотой танилцуулга хуудсан дээр чинь нэг зүйлийг та нар орхиод байх юм. Энэ санаатай орхиод байдаг юм уу. Энэ өөрөө их субъектив л дээ. Мэдлэг чадвар, ёс зүй гэдэг юм 31.1 гээд дөрөв, таван шалгуур байгаа. Тэрний дөрвөн шалгуурыг нь ингээд хангаж байгаа. Одоо эрүүл байна. Яг нэг бүрчлэн бичиж байгаа байхгүй юу. Эрүүл байна. Сэтгэцийн хувьд эрүүл байна. Мэргэжлээрээ тэдэн жил ажилласан байна. Хуульчийн мэргэжлийн гэрчилгээтэй юу, зөвшөөрөлтэй юу гээд.

Яг ингээд л бид дарааллаар нь бичиж явж байгаад л тэр мэдлэг чадвар, ёс зүй гэдэг юман дээр нь аваачаад ямар ч юмгүй хаячих юм. Энэ чинь их субъектив явагдаж байгаа юм байна гэж би ойлголоо. Танай комисс дээр энэ үнэлгээ гаргахдаа.

Энэ чинь эргээд гомдол гарвал бас гаргах юм байна шүү. Хүмүүс.

Бас нэг зүйл. Энэ шүүгчдийнхээ байрыг яах гэж байгаа юм? Энэ шүүх хурал, шүүхүүдийн байрыг. Одоо

түрээсийн байранд байгаа хоёр ч шүүх байгаа. Дархан лав гадаадын байгууллагын байр түрээсэлдэг. Тэр Баянзүрхийн шүүх чинь бас нэг хувийн компанийн байр түрээсэлж байгаа байх.

Энэ хойно бид нөгөө шүүхийн хууль хийж байхад очиж үзсэн юм. Сүхбаатар дүүргийн шүүх ч тэр шүүх хуралдааны танхим, одоо тэгээд л ер нь ерөнхийдөө тэр дотор яаж шүүх хуралдаан явуулах юм гэмээр л юм байна лээ шүү дээ. Өөд өөдөөс нь нүд нүд рүү нь харуулж суулгаж байгаад л чичлээд ширтээд л, хүчээр тулгаад тулгаад л ял өгчихөөр.

Энэ дээр ерөөсөө Шүүхийн ерөнхий зөвлөл дээр санаачилга юм харагдахгүй байна. Гарч дуугарч байгаа юм алга байна. Ярьж байгаа юм алга байна. Үндсэн ажил нэг хэдэн шүүгч нар сонгон шалгаруулдаг ийм ажил болчихсон. Шүүгчдийн хараат бус байх шүүх хуралдаанаас л эхэлнэ шүү дээ. Энэ шүүх хуралдаанд хэргийн оролцогч нар. Прокурор нь урдаас нь харж улаан нүүрэнд нь бараг тулаад нэг метр хүрэхгүй зай нь суучихсан гэх мэтчилэн энэ байр байдлынхаа юмнууд.../минут дуусав/

С.Одонтуяа: Эхлээд Д.Зүмбэрэллхам дарга хариулах уу?

Д.Зүмбэрэллхам: Ш.Раднаасэд гишүүний асуултад хариулья.

Дээд шүүхийн гуравны нэг гэдэг дээр санал нэг байгаа. Тэгээд бид үүнийг судалж, Дээд шүүх дээр сонгон шалгаруулалт явуулахад үүнийг зайлшгүй судалж байж юу яах ёстой юм билээ. Зүгээр нэг асуудал дээр. Одоо ингээд шүүгчээр ажилласан жилүүдийг нь оруулахаар нөгөө шүүгч бусаар яасан

юу нь бол ингээд шилжиж тооцогдох уу, үгүй юу гэдэг дээр бид жоохон яаж л байгаа. Энэ бол яах вэ дотооддоо шийдэх асуудал. Тэгээд энэ анхаарлын төвд байгаа. Ш.Раднаасэд гишүүнтэй санал нэг байгаа.

Хоёр дахь асуудал, 55 нас хүрсэн, 30 жил шүүгчээр ажилласан хүнийг тэтгэвэр тогтоолгох асуудлаар Улсын дээд шүүхэд тайлбар гаргуулахаар хүсэлт тавьчихсан байгаа.

Тэгээд тайлбар гаргуулах шалтгаан байгаа юм. Би энэ түрүүчийн нэр дэвшигчдийг оруулж ирэхдээ би энэ талаар ямар шалтгаан байгаа вэ гэдгийг бүр нэг, хоёр, гурав гэж байгаад хэлж байсан. Тэгээд үнэхээр нэг юу яачихаад хүний хувь заяатай холбоотой, ажил төрөлтэй нь холбоотой, баталгаатай нь холбоотой асуудал учраас Дээд шүүхээс тайлбар гаргуулах шаардлага байна гэж үзсэн. Тэгээд Дээд шүүх үүгээр тайлбар гаргаж гаргаж өгөх байх. Тэгээд тайлбар ирэхээр хэрэгжүүлнэ.

Гуравдугаарт, тэр мэдлэг чадвар, ёс зүйн асуудлыг сая танилцуулга, энэ танилцуулгад оруулаагүй нь дутагдалтай болсон байна. Би үүнийг хүлээж авлаа. Дараачийн танилцуулга дээр оруулж ирнэ ээ.

Ер нь мэдлэг чадвар, ёс зүйн юу чинь тус тусдаа оноогдсон шалгалттай шүү дээ. Тэгээд энэ дээр сая танилцуулаагүй нь бол дутуу болсон байна. Би үүнийг дараа нөхөж, дараачийн юун дээр анхаарч оруулж ирж танилцуулж байя гэж.

Дараачийн юун дээр бол тэр шүүгчийн байрны асуудал үнэхээр бид нарын юунаас хэтийдсэн асуудал байна. Түрээсийн байр бүр гадаадын

өмчлөлтэй байр хүртэл байранд сууж байгаа юу байна. Бусад байгууллагатай хамт ажиллаж байгаа шүүх байна. Шүүхийн огт байргүй шүүхүүд байна. Бүр ашиглаж болохгүй гээд ингээд мэргэжлийн байгууллагаас дүгнэлт гаргачихсан байранд ажиллаж байгаа шүүхүүд байна. Ашиглаж болдог байранд ажиллаж байгаа нь үнэхээр шүүхийн стандарт хангахгүй ийм байранд ажиллаж байна. Үүнийг би олон удаагийн ярилцлагад байж байсан. Одоо ингээд бүх л түвшинд үүнийг танилцуулж байгаа.

Сая ялангуяа Улсын Их Хурал, Засгийн газар одоо энэ саяын төсвийн үеэр энэ бүх асуудлаа тавьсан. Хөрөнгө оруулалтын асуудлыг тэг байна. Улсын хэмжээнд ийм байгаа гээд ингээд шийдэж өгөөгүй. Шийдээгүй. Хөрөнгө оруулалт энэ жил төсөвт ерөөсөө хөрөнгө оруулалт байхгүй. Энэ асуудлаар яаж шийдэх вэ гэдэг асуудал дээр Засгийн газрын оролцоогүйгээр шийдэж чадахгүй. Хууль зүйн сайдтай саяхан манай Шүүхийн ерөнхий зөвлөл бүрэн бүрэлдэхүүнээрээ уулзалт хийж, ер нь шүүх дээр одоо ингээд ахуйн нөхцөл хангах талаар ямар асуудал байгаа юм. Засгийн газраас ямар дэмжлэг авах шаардлагатай байгаа юм гэдэг талаар бид их тийм илэн далангүй уулзалт, ярилцлага болсон. Энэ чиглэлээр бас тодорхой нөхцөл байдалд нь тохирсон тодорхой алхам, гарц хайя гэдэг дээр тохирсон байгаа. Энэ чиглэлээр ажиллаж байгаа гэдгийг би илтгэж хэлье гэж бодож байна. Баярлалаа.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ ёс зүйн асуудал бол бас хамгийн чухал асуудлын нэг. Тэгээд үүнийг энэ удаа орхигдуулсан байна гэж та хэлж байна. Үүнийг дараагийн удаа зайлшгүй

оруулж бичих ёстой зүйл заалтаа гээд Ш.Раднаасэд гишүүнтэй санал нэг байна.

Одоо Ширнэнбаньдийн Адьшаа гишүүн асуулт асууя.

Ш.Адьшаа: Нэр дэвшигч нартай холбогдуулж асуух асуулт байхгүй.

Тэгэхдээ би дээд шүүгчдийн томилгооны асуудалтай холбогдуулж бас хууль тогтоогчийн хувьд байр сууриа илэрхийлье гэж бодож байна.

Тэр Дээд шүүхийн Д.Зүмбэрэлхам дарга бас сайн дүгнэлт хийгээрэй. Та их хариуцлагагүй л юм ярьж байх шиг байна. Тэр Дээд шүүхийн шүүгчдийн насны асуудлаар тэтгэвэрт гарах асуудлаар Дээд шүүх тайлбар гаргана гэдэг чинь юу гэсэн үг юм. Өөрийнхөө ашиг сонирхолтой юм дээр ингэж тайлбар гаргана гэж ийм байдлаар хандаж болохгүй шүү.

Хууль дээдлэх зарчим гэж өнөөдрийн энэ шүүх эрх мэдлийн байгууллагад зайлшгүй байх ёстой.

Энэ нэр дэвшигчид өнөөдөр орж ирсэн. Бид бас сонсгол хийсэн. Ялангуяа энэ өмгөөлөгч орж ирсэн асуудал зөв зүйтэй гэж бодож байгаа. Бид өнөөдөр шүүхийг бие даасан байлгах, шударга байлгах, хараат бус байлгах гэдэг бүх боломжийг эрж хайх ёстой.

Б.Ганболдын тухайд сайн өмгөөлөгч, сайн хуульч гэдгийг бид танилцуулгаас нь харсан. Ингэж салхи оруулахгүй бол системээ хамгаалдаг, багаа хамгаалдаг хонгилын шүүх гэдэг юм чинь үргэлжилж байгаа. Нуух юм бол байхгүй. Улс төрийн захиалгаар, эрх

баригчдын захиалгаар, аливаа бүлэглэлийн захиалгаар гэмт хэрэг, маргааныг шийддэг энэ үйл явдлууд үргэлжилж байгаа шүү. Ард түмэн сохор биш. Үүнийг харж байгаа.

Дээр нь өнөөдөр тогтолцооны хувьд бид Шүүх эрх мэдлийг бие даасан байлгах, хараат байх гэдэг дээр үндэслэж Үндсэн хуулийн 2019 оны өөрчлөлтийн дагуу Улсын Их Хурал Шүүхийн тухай хуулийг байгуулсан. Ерөнхийлөгчийн эрх мэдлийг хумина гэдэг нэрийдлийн доор энэ хуулийг үндсэн зарчмаасаа хазайсан ийм хууль баталсан гэдэг дээр би эргэлзэхгүй байгаа.

Шүүх бие даасан шүүх хараат байх гэдэг энэ зарчим энэ шүүхийн хуулийн дагуу алдагдсан гэж ойлгож явдаг. Хууль тогтоох эрх мэдлийн харьяанд шүүх эрх мэдлийг авч ирсэн.

Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн сахилгын хороо гэдэг Үндсэн хуулийн бүтцийн байгууллагыг 9 гишүүний сонгон шалгаруулах асуудлыг Улсын Их Хурлын нэг гишүүн ахалж хийж байгаа. Улсын Их Хурал гэдэг бол хууль баталдаг, хуулийн хэрэгжилтэд хяналт тавьдаг ийм үндсэн үүрэгтэй. Хүн томилдог, сонгон шалгаруулдаг ийм өөрийн үндсэн бүрэн эрхэд байхгүй асуудал. Гэтэл өнөөдөр шүүх эрх мэдлийн боловсон хүчний нь шийддэг Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүгчтэй хариуцлага тооцдог Шүүхийн сахилгын хороог Улсын Их Хурлын нэг гишүүн ахлаад, нам, эвслийн бүлгүүдээс төлөөлөл оруулаад томилж байгаа. Энэ чинь тухайн эрх барьж байгаа улс төрийн хүчний нөлөөлөл орох хамгийн баталгаатай нотолгоотой үйл явдал шүү. Үүнийг засах ёстой.

Дээр нь өнөөдөр шүүхэд ардчиллыг бий болгоно гэдэг ч юм уу, энэ шүүгч бус гишүүдийг сонгон шалгаруулдаг. Шүүгчдийн төлөөллийг оруулна гэдэг дээр том гажуудал бий болсон. Нийт шүүгчдийн зөвлөгөөнөөс Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг томилж байгаа энэ асуудал өнөөдрийн сонгуулийн асуудал биш.

Хэдийгээр энэ зөв ч гэсэн ийм бодит хөрс бэлтгэгдээгүй байна гэж ойлгож байгаа. Өнөөдөр нийт шүүгчдийн.../минут дуусав/

С.Одонтуяа: Санал хэллээ гэж ойлгосон. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Улсын Их Хурал, Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй танилцлаа.

Дэгийн тухай хуулийн дагуу санал хураалт байхгүй.

Үдээс өмнөх хуралдаан үүгээр өндөрлөж байна. Үдээс хойш Ерөнхий сайдын мэдээлэл. Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл явагдана. Гишүүд үдээс хойших хуралдаандаа идэвхтэй оролцоорой.

Нэр дэвшигчдэд баярлалаа.

ЗАВСАРЛАГА

Дөрөв.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл: Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Эрчим хүчний зорилт болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан томоохон төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, тулгамдаж байгаа асуудлын талаар

Г.Занданшатар: Ерөнхий сайдын мэдээлэл.

Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын эрчим хүчний зорилт болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан томоохон төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, тулгамдаж байгаа асуудлын талаар Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн мэдээлэл хийнэ.

Хэлэлцэх асуудалд орьё. Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын эрчим хүчний зорилт болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан

томоохон төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, тулгамдаж байгаа асуудлын талаар Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн мэдээлэл хийнэ. Индэрт урьж байна.

Б.Чойжилсүрэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газраас Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд хийх ээлжит мэдээллийг эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын зорилт, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан томоохон төсөл, арга хэмжээний талаар мэдээлэл хийхээр бэлтгэж, холбогдох

мэдээллийг гишүүд Та бүхэнд урьдчилан хүргүүлсэн.

Улс орны хөгжил, эдийн засагт тэргүүлэх ач холбогдолтой эрчим хүчний томоохон төсөл, хөтөлбөрүүдийг Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогуудад тусгуулан ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем төвийн, өмнөд, баруун, Дорнод, Алтай, Улиастайн гэсэн 5 хэсгээс бүрдэж, Монгол Улсын нийт 330 гаруй сум, суурин газруудыг эрчим хүчээр хангаж байна.

Сүүлийн хэд хоногт хасах 30 градус давж хүйтэрсэн өдрүүдэд, тухайлбал, 11 дүгээр сарын 29-ний өдрийн 19.00 цагт төвийн бүсийн нэгдсэн сүлжээний оргил ачаалал 1441 мегаватт хүрлээ. Энэ нь өнгөрсөн оны хамгийн их ачааллаас 54 мегаваттаар буюу 4 хувь, өнгөрсөн оны мөн үеийнхээс 134 мегаватаар буюу 10 хувиар их байна.

Энэ оргил ачааллыг эрчим хүчний салбар суурилагдсан бүрэн хүчин чадлаараа нөөц дутагдалгүй ажиллаж, дээр нь Оросын Холбооны Улсаас 270 мегаваттын импортын цахилгаан эрчим хүч авч байж давлаа. Өөрөөр хэлбэл, 4 жилийн хугацаанд дулааны III цахилгаан станц, Дарханы дулааны цахилгаан станцуудын суурилагдсан хүчин чадлын нийлбэрээс ч өндөр давсан ачаалал нэмэгджээ.

Сүүлийн жилүүдийн оргил ачааллыг давахад дулааны IV цахилгаан станцын 89 мегаватт, Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын 35 мегаватт, Дарханы дулааны цахилгаан

станцын 35 мегаваттын өргөтгөлүүд ашиглалтад орсон нь ихээхэн үүрэг гүйцэтгэж байна.

Монгол Улсын хэмжээнд 2022 оны эхний 9 сарын байдлаар 7.1 тэрбум киловатт цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, 6.5 тэрбум киловатт цаг цахилгаан эрчим хүчийг түгээсэн байна.

Нийт түгээс нь цахилгаан эрчим хүчний 76.9 хувийг дотоодын эх үүсвэрүүдээс, 23.1 хувийг импортын цахилгаан эрчим хүчээр тус тус хангасан байна.

Импортын цахилгаан эрчим хүчний 457.9 сая киловатт цаг буюу 29.3 хувийг Оросын Холбооны Улсаас, 1101.9 сая киловатт цаг буюу 70.7 хувийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас импортолжээ.

Монгол Улсын хэмжээнд цахилгаан эрчим хүчний хэрэглээ сүүлийн жилүүдэд дунджаар 7-гоос 8 хувиар өсөж, дотоодын эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ жилд дунджаар 7-гоос 8 хувь хувь өсөх шаардлагатай байна.

Өвлийн их ачааллын горим ажиллагааны үед дулааны цахилгаан станцууд нь бэлтгэл тоноглолгүйгээр бүрэн хүчин чадлаараа ажиллах ба Оросын Холбооны Улсаас авах импортын шугамын дамжуулах чадал 345 мегаваттаар хязгаарлагдах тул дотоодын цахилгаан станцуудын үндсэн тоноглолын болзошгүй гэнэтийн зогсолт, тасралт саатлын үед тухайн нэгж тоноглолын хүчин чадлаар хэрэглэгчдийг хязгаарлах техникийн арга хэмжээ авахаар төлөвлөсөн.

Сүүлийн гурван жилийн хугацаанд үнэ тарифт өөрчлөлт оруулалгүй тогтвортой мөрдөж ирсний улмаас 2019 онд 59 тэрбум төгрөг, 2020 онд 92 тэрбум төгрөг, 2021 онд 78 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж, 2022 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 168.2 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны алдагдалтай ажиллахаар байна.

Мөн төвийн бүсийн дулааны цахилгаан станцуудад нүүрс нийлүүлдэг уурхайнууд энэ онд 109.2 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллах урьдчилсан тооцоо гарлаа.

Хэрэглэгчдийн цахилгаан, дулааны тариф бодит өртгөөс доогуур байгаатай холбоотойгоор эрчим хүчний компаниудын нүүрсний уурхай болон бэлтгэн нийлүүлэгч банкны богино хугацаат зээл, зээлийн хүүгийн өглөг, авлага нэмэгдэж байна.

Мөн түүнчлэн дулааны цахилгаан станц, цахилгаан, дулаан дамжуулах, түгээх, хангах компаниуд хөрөнгийн дутагдлаас шалтгаалж техникийн засвар үйлчилгээг цаг тухайд нь хийгдэхгүй байх нь насжилт өндөртэй, хуучин тоноглол бүхий үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд гэнэтийн аваар саатал гарах эрсдэлийг нэмэгдүүлж, хэрэглэгчдийг эрчим хүчний тасралтгүй, найдвартай байдлыг хангахад хүндрэл үүсэх магадлалтай байна.

Монгол Улсын цахилгаан эрчим хүчний үнийг гадаад орнуудын үнэтэй харьцуулахад хөрш орнууд болох Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын цахилгааны үнээс 2 дахин, бусад

хөгжилтэй орнуудаас 4-өөс 5 дахин хямдхан байна.

Эрхэм гишүүд ээ,

Эрчим хүчний салбарт сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин чадал 280 мегаватт буюу нийт суурилагдсан хүчин чадлын 18.3 хувийг эзэлж байна.

Өнөөгийн байдлаар нарны эх үүсвэрээс үйлдвэрлэсэн 1 киловатт цаг эрчим хүчийг 15 доллар центээр, салхины эх үүсвэрээс 9.5 доллар центээр тус тус нэгдсэн сүлжээнд нийлүүлэн авч байгаа нь дулааны цахилгаан станцуудын 2.5 доллар центийн өөрийн өртгөөс даруй 3-аас 5 дахин өндөр байгаа ба хэрэглэгчдийн тарифт 1 киловатт цаг тутамд 23.7 төгрөгийн сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тарифыг нэмж байна.

Тусгай зөвшөөрлөө сунгуулсан 11 нар, салхины эх үүсвэр шинээр ашиглалтад орсон тохиолдолд дэмжих тарифыг 23.79 төгрөгөөс 2.1 дахин нэмэгдүүлж 57.39 төгрөг болгох ба ингэснээр салбарын нийт орлогын 44 хувийг сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгчдэд хуваарилах урьдчилсан тооцоо гарсан байна.

Дэлхий дахинаа техник, технологи хөгжих хэрээр нар, салхины эх үүсвэрүүдийн үндсэн тоноглолуудын үнэ өртөг буурч, сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохион байгуулснаар зардлыг бууруулах боломж бүрдсэн. Тухайлбал, Монгол орны байгаль, цаг уур, газар зүйн байршлын хувьд ойролцоо Узбекистан Улсад 100

мегаваттын хүчин чадалтай нарны цахилгаан станцын төсөл хэрэгжүүлэгчийг өрсөлдөөний үндсэн дээр сонгон шалгаруулж, нэгдсэн сүлжээнд нийлүүлэх тарифыг 2.7 доллар цент болгон бууруулж чадсан байна.

Эрхэм гишүүд ээ,

Эрчим хүчний салбарт хэрэгжиж буй томоохон төсөл, арга хэмжээнүүдийн талаар товч мэдээлэл хийе.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан томоохон бүтээн байгуулалтын төслүүдийг “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгаж, эрчим хүчний талаар 5 зорилтын хүрээнд 13 арга хэмжээ, 22 хөгжлийн төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд эрчим хүчний системийн нийт суурилагдсан хүчин чадлыг 1756 мегаваттаар нэмэгдүүлэх төслүүдийг эхлүүлсэн.

Дулааны цахилгаан станц IV-ийн хүчин чадлыг 46 мегаваттаар, Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 35 мегаваттаар нэмэгдүүлсэн.

Ховд аймгийн Мянгад суманд 10 мегаваттын нарны цахилгаан станц ашиглалтад орлоо.

Дорнодын дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 50 мегаваттаар нэмэгдүүлэх төсөл 2023 онд, Амгалан дулааны станцын хүчин чадлыг 116

мегаваттаар нэмэгдүүлэх төсөл 2024 онд ашиглалтад орно.

Өмнөд бүс Тавантолгойн дулааны цахилгаан станц, Улаанбаатар хотод дулааны III цахилгаан станцыг 300 мегаваттаар өргөтгөх, оргил ачааллын үед ажиллах дулааны тархмал эх үүсвэрүүдийг барих төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай байна.

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар 2015 оны Парисийн хэлэлцээр байгуулагдсантай холбогдуулан барууны улс орнууд олон улсын банк санхүүгийн байгууллагууд нүүрснээс эрчим хүч үйлдвэрлэх төслүүдэд санхүүжилт олгохоос татгалзаж эхэлсэн бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий ассамблейн 76 дугаар чуулган дээр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ерөнхийлөгч Ши Жиньпин Хятад Улс хилийн чанадад нэмж нүүрсний эрчим хүчний шинэ эх үүсвэр барахгүй гэсэн амлалт өгсөн нь дотоодын нүүрсээр ажиллах томоохон цахилгаан станцуудын төслүүдийн санхүүжилтийг шийдвэрлэхэд тодорхой хэмжээний хүндрэл үүсгэж байна.

Төвийн бүсэд Багануурын 400 мегаваттын дулааны цахилгаан станцын концессын гэрээгээр хэрэгжүүлэхээр гэрээнд 2021 онд нэмэлт, өөрчлөлтийг оруулсан.

Концесс эзэмшигчтэй төслийн хэрэгжилтийг нь хангах талд шахаж ажиллах шаардлага гарч байна. Хувийн хөрөнгө оруулалтаар Бөөрөлжүүтийн нүүрсний уурхайг түшиглэн 300 мегаваттын дулааны цахилгаан станцын барилга угсралтын ажил эхэлчихсэн явж байна.

Баруун бүсийн эрчим хүчний хангамжийг сайжруулах, хэрэглээний өсөлтийг хангах зорилгоор Ховд гол дээр Эрдэнэбүрэнгийн 90 мегаваттын усан цахилгаан станцын зураг төслийн ажил хийгдэж байна.

Энэхүү төсөл нь цэвэр усны нөөц, гадаргын усны нөөц харьцангуй багатай, хуурай уур амьсгалтай манай орны хувьд гадаргын ус хуримтлуулах экологийн ач холбогдолтой төсөл болно.

Цахилгаан дамжуулах шугам сүлжээний талаар Та бүхэнд мэдээлэл өгье.

Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастай, Сайншанд-Цагаансуварга, Чойр-Сайншанд, Мандалговь-Арвайхээр, Багануур-Чойр, Багануур-Налайх-Улаанбаатар, Багануур-Чингис-Чойбалсан чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг барихаар “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгасан.

Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээг горим, ажиллагааны хувьд тогтвортой, өөрийгөө зохицуулах чадвар бүхий систем болгон бүрдүүлэх нь салбар салбарын тулгамдсан асуудал болж байна.

Горим тохируулгын эх үүсвэртэй байх нь өдөр шөнийн хэрэглээний горимыг зохицуулж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх төдийгүй дэлхийн хөгжлийн чиг хандлагатай нийцүүлэн сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх юм.

Төвийн бүсэд Эгийн голын усан цахилгаан станцыг барих хэрэгцээ

шаардлага байгаа бөгөөд Байгаль нуурын эко системд нөлөөлөх байдлыг тодорхойлох, биологийн олон янз байдлын нөлөөллийн судалгааны ажил дууссан.

Тайланг Дэлхийн өвийн хорооны хурлаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр төвийн бүсэд 200 мегаватт цаг багтаамжтай цэнэгт хураагуурын төслийг Улаанбаатар хот дахь Сонгино дэд станцын дэргэд барих төслийг амжилттай эхлүүлээд байна.

Энэ онд эрчим хүчний салбарын 100 жилийн ой тохиолдож байгааг энэ дашрамд Та бүхэнд дуулгая.

Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлэх тодорхой төслүүдийн талаар нэмж тодруулах зүйлсийг миний бие болон манай холбогдох албаны хүмүүс хариулахад бэлэн байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Мэдээлэлтэй холбогдуулж цөөнхийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл үг хэлнэ. Индэрт урьж байна.

О.Цогтгэрэл: Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Засгийн газраас урьдын адил олон бэрхшээл асуудлаар дүүрэн уламжлалт нэгэн мэдээллээ нэгдсэн чуулганы хуралдаанд сонсгож байна.

Монголд асуудал дагуулдаг салбар олон бий. Тэр бүхний нэг нь хөгжлийн хөдөлгүүр, зүтгүүр байх ёстой ч одоо хөгжлийг хязгаарлагч, хөгжлийг боомилгогч болж хувирсан эрчим хүчний салбар.

Энерги эрчим хүчний салбар гэдэг бол эдийн засгийн энгийн нэг салбар бас биш ээ. Цахилгаан дулаан, уур ус хангамж гэдэг бол эдийн засгийн хөдөлгөгч үйлдвэрлэл, бизнесийг хөтлөгч, хөгжлийн тухай ойлголт.

30 жилийн өмнө 1990 онд л тог хязгаарлана, цахилгаан таслан гэж яригддаг байлаа. Хөрс хуулалтаа хийж чадаагүй гэнэ. Нүүрсний уурхай. Хөрөнгө оруулалт, техникээ шинэчлэх нь байтугай урсгал засвараа ч хийж амжаагүй байгаа цахилгаан станцын тухай яриа 30 жилийн тэртээ их тод дуулддаг байсан.

Гунигтай нь 30 жилийн дараа ахиад тог хязгаарлах, цахилгаан таслах тухай ярьж эхлэх нь ээ. Бид урагшаа биш арагшаа ухарч байна.

Үйлдвэрлэл эрхлэх гэсэн олон иргэн, аж ахуйн нэгж техникийн нөхцөл боломжгүй гэдэг ганцхан үгээр амаа таглуулдаг болсон. Бизнес эрхлэгчдийн индексээр цахилгаан эрчим хүчний хүрэлцээ гэдэг үзүүлэлтээр 190 орноос 152 дугаар байранд Монгол Улс орж бизнес эрхлэхэд хамгийн ихээр саад болж байгаа үзүүлэлт эрчим хүч болж хувирлаа.

Үнэндээ Улаанбаатарын түгжрэл ч тэр, Улаанбаатарын утаа ч тэр эрчим хүч, дэд бүтэцгүйгээс улсаараа ганц хонхор луу чихэлдсэнээс л үүдэлтэй. Хөдөөг хөгжүүлэх, нэг төвд хотоо задлах, төвлөрлийг бууруулах,

бизнесийг хөгжүүлэх, эдийн засгаа өсгөх тэргүүтэй бүх ажлын гогцоо магадгүй энэ салбарт бас байгаа.

Улсын нийслэлийн төв цэг энэ танхимаас хойш хоёрхон километрийн хойно модон жорлон, нүүрсэн халаалт, зөөврийн устай иргэд амьдарч байгаагийн шалтгаан нь бас л эрчим хүчний хомсдолтой л холбоотой.

Хомсдсон, хүрэлцээгүй мөртлөө эрчим хүч нь тэгээд маш хямдхан. Эрчим хүч, энергийн нэн чухал салбар хомс, хямд, хөгжилгүй гэсэн нэг ийм чөтгөрийн тойрогт орчихлоо.

Орчлон ертөнц энэ оршин байгааг “энерги”, “мэдээлэл”, “энтропи” гээд хэдхэн үгээр тодорхойлно гэж бас эрдэмтэд нотолдог.

Тэгээд энэ бүхэн ер нь юунаас болоод, хэнээс болоод ийм байдалд хүрчих вэ. Онцгой, стратегийн гэх бүхэл бүтэн энэ салбарын нэг зууны түүхийг, шинэ тогтолцоонд орсны хагас жарны түүхийг бас үгүйсгэх гэсэнгүй.

Энэ бүхэн улс төрийн энэ системийн хамтын бүтээл. Товчоор тодорхой дүгнэвэл чөлөөт эдийн засгийн харилцаа руу алхмын төдий ч шилжээгүй хатуу төрийн өмч, төрийн хяналтад үлдсэний л харгай.

Сүүлийн 30 жилд манай улсын эрчим хүчний нийт хэрэглээ 2.2 дахин өсөж байхад импортоор авдаг цахилгаан эрчим хүч 11 дахин өсжээ. Энэ бол хөгжлийн хөдөлгөгч эрчим хүч маань улам хязгаарлагдмал, бусдаас улам хараат болж, хөгжил өрсөлдөөний боломж бид нараас алсарч буй нь бас нэг жишээ. Тэлэлт өсөлт хийж, тэнцвэр

балансыг нь хангахгүй бол эдийн засгийг боомилсоор улсаараа балрах аюулын харанга эрчим хүчний салбарт байна.

Эрчим хүчний салбар маань өнөөдөр багадсан гуталтай хүн шиг эдийн засгийн өсөлтийг барьж байна. 50 жилийн өмнөх ЗИС-5 машинд хэтэрсэн ачаа ачиж, энхэл донхолд мунгинаж яваа жолооч шиг л ийм дүр зурагтай байгаа нь тун харамсалтай.

Ийм аюул бодит эрсдэл буйг үеийн Засгийн газар мэдэхийн дээдээр мэдэж л байсан. Бараг 5 удаа байршил тогтсон V цахилгаан станц маань хаачив аа. Худалдан авагч нь бэлэн нь үү? Оюу Толгой, нүүрс нь бэлэн Тавантолгой дээр баригдах гэж байсан 450 мегаваттын дулааны цахилгаан станцын төсөл маань хаачив аа.

Хууль тогтоох, гүйцэтгэх, хянах бүх эрх мэдэлд хүчээ нэгтгэсэн нь эрх баригчид Та бүхнийг эрчим хүчний салбарын хямралт нөхцөлөөс нь гаргахад бодлогоо нэгтгэж, хүчээ дайчлахыг сөрөг хүчний зүгээс сануулан уриалъя.

Харин 2012-2016 онд нөгөө муу нэртэй луу данстай Хөгжлийн банкны Чингис хаан бондын санхүүжилтээр сүүлийн 30 жилд цорын ганц шинэн эх үүсвэр болох Амгалангийн дулааны станцыг барьж, III болон IV цахилгаан станцыг өргөтгөснөөс өөр дорвитой бүтээн байгуулалт уг салбарт үнэндээ хийгдээгүй.

Ганцхан станц нэгхэн зуухан дээр бараг эвдрэл гэмтэл гарахад дүн өвлөөр хотоороо дулаангүй, улсаараа цахилгаангүй гал алдах цаг ойрхон ирснийг салбарын яам, сайд,

мэргэжилтнүүд бас хий үглэсээр л байна.

Хариуцсан хүмүүсийн аз, ард иргэдийн заяанд даатгахаас өөр бэлдсэн бэлтгэлгүй идэр есийн хүйтэн рүү бид нар дөхөж явна. Ийм нөхцөлд үйлдвэрлэл хөгжих, эдийн засаг өсөх тухай ярих даанч өнөөдөртөө боломжгүй байна. Алдагдал нь хэдэн зуун тэрбумаар яригддаг эрчим хүчний салбар бас л 2012-2016 оны үед алдагдал нь асар их багассан тоо баримтыг энэ танилцуулгын 3 дугаар хуудас дээр Та бүхэн өгсөн.

Гэтэл тав, зургаан жилийн дараа алдагдлын хэмжээ нэмэгдсээр түүхэн дээд хэмжээндээ очиж байна.

Бид нүүрсний бассейн дотор амьдардаг хэрнээ улс төржиж, эрчим хүчийг хүртэл сонгуулийн хэрэгсэл, халамж болгож, зах зээлийн үнээр биш, бүр өртгөөр нь биш, бүр сүүлдээ үнэгүй цахилгаан хэрэглэдэг ийм улс болж хувирсан.

Энэ хооронд дэлхий нийт нүүрсний станцуудыг санхүүжүүлэхгүй гээд хэлчихлээ. Олон улсын санхүүгийн байгууллагууд нүүрсний эрчим хүчний төслийг дэмжихгүй нь. Одоо тэгээд цаашдаа яах юм бэ.

Иргэдээ дарамталсан, хөрштэйгөө муудалцсан 2 усан цахилгаан станцын төсөл маань гэрлээ асааж гэрэл нэмтэл бас ойрхон биш болчихлоо.

Асуудал шийдэл ярихаараа бид нар аварга том мега төсөл ярьдаг. Гэтэл төвлөрсөн бус бие даасан системүүдийг нэгдэл, сүлжээ бий болгох нь

стратегийн шийдэл байж болохыг бас үгүйсгэхгүй.

Улс орны өнцөг булан бүрт бага, дунд хэмжээний станцуудыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар барьж, түүнийг түгээх, дамжуулах сүлжээнд хөрөнгө оруулж, эрчим хүчний сүлжээгээр тордож чадвал бидэнд бас боломжууд байж магадгүй.

Хувийн хэвшлийг оролцуулах хөшүүрэг, тогтвортой байдлын гэрээ, тууштай дэмжих бодлогоор гэрээт маягийн торлосон эрчим хүчний сүлжээний тухай ярь.

Дэлхийн эрчим хүчний үйлдвэрлэлийн 17 хувийг эзэлдэг АНУ-ын сүлжээ, нүүрсний олборлолт, тээвэрт станцуудад нийлээд 60 мянган хүн л ажилладаг гэнэ. Манай хилийн дөнгөж урдхан талд байгаа Баяннуурын мянган мегаваттын цахилгаан станцад дөнгөж 50 хүн ажилладаг гэнэ.

Технологийн хоцрогдол, нэмэх нь эрх баригч намын шахаа нийлэхээр ийм үрэлгэн бүтэц болдгийн жишээ манайд байна. Төрийн өмчит компаниудын засаглалын шинэчлэл зайлшгүй хийж эхлэх ёстойг энэ бүхэн харуулж байна.

Нүүрсний уурхай, станц, дамжуулах, түгээх тойрсон өрийн цикл өдгөө ч үргэлжилсээр өссөн дүнгээр их наяд давж тоологдож байна. Салбарын жилийн борлуулалтын орлоготой тэнцэх хэмжээний өр зээлтэй жилийн борлуулалтаас 10 дахин их хэмжээний бараг өр зээлтэй. Хүлээгдэж байгаа хөрөнгө оруулалт нь бараг 10 жилийнх нь борлуулалттай ийм юм урьдчилсан тооцоотой.

Энэ чөтгөрийн тойргоо хэрхэн эвдэж, уг салбарыг либералчилж, үрэлгэн, үр ашиггүй төрийн өмчит хувьцаат компаниудаа хувьчлах, засаглалыг сайжруулах бодлого хэзээнээс хийгдэж эхлэх вэ.

Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих нь зүй ч хуудуутай хуулийг баталж, хуулиар хамгаалсан нь дээрмээр хэрэглэгчдийн халаасыг ухсан амьжиргааг дордуулж буй жишээ одоо ч бодитоор оршсоор байна.

Эрчим хүч үйлдвэрлэлийн 10 хүрэхгүй хувийг эзэлж буйж ч нийт борлуулалтын орлогын бараг гуравны нэгийг нь авдаг. Айл өрх бүрийн хэрэглээнд нэг киловатт цаг тутамд 23 төгрөгийг сул иддэг эрүүл бус тогтолцоог нэн даруй эвдэж засах шаардлага байна.

Мянган хүнтэй нүсэр, үр ашиггүй станц нүүгэлтэн ажиллаж, нийт хэрэглээний 70 хувийг нийлүүлэх мөртлөө орлогын 40 шахам хувийг л авдаг ийм ойлгомжгүй, шударга бус тогтолцоо энэ чигээрээ явах уу.

Хүн төрөлхтөн сансар эрхэс, робот ярьж суухад талын монголчууд бид лаа, шүдэнзээ зэхэж гал алдахад яах тухайгаа тулга тойрон шивнэлдэцгээж сууна. Хөгжлийн хөдөлгүүр, хурдасгуур байх ёстой эрчим хүч нь хөгжлөө боймлогч болсон хүндхэн нөхцөл байдлыг нэн даруй өөрчлөх үйлсэд тууштай, зоригтой ажиллахыг эрх баригч Та бүгдээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Нансалын Тавинбэх, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Батмөнхийн Ерэн-Өлзий, Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Батмөнхийн Насантогтох, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга Эрдэнэчулууны Түвшинчулуун, Эрчим хүчний зохицуулах хорооны ажлын албаны дарга Басбаярын Болор-Эрдэнэ, Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Гомборагчаагийн Балжинням.

Мэдээлэлтэй холбогдуулан Эрчим хүчний сайд болон ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж, үг хэлэх цөөнхийн гишүүд бүртгүүлнэ.

Жамбын Батсуурь гишүүнээр тасаллаа. Наянтайн Ганибал гишүүн асуулт асууна.

Н.Ганибал: Энэ өдрийн мэнд хүргэе. Ер нь дэлхий нийт бүгдээрээ эрчим хүч хамгийн хэрэгтэй, хамгийн чухал салбар вэ гэдгийг мэдэрсэн он жилүүд явж байна.

Дэлхий дээр өнөөдөр эрчим хүчнээс болж дайнтай байна. Энэ өвлийг яаж дэлхий нийтээрээ даван туулах вэ гэдэг хүлээлтэд орсон байна. Дэлхий дээр эрчим хүч интеграцад орсон байна. Дэлхий нийтийг хамарсан нэгэн сүлжээ бий болсон байна.

Хөөрхий Монгол ганцаархнаа үлдчихлээ. Монголчууд бид бүхэн энэ салбар дээрээ үнэхээр гадаадын тагнуулууд, туршуулууд, энэ эрчим хүчийг үгүй хийх гэсэн энэ инээж байгаа хүмүүсийн явуулгаар өнөөдөр

монголчууд ингээд хоцрогдоод үлдчихлээ.

Уг нь Багануурын цахилгаан станцыг барья гээд санаачилга гаргаад явсан. Тэрийг маш олон эх орончийн дүртэй танай намын нөхдүүд зогсоосон. Тэр арай тагнуул биш биз дээ.

Өнөөдөр хоёр усан цахилгаан станц ярьж байна. Өнөөдрийг хүртэл явдаггүй. Яагаад өнөөдөр монголчууд энэ цахилгаан эрчим хүчээ нэмэгдүүлэх тал дээр хийсэн оролдлого болгоны цаана үүнийг үгүйсгэдэг, зогсоодог бүхэл бүтэн бүлэглэлтэй болчхов оо. Энэ хүмүүс ямар зорилготой хүмүүс байна вэ? Монголын тагнуул үүнийг судалсан уу?

Амгалангийн дулааны станцыг хийсэн. Тэрийг хийснийх нь төлөө бас хүмүүсийг яллах гэж оролдсон. Энэ бас хийснийх нь төлөө монголчуудыгаа үгүйсгэж байгаа асуудал харагддаг юм. Зүгээр ингээд эрчим хүчний салбарын явж байгаа энэ процессуудыг харахаар дандаа эх орны эсрэг ийм үйлдлүүд нь илүү давамгайлж байна.

Оюу Толгойн станц, Тавантолгойн цахилгаан станц яг барих гэхээр л ямар нэгэн дотоодын эсэргүүцэгч нар гарч ирдэг. Гаднын бодлого энд орж ирдэг. Энэ зүгээр бүгдээр нь мэдэж байгаа. Бүгдээрээ мэдэж байгаа. Үүнийг ярьдаггүй. Тэгээд цаашлаад эрчим хүчний алдагдлын хамгийн том, сүүлийн үед алдагдал авчирч байгаа сайхан нэртэй сэргээгдэх эрчим хүчний тусгай зөвшөөрлийн тэр бизнес байгаа.

Тэр хүмүүс сайхныг ярьж байгаад Монголоо хорлож байгаа. Тэр Монголоо хорлож байгаа хүмүүсийг

олсон уу? Н.Тавинбэх дарга энэ дээр маш тодорхой, ойлгомжтой тайлбарыг хийж байсан. Би үүнийг бас асуучихъя. Үнэхээр тэр сэргээгдэх эрчим хүчний тусгай зөвшөөрөл өгч, монголчуудын хармаа руу гар дүрэх асуудлыг бодлогын хэмжээнд шийдлийг нь гаргасан тэр хүмүүсийг зарлаж өгөөч ээ гэдгийг бас хүсэж байна.

Ингэж байж энэ салбар өөрөө либералчлагдаж цааш явна уу гэхээс ямар нэгэн улс төр, гадаадын геополитикийн сонирхол дунд бид бүхэн өнөөдөр хүчин мөсдөж байгааг бүгдээрээ харж байна.

Жижиг юм яриад яах вэ. Хэдэн станцуудын идэж ууж байгааг яриад яах вэ. Тэд нарыг одоо бид бүгдээрээ мэдэж байгаа. Сая баахан орлогчгүй болгосон л гэсэн. Хэмнэлт хийж л байгаа байлгүй. Том юмаа хэдүүлээ эхлээд дүр зургаар нь олж харах нь зөв өө. Ингэж байж манай энэ салбар цаашаа явна уу гэхээс өнөөдрийн бид нар хэн нэгэндээ буруу өгөх биш, тэр хорлон сүйтгэгч нараа олж авч байж бид нар энэ салбарыг цааш нь авч явна гэдгийг бас хэлмээр байна.

Тэгээд хийгдэж байгаа ажлуудтай холбоотой хоёр асуулт байна. Дорнодын эрчим хүчний өргөтгөл яасан удаж байна вэ? Цаг хугацааны хувьд хэзээ хийгдэж дуусах юм бэ?

Хоёр дахь асуудал нь, аймгууд дээр КОЙКА-тай хамтарсан дулааны станц барих, өргөтгөл хийх ажлууд явагдаж байгаа. Энэ асуудлууд ямар шатандаа явж байна вэ? Эд нарыг асууя.

Баттогтохын Чойжилсүрэн Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд.

Б.Чойжилсүрэн: Н.Ганибал гишүүний асуултад хариулъя.

Дорнодын цахилгаан станцыг 50 мегаваттаар өргөтгөх ажил явж байгаа. 79 орчим сая долларын төсөвт өртөгтэй. Хятад Улсын Хөгжлийн банкны санхүүжилтээр явж байгаа. Монголын талын санхүүгийн зуучлагч нь Монгол Улсын Хөгжлийн банк. Ийм ажил явж байна.

КОВИД-ын өмнө эхэлсэн юм байна. Одоо КОВИД-ын дараа бүх улс орнууд дээр үнийн өсөлт явсан учраас өртөг нь багтахаа байлаа гээд. 25 орчим сая доллароор нэмэх шаардлагатай гэсэн ийм хүсэлтийг ирүүлсэн. Би захиралтай нь хоёр удаа уулзсан.

Манай яамны хоёр газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг энэ 25 сая долларын өсөлт чинь хэр хэмжээнд бодитой юм уу. Хэрвээ нэмэгдсэн бол ямар хэмжээ нэмэгдэх вэ гэдэг ийм ажлын хэсэг гараад явж байна.

Ойрын өдрүүдэд нэг талдаа бид нар шийдвэрээ гаргана. Үүний дараа Хятадын Хөгжлийн банк болон Монголын хөгжлийн банканд саналыг тавиад төсөвт өртгийг шаардлагатай бол нэмэгдүүлээд 2023 ондоо дуусгах арга хэмжээг аваад явж байгаа ийм байдалтай байна.

Энэ 10 аймгуудын дулааны станцын тухай ярьж байх шиг байна. Та. Энэ ажил Бүгд Найрамдах Солонгос Улсын ЭКСИМ банкны санхүүжилтээр явж байгаа ийм ажил байна. 140 орчим сая долларын төсөвт өртөгтэй. 9

аймгийнх нь ажил хэвийн явж байгаа. 1 аймаг дээр маргаан үүссэн. Архангай дээр. Шийдвэр манай талдаа, Эрчим хүчний яам талдаа гарчихсан байна. Ирэх хаврын бүтээн байгуулалтын сезоноос эхлээд энэ өвөл бэлтгэлийг нь сайн хийгээд ашиглалтад оруулах, төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах арга хэмжээнүүд хийгдээд явж байгаа гэдгийг танд мэдээлье.

Энэ Багануурын цахилгаан станцын тухайд та ярьж байна. Шүүмжлэл дагуулсан. Үнэн. 2017 онд анх концессын гэрээ байгуулсан. Түүний дараа бас янз бүрийн шалтгаанаар зогсчихсон байна лээ. Одоо анх концесс эзэмшигч компани нь энэ төслөө үргэлжлүүлж чадахгүй гэдгээ албан ёсоор бичгээр мэдэгдсэн. Хувьцаагаа ондоо хөрөнгө оруулагч нарт шилжүүлнэ. Энэ ондоо хөрөнгө оруулагч нарыг ер нь ерөнхийдөө олчихсон. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хилийн 20-г хориотой байгаагаас шалтгаалаад ойрын өдрүүдэд ирж уулзах байх гэсэн ийм хүлээлттэй байгаа. Багануурын тухайд.

Уг нь хувийн хэвшлийн станц байгаа. Үнэ өртөг нь ч гэсэн бас харьцангуй боломжийн түвшинд хийгдсэн ийм станц байгаа гэдгийг хэлье.

Сэргээгдэхийн талаар та бүхэнд мэдээллийг тодорхой хүргүүлсэн. 2007 онд Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль батлагдсан юм байна. Тэр үед нэг киловатт нарны станцаас жишээлбэл 15 центээр авна. Заримдаа ч бүр 19 центээр хийгдчихсэн юмнууд бий.

ТЭЦ IV-өөс бид нар төвийн эрчим хүчний системдээ 60.5 төгрөгөөр нийлүүлдэг. Төгрөгөөр. Нарны

станцуудаас 560 төгрөгөөр нийлүүлж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ Засгийн газрын тогтоол гарсан. 2023 оны нэгдүгээр улиралдаа багтааж энэ хөрөнгө оруулагч нартай тохиролцож үнийг бууруулах арга хэмжээг явуулж байгаа.

Би нэгдүгээр улиралдаа багтаж Засгийн газарт танилцуулах ийм үүрэг авчихсан ажлаа хийгээд явж байна.

Мэдээж хөрөнгө оруулчихсан улсууд дээр зохих хэмжээний эсэргүүцлүүд явж байгаа. Гэхдээ энэ ажлыг ямар ч байсан үе шаттайгаар шахаж яваад ойлголцоно гэж найдаж байгаа. Одоо хэний үед улс төржөөд, хэн ямар засаглалын үед ийм шийдвэр гарсан тухай яриад яах вэ. Бодит байдал ийм л байна.

Хариулж дууслаа. Дарга аа.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Танилцуулга мэдээлэл дээрээс харж байхад одоо 300 мегаватт орчмыг Оросоос авдаг юм байна. Тэр эрчим хүчний хязгаарлалт, хомсдол, техникийн нөхцөл олгохгүй байгаа. Тэгээд ирээдүйн хэрэгцээг харвал магадгүй манайх мянга мегаваттын дутагдалтай байж ч магадгүй. Тэрийг мэргэжлийн хүмүүс нь мэдэж байгаа байлгүй.

Тэгээд ойролцоогоор 1 мегаватт эрчим хүчний эх үүсвэрүүдийг 2 сая доллар. Энэ тэр гээд бодох юм бол аягүй бол 1000 мегаваттын дутагдал 2 тэрбум долларын, 500 мегаваттынх бол тэрбум долларын санхүүгийн эх үүсвэр хэрэгтэй болох нь.

Манайд үндсэндээ байдаг юм чинь нүүрсний эх үүсвэр л байгаа.

Тэгэхээр одоо Хятад санхүүжилт өгөхгүй нь ээ. Олон улсын санхүүгийн байгууллага энэ дээр санхүүжилт өгөх нь ээ. Дотоодод бид нарт санхүүгийн эх үүсвэр байхгүй ээ. Одоо яг саяын тэр тэрбум, хоёр тэрбум доллароор яригдаж байгаа энэ санхүүгийн дутагдлыг хойшдоо ер нь гарц гаргалгаа яаж нөхөх юм? Энэ мөнгө чинь байхгүй болчихлоо. Нүүрсний станцуудыг санхүүжүүлэхгүй юм байна.

Тэгэхээр энэ дээр одоо яг ямар чиг баримжаа, юу гэж бодож байгаа вэ? Багадаа л тэрбум доллароос дээш хэрэгцээний тухай асуудал энд явах нь байна.

Хоёрдугаарт нь, тэр Оюу Толгой дээр үндсэндээ энэ худалдан авагч нь байгаа гэж үзэж байгаа. Дахиад хажуухан талд нь нүүрсний эх үүсвэр нь байгаа гэж байгаа. Тэр Тавантолгойн цахилгаан станц, дулааны цахилгаан станцын асуудал одоо ямар шатанд, хаана яаж явж байгаа вэ? Энэ ер нь баригдах уу, баригдахгүй юу?

100, 150 сая долларын гадаад төлбөр тооцоо төлөгддөг гэсэн мэдээлэл байдаг.

Тэгээд ер нь төгсгөлд нь энэ салбар одоо яг дундаж үнэ өөрөө хэдтэй байдаг юм? Центээр. Яг ямар үнэ дээр очвол өртгөө нөхөж, ямар үнэ дээр очвол хөрөнгө оруулалтаа хийж энэ салбар хэвийн гэдэг юм уу даа. Тэр либералчлал энэ тэр гээд холын их гоё гоё юмыг зүгээр больё. Дунд хугацаандаа мэдээж Оросоосоо аваад л явдаг байлгүй. Одоо ойрын хугацаандаа.

Дунд хугацаанд ер нь яг энэ салбарт ер нь юу хийгдэх юм. Тэр либералчлал энэ тэр гэдэг үгүүд энэ эрх зүйн систем нь бид нарын энэ улс төрчдийн араншин, улс төрийн намуудын үйл хөдлөлөөс харахад бид нар энэ дээр тийм их сайхан юм яг бодит байдлаар хийж чадахгүй байгаа л даа.

Тэгэхээр яг бодит дунд хугацаанд ер нь энэ салбар өртгөө нөхөөд явахад одоо хэд байгаа үнэлгээ цаашид хэд болж өөрчлөгдөх вэ?

Дахиад тэр танилцуулга дээр нэг тоо бас хэлнэ лээ. Узбекистанд гэл үү. 2.7 центээр. Манайд 15 центээр хийгдэж байгаа гэрээг 2.7 центээр нийлүүлэхээр технологи хөгжөөд тийм болж байгаа юм.

Сэргээгдэх эрчим хүчний ийм төслүүд манайд танилцуулагдаж орж ирж байгаа зүйлсүүд байгаа юу? Энэ чинь тэгэхээр одоо бараг манай энэ нүүрсний станцаас ч өртөг хямд нийлүүлэх үнийн тухай яриа энэ дээр гарах гээд байна шүү дээ.

Тэгээд үндсэндээ энэ нэг ийм аргалдаг систем, аргалдаг байдлаа л хэдүүлээ засаж цаашаа л явахгүй бол үнэхээр эрчим хүчний систем маань бусад салбаруудын л адил аргалсаар байж яг нэг ийм аминд хүрэх л ийм л нөхцөл байдалд оччихлоо. Одоо дахиад сая ч гэсэн түр зуур аргацаагаад, айл өрхийн цахилгаан дулааныг нэмэхгүй. Тэр аж ахуй нэгжүүдэд бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ үнэд шингээд л очиж л, адилхан л тэр өртөг нь нэмэгдээд л очиж л байгаа шүү дээ.

Тэгэхээр одоо яг цаашид ер нь Холыг больё. Дунд хугацаанд ер нь ямар бодлого барьж байгаа вэ? Эдгээр асуултуудад тайлбар өгөөч ээ.

Г.Занданшатар: Батгогтохын Чойжилсүрэн. Эрчим хүчний сайд, Улсын Их Хурлын гишүүн хариулъя.

Б.Чойжилсүрэн: О.Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя.

Санхүүжилтийн эх үүсвэр хумигдсан. Бидний тэргүүн ээлжид хийгдэх ажил “**Дулааны цахилгаан станц III**” өргөтгөлийг 300 мегаваттаар цахилгаанаар, 500 гегакалор цагаар дулаанаар нэмэгдүүлэх ажил Оросын Холбооны Улстай экспортын зээлээр нь хэрэгжүүлэхээр ингээд явж байна.

Техник, эдийн засгийн үндэслэл дууссан. Сая манай Эдийн засгийн хөгжлийн сайд Оросын Холбооны Улсад Оросын Холбооны Улсын экспортын зээлийг авъя гэсэн ийм хүсэлтийг хүргүүлсэн. Үнэ жоохон өндөр байгаа. Үнийг буулгах хэлэлцээрийн ажлууд явж байна.

Магадгүй энэ нэгдүгээр сардаа багтаагаад намрын чуулганы төгсгөлд бид нар энэ хэлэлцээрийг оруулж ирэх байх. Улаанбаатар хотын тухайд.

V цахилгаан станцын тухайд 2012-2016 оны хооронд идэвхтэй яригдаж байгаад зогсчихсон юм байна. Гол шалтгаан нь одоо байгаа байрласан байрлал нь их оновчгүй болчихсон. 20 гаруй километр урт трасс татна. Дулааны хувьд. Үүнийгээ борлуулахад нэгдүгээрт трасс байхгүй. Улаанбаатар хот нэлээн тийм шахуу барилгажсан учраас.

Тийм учраас ТЭЦ-III-ийг өргөтгөсөн нь дээр юм байна гэдэг шийдвэрийг миний урд талын сайд нар гаргасан юм байна. Тэгээд энэ төсөл зөв явах юм бол бид 2023 оны 7, 8 дугаар сар гэхэд ажил нь эхлүүлэх болов уу гэж бодож байгаа. Нөгөө туслан гүйцэтгэгч нартайгаа тендерээ шалгаруулаад ийм юу нэгдүгээрт. Төвийн бүсийн эрчим хүчний систем.

Хоёрдугаар төсөл. “**Тавантолгойн дулааны цахилгаан станц**”-ыг 2023 оны нэгдүгээр сард багтаагаад тендерээ дахин зарлахаар ийм төлөвлөгөөтэй явж байна.

Урьд нь намайг сайд болохоос өмнө 2 удаа энэ жил зарлагдсан юм байна. Шаардлага хангасан оролцогч орж ирээгүй гэдэг шалтгаанаар ингээд зогсчихсон байсан. Одоо хэд хэдэн төрлийн боломжит потенциалын компаниудыг судлаад явж байна.

Ер нь чадвал 2023 оны 5 дугаар сарын сүүл гэхэд бид оролцогчийг сонгон шалгаруулаад гэрээг байгуулна. Ажлыг магадгүй 2023 оны хоёрдугаар хагастаа ажлыг эхлүүлэх ийм ажил явж байна.

Гуравдугаар төвийн бүсийн эрчим хүчний систем дээр гурав дахь эх үүсвэр нь энэ “**Бөөрөлжүүлтийн цахилгаан станц**” төсөл явж байна. Хувийн хэвшлийнхэн явж байна. Ажил нь нэлээн идэвхтэй явж байгаа.

2024 оны дөрөвдүгээр улиралд ашиглалтад оруулахаар төлөвлөгөөтэй явж байгаа ийм ажлууд байна.

Дөрөв дэх нүүрсний эх үүсвэрийн тухайд энэ “**Багануурын цахилгаан станц**”-ын төслийг бид

амилуулахаар ингээд нэлээн идэвхтэй хөөцөлдөж байгаа.

Одоо концесс эзэмшигч нь хувьцаагаа зараад гаръя гэсэн. Хятадын цөмийн энергийн корпораци ингээд сонирхохоо больсон юм байна. Элдвийн шалтгаанууд байсан юм байна.

Энэ ажил нөгөө Ши Жиньпин даргын амлалтаас өмнө хийсэн учраас Хөгжил шинэтгэлийн хороон дээрээ зөвшөөрлийг нь авчихсан. Энэ төслийг санхүүжүүлэхэд Ши Жиньпин даргын амлалтад орохгүй ийм байдалтай байгаа учраас энэ асуудлыг ингээд шийднэ.

Бид 2035 онд хүртэл төвийн эрчим хүчний систем дээр жишээлбэл таазыг нь тооцоолж үзсэн. Энергийн хувьд 2.2 дахин, чадлын хувьд бас 2.1 дахин томрох юм байна.

Сая миний дурдсан эдгээр төслүүдийг хэрэгжүүлэх юм бол нийт хүчин чадлынхаа, саяын хүлээгдэж байгаа 2035 он хүртэлх хэрэглээг бид нар хангаж чадна гэсэн ийм төлөвлөгөө байна.

Тавантолгойн дулааны цахилгаан станцын тухайд бид Оросын Холбооны Улсын бас нэг холбогдох банкуудтай ярьсан. Санхүүжилт өгье гэж байгаа.

Урьд нь нүүрсээр төлбөр төлөх offtake гэрээ байгуулаад явж байгаа. Offtake гэрээ маань бас тодорхой хэмжээний бэрхшээл үүсэх. Нөгөө нүүрсний борлуулалтын орлого энэ төслийнхөө орлогод суутгагдаад байх юм бол төлбөрийн тэнцэл дээр тодорхой хэмжээний эх үүсвэрийн дутагдалд ороод байгаа учраас offtake-үүдийг зогсоогоод бид яг бодит санхүүжилт олж ирэх энэ асуудлуудыг яриад явж

байна. Бас нэлээд амжилттай явж байгаа.

Гэхдээ яг төслөө эхлүүлчихээгүй байгаа учраас их гоё юм яримааргүй байна. Ирэх жилдээ багтаад Та бүхэнд сайн мэдээ дуулгаж болох байх гэж бодож байна.

Аргалаад яваад байж үнэхээр болохгүй. Аргалах бүх нөөц шавхагдаж дууссан. Үүнийг ард түмэн, олон нийтэд шударга хэлсэн нь дээр. Дулааны хувьд Улаанбаатар хот ийм байна

Улаанбаатар хотын дулааны шугам сүлжээнд 4 эх үүсвэрээс дулаан нийлүүлж байгаа. **ТЭЦ-II, ТЭЦ-III, ТЭЦ-IV, Амгалангийн дулааны станц.**

Суурилагдсан хүчин чадал 2 мянга 360 орчим гигакалор цаг хүчин чадалтай. Холбогдсон нь 3 мянга 403 буюу 1100 орчмоор илүү гарчихсан байгаа.

Г.Занданшатар: Гүйцээчих. Баттогтохын Чойжилсүрэн гишүүн.

Б.Чойжилсүрэн: Дулааны хувьд ингээд явж байгаа юм.

Тэгэхээр энэ дутагдаж байгаа эх үүсвэрийг ямар ч байсан 2024-2025, 2025-2026, 2026-2027 оны галлагааны улирлуудын дутагдаж байгаа хүчин чадлыг бид нар тархмал эх үүсвэр, 6 эх үүсвэрээр нэмж байгуулахаар ийм төсөл хийгээд зураг нь хийгдээд дуусаж байна.

Эхнийх нь төслийг эхлүүлсэн. Энэ бол Амгалангийн дулааны цахилгаан станцыг 116 гигакалор цагаар өргөжүүлж нэмэгдүүлэх төслийг

Хөгжлийн банктэй гэрээг нь зураад гүйцэтгэгч нь шалгараад ажил нь явж байна.

Чадвал ирэх өвлөөс өмнө холбох тийм төлөвлөгөө байна.

Бэрхшээл бол Улаанбаатар хотын дулааны шугам сүлжээний борлуулж байгаа өртөг нь үйлдвэрлэж байгаа өртгийнхөө 40 орчим хувьтай л байна. 10 төгрөгөөр үйлдвэрлэхээд 4 төгрөгөөр зарж байгаа.

Улаанбаатар дулааны сүлжээ энэ оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 130 орчим тэрбум төгрөгийн л борлуулалт хийнэ. Яг ийм доогуур үнээр энэ салбарт ямар нэгэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт хийх тийм ойлголт байхгүй.

Тийм учраас бид энэ удаа сая үнэ нэмэгдүүлэх ажлыг хийсэн. Либералчлал гэдэг том алсын ирээдүйн эхний алхам болгоод. Дөрөв, тав алхаж очих юм уу. Ямар ч байсан нэг удаа алхчихъя гээд хийсэн.

Энэ удаа бид ахуйн хэрэглээг нэмж чадаагүй. Дулааны хувьд ч тэр, цахилгаан эрчим хүчний хувьд ч тэр. Шалтгаан нь энэ дэлхий ертөнц хүндрэлтэй. Хоёр, гурван шалтгаан байгаа шүү дээ. КОВИД дөнгөж дуусаагүй байна. Энэ Орос, Украйны цэргийн тусгай ажиллагаанаас шалтгаалсан үнийн өөрчлөлтүүд гэх мэт.

Тийм учраас иргэдийн хувьд дулаан, цахилгааны үнийг эдийн засгийн уналт зогсоод өсөлт гарсан нь нэг жилийн дараах жилээс хэрэглэхгүй бол хэрэглэгч нарын маань бас төлбөрийн чадвар хангалттай биш

байгаа учраас энэ удаа нэмэгдүүлэхгүй орхисон.

Аж ахуйн нэгж, төсөвт байгууллагууд дээр дулааны үнэ нэмэгдүүлсэн, цахилгааны үнэ нэмэгдүүлсэн. Бид Монгол Улсад инфляцад тооцдог хоёр албан ёсны байгууллага бий. Статистикийн ерөнхий газар, Монголбанк хоёулантэй манай яамнаас ажлын хэсэг гаргаж судлаад магадгүй 2023 оны төгсгөл гэхэд 1.2 хувийн инфляцын нөлөөлөл үүсгэж магадгүй гэсэн ийм шалтгаан бий.

Гэхдээ энэ салбарыг тохируулгатай үнээр байгаад байдаг. Зардал нь зах зээлийн юун дээр гардаг. Орлого нь ийм тохируулгатай байсан үед салбар өөрөө дампуурах байдалтай байсан учраас ямар ч байсан шүүмжлэлтэй ч сайн ч муу ч нэг удаа алхсан гэдгийг Та бүхэнд хэлбэ.

Ер нь энэ тооцоонуудыг явах юм бол одоо манай энэ хүлээгдэж байгаа 4 эх үүсвэрүүдийг өөрсдөө өөрийнхөө мөнгөн урсгалаар төвийн эрчим хүчний систем энэ зээлээ төлөх юм бол. Хөнгөлөлттэй эх үүсвэрүүдээр шүү дээ. Дандаа.

Ингээд явахад энэ жилийн тухайд ирэх жилээс 7 орчим центээр. Ер нь дунд хугацаандаа 9-өөс 10 цент хүргэж байж цахилгаан эрчим хүчний салбар **bankable**_[ашигтай] болно гэдэг энэ салбар луу хөрөнгө оруулаад бас тодорхой хэмжээний оруулсан хөрөнгөө олоод дээр нь нэмээд ашиг олох тогтолцоо бүрдэх тэр бүрэн либералчлалын эхний урьдчилсан тооцоо байна.

Улаанбаатар дулааны сүлжээний. Би сая та бүхэнд хэлсэн. Улаанбаатар

дулааны сүлжээний тухайд үүнийг магадгүй энэ алдагдлыг шууд хоёр дахин нэмэгдэж байж өртөг зарлага хоёр нийлэх ийм тооцоо гарч байна гэдгийг хэлье.

Энэ Узбекистанд. Сая хэлсэн. 2007 онд Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль ороод, түүнээс хойш одоо яг өнөөдрийн байдлаар 6 нарны цахилгаан станц, 3 салхин цахилгаан станц Монгол Улсад ажиллаж байна. Тэр үед нөгөө шинжлэх ухаан гүйцэд хөгжөөгүй байсан учраас өртөг нь өндөр байсан байна. Одоо бол саяын та бүхний танилцуулгад дурдсан ийм хэмжээгээр.../минут дуусав/

Г.Занданшатар: Жамбын Батсуурь гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ж.Батсуурь: Монгол Улсын хөгжлийг хязгаарлагч, хойш татаж байгаа, зогсоож байгаа тэр гол онош, эх үүсвэр бол би эрчим хүчний салбар байна гэж ингэж харж байна.

Та бүхний бид нарт өгсөн мэдээлэл, сайдын өгч байгаа танилцуулгад ч ингэж харагдаж байна.

Тэгэхээр энэ нөхцөл байдлыг даван туулах хугацааг дэндүү алсад ярьж байна л даа. Сая сайд өөрөө.

Та хэд чимээгүй байгаач. Байж байгаач.

Сайд бидэнд өгч байгаа. “Шинэ сэргэлтийн бодлого”, Засгийн газрын үйл ажиллагааны салбар эрчим хүчний салбар гэж ингэж мэдээллүүдийг өгч байна.

Тэгээд яг энэ мэдээллүүдийг хараад үзээд байхад энэ чинь одоо шинэ уналтын бодлого руу явж байгаа юм биш үү. Шинэ уналтын бодлогоор явж байгаа юм биш үү. Жишээ нь, та бүхний өгсөн танилцуулга дээр энэ 2012, 2013, 2014, 2015, 2016 онуудад эрчим хүчний салбар чинь алдагдлаа тэглэсэн.

Мөн Монгол Улсын түүхэнд IV цахилгаан станцыг 123 мегаваттаар нэмэгдүүлж байсан. III цахилгаан станцыг 50 мегаваттаар нэмэгдүүлж байсан. Нар, салхины хосолмол эх үүсвэрүүдийг оруулж ирж байсан гээд. Эх үүсвэр талыг нь асар ихээр нэмж байсан.

Мөн алдагдлыг нь тэглээд ингээд өгсөн байгаа.

Тэр үед та бүхэн жинхэнэ Монгол Улсыг мандуулаад өгнө, хөгжүүлээд өгнө, энэ жижиг, дунд үйлдвэрлэлийг чинь ёстой цэцэглүүлээд өгнө гээд авсан. Авсан цагаасаа өнөөдрийг хүртэл өр үйлдвэрлэсэн байна.

Одоо өр нь дааж давшгүй ийм л зүйл болсон байна. Тэгээд одоо ямар амжилт яг ярих гээд байгаа юм. Би ерөөсөө ойлгохгүй байгаа юм. Сайдын танилцуулгад урд хойд хоёр хөршөөсөө хоёр дахин, бусад улсаас гурав, дөрөв дахин хямд нийлүүлдэг гээд нэг их бахархалтайгаар хэлээд байгаа юм.

Бид бусад улс орноос илүү бахархалтайгаар илүү өр үйлдвэрлэж байна гэж байгаатай агаар нэг шүү дээ энэ чинь. Яагаад өнөөдөр зах зээлийн эдийн засаг, нээлттэй нийгэм, либералчлал ярьж байж өнөөдөр Засгийн газрын чинь тэргүүн байнга л ярьж байгаа шүү дээ. Төрийн өмчийг

задлах, либералчлал, эдийн засгийг сэргээх гэж байхад зориудаар үнийг ингэж барьж, Монгол Улсад өр үйлдвэрлэж, өтөнд баригдуулж ингэж байгаа юм бэ.

Дээр нь цаашид жижиг, дунд үйлдвэрлэл суманд, баг, бригадад, аймагт, Монгол Улсад хөгжих ямар ч боломж байхгүй байна.

Таны мэдээлэлд өрийн таазандаа. 1422 буюу дээд тааз хүрчхээд байна гэж байна. Ингээд 30 жилийн өмнө тог хязгаарлаж байсан бол одоо хязгаарласан хэвээр байна.

Өнөөдөр байгаа үйлдвэрлэлээ хязгаарлаж байгаа хүмүүс шинээр үйлдвэрлэл хөгжих үү. Жижиг, дунд үйлдвэрлэл хөгжих үү. Гаднаас төсөл, хөтөлбөр орж ирэх үү. Ингэж боомилогдчихоод байхад хөгжил ярьдаг нь том хөтөлбөр Засгийн газар дэвшүүлэх ямар ч боломжгүй болчихоод байна.

Жишээ нь, сайд хэлж байна. Багануурын 700 мегаваттын цахилгаан станцын гэрээ хийгдээд янз бүрийн шалтгаанаар зогссон гэж байна. Янз бүрийн ямар шалтгаан байгаа юм? Хэл л дээ. Нэгд нь, ямар шалтгаан байгаа юм. Хоёрт нь, ямар шалтгаан байгаа юм. Гуравт нь, ямар шалтгаан байгаа юм.

Янз бүрийн шалтгаан гэдгийн чинь цаана Монгол Улсын хөгжил бүгдээрээ байхгүй болчихлоо шүү дээ. Энэ дэлхий дээр өөрийн өртгөөсөө доош юм зардаг тийм буяны үйл ажиллагаа явуулдаг газар Монгол Улсын эрчим хүчнээс өөр хаана байна.

Та нар юуны төлөө, хааш нь ингэж Монголыг дампууруулах гэж

яваад байгаа юм бэ гэсэн асуултад аягүй ойлгомжтой хариулмаар байна.

Дээр нь Монгол Улсын эрчим хүч халамжийг үйлдвэрлэж байна. Яахаараа халамж өгч байдаг юм. Ер нь тэгээд нэг юм ярихаар КОВИД, дайн ярьдгаа боль. Танай Засгийн газар, танай Засгийн газрын гишүүд. Сүүлийн хоёр жилийн л асуудал байгаа шүү дээ.

2016 онд өргүй. Хөрөнгө оруулалт нь явж байсан. Дараагийн хөрөнгө оруулалт нь цэцэглэж байсан газрыг авангуутаа хэдэн зуун тэрбумаар нь өр үйлдвэрлэж хаячхаад, хэдэн зуун тэрбумаар нь халамж үйлдвэрлэж хаячхаад өнөөдөр “Шинэ сэргэлтийн бодлого” ярина гэдэг чинь ард түмнээ доромжилж байгаа асуудал биш юм уу?

Энэ дээрээ аягүй тодорхой хариулт өгмөөр байна.

Дээр нь халамжийн бодлого нь ямар бодлого байдаг гээч “Долоон буудалд байгаа Должин эмгэн”-ий 20 мянган төгрөгийн хөнгөлөлт авахад Нүхтийн, Залаатын аманд байгаа, уулын амуудад байгаа хаусууд хэдэн арван саяаар нь хөнгөлөлт авч байгаа юм. Ингэж болдог юм уу?

Нөгөө дунд түвшнийг дэмжих.../минут дуусав/

Г.Занданшатар: 5 минутаар явж байгаа. Энэ юуных чинь асуулт, үг хамтдаа 5 минутаар. Нэмэлт минутгүй байдаг. Дэгийн хуулиар 5 минутад багтааж үг хэлнэ гэсэн. Дараа нь 20 минутаар асууж хариулна шүү дээ.

Баттогтохын Чойжилсүрэн гишүүн хариулья. Сайд хариулья.

Б.Чойжилсүрэн: Ж.Батсуурь гишүүн ээ, Үнэн. Хөгжлийг боймлоод эхэлчихсэн манай салбар.

Манай улсын ерөнхий хувьд өрийн тогтвортой байдал их эвгүй байгаа шүү дээ. Би бас Сангийн сайд байсан хүний хувьд,

Тэгэхээр манай салбар нэг станц барих хэмжээний өмнө нь гараад л тийм хэмжээнд хадгалаад явахгүй бол хэт туйлшраад эх үүсвэрүүд барьчих юм бол дампуурах, өрийн тогтвортой байдлаа хадгалж чадахгүй байх нөхцөлүүд үүснэ.

Та шүүмжилж байна. Энэ эх үүсвэрүүд их алсын холын ирээдүй ярьж байна гэж. Үнэн. Одоо хамгийн наад талын эх үүсвэр төвийн эрчим хүчний систем дээр 2024 оны дөрөвдүгээр улиралд орох нь Бөөрөлжүүт. Хувийн салбар. Тавантолгойн цахилгаан станцыг бид 2023 оны эхний хагаст сонгон шалгаруулалтыг зарлаад гүйцэтгэгчийг шалгаруулсан тохиолдолд 2026 оны хоёрдугаар хагаст ашиглалтад орно. 2026 он.

Багануурын цахилгаан станцын тухайд одоохондоо яг шууд цаг хугацаа хэлэхэд эрт байна.

ТЭЦ-III бол нэгдүгээр ээлж нь 2026 онд орно. Хоёрдугаар ээлж нь 2029 онд орох гэсэн ийм л боломж байна. Бодит байдал нь энэ.

Баруун бүсийн тухайд Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг бид төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтад оруулахаар бэлтгэл ажлууд хийгээд явж байна. Би ирэх долоо хоногт Ховд аймаг, Увс аймаг, Баян-

Өлгий аймгуудад ажиллаж энэ станцыг эсэргүүцээд байгаа иргэдтэй төслийг танилцуулж, энэ асуудлыг хурдлуулах арга хэмжээ авна.

Энэ цахилгаан эрчим хүчний үнэ ийм хоёр дахин хямд байгаа гэдгийг бол би бахархалтайгаар ярьж байгаа юм биш ээ. Та бүхнийг бас ойлгоод дэмжээсэй. Ийм алдагдалтай үнээр зардаг яг тантай би санал нэг байна. Хаана байна аа. Одоо үүнийг нэмэхээс өөр аргагүй. Нэмэхийн тулд би сая хэлсэн. Одоо эдийн засгийн тогтворжилт үүссэн үед ард иргэдийн ахуйн хэрэглээг нэмнэ гэсэн ийм шаардлагууд байгаа юм. Тантай ерөнхийдөө олон зүйл дээр санал нэгдэж байна.

Одоо энэ дээр хэн, хэзээ, яагаад ийм болгосон талаар ярих нь улс төржих нь утгагүй байна. Гэхдээ бодит байдал энэ байна. Одоо нэг зовлон тоочоод яриад улс төржөөд суух биш хийх хэрэгтэй байна. Хийхэд ийм хэмжээний л хугацаа орох нь.

Энэ тархмал 6 эх үүсвэрийг бариад ашиглалтад оруулахад, жишээлбэл 2023-2024 оны халаалтын улиралд чадахгүй. 2024-2025 оны халаалтын улиралд дамжиж хийгдэнэ. 2023 оны хавар хийхэд хоёр сезон шаардлагатай юм байна лээ. Наана нь худлаа яриад чадахгүй зүйлийг би та бүхэнд амлаж чадахгүй ээ. Бодит үнэ нь энэ байна. Чадан ядан “Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан энэ зорилтуудыг хэрэгжүүлэх юм бол хамгийн хүнд цахилгаан эрчим хүчний хувьд ирэх 2023-2024 оны их оргил ачааллын жил байна.

Бид ямар ч байсан энд амжаад 200 мегаватт, гаргалгаа нь 80 мегваттын

батарейн цэнэгт хураагуур дэд станц дээр явж байна. Яг өвлийн оргил ачааллын үед бид нар 80 мегаваттыг шөнийн тарифын үед цэнэглээд энэ ямар ч байсан системийн горимын алдагдлыг зохицуулна.

Гэхдээ та бүхэнд нэг юмыг ойлгоорой. Монголчуудын маань нийт хэрэглээ жишээлбэл, жилдээ нэг 6 орчим хувь нэмэгдэж байгаа. Харамсалтай нь нэмэгдэж байгаа хэрэглээний дийлэнх нь дандаа импортоо төлдөг ахуйн хэрэглээ. Монголчууд бид нар зарлагаа л нэмэгдүүлж байгаа. Экспортын үйлдвэрлэл явуулдаг, валют олдог ийм цахилгаан эрчим хүчний хэрэглээ харамсалтай нь бага хувийг эзэлж байгаа гэдгийг бас илэн далангүй ойлголцсон нь дээр байх.

Бид нар сэтгэлгээгээ эдийн засгийнхаа бүтцээ үүнийгээ өөрчлөхгүй бол энэ тогтвортой байдалд очихгүй ээ. Эрчим хүчний салбар ч тэр, улсын хувьд ч тэр. Энэ дээр хэдүүлээ ойлголцсон нь дээр байх.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Одоо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэ заалт 109.11-д заасны дагуу **D-Parliament** цахим хэлэлцүүлгийн платформ дээр байршуулсан Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулж ард иргэдээс ирүүлсэн саналуудыг Засгийн газрын гишүүнээс асууна.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд

дарга Хүрэлбаатарын Булгантуяа Засгийн газрын гишүүнээс асуулт асууна.

Асуулт, хариулт шууд явчихна. Дарга үг өгөхгүй. Ингээд шууд хариулаад явчихаарай. Хоёр микрофон шууд асаалттай хуралдана. 20 минут.

Х.Булгантуяа: Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын эрчим хүчний зорилт энэ асуудлаар ганцхан иргэнээс асуулт ирсэн байна.

Эрчим хүчний хувьд бид Улаанбаатар хотод хамгийн л их яригддаг асуудал. Тэгээд иргэдээс **D-Parliament**-аас бас ганцхан хүнээс асуулт, санал ирсэнд би зүгээр хувь хүнийхээ хувьд бас гайхаж байна.

н.Алтанцэцэг гэдэг иргэнээс ийм асуулт ирсэн байна. Эрчим хүчний үнэ тарифыг тогтворжуулахын тулд Засгийн газар ямар арга хэмжээ авах вэ гэж н.Алтанцэцэг гэдэг иргэнээс.

Улсын Их Хурал дахь манай намын бүлгийн гишүүдээс, бас хувь хүн, миний зүгээс бас нэг ийм хэдэн асуултууд байна.

Нэгдүгээрт, Монгол Улсын эрчим хүчний 5 системүүд ер нь бүгд өндөр авлагатай. Бас өглөгтэй байгаа. Баруун бүсийн эрчим хүчний систем гэхэд 2021 онд 17.1 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны алдагдалтай. Мөн Хөгжлийн банкны энэ зээллэгийн гэж байхад бараг гуравны нэг нь төрийн өмчийн компаниуд, улсын төсвөөс бас авлагын нэлээдгүй нь төрийн өмчийн компаниуд. Үүн дотор эрчим хүчний компаниуд, эрчим хүчний компаниудад ханган нийлүүлдэг энэ уул уурхайн

нүүрсний компаниуд ч бас нэлээн байгаа.

Үүнийг энэ авлага, өглөгийг ер нь яаж барагдуулна гэж бодож байна вэ? Та бүхэн тооцоог нь гаргав уу? Хэдэн он гэхэд яаж барагдуулна гэсэн ийм тооцоолол байна вэ? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, одоо бид нар нийт хэрэглээнийхээ 23.1 хувийг гадаадаас авч байна. Хятадаас авч байгаа 70 гаруй хувь нь шууд Оюу Толгой өмнө хэсэгт байгаа уул уурхайн компаниудын хэрэглээнд зориулж авч байгаа. Бусад нь бидний бусад бүсүүдэд Улаанбаатар хотод ч гэсэн хэрэглээнд бас авч байгаа.

Саяын ингээд дизель түлш гэв гэнэт асуудал үүсэхээр бид нар дизель түлшгүй болдог шиг бид нар бол ямар эрчим хүчийг ингэж хадгална гэж байхгүй шүү дээ. Саванд хийгээд.

Тэгэхээр хэрвээ энэ Орос Улсын эрчим хүчний нийлүүлэлт багасах, эсвэл зогсох ч байдаг юм уу ийм нөхцөл байдал үүсвэл Та бүхэн үүнийг хэрхэн яаж шийднэ гэж бодож байгаа вэ? Энэ дээр ямар нэгэн стратеги, тактик байдаг байх. Энэ үнэ нэмэх, шинэ бүтээн байгуулалт хийх ажлуудыг энэ өвлийг эвтэйхэн давж чадах уу? Иргэд бас их айдастай байна. Тэр тусмаа Улаанбаатар хотын иргэд маань лаагаа бэлдэх ёстой юм болов уу? Одоо яах ёстой юм бол оо. Бараг ийм мэдээлэл бараг явж байна. Бид энэ өвлийг ер нь өнөтэй давж чадах уу гэдэг асуулт байна.

Энэ дээр та бүхэн маань салбарын сайд маань одоо яг энд телевиз үзээд сууж байгаа олон иргэд байгаа байх. Та бүхэн маань энэ дээр нэг тайлбар хийж өгөөч ээ.

Яг маргааш цахилгааны тэг зогсолт хөлдөлт явчихгүй биз дээ? Энэ өвөлдөө.

Дөрөвдүгээрт нь, Тавантолгойн цахилгаан станцын тендерийг дахиад зарлах юм байна. Санхүүжилтийг нь яаж шийдэх гэж байгаа юм бэ? Ер нь дэлхий даяараа нүүрсний цахилгаан станцад санхүүжилт хийгдэхгүй гээд томоохон банк, санхүүгийн байгууллагууд. Хамгийн сүүлд Ши Жиньпин дарга хүртэл Нэгдсэн Үндэстний Байгууллагын хурал дээр амлачихлаа.

Тэгэхээр эсвэл бид бэлэн мөнгө нь байж хийлгэнэ. Эсвэл Засгийн газрын баталгаагаар ч гэсэн бараг барихааргүй нөхцөл байдал үүсэх гээд байна. Тэгэхээр үүнийг яаж санхүүжүүлэх гэж байгаа вэ?

Тавдугаарт, бид энэ сэргээгдэх эрчим хүчин дээр та ер нь хэцүү байгаа гэж тайлбарлалаа. Тэгэхдээ бид энэ эрчим хүчний асуудлыг дэлхий даяар ярихаар дандаа л энэ бол ногоон байж, сэргээгдэх байж л бид санхүүжилт олгоно гэж ярьж байгаа юм.

Тэгэхээр ер нь цаашдаа сэргээгдэх эрчим хүчин дээрээ ямар бодлого барих юм бэ? Явуулах юм уу, бүр огт явуулахгүй юм уу, эсвэл үнэ өртгийн хувьд ийм байна гэх юм уу? Энэ дээр та бүхэн маань бас ямар бодлого цаашдаа сэргээгдэх эрчим хүчин дээр баримтлах гэж байгаа юм бэ?

Зургаад нь, дотоодоо эрчим хүчний эх үүсвэрүүд нэмж барих нь зөв өө. Ялангуяа нөхцөл байдал бол бас нэлээдгүй амаргүй байгаа. Тэгэхдээ энэ хөрш орнуудтай бид нар ганц хоёрхон

эрчим хүчний шугамаар холбогдсон байдалтай өнөөдрийг хүрч байгаа. Үүнийхээ тоог Та бүхэн маань нэмье гэж бодож байгаа юу? Таны хэлж байгаагаар бараг бид нар чинь 2026 он хүртэл эрсдэлтэй нөхцөл байдалтай явж магадгүй юм шиг байна шүү дээ.

Тэгэхээр магадгүй ганцхан шугамаар явж байгаад тэр нь тасраад нэг аймаг харанхуй болчих вий дээ. Хөлдчих вий дээ. Байшин барилга байгууламжууд нь.

Тэгэхээр үүн дээр Та бүхэн маань бас аюулгүйн үүднээс ямархуу бодлогууд барьж байгаа вэ?

Долоод нь, энэ эрчим хүчний урт хугацааны тогтвортой байдлыг хангах дээр Монгол Улсын энэ хоёр хөршөөс гадна ер нь хувийн хэвшил нэг хэсэг Монголын эрчим хүчний салбарыг маш их сонирхож байсан юм. Би өөрөө хувийн хэвшилд ажиллаж байхад энэ төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл дээр ажиллаж байсан. Бид өөрөө мөнгийг нь гаргачихъя. Бид өөрсдөө барьчихъя, хийчихье. Танай төвийн шугам сүлжээ рүү байдаг юм уу. Нийлүүлчихье гэж байхад өнөөдрийг болтол манай баримталдаг гол бодлого бол цахилгааны эх үүсвэр гэдэг бол стратегийнх юм. Энэ бол төрийн оролцоотой л байх ёстой. Мэдээж хувийн хэвшил бол өнөөдрийн энэ иргэдийн хэрэглэж байгаа үнэ тарифаар нийлүүлээд тэндээс нь ашиг олж чадахгүй.

Тэгэхээр бид дундаас нь ер нь дотаци өгөхгүй гэсэн нэг ийм бодлоготой өнөөдрийг болтол явсан. Тэгээд үр дүнд нь заримдаа хэлэхээрээ манайд ийм эрэлт байхгүй ээ.

Үйлдвэрлэл байхгүй, эрэлт байхгүй гээд.

Тэгээд бид нөгөө өндөг анхдагч шүү, тахиа анхдагч уу гэдэг шиг эрэлт нь түрүүлж яваад нийлүүлэлт нь хийгдэх юм уу, нийлүүлэлт нь түрүүлж яваад эрэлт нь үүсэх юм уу гэдгийг нь ярьсаар байгаад сүүлийн арав гаруй жилүүд явчихлаа.

Одоо манай нүүрсийг ухаад эндээс эрчим хүч үйлдвэрлээд гэдэг сонирхож байгаа хөрөнгө оруулагчид багасах шиг боллоо. Та өөрөө түрүүн хэлж байна.

Тэгэхээр эрчим хүч үйлдвэрлээд. Асуучихъя. Нэгмөсөн. Үйлдвэрлээд тэгээд экспортольё гэж санал тавьж байгаа Та бүхэнд хэчнээн төсөл байгаа вэ? Тэгээд энэ бодлогыг ер нь Та бүхэн маань дэмжиж байгаа юу гэдэг. Эхлээд энэ хэдэн асуултуудыг асуучихъя.

Б.Чойжилсүрэн: Х.Булгантуяа гишүүний асуултад хариулъя.

Авлага, өглөг нэмэгдэж байгаа. Би Эрчим хүчний сайдын хувьд 2023 оны 01 сарын 01-нээс нэг л ажлыг эхлүүлж байгаа.

Тэр либералчлал гэдэг том зорилго ярьж байгаа юм. Би тэгж шоудаж чадахгүй байгаа. Либералчлалын эхэнд ямар ч байсан өр нэмэгддэггүй байх ёстой гэж бодож байгаа. Өр нэмэгдэхгүйн тулд ямар ч байсан орлого, зарлага хоёрт эхний ээлжид тэнцүүлье гэдэг ийм шаардлага тавьж байгаа.

Манай яамны хоёр газрын дарга энэ Б.Насантогтох дарга, З.Мөнх-Оргил дарга хоёроор зохицуулах хороотой

нийлж Диспетчерийн үндэсний төвтэй нь хэлэлцсэн. Салбарын харьяа бүх байгууллагуудын бизнес төлөвлөгөөг хийлгэж байгаа. Бизнес төлөвлөгөө хийхээр мөнгөн урсгалын төлөв бас гарч ирнэ. Ямар ч байсан 2023 оныг өр нэмж үйлдвэрлэдэггүй байя гэдэг ийм зорилго тавиад явж байгаа. Үүний тулд менежментээ сайжруулна. Хэмнэлтийн горимд ажиллах ийм сайдын албан даалгавар гаргаад явж байгаа.

Яг өнөөдрийн байдлаар манай эрчим хүчний систем маань 1.6 их наяд төгрөгийн борлуулалт хийж байна. 1 их наяд 580 орчим тэрбум төгрөгийн өр төлбөртэй байна.

Энэ одоохондоо бас яах вэ гэж бодоход. Дээр нь нэмээд намайг сайд болоод очиход гадаадын зээл, тусламжаар 9 төсөл, арга хэмжээ байна. Эрдэнэбүрэнг оруулаад. Төсөвт өртөг нь 750 сая доллар болж байгаа. Энэ төсөл хэрэгжүүлсэн тохиолдолд системийн өр төлбөр энэ хэмжээгээр нэмэгдэнэ.

Тэгэхээр борлуулалтыг нэмэгдүүлж, орлогыг нэмэгдүүлэхээс өндөр аргагүй болж байгаа юм. Ийм тулгамдсан асуудал үүсэж байгаа юм.

Тэгэхээр манай салбарын харьяа байгууллага. Хэрвээ та бүхэн сонирхвол 12 сарын 20-ноос хойш энэ ондоо багтаагаад бид энэ салбарын компаниудын бизнес төлөвлөгөөг шинэчилж баталж байгаа. Ямар ч байсан хамгийн хатуу даалгавар өгч байгаа нь өр нэмэгддэг байдлыг. Өргүй болгоно гэж буруу ойлгож байгаа хүмүүс өр нэмэгддэг байдлыг зогсоож байгаа. Эхний ээлжинд.

Нөгөө доошоо уруудаж байгаа юманд нэг чагт тавиад авна. Тэрний

дараа жоохон ашиг олоод эхлэх юм бол өр төлбөрийг үе шаттайгаар барагдуулах ийм төлөвлөгөөнүүдийг хийж байгаа гэж хэлье.

Импортын хувьд та бүхэн мэдэж байгаа. Тийм ээ. Танилцуулга дээр аваачсан. Нийт борлуулж байгаа цахилгаан эрчим хүчний 23 хувийг бид нар импортолж байгаа.

Оросын Холбооны Улсаас 220 киловольтын хоёр хэлхээтэй шугам ирж байгаа. Цаанаасаа Гусиноозёрск талаасаа 345 мегаватт, шугамын алдагдлаа дотоод юугаа тооцохоор Улаанбаатар хот орчимд 310 мегаватт ирнэ.

Ингээд тулсан. Одоо бид нар ирэх жилийн оргил ачаалал дээр ондоо арга зам байх ёстой. Магадгүй дахиад 40, 50, 60-аад мегаваттаар нэмэгдэх байх. Ямар ч байсан энэ оргил ачааллын үед гайгүй. Шөнөдөө бол хэрэглэгчийн ачаалал буурчих учраас шөнөдөө аккумулятор цэнэглээд нэг арга хэмжээ авна.

Хоёрдугаарт, хэрэглэгч нартаа яг энэ оргил ачааллын цаг, нэн ялангуяа 11, 12, 01, 02, 03 дугаар сарын энэ хүйтэн саруудад оройн 18-аас шөнийн 21 цаг, 22 цаг хүртэл хэрэглээгээ хязгаарлаач ээ гэдэг ийм уриалга гаргаж байгаа. Ард иргэддээ, бас хэрэглэгч нартаа ийм зүйлийг аргагүй бодит байдал, үнэнийг хэлсэн нь дээр.

Хоёрдугаарт, тэр нь тарифын өөрчлөлт бид нар хийж эхэлнэ. Одоо. Оргил ачааллын цагаар илүү үнэтэй болоод өдрийн цагаар бусад цагуудаар нь тэр хэмжээгээр нь буулгах. Нөгөө үнээр зохицуулах арга хэмжээ бас давхар авахгүй бол болохгүй. Дан ганц

үүссэн хэрэглээ болгоныг ямар ч хамаагүй өртгөөр барагдуулна гээд ингээд явах юм бол салбар өөрөө магадгүй миний сая дээр дурдсан салбаруудыг хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхгүй бол 10 их наяд төгрөгийн өр төлбөртэй болж магадгүй болох гээд байгаа юм.

Тэгэхээр нөгөө дампуурал гэдэг өрийн тогтвортой байдлыг хангах гэдэг энэ сэдвийг аягүй төвөгтэй байдал үүсэх учраас би эрчим хүчний салбар дээр Эрчим хүчний сайд болоод очиж байгаа миний хоёр дахь мессеж бол бүртгэлийг сайжруулна, үр ашгийг нэгдүгээрт тавина. Үр ашиг, техникийн бэлэн байдал хоёр ижил тэнцүү түвшинд үнэлэгдэнэ гэж ойлгож, би энэ салбарын бүх компанийн удирдлагууд, ТУЗ-уудад ийм чиглэл өгч байгаа.

Оросын Холбооны Улсаас импорт зогсвол яах вэ гээд. Ер нь яг үнэндээ Оросын Холбооны Улсын энэ шугам дээр юм уу, цаад талдаа аваар гарах юм бол бид тэр импортлох хэмжээгээр л хязгаарлалтад тулна.

Одоо та бүхэнд нэг зүйлийг. Одоо ТЭЦ-IV гээд жишээлбэл 8 турбо генератор, турбинтой бол наймуулаа ажиллаж байгаа, 7 зуухтай гэвэл долуулаа ажиллаж байгаа. Ямар ч нөөц байхгүй байгаа. Аль нэг тоноглолд эвдэрсэн хэмжээгээр хязгаарлалт явна.

Тэгэхээр бид ТЭЦ-IV дээр хамгийн том турбин 80 мегаваттын турбин зогслоо гэхэд 80 мегаваттаар хязгаарлаж таарна даа.

Тэгэхээр бид нар эхний ээлжид энэ ард иргэддээ арай бага нөлөөтэй том хэрэглэгч нар дээрээ эхний ээлжид 82 мегаваттын эхний ээлжид жагсаалт

гаргачихсан байгаа. Тэр хүмүүсийг энэ оргил ачааллын цагаар хязгаарлана. Ард иргэдийг бол нэг лаа шүдэнз бэлтгэх хэмжээнд хүргэхгүй байх.

Тавантолгойн цахилгаан станцын тухайд одоо нэрийг нь хэлэлцүүлээд ид явж байна. Нэрийг нь ил зарламааргүй байна. Зээл авахаар ярьж байгаа. Offtake-ээр санхүүжүүлэхгүй гэж бодож байгаа. Тавантолгойн цахилгаан станцыг.

Энэ 2023 оны 01 дүгээр сар гэхэд санхүүжилтийг нь шийдсэн тохиолдолд бид тендерийг зарлана.

Тийм учраас би 2023 оны эхний хагастаа багтаж тендерийн дүнд гүйцэтгэгч шалгарна. Ажлыг эхлүүлэх ийм төлөвлөгөөтэй гэж Та бүхэнд танилцуулаад байгаа.

Уучлаарай. Эцэслээгүй байгаа учраас нууцлалын хэмжээнд байгаа асуудлыг олон нийт болон Та бүхэнд ярьж боломгүй байна.

Сэргээгдэх эрчим хүчний талаар төвөгтэй байна. Сэргээгдэх эрчим хүч маань. Та бүхэн мэдэж байгаа шүү дээ. Усан цахилгаан станц бол бас бололцоотой. Диспетчерийн удирдлагад орж болдог. Хэзээ, хаана, ямар үнээр авахаа захиалж болдог. Нар, салхин дээр бол үнэхээр түвэгтэй. Наргүй бол үйлдвэрлэхгүй, салхи зогсвол үйлдвэрлэхгүй.

Тэгэхээр энэ хэмжээний чадлыг бусад газартай бид нар нөөцлөх хэрэгтэй болно.

Тэгэхээр одоо яг манайд эрчим хүчний системийн хувьд, төвийн бүсийн

хувьд түвэгтэй байдал үргэлжилнэ. Тохируулгын асуудлыг ярьж байгаа.

Энэ **storage battery** гэдэг юмаар шийдэх гэж оролдсон чинь бас бүрэн шийдэл биш байна. Сул талууд байна. Ямар ч байсан бид одоо ингээд 200 мегаваттын нэг батарей юун дээр эхлүүлчихсэн байна. 2023 ондоо ашиглалтад оруулна гэж бодож байгаа.

Дэлхийн банктай бас нэг тодорхой хэмжээний Говь-Алтай дээр нэг батарей ярихаар санал өгчихсэн явж байгаа. Ийм байдалтай байна.

Ямар ч байсан хязгаарлалт хийхгүйхэншиг энэ хүнд хямралт нөхцөл байдлыг 2024 оны төгсгөл 2025 он гэхэд хэвийн болгох ийм л бололцоо бий. Үүнээс наана яаж ч гүрийгээд, яаж ч амлаад хоосон зүйл шүү гэдгийг бас таны асуултаар дамжуулаад олон нийтэд хэлье.

Эрчим хүчний тогтвортой байдлыг яаж хангах вэ гэдэг энэ асуудлыг ерөнхийдөө асуултад хариулчих шиг боллоо.

Бүх эрчим хүчний систем, төвийн эрчим хүчний систем гэж байгаа л бол төрийн оролцоо байна. Төрийн оролцоо байхдаа юу вэ гэхээр эрчим хүчнийхээ горим тохируулгаар одоо манай Диспетчерийн үндэсний төвийн захирал байна. Бид нар хэрэглэгч, үйлдвэрлэгчийн хооронд манай энэ дамжуулах шугам, түгээх шугамаар дамжиж л байгаа бол бид захиална. Төдийд ийм хэмжээний захиалга өгнө өө. Ингэж нийлүүлээрэй гэдэг зүйлийг ярина. Тус тусдаа ер нь дамжуулах сүлжээ, түгээх сүлжээ дахин параллел барина гэдэг бол утгагүй зүйл. Бусад зүйл дээр нь аль болох төрийн оролцоо

бага болгоод энэ салбар луу хөрөнгө оруулсан хүн ямар ч байсан эхний ээлжид оруулсан хөрөнгөө буцаагаад олж авдаг ийм үнийн зохист харилцаанд хүргэхийн тулд энэ миний бүрэн эрхийн хугацаа хүрэхгүй юм билээ.

Одоо 2024 оны 7 сар хүртэл миний бүрэн эрхийн хугацаа 600 орчим хоног байна. Энэ хугацаанд би магадгүй дахиад нэг алхам хийх байх. Тэр либералчлал гэдэг бол үе үеийн эрчим хүчний сайд нар маш үзэл бодол дээрээ хатуу чанга энэ шүүмжлэлийг давж гараад хийдэг ажил юм шиг байна лээ.

Би эхний хоёр алхмыг хийгээд миний бүрэн эрхийн хугацаа дуусах байх гэж би бодож байгаа юм.

Нийлэлт эрэлт хоёрын аль нь түрүүлэх вэ гэж байна. Одоо бол эрэлт нь түрүүлчихсэн байгаа. Нийлүүлэлтийг түрүүлэх арга хэмжээг би сая хэлсэн. Эх үүсвэрүүдийг хийхэд жоохон төрүүлнэ. Гэхдээ шарга азарга шиг хол төрүүлэхгүй. Нэг цахилгаан станц барих юм нь 3 жилийн нөөц л барина. Түүнээс илүү эх үүсвэрүүд барих юм бол нөгөө өрийн тогтвортой байдал, систем өөрөө дампуурчих гээд байгаа учраас магадгүй ойрын 10, 15, 20 жилийн тухайд иймэрхүү харилцаанд л байна.

Олон нийт ч ярьж байна. Зарим гишүүд ч ярьж байна. Боомилж байна гэж ярьж байгаа. Иймэрхүү зүйлүүд боомилж байгаа нь үнэн. Гэхдээ боомилохоо болихдоо боомилохоо болихгүй гээд ямар ч тооцоогүй хүчин чадлыг нэмэх нь утгагүй байгаа. Ийм л бодлого барьж байгаа.

Үйлдвэрлээд экспортольё гэсэн ийм төслүүд урьдны Засгийн газрын үед санал тавьж байсан юм байна.

Харамсалтай нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын “Тэг КОВИД” гэдэг бодлогын дагуу сүүлийн хоёр, гурван жил ерөнхийдөө аж ахуйн харилцаанууд бүрэн зогссон гэж болно.

Дөнгөж сая өнгөрсөн долоо хоногт Хятадын нэг аж ахуйн нэгжтэй би уулзлаа. Монгол Улс сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр бараад Хятад Улс руу экспортолье. Эрчим хүчний сайдын хувьд дэмжих үү гэсэн. Дэмжинэ гэсэн. Хоёр гар, хоёр хөлөөрөө дөрвүүлэнгээр нь гар өргөж дэмжинэ гэдгээ илэрхийлсэн байгаа. Хамтарсан ажлын хэсэг байгуулья гэсэн ийм л байдалтай байна.

Х.Булгантуяа: Манай Улаанбаатар хотоос сонгогдсон М.Оюунчимэг гишүүн, манай гишүүдээс ийм саналууд ирсэн.

Шахмал түлшний асуудал. Энэ шахмал түлшний чанар бас муудаад байна гэж иргэдээс санал ирээд байна. Энэ шахмал түлшний чанарын асуудал, хангамжийн асуудал энэ өвөл ямар нэгэн байдлаар доголдохгүй биз дээ. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Налайх бас энэ шахмал түлш хэрэглэдэг дүүрэг болсон. Үүнтэй холбоотойгоор манай Төв аймгийн иргэд түүхий нүүрсээ Багануураас аваад ингээд Налайхаар дамжуулаад тээвэрлэх гэхээр Налайх дээр үүнийг хурааж аваад байна.

Тэгэхээр үүнийг яах вэ? Одоо жишээлбэл, 11 дүгээр сард Төв аймгийн н.Даваадорж гэдэг иргэн Mighty дүүрэн өөрийнхөө нүүрсийг хураалгасан гэж байгаа юм. Улсын өмч болгон авчихдаг.

Тэгэхээр энэ Төв аймгийн иргэдийг одоо яаж гэр орноо халааж, нам даралтыг нь зуухуудаа халаана гэж тооцож байгаа юм бэ?

Гуравдугаарт, гэр хорооллын айл өрхүүдийн шөнийн тарифын цахилгааны тарифын хөнгөлөлтийн асуудлын санхүүжилтийг 2022 оны төсөвт ч шийдсэн, 2023 оны төсөвт Улсын Их Хурлын гишүүд санал гаргаад үүнийг шийдсэн. Хөдөө орон нутгийн аймгуудын төвүүдийг ч гэсэн үүнд хамруулсан. 30 гаруй тэрбум төгрөгийг баталсан.

Гэтэл энэ дуусчихсан, зогссон гээд одоо яг энэ ид хүйтэн үед хэрэгжихгүй байна гэсэн ийм гомдол, санал бас ирээд байна. Энэ хэрэгжиж байгаа юу?

Дээрээс нь цахилгаан станцууд руу ханган нийлүүлдэг нүүрсний уурхайнууд маань өөрсдөө нэлээн их авлага үүссэн. Тухайлбал, Шарын гол, Дархан, Эрдэнэт гээд дулааны цахилгаан станцуудад нийлүүлдэг эдгээр хөрс хуулалт нь явахаа байлаа гэж байна. Мөн дизель түлштэй холбоотойгоор олборлолт татан авалт муу байна гэж байна.

Тэгэхээр эдгээр аймгуудын дулаан хангамжийн асуудал гайгүй биз дээ. Нүүрсний уурхайнуудтай холбоотой хүндрэл бэрхшээл байна уу гэдэг ийм хэдэн асуултуудыг асуух гэсэн юм.

Б.Чойжилсүрэн: М.Оюунчимэг гишүүний асуулт юм байна. Тийм ээ.

Шахмал түлш дутагдахгүй ээ. Доголдлын талаар янз бүрийн хүмүүс шүүмжлэл ярьж магадгүй. Гэхдээ зүүн

үйлдвэр дээр баруун үйлдвэр, ТЭЦ-Ш-ын үйлдвэр дээр байгаа 19 шугам ажиллаж байгаа. Шахмал түшний.

14-ийг нь ажиллуулаад энэ өвлийг давна гэсэн тооцоо хийсэн. 5 шугам, 16, 17, 18 дахь шугамууд нь 12 сард багтаад ашиглалтад орно.

Бүх шугамууд дээр хатаалгатай гаргаж байгаа. Өнгөрсөн жилүүдэд ганц нэг тийм түүхий, гүйцэд хатаалгүй гараад түшний чанар муудсан янз бүрийн шүүмжлэлүүд байсан юм билээ. Энэ жилдээ одоохондоо бид нар тэр тийм шүүмжлэл бол харьцангуй бага ирж байна. Ганц нэг шүүмжлэл би ирснийг нь орхигдуулсан байж магадгүй. Гэхдээ ерөнхийдөө гайгүй байгаа.

Налайх дээр түүхий нүүрс оруулахгүй байгаа учраас Төв аймаг руу иргэдийг таны ярьсан ганц нэг тохиолдол гарсан байх. Улаанбаатар хот руу түүхий нүүрс оруулахгүйн тулд Цагдаагийн ерөнхий газрын хяналт байгаа. Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга Ц.Ням-Очироор ахлуулсан ажлын хэсэг явж байгаа.

Хадад хоёр удаа ийм шүүмжлэл ирэхээр нь Ц.Ням-Очир даргатай ярьсан. Сүүлийн өдрүүдэд над дээр ийм асуудал ирээгүй. Ямар ч байсан Төв аймгийн иргэдийг Багануураас нүүрсийг нь оруулж байгаа. Хэрвээ тийм гомдол байгаа бол дахиад бид нарт холбогдоорой. Бид энэ Цагдаагийн ерөнхий газартай холбогдож асуудлыг шийдье. Асуудал гайгүй л байх ёстой гэж би бодож байгаа юм.

Гэр хорооллын цахилгааны хөнгөлөлтийн талаар Та бүхэнд бас мэдээлэл өгье.

С.Одонтуяа: Минут нь дуусчихсан даа. 20 минут нь.

Тэгэхээр Улсын Их Хурал дахь Монгол Ардын Намын бүлгийг төлөөлж Х.Булгантуяа гишүүн асуултаас асуусан.

Одоо Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь Засгийн газрын гишүүнээс асуулт асууна. 20 минут үргэлжилнэ.

Ж.Батсуурь: Сая Х.Булгантуяа гишүүн асуултаа эхэлж бүгдийг тавьсан.

Миний бодлоор шууд асуугаад хариулаад, асуугаад хариулаад явах нь илүү оновчтой болов уу гэж бодож байна.

Тэгээд түрүүнд миний хувь гишүүнийхээ хувьд асуусан асуултад та бас хариулаагүй байгаа. Тэрнээсээ үргэлжлүүлээд явчихъя гэж бодож байна.

2016 онд эрчим хүчний салбарын үйл ажиллагааны алдагдал үндсэндээ тэглэж байсан. Тэгээд 2016 оноос хойш шинэ эх үүсвэр барьж чадсангүй. Үүнээс хойш хамгийн их өрийг үйлдвэрлээд энэ хүрлээ гэж. Үүнтэй та санал нэг байна уу? Салбарын сайдын хувьд. Ингээд хариулаад явчих.

Г.Занданшатар: Асууж хариулаад, мэтгэлцэх зарчмаар шууд хоёр микрофон асаалттай явна шүү.

Мэтгэлцээний зарчмаар явж байгаа шүү дээ. Сая асуулт хариулт явчихсан юм шиг байна.

Б.Чойжилсүрэн: Ж.Батсуурь гишүүн ээ, би наад танилцуулгыг чинь бэлтгэж хүргэхдээ жишээлбэл, би 2012-2016 онд алдагдал багатай байсан үеийг нь нууж болох байсан юм. Би бодит мэдээлэл Та бүхэн нэгдүгээрт хүргэж гэж бодсон.

2016 оноос хойш эх үүсвэрүүд ашиглалтад орсон уу гэсэн ийм шүүмжлэл явж байна. Магадгүй тэр Багануурын цахилгаан станцын тухайд ашиглалтад оруулаагүй хойшлуулсан байна.

2017 онд энэ ТЭЦ-III-ын өргөтгөлийн талаар би Сангийн сайд байхдаа гэрээг нь хийгээд Оросын Холбооны Улсын Сангийн сайд А.Г.Силуановтай тохироод эх үүсвэрийг нь олж ирээд явсан. Харамсалтай нь өнөөдрийг хүртэл ажиллуулаагүй ийм шүүмжлэлүүд байгаа.

Ж.Батсуурь: Ойлгочихлоо. Та түрүүнд хариулахдаа Багануурын 700 мегаваттын цахилгаан станцын гэрээ хийгдээд янз бүрийн шалтгаанаар зогссон гэж. Янз бүрийн шалтгааныхаа эхний 5 шалтгааныг хэлнэ үү? Эхний 5 шалтгаан нь хэлнэ үү.

Б.Чойжилсүрэн: Ярья. Эхлээд Багануурын цахилгаан станцыг 2017 онд концессын гэрээ байгуулсан.

Хоёрыг үржих нь 350 мегаваттын хүчин чадалтайгаар гэрээ байгуулсан юм билээ. Ц.Даваасүрэн сайдын үед энэ хүчин чадал системд нөлөөлнө. Аль нэг турбин зогсоод гэмтэл гарах юм бол системд нөлөөлөх юм байна гэдэг ийм шалтгаанаар удаашруулсан юм билээ.

Сүүлд дахиад хоёрыг үржих 200, нэмэхэд 300 гэдэг ийм турбиныхээ

сонголтыг өөрчлөөд ийм асуудлаар хийж явж байгаад Ши Жиньпин даргын энэ юу мэдэгдэлтэй холбоотойгоор ингээд зогсчихсон байгаа юм билээ.

Ж.Батсуурь: Дээр нь энэ Эрчим хүчний зохицуулах хороо гэж байдаг. Эрчим хүчний тухай хуулийн 9.1.5-д Эрчим хүчний зохицуулах хороо зохих ашгийн түвшин бүхий үнэ тарифын тогтолцоог бий болгох эрхтэй гээд ингээд эрхийг нь өгчхөөд байхад яагаад ажлаа хийхгүй ингээд Монгол оронд өр үйлдвэрлээд байдаг юм бэ?

Ингээд хуулийнхаа дагуу ажлаа хийхгүй байгаа ийм байгууллага байх ёстой юм уу, байх ёсгүй юм уу? Энэ ажлаа хийхгүй байгаа хүмүүстээ ямар хариуцлага тооцдог юм бэ? Энэ чинь хуулиар үүрэг өгчхөөд байхад тэр үүргээ биелүүлэхгүй байгаа хүмүүсийг та арга хэмжээ авах уу? Энэ энэ байгууллага цаашид байх ёстой юу гэсэн асуултад хариулаач.

Б.Чойжилсүрэн: Ж.Батсуурь гишүүн ээ, яг Эрчим хүчний хуулийн наад заалтаар чинь Эрчим хүчний зохицуулах хороо бусдаас хараат бусаар үнэ тарифыг ч нэмэх зохицуулах дотоод бүрэн эрхтэй.

Гэхдээ энэ Засгийн газрын харьяа байгууллага. 2020, 2021, 2022 он хүртэл энэ КОВИД-ын хүндрэлтэй, хөл хориотой нөхцөл байдал байсан учраас нэмэгдүүлж чадаагүй гэдэг. Одоо намайг ажил авахад ийм танилцуулга хийсэн. Сая 11 сарын 01-нээс тодорхой хэмжээний тарифын өөрчлөлт нэмсэн. Үүний дагуу 2022 оны 12 сарын 01-нээс 3 уурхай. Багануурын уурхай, Шарын голын уурхай, Шивээ-Овоогийн уурхай дээр нүүрсний үнийг дунджаар нэг тонн нүүрсний үнийг ар 10000 төгрөгөөр

нэмсэн. Энэ үнийн нэмэлт дээр энэ 3 уурхай дээр одоо нэмэлт 71 орчим тэрбум төгрөг нэмэгдэж очно.

Ж.Батсуурь: Бид хоёрын хоёулангийнх нь микрофоныг байнга нээчхээч. Мэтгэлцэж байгаа учраас. Цаг алдмааргүй байна.

Та ингэж яриад байх юм. КОВИД-ын юм гэж яриад байх юм. 2016 оноос чинь хойш 7 жил болчихсон байна шүү дээ. КОВИД сүүлийн нэг жил юм уу, сүүлийн хоёр жилийн л асуудал шүү дээ.

Яагаад ингээд бүх болохгүй өр үйлдвэрлэхээд, долоо, найман өр үйлдвэрлэхээд зүгээр явж байсан системийг доголдуулчихаад, эх үүсвэрийг нь зогсоочхоод. Тэгээд яагаад сүүлийн 2 жилийн КОВИД дайн руу чихээд байдаг юм бэ? Үүнийгээ та нэг тайлбарлаж өгөөч.

Б.Чойжилсүрэн: Танд хүргүүлсэн танилцуулгаар хамгийн өндөр алдагдлууд нь 2022 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэл, 2021 он, 2020 он байгаа.

Түүнээс өмнөх нь хэдийгээр мэдээж алдагдалтай байсан боловч ийм огцом алдагдлууд байгаагүй юм билээ. Энэ КОВИД гэдэг ертөнц чинь дэлхий ертөнцийг сэгсрээд дуусгаж байна шүү дээ. Хүндрэлүүд гарч байна. Та бүхэн мэдэж байгаа.

Үнийн өсөлтүүд гээд. Одоо сүүлийн жилүүдэд Төв банкнууд бодлогын хүүгээ чангаруулснаас шалтгаалаад санхүүгийн зах зээл дээр эх үүсвэрийн хомсдолууд үүсэж байна. Гэх мэт олон асуудлууд байгаа.

Ж.Батсуурь: Та КОВИД-ын хүндрэл гээд байх юм. Таны өгсөн энэ график дээр чинь 2017 оноос авхуулаад л энэ өр чинь нэмэгдээд явчихсан байна шүү дээ. 2017, 2018, 2019 он, 2020 оны эхний он жилүүдэд КОВИД гэдэг юм чинь сураг ч үгүй байсан шүү дээ. Тэгээд яагаад ингээд өр үйлдвэрлэгдээд яваад байдаг юм? Энэ таны яаж өгсөн юу байна л даа.

Тэгэхээр үүнийг 2022 оноор тайлбарлаад, 2021 оноор тайлбарлаад байх юм. Би танаас 2017, 2018, 2019, 2020 онуудад яагаад ингээд зөв зүгээр явж байсан системийг өр үйлдвэрлээд байдаг юм бэ? Яагаад эх үүсвэрийг бариулахгүй гацаагаад байдаг юм бэ? Эхнийхээ 5-ыг хэл гэнгүүт нэг л зүйл яриад байх юм.

Үүнийгээ та тодруулаад хэлж өгөөч.

Б.Чойжилсүрэн: Тодруулья. Ийм алдагдлууд байсан. Харамсалтай нь уг нь эрчим хүчний систем нэг ийм онцлогтой байна. Зардал нь дандаа зах зээлийн ханшаар гардаг. Дээд талаасаа үнэн тохиргоотой байхаар цаг хугацаандаа үнийг өөрчилж явахгүй бол наад алдагдал чинь үүсчхээд байгаа юм.

Бид дараагийн алхам болгоод эдийн засгийн нөхцөл байдал сэргэх юм бол энэ үнэ, тарифыг бүгдийг нь индексжүүлчихээр байгаа юм. Томьёотой. Тэгээд яг зардал өсөж байгаа бол үнэ дагаж өөрчлөгддөг ийм байдал руу шилжүүлэхгүй бол ийм хүндрэлүүд байгаад байгаа юм.

Манай энэ салбар бол яг ингээд 1990 оноос хойш ардчилсан өөрчлөлт явснаас хойш бүрэн либералчилж энэ зах зээлийн системд шилжиж чадаагүй

үлдсэн цөөн хэдэн салбарын нэг нь мөн үү мөн. Үүнийг бид үе шаттайгаар либеральчилж зах зээлийн горимд нь шилжүүлэх арга хэмжээнүүдийг авна.

Гэхдээ өөрчлөлт хийх гэж байна гээд нураачих ч бас болохгүй байх. Үе шаттай очих байх энд.

Ж.Батсуурь: Энэ Монголын эрчим хүчний үйлдвэрлэлийн оргил ачаалал 1422 мегаватт. Үүн дотор нарных 90 мегаватт, салхиных 150 мегаватт гээд. Тэгээд энэ нар, салхи хоёр нь өвөлдөө бол үндсэндээ дэм болдоггүй л дээ. Болдоггүй юм байна. Тооцоогоор.

Гэтэл энэ нар, салхины эрчим хүчийг босгож ирнэ гээд энгийн хэрэглэгч бид нараас хулгайлаад энэ нар, салхины эрчим хүчний бизнесийн мафийг дэмжээд байдаг юм биш үү?

Энэ чинь Монгол Улсад бид нарт дэм биш энгийн иргэдээс Монгол орны бүх нутаг дэвсгэрийн сахлын машин хэрэглэж байгаа, индүү хэрэглэж байгаа хүн болгоноос хулгайлж аваад ингээд нар, салхины бизнес эрхэлж байгаа мафийг дэмжээд байдаг юм биш үү? Та үүнийг ер нь юу гэж бодож байна?

Б.Чойжилсүрэн: Ж.Батсуурь гишүүн ээ, би тантай ер нь ойролцоо байр суурьтай байгаа учраас энэ нар, салхины станцуудыг үнэ буулга гэдэг шахалт явуулаад байгаа юм.

2023 оны нэгдүгээр улиралдаа багтааж Засгийн газарт энэ хөрөнгө оруулагч нартаа танилцуулна.

Одоо ажиллаж байгаа 9 сэргээгдэхээс гадна тусгай зөвшөөрлөө сунгуулчихсан дахиад 11 бий.

Тэгэхээр одоо энэ Эрчим хүчний тухай хуулийг 2007 онд баталсан юм байна лээ. Улс төржүүлээд яах вэ. Тэрнээс хойш олон Засгийн газрууд солигдсон. 15 центээр байна гээд баталчихсан юм билээ. Одоо энэ хуулийг өөрчлөхөөр бид судалгааг нь хийж байна. Энэ хөрөнгө оруулагч нартай хийх хэлэлцээрээ хамт.

Таны яриад байгаа тэр дэмжих тариф үнэн. Нүүрсний эх үүсвэрээс 60 төгрөгөөр борлуулчихаад дахиад тэр таны яриад байгаа тэр дотор чинь 23 төгрөг байгаа. Сэргээгдэх эрчим хүчний хувь нь, систем дотроо эзлэх хувь нь нэмэгдэх юм бол томьёо гараад дахиад бүр нэмэгдэнэ. Тавин хэд болно. Үүнийг өөрчлөхөөс өөр аргагүй.

Тэр мафи гэж улс төржүүлээд шоудаад худлаа яриад яах вэ. Иймэрхүү хууль бид нялхсын өвчин гэх юм уу. Мэдэхгүй байж байгаад л тэр үеийн улс төрчид баталжээ энэ хуулийг.

Ж.Батсуурь: Мафи л гэсэн үг л дээ. Мэдсээр байж энгийн иргэдээс булааж аваад энэ салбарыг дэмжээд байна гэхээр мафи биш юу гэх вэ дээ. Хулгай шүү дээ. Энэ чинь. Ил цагаан дээрэм шүү дээ.

Дээр нь энэ дулаан. Монгол Улсын бүх нутаг дэвсгэрт тог хэрэглэдэг. Монгол Улсын өрх бүр дулаан хэрэглэж чаддаггүй. Тэгээд тог хэрэглэдэг бүх хүмүүсээс мөнгөний дээрэм аваад дулаан хэрэглэдэг цөөн хүмүүст дотаци өгөөд байх юм. Энэ одоо шударга явдал уу? Та үүнийг юу гэж бодож байна? Бүх хүний тог хэрэглэдэг үнээс нэг хэсгийг нь булааж аваад нар, салхины эрчим хүчинд та

мафи ч, мафигүй ч бай тэжээчихэж байна.

Дээр нь ахиад үйлээ барж, үсээ цайлгаж байгаа хүмүүсээс энгийн иргэдээс бас баахан мөнгө булааж аваад энэ дулааныг дэмжээд байдаг нь ямар учиртай юм бэ? Үүнийг та ер нь юу гэж бодож байна? Бас л тантай санал нэг байна гээд хэлэх үү?

Б.Чойжилсүрэн: Хариулъя. Та зөв шүүмжлэл, шударга санал дэвшүүлж байгаад талархаж байна. Нэг.

Яг энэ цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхээр дэргэд нь бас дулаан үйлдвэрлэгдэнэ. Тодорхой хэмжээгээр.

Тэгэхээр энэ зэрэг үйлдвэрлэгдэж байгаа. Эрчим хүчний зохицуулах хороон дээр бид судалгааг хийж байгаа. Дулааны үнэд хэтэрхий доогуур байгаагаас шалтгаалаад цахилгаан хэрэглэгч нар нь дулаан хэрэглэгч нарынхаа дотациар тойруу замаар санхүүжүүлж байгаа нь үнэн.

Нэг жишээ. Улаанбаатар хотын төвд 50 метр квадрат орон сууцанд амьдарч байгаа айл 8 сарын хугацаандаа дулааны улиралд 320 орчим мянган төгрөгийн зардал гаргаж байгаа юм. Гэтэл гэр хороололд амьдарч байгаа нэг айл 50 метр квадраттай хувийн орон сууцтай айл 4 тонн нүүрс хэрэглэж байна. Энэ хооронд нүүрсийг нүүрс борлуулах цэгээс авч ирээд галлах зардлыг ерөөсөө огт тооцохгүйгээр хувийн хэрэглээнд нь гэж бодоход 4 тонн нүүрс маань 600 мянган төгрөг.

Тэгэхээр дулааны үнэ дээр иргэд зайлшгүй эргэж харах гээд байгаа шалтгаан нь би танд энэ. Би сая хэлсэн шүү дээ. Үйлдвэрлэсэн өртгийнхөө 40-

хөн хувиар дулааныг борлуулж байна. Энэ харилцааг өөрчлөхгүй бол, харьцааг өөрчлөхгүй бол Улаанбаатар хотын дулааны системийг одоо байгаа хэрэглэгчийнхээ хувьд л алдагдалтай явна уу гэхээс биш шинээр эх үүсвэр, дулааны эх үүсвэр барихад тун хүндрэлтэй болсон байдалтай байна.

Ж.Батсуурь: Минут бага байгаа учраас би Монголын ард түмэнд бас олон зүйлийг танаас юу авчихъя гэж бодож байна.

Танайх Эрчим хүчний яам биш бараг эрчим хүч, халамжийн яам яасан юм бэ. Монголын бүх эрчим хүч хэрэглэдэг хүмүүсээс нэг хэсэг мөнгийг нь дээрэмдэж аваад нар, салхины эрчим хүчинд өгчихнө. Тэрийгээ мафи гэхинэ. Хэчнээн жил тэжээчихсэн. Хэдэн арван тэрбум, хэдэн зуун тэрбумаар нь цусалчихсан.

Индүү, плитка хэрэглэж байгаа бүх ядарсан хүмүүсээс мөнгө хурааж аваад дулааныг нь нөхчихнө.

Өхиад илүүг нь КОВИД-ын үед гээд тэр халамжийн бодлого Засгийн газар нь явуулдаг л юм байгаа биз. Нийгэм халамжийн яам нь явуулдаг л юм байгаа биз. Өгөөмөр хүн өөртөө хоосон. Өөрсдийгөө яая гэж байж яахаараа энд тэндхийн юманд илүү дутууг зарцуулж байдаг юм бэ?

Тэгээд тэр нь шударга бус. Долоон буудалд байгаа эмгэн болохоор танайхаас КОВИД-ын үед нэг сард 20-иос 30 мянган төгрөгийн хөнгөлөлт авч байдаг. Нүхтийн аманд байгаа, бусад уулын амуудад байгаа хүмүүс саяас гурван сая төгрөгийн хөнгөлөлт авч байдаг.

Баян, дундаас илүү, байж ядсан хүмүүс нь болонгуут төрөөс хэчнээн арван тэрбумаар нь хөнгөлөлт аваад байдаг. Энгийн иргэн 20-иос 30 мянган төгрөгийн хөнгөлөлт аваад байдаг. Тэгсэн мөртлөө бүх энгийн иргэдээс авсан мөнгөөрөө ингээд халамжийн бодлого явуулаад байдгийг та хэзээ таслан зогсоож чадах юм? Одоо би сайд болоод удаагүй л гэж байна. Та. Одоо сайд байх хугацаандаа энэ халамжийн бодлогоо зогсоох юм уу? Үгүй бол Эрчим хүч халамжийн яам болох юм уу? Үүнийг та шууд хариулаад өгөөч.

Б.Чойжилсүрэн: Ж.Батсуурь гишүүний асуултад хариулья.

Сая би хэл амд орон чадан ядан энэ либералчлал гэдэг бодлого руу чинь явж байгаа. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртгийг бүрэн хураадаг байх ёстой. Ийм шилжилт рүү явж байгаа. Халамжийн үйлчилгээ үзүүлэхгүй байгаа.

Гэр хорооллын иргэдийн шөнийн эрчим хүчний тарифыг хөнгөлөлтийн талаар улсын төсөвт суугаад тэр иргэдийн өмнөөс эрчим хүчний салбарт бид борлуулсан бүтээгдэхүүнийхээ үнийг улсын төсвөөс авч байгаа ийм л байдалтай байна.

Ж.Батсуурь: Дараагийн асуултауд олон газраас ирсэн. Асуугаад та бид хоёр 20 минутад би ч асуугаад та ч хариулаад дуусахгүй байх.

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг барихад 200 айл нүүхээр байгаа. Увс, Баян-Өлгий аймгийнх. Намаржаа, өвөлжөө, хаваржааны асуудлыг яаж шийдэж байгаа вэ? Шийдвэр нь бүрэн гарсан уу гэсэн асуулт байна.

Хоёр дахь асуулт нь, баруун бүсийн цахилгаан эрчим хүчний хөнгөлөлтийг яагаад хэрэгжүүлэхгүй байгаа юм бэ гэсэн асуулт байна.

Гуравт нь, Баян-Өлгий аймгийн Булган, Дэлүүн сумдад нэг тонн нүүрс 260 мянган төгрөг болсон. Үүнийг та мэдэж байгаа юу? Буулгах боломж бий юу гэсэн энэ гурван асуултад товчхон хариултаа авъя.

Б.Чойжилсүрэн: Ж.Батсуурь гишүүн ээ, 200 айл биш, 270 айл байгаа.

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын усан сангийн нөлөөлөлд автаж байгаа. Увс, Баян-Өлгий, Ховд гурав ороод. Ирэх ирэх долоо хоногийн 12 сарын 07, 0,8 09-нд манай Эрчим хүчний яам бид нар энэ 3 аймаг, 3 сум дээр очиж ажиллахаар төлөвлөчихсөн байгаа.

Баруун бүсийн эрчим хүчний систем маань өөрөө алдагдалтай байгаа шүү дээ. Энэ жилийг хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр бараг 22 орчим тэрбум төгрөгийн алдагдалтай байгаа. Үүнийг яриад эхлэх юм бол нэлээн урт түүх болно.

Хэрэглэгч дээр нь очиж би энэ асуудлыг ярья. Баян-Өлгий аймгийн зарим сумууд дээр нүүрсний үнэ ингэж өссөн нь үнэн. Увс аймгийн Бөхмөрөн сумын нутагт байгаа Хотгороос нүүрс авч явдаг. Тээврийн зардал өндөр байгаа учраас ийм өндөр үнэтэй болчихсон байгаа.

Ж.Батсуурь: Таны өгсөн мэдээлэл дээр эрчим хүчний салбар сүүлийн жилүүдэд өвлийн их ачааллыг 63 зуух, 42 генератор ажиллаж, ашиглах

нөөц тоноглолгүй ажиллаж байна гэж байна.

Тэгэхээр аваар үүсэх бүрэн нөхцөл байна гэж ойлгох уу? Нэгдүгээрт.

Нэгэнт аваар ярьсантай холбогдуулж Оросын Холбооны Улсаас 310 мегаватт цахилгааныг авдаг гэж байна. Мэдээж өгөхгүй бол яах вэ гэж. Гэнэтийн осол гарвал яах вэ? Баруун бүс чинь шугам салхинд янз бүрийн шалтгаануудаар нурдаг. Оросоос орж ирж байгаа цахилгааны хөл нурах юм уу, шугам тасрахад 310 мегаватт тасалдахад Монгол Улсыг яаж аваръя гэж байгаа юм бэ?

Хоёр дахь А, Б, В төлөвлөгөө нь юу байгаа юм бэ гэсэн асуулт байна.

Б.Чойжилсүрэн: Төвийн эрчим хүчний системд цахилгаан эрчим хүч нийлүүлдэг 8 дулааны цахилгаан станц байна.

Эдгээр 8 станц дээр 63 зуух, 42 генератор бүгдээрээ зэрэг ажиллаж байгаа. Уг нь 8 зуухтай бол нэг нь нөөцөд байдаг. 7 нь ажиллах ёстой байсан. Ийм эх үүсвэр бүгд шавхагдаад дууссан.

Эвдэрсэн тоноглолын хэмжээгээр хязгаарлалт хийгдэх шаардлага үүсэж байгаа юм. Өвлийн оргил ачааллын хувьд. Үүнийг нуухгүй. Үнэн.

Оросын Холбооны Улсаас импортолж байгаа шугам дээр гэмтэл гарсан тохиолдолд тэр хэмжээгээр хязгаарлалт хийхээс ондоо арга энэ өвлийн тухайд алга байна.

Иймэрхүү аваар осол бага гараасай гэдэг нэгдүгээрт ийм бэлтгэл ажлуудыг энэ зуух, генераторууд, энэ шугамуудыг байнга эрчим хүчний системийн салбарт ажиллаж байгаа мянга мянган улсууд зөвхөн үүний төлөө ажиллаж, бэлэн байдлыг хангахын тулд явж байгаа.

Гэхдээ байгалийн нөхцөл байдал, хүний хүчин зүйлээс давсан нөхцөл байдал үүсэхэд хязгаарлалтад орно гэж хэлээд хүнд байгаа гээд байгаа нь л энэ. Үүнийг миний өмнөх сайд Н.Тавинбэх бас олон нийтэд ойлгоосой гэж олон удаа ярьсан юм билээ. Би бас энэ нөхцөл байдалд.

Ж.Батсуурь: Ганц минут байна. Энэ дээр нь саналаа хэлчихье дээ.

Эрчим хүчний салбарыг би босож болохгүй салбар гэж ойлгодоггүй ээ. Үнийг яаралтай чөлөөлөөд хөрөнгө оруулалтыг тогтвортой байдлыг урих юм бол хөрөнгө оруулалт орж ирэх бүрэн боломжтой. Ашгаа нөхөөд алс явах ийм боломжтой гэж үздэг ээ.

Зөвхөн одоо энэ улс төрчдийн гараас эрчим хүчний салбар гараач дээ. Хууль нь байна, эрх нь байна. Ингээд бид Засгийн газрын байгууллага гэсэн байдлаар ингэж явж болохгүй ээ.

Үнийг нэмэхдээ 150 киловатт цаг хэрэглээнээс дээш хүмүүсийг нэммээр байна. 150 киловатт цаг хүртэл амиа аргацаасан. Одоо жорлон, плитка ажиллуулахаас цаашгүй л ийм зүйлүүд байж байгаа.

Дээр нь экспорт үйлдвэрлэдэг үйлдвэрт өртгөөр нь ч юм уу цахилгаанаа хүргэмээр байна. Экспортод гаргадаг.

Мөн одоо тэр хөндлөн дотаци гэж нэрлэдэг тэр хүмүүсээс цахилгаан нэрээр дээрэмдэж авч нар, салхины цахилгаан станц, мөн дулааны асуудлыг нөхдөг асуудлаа зогсоогооч ээ. Та зоригтой зоригтой юмнууд яриад байна.

ТЭЦ-IV дээр 66 удаа гэмтэл гарсан л гэж байна. Цаашдаа.../минут дуусав/

Г.Занданшатар: Ж.Батсуурь гишүүн асуулт асуулаа. Тийм.

Цаашдаа систем дээр яг тэнцүү 10, 10 минутыг өгөөд хоёр тал шууд ингээд яадгаар системийн тохируулгаа бас тэгээд юу яачихаарай. Сая тэгэхдээ 20 минут бас яг цагаа тулахаар багадаа гээд байна уу, гайгүй байна уу?

Тэгэхдээ аягүй их юм асуусан. Сая арван хэдэн асуулт асуусан.

Б.Чойжилсүрэн сайд ч гэсэн сайн хариуллаа. Ер нь ийм мэтгэлцээний журмаар явбал илүү бас хүмүүст мэдээлэл өгч байгаа юм л даа. Гол нь. Одоо систем дээр зөвхөн нэг л нэр гардаг учраас л.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар эрчим хүчний салбарын нөхцөл байдлын талаар, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын эрчим хүчний зорилт болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан томоохон төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, тулгамдаж байгаа асуудлын талаар Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн мэдээлэл хийлээ. Мэдээлэл сонслоо. /алх цохив/

Одоо дараагийн асуудалд орно.

Тав.Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, нэн яаралтай/

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн байгаа. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ сайд байна уу? Ажлын хэсэг ороорой.

Дараагийн асуудалд орно. Аялал жуулчлалын тухай хуулийн шинэ шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Ажлын хэсгийнхнийг оруулъя.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Бат-Өлзийн Бат-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая,

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 4.2-т заасан эдийн засгийн тэргүүлэх салбарыг хөгжүүлэх зорилтын хүрээнд 2021-2030 онд үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадвар дээшилсэн байна гэж.

Мөн зорилт 8.2-т заасан эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон байршлын давуу талд тулгуурлан бүс, орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилтын хүрээнд 2021-2030 онд байгаль экологи, археологи, палентологи, нүүдлийн өв, түүх, соёл, **рекреац**_[амралт зугаалгын цогц арга хэмжээ]-ийн нөөц, нутгийн иргэдээ түшиглэсэн аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлнэ гэж тус тус заасан бөгөөд эдийн засгийг сэргээх үндсэн хөшүүргийн нэгээр аялал жуулчлалын салбарыг онцолж, тэдгээрийг биелүүлэх тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгож, үндсэн чиглэлийн 27-д Монгол Улсын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан иргэн, хуулийн этгээд хооронд үүсэх харилцаа болон төрөөс аялал жуулчлалыг хөхиүлэн дэмжихтэй холбогдсон харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтыг дэвшүүлсэн.

Иймд Аялал жуулчлалын тухай хуулийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгад ихээхэн өөрчлөлт гарч,

түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн батлах шаардлагатай байх тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 25.1.4-д заасны дагуу Аялал жуулчлалын тухай хуулийн төслийг шинэчлэн найруулгын хэлбэрээр боловсрууллаа.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зорилт нь үндэсний онцлог бүхий байгаль, түүх, соёлын өвд тулгуурласан тогтвортой аялал жуулчлалын үйлдвэрлэлээр дамжуулан эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, дэмжихэд чиглэгдсэн аялал жуулчлалын үйл ажиллагаанд төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулна.

Хуулийн төсөлд уг хуулиар зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгасан.

Аялал жуулчлалын байгууллагыг тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага гэж ангилж, тур операторын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй эрхлэх зөвшөөрөл эзэмшигчдэд тавигдах шаардлагыг тодорхой болгосон.

Тодорхой газар нутагт тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх, орон зайн зохистой төлөвлөлтийг бий болгох зорилгоор тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрээс гадна аялал жуулчлалын бүсийг улсын болон орон нутгийн аялал жуулчлалын бүс гэж ангилж, бүсийн менежментийг бүхэлд нь, эсвэл тодорхой хэсгийг гэрээний үндсэн дээр хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломжийг бүрдүүлсэн.

Аялал жуулчлалын салбар дахь орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, үүрэг хариуцлага, эрх хэмжээг тодорхой болгосон зохицуулалтыг тусгана. Тухайлбал, харьяалах нутаг дэвсгэртээ аялал жуулчлалын арга хэмжээг төлөвлөн, мэргэжлийн холбоо, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх, жуулчин болон аялагч байрлах отоглох цэгийн төлбөр, хураамжийг тогтоох эрхийг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай нийцүүлэн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд отоглох, цэгийн байршлыг тогтоох, аяллын маршрудыг тогтоох, тэмдэгт тэмдэглэгээ байрлуулах эрхийг сум, дүүргийн Засаг даргад, дэвсгэртээ жуулчны мэдээллийн төв байгуулах эрхийг аймаг, нийслэлийн Засаг даргад тус тус олгож, отоглох цэгийн менежментийг хувийн хэвшилд гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх, жуулчдын аюулгүй байдлыг хангахын тулд олон нийтийн англи хэлтэй жуулчин цагдаа ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн.

Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага нь Монгол Улсын болон олон улсын холбогдох стандартын шаардлагыг ханган ажиллах ба ялангуяа ариун цэврийн байгууламжийг онцгой анхаарч, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж барих, засварлах зардлыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хасагдах зардалд тооцох зориулалтыг тусгасан.

Хил орчмын аялал жуулчлалыг байнгын ажиллагаатай боомт, олон улсын боомт болон хил орчмын нутаг дэвсгэрт байрлах чөлөөт бүсэд олон улсын аялал жуулчлалын үйлчилгээ

үзүүлэх, Тусгай зөвшөөрөлтэй тур оператор гүйцэтгэх зохицуулалтыг тусгасан.

Тусгай зориулалтын агнуурыг аялал жуулчлалыг дэмжих зорилгоор сүргийн бүтцийг алдагдуулахгүйгээр тооцоо судалгаанд үндэслэн аргал, хонь, янгир ямаа, идлэг шонхор, тул загасыг агнах, барих тусгай зөвшөөрлийг дуудлага худалдааны зарчмаар нээлттэй, ил тод олгох эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Төрөөс аялал жуулчлалыг дэмжих, тогтвортой санхүүжүүлтийг бүрдүүлэх зорилгоор аялал жуулчлалыг хөгжүүлэх сан байгуулж, сангийн хөрөнгийг агаарын тээврийн үйлчилгээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулах, аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, Монгол Улсыг гадаад дотоодод сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах, аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгох, хөгжүүлэхэд зарцуулах бөгөөд санхүүжилтийн эх үүсвэрийг казиногийн татварын орлого болон олон улсын нислэгийн зорчигчоос хураан авах аялал жуулчлалын төлбөр зэрэг эх үүсвэрүүдээс бүрдүүлэх зохицуулалтуудыг тусгасан.

Жуулчдын худалдан авсан бараа, бүтээгдэхүүнд ногдуулсан нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгох, жуулчны татвар бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Төр, хэвшил, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аялал жуулчлалын зарим төрлийн төрийн үйлчилгээг аялал жуулчлалын мэргэжлийн холбоогоор гүйцэтгүүлэх, тухайлбал, аялал

жуулчлалын үйлчилгээний байгууллагын зэрэглэл олгох, тур операторын тусгай зөвшөөрөл олгох чиг үүргийг гүйцэтгүүлэх эрх зүйн үндэслэлийг нарийвчлан тодорхойлсон.

Монгол Улсын аялал жуулчлалын салбараар дамжуулан 2023, 2024, 2025 онуудад экспортын орлогыг 2019 онтой харьцуулахад 3-аас 4 дахин нэмэгдүүлж 2.4 тэрбум ам.долларын эдийн засгийн эргэлтийг бий болгон, дотоодын нийт бүтээгдэхүүний 15 орчим хувийг бүрдүүлэхийг зорьж байна.

Өдрөөс өдөрт өөрчлөгдөж буй гараг ертөнц дээр хүний хөдөлгөөн, дуу чимээнээс ангид, онгон дагшин байгальд өөрийгөө олох, эрэлхийлэх, дахин төрсөн мэт мэдрэмж авахын тулд зорин аялах газрын нэг нь баян бүрд болох Монгол Улс болно гэдэгт итгэлтэй байна.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавсанд баярлалаа.

Г.Занданшатар: Одоо төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд нэн яаралтай

хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч нь үндэсний онцлог бүхий байгаль, түүх, соёлын өвд тулгуурласан тогтвортой аялал жуулчлалын үйлдвэрлэлээр эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, тодорхой газар нутагт тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах, тур оператор болон тур агент, жуулчны хөтчийн талаарх харилцааг шинэ түвшинд гаргах, тур операторын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй болгох, мэргэжлийн хариуцлагын даатгалд албан журмаар даатгуулах замаар хариуцлагыг нэмэгдүүлэх, жуулчны аюулгүй байдлыг хангах, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагыг төрөөс бодлогоор дэмжих, аялал жуулчлалын салбарт олон улсын жишгийг нэвтрүүлэх, хил орчмын аялал жуулчлалын үйл ажиллагааг батлагдсан маршрутаар тусгай зөвшөөрөлтэй тур оператор гүйцэтгэх аялал жуулчлалын үйл ажиллагаанд төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага нь Монгол Улсын болон олон улсын холбогдох стандартын шаардлагыг ханган ажиллах, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж барих, засварлах зардлыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хасагдах зардалд тооцох, жуулчдын худалдан авсан бараа, бүтээгдэхүүнд

ногдуулсан нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгох, жуулчны татвар бий болгох зэрэг эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төсөл батлагдсанаар аялал жуулчлалын байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлж, чадавхжуулах нөхцөл бүрдэх, аялал жуулчлалын үйл ажиллагааг дэмжих, тогтвортой санхүүжилтийн эх үүсвэр бүрдэж, аялал жуулчлалыг хөгжүүлэх сангийн удирдлагын дийлэнх олонхыг олон нийтийн төлөөлөл хэрэгжүүлэх, зарцуулалтад тавих хяналтыг төр, олон нийтийн төлөөлөл хамтран хэрэгжүүлэх, тусгай зориулалтын агнуурын аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжих, гадаадын жуулчны виз олголтыг хөнгөвчлөх, хурдан шуурхай болгох, визгүй зорчих орны тоог нэмэгдүүлэх боломж бий болох, Монгол Улсыг зорин ирэх жуулчны тоо нэмэгдэнэ гэж төсөл санаачлагч үзжээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа жишиг аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялах чиглэлийг тогтоож, тодорхой болгох, энэ чиглэлээр мэргэшсэн олон улсын зөвлөх ажиллуулах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ жуулчдыг аялах таатай орчныг бүрдүүлж, жуулчны визний асуудлыг хөнгөвчлөх, зорчигч тээврийн зардал, үйлчилгээг оновчтой болгоход анхаарах, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болоход анхаарах, Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг аялал жуулчлалын маршрутыг Засгийн газраас тогтоодог

болох, агаарын тээврийн үндэсний авиа компаниудаа бодлогоор дэмжих гэсэн саналуудыг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Аялал жуулчлалын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Энэ хооронд эхлээд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд бүртгүүлнэ үү.

Ажлын хэсгийн гишүүд. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд Гантөмөрийн Түвдэндорж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга Батсүхийн Болортуяа, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ногоон хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Борисын Буяннэмэх, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Дорждэрэмийн Цолмон, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хуулийн хэлтсийн дарга Сүхбаатарын Цогтгэрэл.

Тус яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн Паламдоржийн Баярцэцэг, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Содномрэнцэнгийн Мөнхнасан, С.Мөнхнасан дарга хаана байна? Сая байсан. С.Мөнхнасан даргыг дуудъя. Энэ агаарын тээврийн асуудал чинь энэ дотор их чухлаар тавигдаж байгаа.

“Монголын эрх зүйн судалгаа хөгжлийн төв” төрийн бус байгууллагын хуульч Ренчинпүрэвийн Лхагвабаяр, Монголын Аялал жуулчлалын холбооны хүндэт Ерөнхийлөгч, “Нью жуулчин тур” ХХК-

ийн ерөнхий захирал Шагдарсүрэнгийн Нэргүй.

Сайдынхаа дээр суучихсан байна уу? Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуулт асууна.

Ш.Адьяшаа: Энэ хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа.

Өнөөдөр аялал жуулчлалаар дамжуулж Монгол Улсын эдийн засгийг хөгжүүлэх, эдийн засгийн таатай нөхцөлийг бүрдүүлэх бас нэг гарц гэж харж байгаа. Энэ дээр сайн хэлэлцээд дэмжих ийм саналтай байна.

Тэгэхдээ энэ нэн яаралтай горим гэдэг энэ юм чинь ер нь ямар учиртай юм бэ? Энэ дандаа нэн яаралтай горим гээд л нэг юм орж ирж байдаг. Энэ үгнээсээ эхлээд л энэ нэг л их сонин санагдаад байгаа юм.

Дэр нь энд Зөвшөөрлийн тухай хуулийг бид сая хэлэлцсэн. Тэгээд энэ дахиад л энэ тур операторуудад зөвшөөрөл олгоно гэдэг энэ асуудал дахин орж ирж байна.

Ер нь зөвшөөрлийн системийг багасгая. Аль болох цахим болгоё. Аль болох иргэдэд чирэгдэл багатай, төр хувийн хэвшлийн хэмжээнд, ялангуяа хувийн хэвшлийг дэмжье гэсэн ийм бодлогыг энэ Засгийн газар явуулж байгаа гэсэн ойлголттой байгаа. Энэ дээр нэг хариулт авъя.

Дээр нь энэ агаарын тээврийн компаниудад дотаци олгох юм байна. Энэ бол яав ч байж болохгүй. Ингээд дотаци өгсөөр байгаад бид чинь эдийн засаг сөхөрчхөөд байна. Энэ ямар бодлого, хэний ийм лобби яваад байна.

Тэртээ тэргүй Монгол Улсад ирэх жуулчин ирэхээ хүрвэл дотациар багасгасан ч ирнэ. Ирэхгүйгээ хүрвэл үнэгүй байсан ч ирэхгүй шүү дээ. Менежмент, сурталчилгаагаа, бодлогоо тодорхойлъя.

Аливаа юмыг дотациар, энэ татвар төлөгчдийн мөнгийг янз бүрийн байдлаар энэ угаах хэлбэр рүү оруулахаа больё гэж бодож байгаа. Би энэ дээр маш хатуу байр суурьтай байх болно.

Дээр нь энэ Үндэсний хороо гээд нэг байгууллага байгуулагдах юм байна. Үгүй ээ, энэ чинь энэ чиглэлийн яам нь байж байхад энэ Үндэсний хороо заавал яахаараа байгуулдаг юм. Одоо энэ Үндэсний хороо, яамгүй сайд гэдэг энэ Засгийн газар ийм асуудлуудыг оруулж ирж байгаа. Яамгүй сайдтай Үндэсний хорооны дарга гээд.

Ингээд өнөөдөр энэ орон тоо нэмдэг аливаа энэ асуудлуудыг хүнд зориулсан ийм тогтолцоог битгий оруулж ир ээ. Засгийн газар энэ дээр анхаарлаа хандуул. Одоо яамгүй сайд гэж байсан. Одоо Үндэсний хороо гээд.

Тэгтэл энэ асуудлыг хариуцсан Байгаль орчин, аялал жуулчлалын яам чинь юу хийх юм?

Дээр нь энэ асуудлыг хариуцсан тэр Зам, тээврийн хөгжлийн яам чинь юу хийх юм?

Тэгээд ийм сонирхолтой ч гэх юм уу, ер нь бодлогогүй ч гэх юм уу, хүнд зориулсан албан тушаал бий болгохыг санаархсан ийм бодлогоо Засгийн газрууд татаж ав.

Дээр нь энэ аялал жуулчлалыг хөгжүүлэх хамгийн чухал асуудал бол энэ визийн асуудал байгаа. Энэ визийн бодлого бол маш зөв байна. Энэ дээр бол энэ визийг хөнгөвчлөх асуудлыг бид шийдэж байж тэр цахим визийн системийг нэвтрүүлж байж Монголд ирэх аялал жуулчлалын урсгалыг бий болгоно. Түүнээс биш өнөөдөр энэ Хятад, бусад орнуудад байдаг энэ визийн бизнес, визийн энэ хулгай луйварт бас цэг тавьсан байгаа шүү дээ. Энэ дээр маш зөв шийдвэр гаргаж ажиллавал бид Монгол Улсад тэр тээврийн хөнгөлөлтөөс ч илүү энэ визийн систем, визийн цахим бодлогоо зөв бодлого явуулах асуудал бол хамгийн чухал байна гэдгийг хэлье. Энэ асуултууд хариу авъя.

Г.Занданшатар: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд хариулна. 81.

Б.Бат-Эрдэнэ: Ш.Адъяаа гишүүний асуултад хариулъя.

2023, 2024, 2025 оныг Монголд зочлох жил болгож зарласантай холбогдуулан өнгөрсөн хавраас явж байсан Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хурдавчлуулж байгаа.

Үндэсний хорооны хувьд Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хороо бол Монгол Улсын Засгийн газар дээр байгуулагдчихсан ажиллаж байгаа. 6 дэд хороотойгоор ажиллаж байгаа.

Дэд хороодуудын хариуцаж авсан ажлын хүрээнд ч гэсэн энэ Аялал жуулчлалын хуулийн шинэчилсэн найруулга маань Хууль зүй, дотоод

хэргийн яаман дээрээс одоо ингээд бас давхар ажлын хэсэг дээр ороод явж байгаа гэдэг ийм асуудал байна.

Энэ агаарын тээврийн дотацитай холбоо бүхий асуудал дээр навигацийн орлогын 20 хувийг буцаан аялал жуулчлалыг хөгжүүлэх санд төвлөрүүлж, тэндээс дотоодын агаарын тээврийг дэмжих холбоо бүхий асуудлуудыг бид хөндөж байгаа. Дотоодын агаарын тээвэргүйгээр орон нутгийн нэгдүгээрт иргэдээ бид тээвэрлэх.

Хоёрдугаарт, жуулчин явах боломжгүй ийм нөхцөл байдалтай байгааг та бас мэдэж байгаа байх.

Гуравдугаарт, Зөвшөөрлийн тухай хуультай холбоо бүхий асуудал байна.

Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлнэ. Энэ хуулийн 1.5.3-т хуульд зааснаас бусад тохиолдолд зөвшөөрөл, лиценз, бүртгэл явуулахыг хориглохоор заасан байгаа.

Яг энэ утга агуулгаар нь харах юм бол аялал жуулчлалын байгууллагын ангилал тогтоох журмын дагуу одоо олгогдож байгаа ангиллын гэрчилгээг цаашдаа олгох боломжгүй болж байгаа учраас хуулийн төслийн шинэчилсэн найруулгад тусгай зөвшөөрөл байдлаар тусгаж үндсэн шалгуурыг мөн тус журам дээр буюу одооны байгаа эрх зүйн орчин дээр үндэслэн тусгасан.

Тусгай зөвшөөрөл шинээр гаргаж байгаа зүйл ерөөсөө биш. Монголын аялал жуулчлалын холбоо одоогийн байдлаар 5 ангиллын гэрчилгээг олгож

байгаа. Энэ бол зөвшөөрөл байдалтай явж байгаа. Хэрвээ цаашдаа тусгай зөвшөөрөл олгогдохгүй гэж тооцох юм бол ялангуяа тусгай зөвшөөрлийг бид олгохдоо тур оператор компаниуд дээр олгохоор зохицуулалтыг хийж байгаа. Тур операторын үйлчилгээн дээр тусгай зөвшөөрөлгүй болсон тохиолдолд гадаадын тур оператор компаниуд ч гэсэн орж ирж Монголын байгаль, түүх соёлын өвийг ашиглаж аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулчхаад татвар төлөхгүй, эрх зүйн орчин дээр ямарваа нэгэн хариуцлага хүлээхгүй ийм нөхцөл байдлууд үүсэхээр шинжтэй байгаа.

Тийм учраас бид Монгол Улсад үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд байх. Зөвшөөрлийн үндсэн дээр тур операторын үйл ажиллагааг явуулдаг болох ёстой гэсэн энэ заалтыг аялал жуулчлалын холбоотой хамтарч мөн бусад компаниудтай харилцан ярилцаж энэ асуудал орж ирж байгаа юм.

Үндэсний хорооны хувьд би түрүүн хэлчихсэн. Визний хувьд ялангуяа дотоод нийт бүтээгдэхүүний хувьд өндөр орнуудыг бид бүгдийг нь визгүй болгох энэ боломж, мөн цахим виз рүү шилжихтэй холбоо бүхий асуудлуудыг Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам харилцан ярилцаад аль болох визнээс чөлөөлөх, цахим визэнд шилжүүлэх энэ ажлууд эхэлчихсэн явж байгаа гэж хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Ш.Адъяаа гишүүн 1 минут. Нэмэлт асуулт.

Ш.Адъяаа: Тэр навигацийн орлого гэдэг чинь татвар төлөгчдийн мөнгө. Энэ орон нутагт үндэсний

компаниуд гээд энэ нэг лобби хийдэг. Энэ ашиг сонирхлын зөрчилтэй. Салбарынхаа сайдтай холбогдсон ийм асуудал байгаа шүү.

Үүнийг энэ хуулийн хүрээнд ч гэсэн, цаашдаа ч энэ асуудлыг ярих болно.

Дээр нь Б.Бат-Эрдэнэ сайд бас маш сайн зүйлийг хийж байгаа юм байна. Ялангуяа дархан цаазат ан амьтдыг аялал жуулчлал нэрээр гадаадад зарж борлуулдаг бүхэл бүтэн мафийн систем байгаа. Үүнийг дуудлага худалдааны хэлбэрт шилжүүлж энэ хуулийн хүрээнд орж ирсэнд Б.Бат-Эрдэнэ сайдад бас талархал илэрхийлье би.

Г.Занданшатар: Талархал дэвшүүллээ. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна.

М.Оюунчимэг: Монгол Улсын Засгийн газар ирэх 3 жилийг аялал жуулчлалын жил болгон зарлаж байгааг дэмжиж байгаа. Энэ үнэхээр чухал. Аялал жуулчлалын салбар бол чухал салбар байгаа. Үүнийгээ амжилттай хэрэгжүүлэхийн тулд хууль эрх зүйн орчинг нь сайжруулахаар Аялал жуулчлалын тухай хуулийг шинэчилсэн найруулгаар оруулж ирж байгаа гэж ойлгож байгаа шүү дээ.

Тийм учраас энэ өөрөө аялал жуулчлалыг бүхий л талаараа дэмжсэн ийм хууль шинэчилсэн найруулга байх ёстой. Тэгээд хуулийг нэлээд нарийвчлан уншиж үзээд бас салбарын мэргэжилтнүүд, олон жил аялал жуулчлалын салбарт бизнес эрхэлсэн компаниудын төлөөллүүд сүүлийн үед Их Хурал дээр Аялал жуулчлалын хуулийн шинэчилсэн найруулга явж

байна гэхээр бидэнтэй бас уулзаж байна. Зарим шүүмжлэл, саналаа ч илэрхийлж байна л даа.

Одоо жишээлбэл, энэ дээр торгоно, хураана гэсэн заалтууд их байна. Зөрчлийн тухай хуулиар тэгж байна. Дээрээс нь уг нь бол Монголын Засгийн газар аль болохоор хувийн хэвшилдээ даатгаж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиа хүртэл ингээд гаргаад хувийн хэвшилдээ найдаж, тэдэнтэй ажиллах боломжийг нь олгоно гэхихсэн хэрнээ тэгээд л хууль орж ирэхээр л нэг л шинэ компани, шинэ байгууллага шинээр байгуулах л гэсэн нэг давхар ойлголт давхар санаа яваад байх шиг байх юм.

Энэ дээр л гэхэд бас одоогийн Аялал жуулчлалын холбоо гэдэг нэр нь байхгүй, харин шинээр нэг компани байгуулаад түүн дээр бүх эрх мэдэл нь төвлөрөөд одоо Монголд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 1600 гаруй аж ахуйн нэгжүүддээ сар бүр сая төгрөгийн хураамж аваад сууж байх юм уу? Энэ тэрбум 600 саяын мөнгө аваад л ингээд сууж байх юм байна л даа. Тийм ойлголт төрүүлэхээр байна. Энэ чинь өөрөө өнөөдөр үйл ажиллагаа явуулж байгаа ёстой бор зүрхээрээ ажиллаж байгаа аялал жуулчлалын компаниудыг бухимдуулж байна.

Тэгэхээр яг ийм зорилгыг агуулж байгаа юм уу? Аялал жуулчлалын холбоо биш, одоо харин шинэ байгууллага байгуулагдах уу? Энэ байгууллага ямар үүрэгтэй байх юм? Яахаараа тур операторуудаас ингээд сар болгон хураамж аваад сууж байна. Энэ бол их буруу. Энэ дээр нэгд хариулт өгөөдхөөрэй. Нэгдүгээрт.

Хоёр дахь нь, тур операторууд зөвшөөрөл авна гэж байгаа юм. Тэгээд түүндээ төлбөр төлнө гэж байгаа юм. Одоо аялал жуулчлалын холбоо угаасаа хураамжаа аваад үйл ажиллагаагаа хэвийн энгийн явуулаад байж байгаа. Гэтэл дахиад тэр тур операторууд нь зөвшөөрөл аваад байх юм. Энэ чинь өөрөө нөгөө нэг аялал жуулчлалаа дэмжих биш, одоо ажиллаж байгаа энэ аялал жуулчлалын хэдэн компаниа санхүүгийн дарамтад учруулах юм уу, эсвэл хүнд суртал уу? Энэ зүйлүүд бол байж болохгүй шүү.

Тэгээд энэ дээр яагаад ингэж оруулж ирж байгаа юм? Энэ дээр нэг тодорхой ойлголт, тайлбарыг нь заалтаараа өгөх. Эсвэл бид үүнийг засах хэрэгтэй. Ажлын хэсэг дээр. Хоёр дахь асуулт нь энэ байна.

Гурав дахь асуулт нь, монголчууд бол гэр бүлээрээ, найз нөхдөөрөө аялах дуртай. Бас өөрсдөө. Энэ хууль зөвхөн гадаадын жуулчдыг, тэр 400 сая жуулчин гаднаас авчрах гол зорилго биш. Яагаад гэвэл хууль бол монгол хүнд ч үйлчилнэ, гаднын хүн ч үйлчилнэ.

Гэтэл дотоодын иргэдийнхээ аялах, зугаалах эрхэнд халдсан заалтууд энд бас орж байна л даа. Одоо жишээлбэл, зөвшөөрөөгүй газар майхантайгаа гэр бүлээрээ буудалласан бол 100 мянган төгрөгөөр торгоно. Зөвшөөрөлгүй газар явсан бол найз нөхдөөрөө ч гэдэг юм уу. Тийм ээ. Тэгвэл сая төгрөгөөр торгоно гээд. Дандаа тийм заалтууд энд бас ороод ирчихсэн байна л даа.

Ийм заалтууд байж болохгүй. Бид энэ аялал жуулчлалын салбарын шинэчилсэн найруулгаар оруулж ирэх

гэж байгаа бол ингэж буруу зөрүү заалтууд оруулж болохгүй.

Тэгэхээр энэ дээр тодорхой хариулт нэг өгнө үү? Ингэж торгох хаах юм уу, эсвэл зөвшөөрөл гэж байхын оронд та нар маань харин яаж энэ саваа бий болгох вэ? Дэд бүтэц жишээлбэл. Нэгдүгээрт, ариун цэврийн байгууламж. Сая зун ирсэн солонгосууд, японууд бүгд хамгийн хүндрэлтэй нь ариун цэвэр, нолийн асуудал байлаа гээд бүгдээрээ л очоод ярьсан байна лээ шүү дээ.

Тэгэхээр өнөөдөр жишээ нь ариун цэврийн байгууламжийг яаж бий болгох юм. Аялал жуулчлалыг дэмжих сангийн хөрөнгийг юунаас босгоод яг юунд эхний ээлжид зарцуулах юм гэх мэт зүйлүүд маань тодорхой байх ёстой. Одоо урсгал нь та нар маань хураамж төлбөрөөс л энэ санг эхлээд бүрдүүлэх бодлоготой бол энд харагдаад байх шиг байх юм.

Тэгэхээр энэ дээр хариулт авчхаад тодотгоё гэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданшатар: 81. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ сайд тариулья.

Б.Бат-Эрдэнэ: М.Оюунчимэг гишүүний асуултад хариулья.

Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны асуудлыг би сая хэлсэн. Тур операторууд зөвшөөрөл авч байгаатай холбоотой асуудлуудыг хэлсэн. Энэ бол 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж байгаа Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5.3 буюу хуульд зааснаас бусад тохиолдолд зөвшөөрөл, лиценз, бүртгэл явуулахыг хориглохоор заасан ийм заалттай.

Энэ заалтынхаа дагуу тур операторууд одоо олгож байгаа. Одоо ч гэсэн 5 төрлийн ангиллын гэрчилгээг Монголын аялал жуулчлалын холбооноос тур оператор компаниудад бүгдэд нь олгоод явж байгаа юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, 100 мянган төгрөгийн хураамжтай. Жил болгон. Энэ мөнгийг нь авч байгаа. Бид энэ дээр ямар ч өөрчлөлт хийгээгүй. Өөрөөр хэлбэл Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэх хэлбэр дээр буюу миний түрүүний хэлдэг зөвшөөрөлгүй тур оператор компаниуд Монгол Улсын нутаг дэвсгэрт магадгүй гадаадын компаниуд орж ирээд дотоодын зах зээл дээр эзлэх.

Хоёрдугаарт, саяхан бас л энэ намаржингаа шуугьсан. Хавар, зунжингаа шуугьсан. Гадаадад аваачаад тухайн тур оператор нэртэй компаниуд монголчуудыг паспортгүй, билетгүй, буудалгүй болгож хаясан асуудлууд бол хүртэл үүсэж байсан юм.

Тэгэхээр тур оператор компаниудын хувьд ийм эрсдэлтэй алхмууд хийгдэхгүйн үүднээс бид одоо байгаа ангиллын гэрчилгээг тусгай зөвшөөрөл гэдэг утгаар нь Зөвшөөрлийн тухай хууль дээр нь нийцүүлж оруулж байгаа гэсэн үг. Хураамжийн хувьд ч 100 мянган төгрөг авч байгаа. Түрүүний хуульд зоогдсон байгаа 500 мянга гэдэг бол 5 жилийн хугацаа буюу 100, 100 гэдэг хэлбэр дээрээ явж байгаа мөнгө байгаа юм шүү.

Гэр бүлээрээ аялахад дотоодын иргэд энд тэнд очоод майхан барьж болохгүй болсон байна гэдэг асуудлыг хөндөж байна.

Энэ дээр маш буруу ойлголт түгээсэн. Өөрөөр хэлбэл бид улсын аялал жуулчлалын бүс, орон нутгийн аялал жуулчлалын бүс гэж хоёр гаргаж байгаа юм. Улсын аялал жуулчлалын бүс гэдэг маань өнөөдөр Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар нийт газар нутгийн 21 хувийг хамарч байгаа 32.7 сая га газар дээр байгаа ашиглалтгүй буюу яг тусгай хамгаалалтад авчихсан байгаа энэ газрууд дээр бид тодорхой хэмжээнд аялал жуулчлалыг зохистой ашиглалтаар нь хөгжүүлэх буюу тодорхой отголог цэгүүдийг байгуулж, тусгай хамгаалалттай газар нутгууд дээр зөвхөн отоглох цэгээр үйлчлүүлэх хэлбэр дээр оруулж байгаа.

Хууль дээр яах вэ, нэг заалт орсон байна лээ. Тэр нь орон нутгийн аялал жуулчлалын бүс гэдгийг бас хамтатгаад оруулчихсан байсан. Үүнийг бид хасах ёстой гэж харж байгаа. Зөвхөн улсын аялал жуулчлалын бүс буюу тусгай хамгаалалттай газар нутгууд дээр явагдаж байгаа аялал жуулчлалын хэлбэр, эдийн засгийн эргэлтэд газар нутгийг оруулах хэлбэр дээр явж байгаа заалт юм шүү.

Түүнээс биш иргэд маань дуртай газраа очоод хонодог байсан энэ зүйлийг бид болиулж байгаа ийм утга агуулга байхгүй гэдгийг би хэлье.

Ингээд аялал жуулчлалын мэргэжлийн холбооны асуудлаар манай Р.Лхагвабаяр 83 нэмж хариулаад.

Г.Занданшатар: 83.

Р.Лхагвабаяр: Ажлын хэсгийн хуулийн зөвлөх, хуульч Р.Лхагвабаяр.

М.Оюунчимэг гишүүний асуултад мэргэжлийн холбооны харилцаа дурдагдсан. Энэ нь ямар холбоо вэ, шинээр байгуулагдаад төсөв мөнгө яригдах уу, ямар гишүүнчлэлтэй байх вэ гэдэг дээр.

Нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэдэг ойлголт өөрөө манайд эрх зүйн тогтолцоо нэгдүгээрт нэвтэрчихсэн. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.1.7, Захиргааны ерөнхий хуулийн 5.1.3-т заасан хуулийн үндсэн дээр эрх шилжүүлээд авсан төрийн институт биш хувийн хэвшлийн төрийн бус байгууллагын хуулиар зохицуулагддаггүй ийм тусгайлсан субъект эрх зүйн статус бүхий субъект байгаа.

Энэ жишгийн маш сайн жишгүүд юу байна вэ гэвэл Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 44-д заасан Хуульчдын холбоо, Өмгөөллийн тухай хуулийн 38-д заасан Өмгөөлөгчдийн холбоо, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 26-д заасан Өргөн нэвтрүүлгийн холбоо гээд гэх мэт маш сайн холбоонууд өөрсдөө бий болчихсон байгаа.

Эдгээр холбоонууд маань хуулиар эрх шилжүүлээд авчихсан нийт эрх зүйн хуулийн этгээд бөгөөд төрийн зарим чиг үүргийг хуулийн үндсэн дээр хэрэгжүүлдэг.

Тэгэхээр энэ бас салбарын өөрийн удирдлагын зарчмыг бид энэ аялал жуулчлалын салбарт нэвтрүүлэх бүрэн боломжтой юм байна гэдгийг салбарын оролцогчидтой 7, 8 дугаар сард холбоодын төлөөллүүд тэргүүнүүдтэй нэг бүрчлэн уулзалт

хийхдээ тэмдэглэж аваад энэ байдлаар бол энэ Холбоог томъёолсон.

Холбооны хурлыг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр бүх гишүүдийн хурлаа хийгээд хурлыг нь аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хийж өгөхөөр ингэж хуулийн төсөлд одоогоор томъёолсон байж байгаа.

Г.Занданшатар: М.Оюунчимэг гишүүн 1 минут тодруулж асууя. 1 минут.

М.Оюунчимэг: Б.Бат-Эрдэнэ сайд аа, энэ заалтууд чинь яг иргэд ингэж ойлгохоор зүйлүүд байгаад байна шүү дээ.

Одоо угаасаа сумын Засаг дарга юм уу, аймгийн Засаг дарга нар бүр замбараагүй олгогдсоноос болоод өнөөдөр тэр сайхан Хөвсгөл нуурын эрэг юу болсон билээ. Тийм ээ. Энэ Тэрэлж юу болов? Харин ч бид энэ хуулиараа үүнийгээ цэгцлээд иргэд биш харин тэр дарга нар чинь ийм замбараагүй байдал үүсгэчихсэн шүү дээ.

Тэгэхээр одоо сумын Засаг дарга маршрут зааж өгөөд л, тэр маршрутаар нь явахгүй бол торгоод л байгаад байх ойлголт байгаад байна шүү дээ. Тэр дээр засаа. Үүнийг ажлын хэсэг дээр засахгүй бол нэгт болохгүй.

Хоёрт нь, хуульч ярьж байна л даа. Тусгайлсан объект гэнэ үү. Байгаль орчин, аялал жуулчлалын яам тэгээд юу хийх юм. Ажлаа хийж чадахгүй байгаа юм уу?

Тийм учраас дахиад энэ сайд нь ч юм уу, хэн нэгнээр ахлуулсан

тусгайлсан объект. Тэр нь төрийн байгууллага биш, төрийн бус байгууллага биш, компани биш, тэгээд тусгай субъект гэнэ. Ингэж бас болохгүй л дээ. Тэгээд энэ яагаад заавал ингэж хийх ёстой юм. Нэгдүгээрт.

Хоёр нь, миний түрүүний хэлээд байгаа тэр ариун цэврийн байгууламжийн дэд бүтэц гээд. Одоо бол бараг бүх газар тэг байгаа шүү.

Тэгээд ирэх жилийн 2023 оны 01 сарын 01-нээс бид.../минут дуусав/

Г.Занданшатар: 81. Б.Бат-Эрдэнэ сайд хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: М.Оюунчимэг гишүүний асуултад нэмж хариулъя.

Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага нь Монгол Улсын болон олон улсын холбогдох стандартын шаардлагыг ханган ажиллах ба ялангуяа ариун цэврийн байгууламжийг онцгой анхаарч, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж барих, засварлах зардлыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хасагдах зардалд тоосгох зохицуулалтыг тусгаж өгсөн.

Тэгэхээр ариун цэврийн байгууламжууд байгуулагдана. Байгуулагдах хэрээрээ саяын татварын боломжуудаа өөрсдөө эдлээд явчихна гэсэн үг.

Тэгэхээр энэ бол цаашдаа хэрэгжээд явчих хэмжээний заалт.

Ер нь тэр аялал жуулчлалын мэргэжлийн холбооны холбоо бүхий асуудал дээр өнөөдөр яг аялал жуулчлалын холбоо нэртэй 5, 6 холбоо

байгаа. Төр аль болох өөрсдийнхөө зарим чиг үүргийг төрийн бус байгууллага буюу мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх хэлбэр дээр л ажиллах ёстой. Энэ хэлбэр дээр л бид энэ аялал жуулчлалын мэргэжлийн холбооны асуудлуудыг оруулж ирээд явуулж байгаа юм.

Одоо тухайлах юм бол “Шинэ сэргэлтийн бодлого”-ын.../минут дуусав/

Г.Занданшатар: 83.

Р.Лхагвабаяр: Тийм. Энэ нийтийн эрх зүйн статус нь өөрөө түрүүн хэлсэн. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай, Захиргааны ерөнхий хуулиар зохицуулагдаж байгаа. Тусгай объект гээд та бас түрүү хэлсэн.

Энэ холбоо байгуулагдаад гишүүдээсээ жил бүр сар бүр сая төгрөг, 100 мянган төгрөг аваад байх юм уу гээд. Энэ өөрөө бүх гишүүдийн хурлаараа өөрийнхөө санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэдэг буюу жишээлбэл, би хуульч хүн. Хуульчдын холбоо нь өөрөө бүх гишүүдийнхээ хурлыг хийгээд бид сар бүр хураамж авах юм уу, үгүй юм уу, үйл ажиллагаандаа орлого байх юм уу, ажлын албатай байх юм уу, энэ дээрээ ямар хөрөнгө мөнгө зарцуулагдах юм гэдгээ бүх гишүүдийн хурлаар буюу хувийн аж ахуйн нэгжүүд өөрсдөө шийддэг.

Тэгэхээр улсын төсвөөс ямар нэг байдлаар нэмэлт зардал шаардагдахгүй буюу энэ байгууллага нь өөрөө бүх гишүүдийн хурлаараа бүх санхүүгийн болон зохион байгуулалтын асуудлаа шийддэг манайд хэрэгжээд эхэлчихсэн хоёр, гурван ийм сайн жишиг байгаа

болохоор бид бас аялал жуулчлалын салбарт энэ салбарын өөрөө удирдлагын байгууллага нь байх бүрэн боломжтой гэж хараад байгаа юм.

Г.Занданшатар: Одоо Содномын Чинзориг гишүүн асуулт асууна.

С.Чинзориг: Хоёр, гурван зүйл тодруулъя.

Нэг дэх асуудал, энэ аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудынхаа саналыг яам та бүхэн хэр сонсож, саналыг нь энэ хуулийн төсөлд тусгасан юм бэ?

Их Хурлаар энэ хуулийг чинь хэлэлцэх эсэх нь орно гээд өнөөдөр зэрэгцээд аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөллүүд чинь өдөр хэвлэлийн хурал хийгээд байгаа бололтой фэйсбүүкээр харагдаад байлаа шүү дээ. Бидний эрх ашгийг хангаж чадаагүй хууль боллоо гэсэн утгатай юм яриад байгаа юм шиг.

Тэгэхээр энэ байгууллагуудынхаа саналыг хэр сонссон юм? Санал нь хэр туссан юм бэ гэсэн нэг ерөнхий асуудал.

Хоёр дахь асуудал нь, би ингээд хуулийг чинь харахаар 5 дугаар зүйл дээр би эртүүд Эдийн засгийн байнгын хороон дээр чинь ярьсан. 5 дугаар зүйлийг харахаар аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага гээд байгаа юм. Яг аялал жуулчлалаар юу үзүүлэх юм бэ гэдгээ хэлэх гээд байгаа юм уу гээд.

Гаднаас ирж байгаа жуулчид чинь бидэнд энэ нэг зочид буудалд байрлах гэж, хоол идэх гэж ирэхгүй шүү дээ. Энэ нүүдлийн аж ахуй, нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг Монгол орны чинь аж байдалтай, ахуй соёлтой танилцах гэж ирж байгаа. Энэ байгалийн ариун дагшин байгальтай танилцах гэж ирж байгаа. Үүх түүх, соёлтой танилцах гэж энд ирж байгаа. Ийм чиглэлийн юмнуудыг үзүүлнэ гэдэг юм ч энд орохгүй юм уу?

Тэр үйлчилгээний байгууллага үйлчилгээ үзүүлнэ гэж байгаа юмнуудыг чинь харахаар зочид буудал, тэгээд нэг худалдаа үйлчилгээ, хоол л гэсэн юм байгаад байгаа юм.

Энэ концепцоо одоо та бүхэн нь буруу тодорхойлчихсон юм биш биз дээ гэж би гайхаад байгаа юм.

Гурав дахь асуудал нь, тэр агаараар тээврийн үйлчилгээ үзүүлж байгаа бол санхүүгийн дэмжлэг үзүүлнэ гээд байгаа юм. Энэ чинь тэгээд дотоодын жуулчдад хамаарах юм уу, дотоодын авиа компани хамаарах юм уу, гаднын авиа компани хамаарах юм уу? Эртээд би Эдийн засгийн байнгын хороон дээр асуусан. Х.Нямбаатар сайд бүр гаднын хавийн компанид ч гэсэн санхүүгийн дэмжлэг үзүүлэх юм шиг юм ярьчихсан л даа. Яг тэгж ярьсан. Тэрийгээ тодруулж өгөөч.

Гурав дахь асуудал. Энэ сантай болох юм байна. Энэ сангийнхаа үйл ажиллагааг жаахан өргөжүүлж болохгүй юу? Сайд. Тухайлбал, Монголын соёлын үнэт дурсгалт зүйлийг үзэх гэж гаднынхан их ирдэг. Энэ онгон дагшин байгалийг чинь үзэх гэж ярьж байгаа. Үзэсгэлэнтэй газрыг үзэх гэж.

Тэгээд энэ түүх соёлын зүйлүүдийг сэргээн засварлах зардал, мөнгө олддоггүй. Энэ байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах чиглэлийн зардлыг энэ сангаасаа санхүүжүүлэхээр хийж болоогүй юм уу? Яагаад ийм зүйл дутуу. Би бол арай дутуу орсон юм уу гэж бодоод байгаа юм.

Дараагийн асуудал. Энэ нийтийн эрх зүйн байгууллага гэж. Би бод одоо энэ төрийн бус байгууллага, энэ холбоог нь хэлж байгаа юм уу гэж ойлгоод байгаа юм. Энэ чинь нэлээн үүрэгтэй болох нь.

Тэр тур оператор, агент эд нар чинь заавал эднийд бүртгүүлсэн байх нь. Сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн байх ёстой. Төрийн бус байгууллагууд. Энд нь халдаад шууд тэр нийтийн эрх зүйн байгууллагын гишүүн байх үүрэгтэй гээд ингээд үүрэгжүүлээд өгчих юм. Энэ хэт хатуудаж байгаа, чангадаж байгаа юм биш үү?

Бид чинь тэгээд энэ дотоодын аялал жуулчлагчдад энэ хууль гарснаараа ямар давуу байдал олгох юм? Ямар үйлчилгээ үзүүлэх юм? Тэр юмнууд чинь харагдахгүй байна.

Бид чинь арга ядахдаа тэгээд л агаар салхинд гараад байгалийн сайхантай газар очоод нэг майхнаа босгоод л хүүхдүүдтэйгээ нэг хоол унд идээд л амардаг шүү дээ. Тэгээд та нарын оруулж ирсэн хуулийг чинь харахаар тэр улсын болоод орон нутгийн чанартай аялал жуулчлалын бүсэд отоглох цэгүүдэд байршаагүй бол торгоно гээд. Тэгээд одоо бид нар чинь хээр гараад нэг майхан хатгаад, нэг айлын хаяанд нэг голын хөвөөн дээр хоноод ирвэл тэгээд л бүгдээрээ

торгуулах юм уу. Гэх мэтчилэн ингээд бас асуугаад байвал зөндөө юм байна. Тэгээд энэ хэдэн асуултаар асуултаа асуучихаад.../минут дуусав/

Г.Занданшатар: 81. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ сайд.

Б.Бат-Эрдэнэ: С.Чинзориг гишүүний асуултад хариулъя.

Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжүүдийн саналыг авсан. Хуулийн төсөлд бас тодорхой хэмжээнд тусгагдсан. Нэгэнт хэлэлцүүлгийн шатанд явж байгаа учраас нэмж тусгах боломжтой байгаа.

Өнөөдрийн хэвлэлийн хурлын хувьд тур операторуудын холбоо гэдэг байгууллагаас энэхүү хурлыг хийсэн. Би өнөөдөр өглөө Тур операторуудын холбооны дарга н.Ганзориг гэдэг хүнтэй би бас утсаар ярьсан.

Ер нь Тур операторуудын холбоон дээр нэг л асуудал байгаа юм билээ. Тэр нь юу байна гэхээр нөгөө зөвшөөрлийг хэн олгох юм бэ гэдэг л асуудал. Одоо нөгөө миний түрүүний хэлээд байгаа дөрөв, таван холбоо маань хоорондоо би олгоно, би олгоно гэдэг ийм байр суурин дээр оччихсон.

Тэр хураамжийн орлого бол. Би түрүүн хэлсэн. Нэг ч өөрчлөлт ороогүй. 100 мянган төгрөг хэвээрээ явж байгаа. Тэр мөнгө бол эргээд аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр аялал жуулчлалыг хөгжүүлэх сандаа төвлөрөөд эргээд зарцуулагдаад явах ийм л мөнгө байгаа юм.

Агаарын тээврийн үйлчилгээний хувьд дотоодын авиа компаниуд буюу дотоодод нисэж байгаа дотоодын авиа

компаниудад бид дэмжлэг үзүүлэх зорилготой л энэ дээр оруулж өгсөн. Үүнийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт сайдтай бид бас маш сайн ярьсан.

Сангийн үйл ажиллагааг өргөжүүлж болох уу гэдгийн хувьд Соёл, урлагийг дэмжих сан гэж тусдаа сантай. Байгаль орчныг нөхөн сэргээх нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар орон нутагт төвлөрсөн орлогоос хуулийн дагуу тодорхой байгаль орчныг нөхөн сэргээх хуулийн заалтуудтай эргэж явдаг. Энэ нь өнгөрсөн 11 сарын 30-ны өдөр бид нар бас Авлигатай тэмцэх газартай аймгийн нийслэлийн тодорхой удирдлагуудтай бид хурлаа хийчихсэн явж байх жишээтэй байгаа.

Таны нэг саналтай би санал нэг байна. Нийтийн эрх зүйн этгээд буюу тур оператор гишүүнчлэл дээр албадлагын шинж чанар хэрэглэсэн байна гээд. Энэ бол сайн дурын үндсэн дээр явах ёстой. Үүнийг хуулийн хэлэлцүүлгийн шатанд бид өөрчлөөд явах ёстой гэж харж байгаа юм.

Отоглох цэгийн хувьд би бас түрүүн хэлсэн. Буруу ойлголттой байна. Отоглох цэг бол байгальд гарч, монголчуудын маань өөрсдөө аялж зугаалдаг хэлбэр дээр бол огт хамаарахгүй. Энэ бол миний түрүүний хэлсэн улсын аялал жуулчлалын бүс буюу стратегийн хувьд Монгол Улс өөрөө аялал жуулчлалын байгалийн нөөц, соёл дурсгал, үнэт зүйлсүүдтэй газар, мөн тусгай хамгаалалттай газар орон нутгууд дээрээ отоглох цэгийг байгуулж өнөөдөр эдийн засгийн эргэлтэд ороогүй байгаа буюу огт ашиглагдахгүй байгаа энэ газар орон

нутгийг ашиглахтай холбоотой асуудлууд л орж байгаа юм.

Түүнээс биш зүгээр хээр гараад майхантай хоноод ингээд аль нэгэн малчин айлын гадаа очоод хоноглоод явах юм уу, эсвэл монголчууд маань зундаа аялал жуулчлалаар дотоодын аялал жуулчлалын эрхлэнгээ бас амралт зугаалгын цагаа тааруулаад явдаг. Энэ дээр ямарваа нэгэн нөлөөлөл байхгүй ээ гэдгийг би албан ёсоор хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн тодруулж асууя.

С.Чинзориг: Зөрчлийн хуульд оруулах гэж өөрчлөлтөө Б.Бат-Эрдэнэ сайд аа, хараарай даа. Та нар буруу ойлгоод байна гээд яриад байх юм.

Энэ дээр бичсэнээр чинь улсын болоод орон нутгийн аялал жуулчлалын бүсэд хээрийн отоглох цэгийн байршлаас бусад газар жуулчин аялагч отоглосон бол торгоно гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр чинь жуулчин ч орох нь, аялагч ч орох нь л дээ. Тэгээд торгуулах гээд байгаа юм. Үүнийг нэг анхаармаар байгаа юм.

Хоёрдугаарт, ингээд заавал тур оператор, агентаар дамжих юм уу? Тэр нь заавал тэр нийтийн эрх зүйн байгууллагын гишүүн байх ёстой юм уу? Бид чинь манайд ирж байгаа аялагч нар чинь ихэнх нь дандаа эд нараар дамждаггүй үүргэвчтэй аялал ирдэг. Бид ч гэсэн залуучууд ч гэсэн гадагшаа явахдаа тэгээд л өөрсдөө юмаа захиалаад л заавал тур оператор, тэр агентаар дамжихгүйгээр явдаг шүү дээ.

Тэгээд манайхан заавал нэг байгууллагаар жуулчлуульж байж аялал жуулчлал авна. Тэр нь заавал тэр нийтийн эрх зүйн байгууллагын гишүүн байна гээд.

Тэр нь бүх зэрэглэлийг нь тогтоодог байна гээд ингээд маш одоо.../минут дуусав/

Г.Занданшатар: Аялал жуулчлалын хэвтээ биш босоо тогтолцоо руу шилжихээр гэж байна. 81. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ сайд.

Б.Бат-Эрдэнэ: Би сая улсын аялал жуулчлалын гэдэг агуулгыг нь бол хэлчихсэн.

Ажлын хэсэг дээр орон нутгийн отоглох цэгийг хасах саналтай явж байсан. Энэ бол хэлэлцүүлгийн шатандаа хасагдаад явчихна гэж ойлгож байгаа.

Тур оператороор жуулчин заавал дамжина гэдэг ийм үг үсэг заалт байхгүй. Түрүүн би хэлсэн. Нийтийн эрх зүйн этгээд буюу тур оператор, компаниуд заавал аялал жуулчлалын мэргэжлийн холбоонд бүртгэгдэж байж үйл ажиллагаа эрхлэх эрх нь үүсэж байгаа мэт ойлголт бас яваад байгаа. Энэ бол тухайн аж ахуйн нэгж, компаниуд маань заавал аялал жуулчлалын мэргэжлийн холбоонд элсэж байж үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагагүй гэж бид харж байгаа.

Энэ бол түрүүний хэлсэнчлэн албадлагын шинж чанартай ийм заалт орсон байсан. Үүнийг бид хасна. Дээрээс нь аялал жуулчлалын бүтээгдэхүүн. Түрүүн би бас хариулаагүй байна.

Аялал жуулчлалын бүтээгдэхүүний хувьд манай “Хөх сувд” мөсний баяр, “Түмэн тэмээ”-ний баяр гэх мэтчилэнгээр ингээд маш олон аялал жуулчлал.../минут дуусав/

Г.Занданшатар: Балжиннямын Баярсайхан гишүүн асуулт асууна.

Б.Баярсайхан: Баярлалаа. Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Хэд хэдэн асуулт байна.

Манай Завхан аймаг говь, хангай хосолсон байгалийн үзэсгэлэнт олон газруудтай. Сүүлийн жилд дотоодын жуулчдын хөл нэлээн тасрахгүй ийм олон жуулчид хүлээж авч байгаа. Тэр дундаа Отгонтэнгэр орчмын бүс нутгийн асуудал нэлээн олны хөлд талхлагдсан ийм байдалтай байж байгаа.

Тэгэхээр энэ асуудлын гол нь бол улсын тусгай хамгаалалтад авсантай холбоотой байгаад байгаа юм. Улсын тусгай хамгаалалтад авсан гэгчхээд байгаль танай яамнаас болохоор төдийлөн хяналтаа тавьж өгдөггүй. Сум орон нутаг, нутаг өөрсдөө хамгаалаад гүйгээд байдаг. Эрх мэдэл нь бага ийм асуудал байна.

Үүнээс болоод манай Эрдэнэхайрхан сумын нутагт оршиж байгаа Хар нуур, Мухартын гол хог шороондоо дарагдсан, олны хөлд талхлагдсан ийм байдалтай байгаа гэдгийг танай яаманд бас удаа дараа ингэж хэлж байгаа.

Энэ дээр тусгай хамгаалалттай бүс нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэхэд ямар менежментээр Та бүхэн ажиллах гэж байгаа юм бэ? Сум,

орон нутагт нь тодорхой эрх мэдэл өгөх юм уу? Сум нь тусгай хамгаалалттай газраа тодорхой эрх мэдэлтэйгээр хянаж оролцож төлбөр хураамж, отоглох цэг байгуулах, буцаагаад хяналт тавих ийм зохицуулалт зайлшгүй шаардлагатай байгаад байна. Энэ дээр та бүхний хариултыг сонсмоор байна.

Хоёрдугаарт нь, Хар нуур орчмын загас агнуурын асуудал байгаа. Мөн л адил тусгай хамгаалалтын бүс нутаг учраас сум орон нутагт тодорхой хяналт анхаарал тавьж, хариуцлага хүлээлгэх боломжгүй байгаад байна.

Энэ дээр өнөөдрийг хүртэл нутаг орноо сахиад тодорхой хэмжээгээр аялал жуулчлалыг хөгжүүлэх гэж оролдож байгаа иргэд байна. Энэ иргэд өнөөдөр зөвшөөрлөө авах гэхээр тусгай хамгаалалтын газар учраас зөвшөөрөл өгөхгүй гэдэг.

Энэ дээр Та бүхэн маань ямар зохицуулалт хийх юм бэ?

Гурав дугаар асуудал. Энэ дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлнэ гээд л ярьж байгаа. Энэ хүмүүсээ соён гэгээрүүлэх асуудал дээр яам ямар арга хэмжээ авч ажиллах вэ, ажиллаж байгаа вэ? Өөрөөр хэлбэл байгаль дэлхийгээ хайрлах, ус нуураа хайрлах, хамгаалах, хогоо цэгцлээд явдаг байх, Монгол Улсынхаа энэ үзэсгэлэнт газруудыг хайрладаг байх тал дээр ямар соён гэгээрүүлэх дорвитой ажил хийх юм бэ гэдэг гуравдугаар асуулт байна.

Дөрөвдүгээр асуулт бол Монголд зочлох жил болгож Засгийн газар ирэх жилүүдийг зарлаж байна. Энэ сайн. Гэхдээ ямар нэгэн улс оронд очиход яг үүнийг нь үзэх юм бол тухайн улс орныг үзсэн гэсэн үг гэдэг ийм бэлгэдэл

байдаг. Өөрөөр хэлбэл тухайн үндэстнүүдийн брэнд болсон ийм жуулчид очдог ийм газрууд байдаг. Тэгвэл өнөөдөр Монгол Улсынхаа ямар ямар аймгийн, ямар ямар үзэсгэлэнт газруудыг та бүхэн маань нэрлэх гэж байгаа юм бэ? Ийм ажлуудыг хийх гэж байна уу?

Өнөөдөр Монгол Улсад ирэхэд ямар нутгийн ямар газар, ямар уул усыг үзээд явах талаар мэдээлэл байхгүй ээ. Тэгээд энэ дээр ямар ажил хийж байгаа юм бэ? Хийгдэх вэ гэсэн энэ асуудлууд дээр тодорхой хариулт авмаар байна.

Түрүүн тэгээд дээр нь нэмээд М.Оюунчимэг гишүүний ярьж байгаа. Үнэхээр Монголд зочлох жил болж байгаа юм бол заавал гадаадын хүмүүс жорлон хэрэглэдэггүй ээ. Дотоодын аялал жуулчлагчдад ч гэсэн тавтай тухтай тэр бие засах газар байгаль дэлхийгээ хайрлаад үлдээх ийм нөхцөлийг үүсгэх энэ ажил бол зайлшгүй шаардлагатай.

Үнэхээр усанд ордог душийг нь барьж чаддаггүй юм гэхэд байгаль орчноо хайрлаж хамгаалаад бие засуулах газартай байх гэдэг бол жуулчин татах хамгийн номер нэг хийх ажлаа. Энэ дээр юу хийж байгаа юм бэ гэсэн энэ асуултуудад тодорхой хариулт авъя.

Г.Занданшатар: 81. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ Байгаль орчин, аялал жуулчлалын сайд хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: Б.Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Завхан аймагтай холбоотой, ялангуяа Отгонтэнгэр орчмын бүс орчимтой холбоотой.

Ер нь энэ зөвхөн Завхан аймаг гэлгүйгээр л байгаа асуудлуудын нэг л дээ.

Тийм учраас бид Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгад 19 дүгээр зүйл дээр “аялал жуулчлалын бүс” гэж бид албан ёсоор оруулж өгч байгаа.

19.11 дээр аялал жуулчлалын бүсийн менежментийг бүхэлд нь, эсхүл тодорхой хэсгийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно буюу төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тодорхой чиг үүрэг, зарим ажлыг менежментээр хувийн хэвшил рүү шилжүүлж гүйцэтгүүлж ажиллуулахаар ийм заалтуудыг бид оруулж байгаа юм.

Саяын таны хэлдэг мөн нутгийн иргэнтэй холбоо бүхий асуудал бол Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 11 дүгээр зүйл дээр жуулчны үйлчилгээ үзүүлэгч иргэний үйл ажиллагаа буюу жуулчны үйлчилгээ үзүүлэгч иргэн нь орон нутагт гэр түрээслүүлэх, нүүдлийн соёл ахуй, зан заншил, жуулчдад таниулан сурталчлах, аялал жуулчлалын дагалдах бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэх, мөн менежментээ хийх. Төрөөс тодорхой хэмжээнд нутгийн иргэдээ түшиглэсэн аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахыг төр болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас бодлогоор дэмжлэг үзүүлнэ. Жуулчны үйлчилгээ үзүүлэгч иргэнд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлагыг бас тодорхой хэмжээнд гаргана гээд ийм тодорхой заалтуудыг бид бүгдийг нь ингээд оруулаад өгч байгаа юм.

Энэ агуулгаараа аль аль нь зөвхөн төрийн гар хараад хүлээгээд суухгүйгээр хувийн хэвшлийн байдлаар цаашдаа үргэлжлээд явчих болов уу гэсэн.

Соён гэгээрүүлэх ажлуудын хүрээнд ялангуяа байгаль орчин, аялал жуулчлал маань Монгол Улсын хувьд нэг явдаг учраас. Дээрээс нь гаднаас ирж байгаа нийт жуулчдын дийлэнх нь байгаль орчинд түшиглэсэн байдлаар Монгол орны байгаль орчныг сонирхож ирсэн гэдэг ийм хариултыг өгдөг.

Энэ агуулгаараа бид бас тухайн орон нутгийн иргэдийг соён гэгээрүүлэх, ялангуяа бид шинээр эхлүүлж байгаа буюу Монгол Улс 3.4 сая иргэнтэй. 1.3 сая нь 18 хүртэлх насны хүүхдүүд. Түүн дотроо ерөнхий боловсролын сургуулийн 712 мянга 400 сурагч байна. Энэ сурагчдаар дамжуулсан бид **Green Generation** буюу байгаль орчин, эх дэлхийгээ хамгаалах, мөн соён гэгээрүүлэх энэ ажлуудыг бид хийгээд эхэлчихсэн явж байгаа.

“Монголд зочлох жил” болгон зарлаж байгаатай холбогдуулаад бид ер нь аялал жуулчлалын маршрутуудыг бид зайлшгүй бий болгох ёстой гэж харж байгаа. Энэ маань тухайлсан орнуудын хувьд. Тухайлах юм бол Бүгд Найрамдах Солонгос Улс, Япон Улсын иргэд говь руу явж үзэх их сонирхолтой байдаг.

Тэгэхээр бид аялал жуулчлалын маршрутыг жишээлбэл, яг тэр чиглэлд нь бид Өмнөговь, Дундговь гэдэг чиглэлээр гаргах. Хархориныг түшиглэсэн манай томоохон аялал жуулчлалын бүсийг бид бас

маршрутуудыг бүгдийг нь гаргаад явж байгаа.

Олон улсад мэдээлэл гараад цацаад бид олон улсын байгууллагуудтай, мөн Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрууд, мөн Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрууд ойрыг үед нисэх онгоцуудад бид цацаж эхлээд ингээд явуулахаар бүх цахим платформоо 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр бэлэн болгож цацагдсан.

Mongolia Travel Guide буюу тухайн ямар ямар аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүд, эвентүүд Монгол Улсад хэзээ, хэзээ байдаг вэ. Монгол Улсын соёл заншил нь юу вэ, иддэг уудаг хоол нь юу вэ, өмсдөг хувцас нь юу вэ гэх мэтчилэнгээр ингээд бүх зүйлсүүдийг бид оруулаад явж байгаа.

Энэ бол бүрэн, одоо ч гэсэн ажиллаж байгаа ийм платформ байгаа. Мөн хоёр сар тутам сэтгүүл update хийгдэж явж байгаа.

Ариун цэврийн байгууламжийн асуудлуудын хувьд ерөөсөө л шийдэл нь отоглох цэгээр шийдвэрлэх ёстой асуудал байгаа. Отоглох цэгийг бид төрөөс зуун хувь хийж чадахгүйгээс хойш миний түрүүний хэлсэн энэ аж ахуйн орлогын албан татвараас хасагдах зардалд тооцох замаар бид аж ахуйн нэгжийг өөрсдийн энэ отоглох цэгийг байгуулах, отоглох цэг, дотор нь ариун цэврийн байгууламжийн асуудлыг цогцоор нь шийдэж өгөх энэ асуудлыг бол бид энэ хууль эрх зүйн хүрээнд тусгаад явж байгаа гэж ойлгож болно гэсэн үг. Баярлалаа.

Г.Занданшатар: Б.Баярсайхан гишүүн тодруулъя. 1 минут.

Б.Баярсайхан: Мэдээж яамнаас 21 аймгийнхаа бүхий л газруудад ингээд ижил тэгш хандаад анхаараад явж байгаа байх.

Би Отгонтэнгэр уулын орчим бүс нутгийг Аялал жуулчлалын яам тодорхой хэмжээнд онцгой анхааралтай аваач ээ. Улаагчны хар нуур одоо бараг дэлхийд ганц нуур Мухартын гол, элсэн уулнаас гарч ирж байгаа эх авч байгаа ийм ус байгаа. Үүнийг нэгэнт тусгай хамгаалалтын газар авчихсан гэж байгаа боловч яг амьдрал дээр энэ асуудал ерөөсөө хэрэгжихгүй байна.

Би өөрөө гишүүн болоод нэг төсвөөс хог шатаах зуухны асуудлыг л шийдүүлж чадсан байгаа.

Тэгэхээр нэгэнт тусгай хамгаалалтад байгаа, нэгэнт энэ дэлхийд бас ховорхон ийм байгалийн өвөрмөц ийм үзэсгэлэнт тогтоц учраас энэ онцгой байгаль газар нутгийг хамгаалахад бас онцгой анхаарч өгөөч ээ гэж эрхэм сайд, яамны удирдлагуудад Завхан аймгийг төлөөлөн хүсэж байна.

Г.Занданшатар: Хүсэлт байна. Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуулт асууна.

Б.Энхбаяр: Энэ аялал жуулчлалын хуулийг баталбал манай улс аялал жуулчлалын бүрд болно гэж сайд маань түрүүн танилцууллаа.

Тэгээд яг уншаад үзэхээр аялал жуулчлалын бүрд биш, эсрэгээрээ аялал жуулчлалгүй ийм шорон болчихмоор юм шиг хуулийнх нь бичилт нь

бичигдчихсэн юм шиг надад эргэлзээ төрж байгаа учраас хэдэн асуулт байна.

Нэгдүгээрт, хуулийн төслийн 4 дүгээр зүйл “жуулчин” гэж аялал жуулчлалын байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авч, аялал жуулчлал хийж байгаа хүнийг л. 4.1.3.“аялагч” гэж аяллын зорилгоор аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэнийг.

Тэгэхээр аялал жуулчлалын байгууллагаар заавал үйлчлүүлж байж аялагч юм уу, жуулчин болно гэсэн ийм санаа энэ хуульд хатуу бичигдсэн байна. Энэ байгууллагаар үйлчлүүлээгүй явж байгаа хүмүүсийг юу гэж үзэх юм? Энэ хүмүүс аялагч биш, жуулчин биш болчихоод байна шүү дээ. Хууль зүйн хувьд.

Тэгээд түрүүний С.Чинзориг гишүүний асуугаад байгаа асуулт чинь тэр Зөрчлийн хууль дээр гарч ирээд байна. Тэр отоглох газар зөвшөөрөлгүйгээр отоглосон байх юм бол 100 мянгаар торгоно. Аялал жуулчлалын байгууллагаар дамжуулж үйлчилгээ аваагүй бол нэг сая төгрөгөөр торгоно гэдэг Зөрчлийн хуулийн чинь хариуцлага тэндээс гарч ирээд байна.

Тэгэхээр цүнхээ үүрээд, нөгөө үүргэвчээ үүрээд явж байгаа хүн чинь Зөрчлийн хуулиар торгуулах болчихож байгаа учраас манай улс хэрэг дээрээ аялал жуулчлалыг хаах гэж байна гэсэн үг. Эсрэг ийм бодолтой болчихоод байна.

Хоёр дахь асуулт нь. Энэ хууль дээр аялал жуулчлалын байгууллага гурав ангилсан байна. Тур оператор, аялалын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага гэж байгаа.

Тэгээд энэ ангилж байгаагийн би утга агуулга энэ хуулийн бас гол концепц юм байна гэж ойлгосон. Тэгтэл энэ ер нь яг тур оператор юмнуудаа ер нь хууль санаачлагч маань хэр ойлгосон юм бол оо? Яагаад ингэж асууж байна вэ гэхээр энэ аялал жуулчлалын хуулийг дагаж өргөн мэдүүлсэн Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 36 дугаар зүйлийн 3-т энэ тур операторт газрыг 15 жилийн хугацаагаар олгоно гээд биччихсэн байна. Энэ тур операторт газар олгож яах гээд байгаа юм.

Одоо жишээлбэл, энэ чинь зүгээр жуулчин зуучилж байгаа нэг компани байх нь байна шүү дээ. Тэр заавал Баян-Өлгий аймагт 15 жилийн хугацаагаар газар авна гэж. Эсвэл тэр Буйр нуурын эрэг дээр тэр газар авдаг газар биш байхгүй юу. Энэ ер нь юмаа ойлгоогүй юм биш үү.

Тэгээд энэ Тусгай хамгаалалттай газар нутгийн хууль өчигдөр Газрын хууль хэлэлцэж байхад өргөн барих ёстой гэдэг асуудал яригдсан шүү дээ. Энэ хууль чинь орж ирэх ёстой юм биш үү? Энэ дагасан тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын хуулийг бол би ерөөсөө агуулгыг нь ойлгохгүй. Энэнээсээ улбаалаад энэ ер нь тур компани гэдгээ ер нь ойлгоогүй юм биш үү?

Одоо ер нь энэ дэлхий нийтийн аялал жуулчлал чинь тур компани гэдэг ойлголт байхгүй болчихсон шүү дээ. Дэлхий нийтийн аялал жуулчлал чинь ерөөсөө гар утас нь шилжчихсэн. Гар утасны нэгхэн аппликэйшн болчихсон байхгүй юу. Гар утсаараа билетээ захиална. Гар утсаараа буудлаа

захиалчхаж байна. Гар утсаараа үзвэрээ захиалчхаж байна. Гар утсаараа **UBER**-ээ дуудаад унаагаа уначхаж байна. Ямар ч тур компанийн хэрэггүй болчихсон байхгүй юу.

Тэгэхэд заавал ийм тур компаниар бүх аялал жуулчлалыг хийнэ гэдэг хууль орж ирчхээд байна шүү дээ. Энэ чинь эсрэгээрээ яг энэ бодлогыг дэлхийн эсрэг.../минут дуусав/

Г.Занданшатар: Хариулт байна уу? 85.

Б.Болортуяа: Өдрийн мэнд. Б.Энхбаяр гишүүний асуултад хариулъя.

Аялал жуулчлалын тухай хууль маань ерөнхийдөө эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтийг тооцох гэдэг энэ агуулгаараа энэ хуулийн шинэчилсэн найруулга явж байгаа.

Тийм учраас энэ хуулиар бүх үүргэвтэй аялагчаас эхлээд бүх дотоодын иргэний аяллыг хүртэл зохицуулах өөрөө ийм бас боломжгүй байгаа.

Тийм учраас энэ дээр одоо яг тур оператор буюу аялал жуулчлалын үйлчилгээ эрхэлж байгаа байгууллагаар үйлчлүүлж байгаа жуулчин болон аялагчийн асуудлыг хуулийн нэр томъёоны асуудалд тусгасан байгаа.

Тэгэхээр энэ тур оператор болон аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага гэдэг маань өөрөө энэ аялал жуулчлалын байгууллага дотроо яг аялал жуулчлалын үйлдвэрлэлийг бий болгож

байгаа үндсэн ийм бүрэлдэхүүн байгууллагууд байгаа.

Тийм учраас энэ байгууллагуудын үйлчилгээг авч байгаа жуулчин болон аялагч нь өөрөө эдийн засгийн үр өгөөжийг бий болгож байгаа. Үүгээрээ эргээгээд Монгол Улсын эдийн засагт оруулж байгаа статистик тоо баримтыг бас бүрдүүлж байгаа энэ бүртгэл мэдээлэл бол ингэж уялдаж үүгээр ингэж зохицуулагдаж гарах юм.

Г.Занданшатар: Яагаад дэлхийн эсрэг яваад байгаа юм гэсэн. 83.

Р.Лхагвабаяр: Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбоотой Б.Энхбаяр гишүүний асуултад хариулъя.

Нэмэлт, өөрчлөлтийн төсөл дээр тур операторт Аялал жуулчлалын тухай хуулийн 12.2.1, 12.2.2, 12.2.3-т заасан тур операторт 15 жилийн хугацаагаар газар ашиглах тусгай зөвшөөрөл олгоё. Цаашлаад шаталсан байдлаар гурван байгууллагууд мөн 10-аас 12 жилийн хугацаагаар олгоё гэж томъёолсон.

Энэ томъёолол тур оператор маань Б.Энхбаяр гишүүний хэлж байгаа бол зөв. Аяллыг зохион байгуулж байгаа буюу тодорхой хэмжээнд зуучлалын үйлчилгээ үзүүлээд энэ аяллыг бүхэлд нь зохион байгуулах үүрэг хүлээдэг. Гэсэн хэдий ч Монголын практикт тур оператор маань ихэнх тохиолдолд өөрөө бүх үйлчилгээгээ нэгэн зэрэг хийж байгаа буюу тур оператор нэгдүгээрт аялал жуулчлалын үйлчилгээ зохион байгуулж байгаа.

Хоёрдугаарт, зочид буудал ажиллуулж байгаа. Цаашлаад амралтын газар ажиллуулж байгаа. Энэ бүх үйлчилгээгээ хийж байгаа ийм нөхцөл байдал үүсээд байгаа юм.

Тэгэхээр энэ компаниудад нэгдүгээрт, тусгай зөвшөөрөл олгох гээд хуулийн төсөлдөө тусгасан бөгөөд энэ дээр тур оператор компаниуд маань энэ аялал жуулчлалыг дэмжих жилүүдэд шинэчилсэн хуулиар ямар боломж бий болох юм бэ гэдэг дээр хамгийн том хүндрэлүүдийн нэг болох газар ашиглалтын асуудлыг шийдвэрлэж өгөхийг хичээсэн. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа тусгай хамгаалалтай газар нутгын тухай хуульд 5 жилийн хугацаагаар газар ашиглуулахыг заасан байдаг хэдий ч тодорхой аялал жуулчлалын зориулалтаар бол ямар тусгай шалгуур харгалзан үзэх юм гэдэг нарийвчилсан зохицуулалтууд байдаггүй.

Тэгэхээр яг аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглах, цаашлаад тур операторын үйлчилгээ эрхлэгч энэ компани байвал ийм хөнгөлөлт эдэлж болох юм гэдэг байдлаар томьёолохыг хичээсэн.

36.3.3 дахь хэсэгт Аялал жуулчлалын тухай хуульд заасан шаардлага хангасан аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага аяллын агентад 10 жил хүртэл хугацаагаар олгоно гээд энэ тусгайлсан аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглах хугацааг аялал жуулчлалын байгууллагууддаа дэмжлэг болгох үүднээс ийм тусгайлсан хугацааг оруулж ирсэн юм.

Г.Занданшатар: 86.

П.Баярцэцэг: Б.Энхбаяр гишүүний асуултад хариулъя.

Төр операторыг дэлхийн аялал жуулчлалын чиг хандлага бол цахим болсон. Тийм учраас технологи оролддог болчихсон гээд тэрсэн.

Тэгэхээр зэрэг бусад улсууд Казахстан, Киргизстан, Япон, Сингапур, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хууль тогтоомжид бол энэ тур оператор, аялалын агентын нэр томьёо нийтлэгээр хэрэглэгддэг. Тэгээд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа энэ Аялал жуулчлалын тухай хуульд мөн тур оператор, тур агент нь аялал жуулчлалын үндсэн байгууллага байхаар тодорхойлсон байгаа.

Тэгэхээр бид тур оператор, тур компани гэдэг ойлголт нь бид дэлхийн аялал жуулчлалын байгууллагын үндсэн чиг хандлага, хууль тогтоомжид нийцүүлж оруулж ирсэн ийм ойлголт. Баярлалаа.

Г.Занданшатар: Баттөмөр Энхбаяр гишүүн тодруулж асууна. Нэмэлт 1 минут.

Б.Энхбаяр: Энэ Аялал жуулчлалын тухай хуулийн төсөл, хууль тогтоомжийн хуулийн шаардлагыг хангаж Улсын Их Хуралд орж ирсэн үү гэдэг асуулт байна.

Хууль тогтоомжийн хуулиар чинь хуулийн төслийг боловсруулах ёстой. Цахим санд доор хаяж 30 хоног байршуулах ёстой. Иргэд, олон нийт, ялангуяа эрх ашиг нь хөндөгдөж байгаа байгууллагуудаар хэлэлцүүлэг хийж саналыг нь авах ёстой. Ийм олон шаардлага байгаа шүү дээ.

Тэгээд энэ Хууль тогтоомжийн хуулийн шаардлагыг хангасан юм уу? Энэ аялал жуулчлалын байгууллагууд нь өөрсдөө асуудал яриад байх юм. Мань мэт болохоор өчигдөр аваад л өнөөдөр хэлэлцээд суугаад байх юм. Бүрэн гүйцэд уншиж амжихгүй.

Тэгээд энэ дагасан Зөрчлийн хууль бол үнэхээр асуудалтай юм байна. Энэ бол ер нь яаж бодохоороо.../минут дуусав/

Г.Занданшатар: Хууль зүйн яам, Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон. 84.

Д.Цолмон: Б.Энхбаяр гишүүний асуултад хариулья.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах энэхүү явц маань яг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хэлбэрийн хувьд хангасан байгаа. Өөрөөр хэлбэл Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар тодорхой гурван судалгаа хийгдсэн байх ёстой. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын өрнөлөөр. Хуулийн төсөл боловсруулагдсаны дараа хуулийн төслийн үр нөлөө, зардлын тооцоо гэсэн энэ гурван судалгаа хийгдсэн байгаа.

Үүний хажуугаар Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу тухай хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн байх шаардлагыг тавьдаг.

Тэгэхээр энэ олон нийтийн хэлэлцүүлгийг энэхүү Аялал жуулчлалын тухай хууль бол 2016 оноос хойш энэ төсөл маань хэлэлцэгдэж явж ирсэн. Тэгээд сүүлийн энэ үзэл баримтлалын хүрээнд

хамрагдах холбогдох энэ ашиг сонирхол бүхий этгээдүүдийн хүрээнд энэ оны 4 сараас эхлээд цуврал хэлэлцүүлгүүдийг хийсэн. Аялал жуулчлалын холбоодуудаар ээлж дараалан хийсэн. Холбогдох саналуудыг нь бас хүлээж авсан.

Г.Занданшатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Аялал жуулчлалын хуулийг үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа юм.

Монгол Улсын гадаад валютын нөөцийг бүрдүүлэхэд ганцхан уул уурхайг харж байгаа. Уг нь манай хөдөө, аж ахуй бас их дорвитой жин үзүүлэх ёстой. Харамсалтай нь тийм байж чадахгүй байгаа. Гэхдээ аялал жуулчлалын энэ салбараас нэлээдгүй эдийн засгийн эргэлт орж ирнэ гэж ингэж тооцож, тэгээд Монгол Улсын Засгийн газраас энэ хуулийг оруулж ирэхдээ тэр визний асуудал, тийзний асуудал гээд олон асуудлуудыг бас хамтдаа оруулж ирж. Өнөөдөр бас Их Хурлаар баталсан тэр Газрын тосны тухай хуулиар бол бас энэ тийзний хямдрал үзүүлэхэд авиа компаниудын шатахууны үнийн асуудал дээр л бас тодорхой хэмжээнд өөрчлөлт оруулахын төлөө ингээд шийдэгдэж байх жишээтэй.

Манай Хэнтий аймаг бол түүхэн аялал жуулчлалын бүс болж, Монгол Улсын Засгийн газрын шийдвэр гарч хэрэгжээд явж байгаа. Үнэхээр одоо бас энэ өнгөрсөн хугацаанд энэ асуудлууд яригдахаас ч өмнө, ер нь зүгээр Эзэн хаан Чингис хааны нутагт ирж миний энэ насны маань хүсэл биеллээ гэж байгаа монгол туургатныг би бас олон удаа хажуунаас нь харж байсан.

Тэгэхээр дэлхий даяар тархан суурьшсан 10 сая гаруй монголчууд бүгдээрээ л Монгол Улсад айлчлах, ирэх, аялах ийм л сонирхолтой байдаг. Тэндээс ямар тээг саад та нар байдаг болоод та ингэж бас хэлж байгаа юм бэ гэж би тухайн үед 10-аад жилийн өмнө асуухад Монгол Улсад ирэхэд энэ тийз, виз гэдэг энэ асуудал чинь маш хэцүү. Харин би энэ удаа албаны айлчлалаар ирж чадсан тулдаа энд ирлээ гэж нүдэндээ нулимстай хүн байхыг би харж байсан юм.

Тэгэхээр энэ өнөөдрийн орж ирж байгаа хууль бол Монгол Улс руу аялал жуулчлалыг бас татахад нэлээдгүй том эрх зүйн тээг саадууд, эдийн засгийн тээг саадуудыг нь нээж өгсөн, арилгасан ийм л хууль болох нь ээ гэж ингэж бодож байгаа юм.

Тэгээд Улсын Их Хурлаар хэлэлцэж эхэлсэн цагаас эхлээд яг одоо энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хүмүүсээс бас санал, хүсэлтүүд ирж байна л даа. Мөн энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг оператор компаниуд, хувь хүмүүстэй бас холбогдож энэ хууль дээр ямар санал онол байна вэ? Та бүхнээс санал онол авсан уу гээд ингээд олон талаас нь асууж үзлээ.

Тэгэхээр яамны зүгээс энэ салбарын байгууллагуудтай бас нэлээн сайн уялдаа холбоотой ажилласан юм байна гэж би дүгнээд байгаа юм. Саяхан энэ 20, 30 жил ширэнгийн хуулиар явж ирсэн энэ аялал жуулчлал өнөөдөр ингээд нэг юм хууль эрх зүйн хувьд тогтвортой, ойлгомжтой болоод ирж байгаа нь бас их зүйтэй юм гэж байгаа хүний ярилцлагыг сая уншлаа.

Гэхдээ энэ дээр бас нэг жоохон амьдралгүй юмнууд байна уу даа гэсэн зүйлийг хэлж байна. Манай Хэнтий аймгаас энэ аялал жуулчлалын бизнес эрхэлдэг хүмүүсээс. Ялангуяа энэ Зөрчлийн хууль. Тэрний нөгөө 8 дахь заалт дээр энэ одоо яг ямар учиртай юм бэ? Энэ батлагдвал бидэнд бас их хэцүү болох нь ээ. Энэ жоохон амьдралаас хөндий зүйл, заалт явж байна уу? Энэ дээр та бас асууж сурч тодруулж өгөөрэй гэж ингэж хэлсэн учраас асууж байгаа юм.

Энэ дээр энэ зөрчлийн дагалдах хууль дээр байгаа зөрчлийн 9 заалт байна. 2 зүйл, 8 заалт. Үүний тэр 8 дахь заалт буюу улсын болон орон нутгийн аялал жуулчлалын бүсэд хээрийн отоглох цэгийн байршлаас бусад газарт жуулчин, аялагч отоглосон бол хүнийг зуу, нэг зуун нэгжтэй тэмцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэсэн. Энэ ямар учиртай зүйл, заалт байгаа юм бэ? Энэ Зөрчлийн хууль дээр. Үүнийг та бүхэн нэг тодорхой хариулаад өгөөч ээ гэж хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: 82.

С.Цогтгэрэл: Ц.Идэрбат гишүүний асуултад хариулъя.

Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 8-д заасан заалтын талаар ярьж байна. Улсын болон орон нутгийн аялал жуулчлалын бүсэд хээрийн отоглох цэгийн байршлаас бусад газарт жуулчин, аялагч отоглосон бол хүнийг зуу, нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж.

Энэ дээр түрүүн Б.Бат-Эрдэнэ сайд хэлсэн. Энэ дээр бас боловсруулалтын шатанд энэ орон

нутгийн аялал жуулчлалын бүс гэдэг зүйл бол бас алдаатай тусгагдсан байж болзошгүй юм байна гэж байгаа. Улсын аялал жуулчлалын бүсийг бид хуулийн төсөлд тусгахдаа Монгол Улс тодорхой газар нутгаа улсын аялал жуулчлалын бүс гэж зарлаад Засгийн газраас тэр аялал жуулчлалын бүсийг тогтоогоод хил заагийг нь баталдаг байхаар ингэж хуулийн төсөлд тусгасан байгаа.

Сая Б.Баярсайхан гишүүн хэлж байна. Зарим газар нутаг хүний хөлд талхлагдаад хог шороонд дарагдаад байна гэж. Яг энэ асуудлыг шийдэх гээд тухайн байгалийн цогцолбортой түүх, соёлын өлгий болсон энэ газрыг аялал жуулчлалын бүс болгоод бүсчилсэн байдлаар хөгжүүлээд тэнд тодорхой дүрэм журам, стандартыг мөрдүүлээд байгаль орчноо хамгаалах, хариуцлагатай аялал жуулчлалыг хөгжүүлэх энэ гол бодлогын хүрээнд энэ асуудал орж ирж байгаа юм.

Мэдээж тухайн бүс нутаг дээр отоглох цэг байгуулна. Отоглох цэг дээр буугаарай гэдэг шаардлагыг хуулиар тавьж байгаа бол үүнийг зөрчсөн тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэх вэ гэдэг асуудал хуулиар зохицуулагдах зайлшгүй шаардлагатай.

Тийм учраас Зөрчлийн тухай хуульд энэ зохицуулалт бас орж ирж байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар:

Ёндонпэрэнлэйн Баатарбилэг гишүүн. Байхгүй байна. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууна.

Х.Булгантуяа: Энэ хуультай холбоотойгоор аялал жуулчлалын компаниудаас бид заавал энэ холбоогоор дамжиж үйл ажиллагаагаа

явуулахгүй бол үйл ажиллагаа явуулах ямар ч аргагүй болж байгаа юм байна. Бид одоо яг өөрийн гэсэн нэг тийм сүртэй холбоо, эвлэлдэн нэгдээд том бодлого гаргаад байгаа зүйл бол байхгүй ээ гэдэг ийм шүүмжлэл маш их ирээд байна.

Тэгээд ер нь энэ хуулийг өргөн барихаасаа өмнө та бүхэн энэ холбооныхоо байдаг юм уу, аялал жуулчлалынхаа компаниудын дунд хэчнээн компанийн дунд, аж ахуйн нэгжүүдийн дунд ямар ямар хэлэлцүүлгүүд явуулсан юм бэ? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, танай байгууллагынхан, танай салбарынхан өөрсдөө эвлэлдэн нэгдээд ингээд бодлогоо гаргаад явах дээр ер нь ямархуу байр суурьтай байгаа юм бэ? Бараг энэ аж ахуйн нэгжүүдийг боомилох гээд байна. Зайлшгүй холбоо болж нэгдэх гээд байна. Тэр дээр хэдхэн цөөхөн компаниуд байдаг. Хөдөө орон нутгийн жижиг компаниуд, бид нар бол үүн дээр ямар ч дэмжлэг байхгүй. Бүх мэдээллээс хол ингээд явчих юм байна л даа гэсэн нэг ийм шүүмжлэл байгаад байна.

Тэгэхээр үүн дээр та бүхэн маань ямар ямар хэлэлцүүлгүүд явуулсан. Энэ бүгд дээр чинь мэргэжлийн холбоод чинь ямар байр суурьтай байгаа юм бэ гэдэг дээр.

Гуравдугаарт нь, ер нь дарга аа, энэ Мэргэжлийн холбоодын тухай хуулийг ер нь нэн яаралтайгаар бас бид батлахгүй бол. Уг нь аминдаа бид аль болохоор мэргэжлийн байгууллагуудтайгаа нэг улс төрчид байдаг юм уу, салбарын яам өөрсдөө хуулиа бичээд боловсруулаад

баталчихдаг биш. Мэргэжлийн байгууллагуудтайгаа хамтран ажиллаж гэхээр дандаа мэргэжлийн байгууллагууд нь дундаа ингээд хэд хуваагдчихсан.

Тэгээд бараг нэгэнтэй нь ярихаар нөгөөдөх нь тэгвэл бид нар та нартай ярихгүй гэх нь холгүй. Нэг ийм байдалтай яваад байгаа болохоор энэ нэг Мэргэжлийн холбоодын тухай хуулийг Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал болон бусад гишүүдээс өргөн барьсан энэ хуулийг ер нь яаралтай баталмаар байна. Тэгвэл бид энэ зөвшөөрөл олгосныг бараг салбарын яам ч олгодог биш мэргэжлийн холбоод олгоод үүний үр дүнгийнх нь араас нь өөрсдөө хөөцөлдөөд энэ бодлого шийдвэр дээр нь өөрсдөө саналаа гаргаад явдаг байвал хэн хэндээ их амар байх юм. Түүнээс улс төрч ингээд Улсын Их Хурлын гишүүн гээд бүх юмыг мэддэг, чаддаг байх албагүй.

Тэгэхээр насаараа энэ салбарт ажиллаж байгаа хүмүүсийн уг нь үг хэлийг нь ингээд сонсмоор байх юм.

Эцэс сүүлд нь ялангуяа энэ нэг отоглох газартай холбоотойгоор бас хүмүүсээс маш их шүүмжлэл ирж байна. Хамгийн их том газар нутагтай ийм нягтаршил багатай энэ улс орны хувьд дотоодын аялал жуулчлал ч тэр, biker-ууд ч гэсэн энд тэнд очоод одоо тэгээд отоглох газраа хайгаад явж байх юм уу гэсэн ийм шүүмжлэл байгаад байна.

Энэ дээр магадгүй би зүгээр хуулийн ажлын хэсэг дээр байдаг юм уу? Та бүхэн маань энэ дээр судлаарай. Хаа сайгүй заавал отоглох газар гэхгүй ээ. Тэр отоглох газруудыг нь зааж өгдөг газруудын тусгайлан заана. Жишээлбэл,

Хөвсгөл нуур байдаг юм уу. Жишээлбэл, Өгий нуур байдаг юм уу. Нээрээ бүгдээрээ очоод тэнд хог хаяад завааруулаад байдаг ийм газрууд дээр нь бид яг зааж өгнө. Тэнд нь хогийн савтай, ноль, ариун цэврийн байгууламжтай ийм байна гээд.

Түүнээс биш машинаа барьж явж байгаад хаана нэгэн газар хөдөө очоод майхнаа зоох гэхээр отоглох газар дээр та буугаагүй байна гээд очоод торгочихдог бас баймааргүй байна.

Үүнтэй холбоотойгоор манай өнгөрсөн оны өсвөрийн парламентын маань хүүхдүүд манай Б.Бат-Эрдэнэ сайд бас их дэмжиж байгаа. Иргэд өөрсдөө бид нар бас байгаль хамгаалагч нар байа гээд НҮБ-ын Хүүхдийн сантай хамтраад нэг аппликэйшн хийгээд явж байгаа. Энэ ажил манай Байгаль орчны яам дээр явж байгаа. Энэ ажиллагаа та бүхэн маань бас шуурхайлмаар байна.

Энэ хүрээнд яах вэ гэхээр иргэн өөрөө ямар нэгэн байгаль орчинтой холбоотой зөрчил байх юм бол ухаалаг гар утастай хүн бол шууд ингээд байршлаа нээгээд тухайн зургийг нь аваад явуулахад төв рүү ирдэг. Та бүхэн маань тухайн орон нутгийнх нь байгаль хамгаалагчид мэдэгддэг.

Одоо бид нар зөрчил илрэхээр хаашаагаа хандахаа мэддэггүй байхгүй юу. Хог хаячихсан байвал. Хулгайн ан хийж байвал. Одоо гал түймэр хэрвээ гарч байх юм бол бид иргэд хаашаагаа хандахаа мэддэггүй учраас энэ тохиолдолд иргэн болгон байгаль хамгаалагч болдог, е-баримттай хүн болгон татварын байцаагч болсонтой адилхан иргэн болгон байгаль хамгаалагч болдог ийм шийдлийг манай хүүхдүүдээс гараад байгаа юм. Энэ

ажлыг маань та бүхэн бас давхар эрчимжүүлээрэй.

Г.Занданшатар: 82. Эхлээд 80 хариулъя.

С.Цогтгэрэл: Х.Булгантуяа гишүүний асуултад хариулъя.

Энэ хуулийн төслийг боловсруулах шатанд маш олон удаагийн хэлэлцүүлгийг салбарын оролцогчдын дунд хийсэн. Хамгийн эхлээд хуулийн төслийн үзэл баримтлал, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох шатанд аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компаниудыг бүлэг бүлгээр нь, чиглэл чиглэлээр нь хувааж байгаад тухайн үед тухайн чиглэл болгонд нь хэлэлцүүлэг хийгээд энэ одоо байгаа аялал жуулчлалын хуульд юу нь болохгүй байна, ямар хэрэгцээ шаардлага байна, төсөлд юуг тусгах вэ гэдэг чиглэлээр нийтдээ 7-гоос 8 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж хийсэн байгаа. Монгол аялал жуулчлалын холбоотой хамтарч.

Хамгийн сүүлд 11 дүгээр сард бас нэг хэлэлцүүлэг хийсэн. Энэ хуулийн төслийг боловсруулах шатанд Монгол аялал жуулчлалын холбоо болон салбарын төлөөлөл бүх шатанд нь оролцоод хамтдаа хуулийн төслийг бичилцээд боловсруулаад ингээд явсан байгаа.

Тэгэхээр энэ салбарын оролцогчдын дуу хоолой, үзэл санаа бол энэ хуульд маш сайн туссан гэж ингэж үзэж байгаа.

Отоглох цэгийн тухайд бас дахиад тодруулаад хэлье. Зөвхөн улсын аялал жуулчлалын бүс дээр л отоглох цэг дээр буугаагүй хариуцлагын асуудал

яригдахаар байгаа. Тэр нь түрүүн хэлсэн байгаль, түүх соёлоо хамгаалах тэгээд таны саяын хэлсэнтэй яг утга нэг. Тэр заасан газар дээр л тэр хэрэгжинэ.

Улсын бусад нутаг дэвсгэр дээр бол бүхэлд нь хэрэгжинэ гэсэн утга санаа энд байхгүй. Улсын аялал жуулчлалын бүсийг Засгийн газраас тогтоож, хил заагийг нь батлахаар ийм хуулийн зохицуулалт байгаа.

Тэгэхээр хууль хэрвээ батлагдсан тохиолдолд Засгийн газраас аль аль газар нутгийг улсын аялал жуулчлалын бүсэд тооцож, бүсчилсэн хэлбэрээр аялал жуулчлалыг хөгжүүлэх вэ гэдгийг тухайн үед нь шийдээд ингээд явахаар байгаа.

Г.Занданшатар: Х.Булгантуяа гишүүн тодруулж асууя.

Х.Булгантуяа: Аялал жуулчлалын салбарт одоо яг бүртгэлтэй хэдэн компани идэвхтэй үйл ажиллагаа, тайлангаа өгдөг, икс тайлангаас өөр байдлаар тайлангаа өгдөг хэдэн компани. Үүнээс хэдэн компани нь та бүгдийн 7 удаагийн хэлэлцүүлэгт орсон бэ? Хэдэн компаниас санал ирсэн бэ? Бид нөгөө төлөөлөл оролцсон гэдэг нь 150 компаниас 10 компаниас та бүхэн оруулчхаад төлөөлөл гэж яриад байгаа юм уу, үгүй юм уу? Мэдэхгүй байна л даа.

Тэгэхээр одоо яг олон нийт харж байгаа байх. Танай салбарын аж ахуйн нэгжүүд бас харж байгаа байх. Тэгэхээр үүнийг бүр нэг тодорхой хэлж өгөөч.

Г.Занданшатар: 85.

Б.Болортуяа: Х.Булгантуяа гишүүний асуултад хариулъя.

Өнгөрсөн 7 удаагийн хэлэлцүүлэгт салбар тус бүрээс 30-аас 40 аж ахуйн нэгжийн оролцоотойгоор 200 гаруй иргэн, аж ахуйн нэгж хэлэлцүүлэгт оролцсон.

Яг энэ жилийн байдлаар тур оператор компанийн тусгай зөвшөөрөлтэй 175 аж ахуйн нэгж, байгууллага Монголын аялал жуулчлалын холбооноос тур операторын ангиллын гэрчилгээгээ 5 төрөл дээр аваад үйл ажиллагаагаа явуулж байгаа.

Энэ бол зөвхөн тур операторын тусгай зөвшөөрлийн гэрчилгээтэй үйл ажиллагаа явуулж байгаа компани. Аялал жуулчлалын салбараар нь ярих юм бол энэ дээр зоогийн газар, зочид буудал, зочлох үйлчилгээний салбар гээд худалдаа, үйлчилгээнээс авхуулаад ер нь маш өргөн хүрээг хамарч байж аялал жуулчлалын үйл ажиллагаа Монгол Улсад явагддаг.

Тэгээд энэ дотроо илүү жуулчинтай үйл ажиллагаанд шууд холбогдож ажилладаг.../минут дуусав/

Г.Занданшатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асууя.

С.Ганбаатар: 2000 онд л анх Аялал жуулчлалын тухай хууль батлагдаж байсан. 12 удаа өөрчлөлт орсон. Тэгээд Б.Бат-Эрдэнэ сайд бол том реформ. Үүнийг цогцоор нь оруулж ирдэг нь бол зөв өө.

Харин энэ хуулийг боловруулсан улсууд их л ядмаг, яарч сандарсан л юм хийсэн байх юм. Хэдэн тодруулж асуух зүйлүүд байна.

Нэгдүгээрт, төслийн 12.2-т тур операторын үйл ажиллагаа тусгай зөвшөөрөлтэй эрхлэх ба гурван ангилалтай байна гэж байгаа. Монгол Улсаас бусад улс руу хийх аялал жуулчлалын үйлчилгээ, бусад улсаас Монгол Улс руу аялал жуулчлах үйлчилгээ. Энэ хоёрыг хамтад нь гэсэн ийм 3 ангилалтай.

Энэ ер нь тэгээд л ерөөсөө л Олон улсын аялал жуулчлалын тухай хууль болчихсон юм биш үү? Дотоодын аялал жуулчлал, дотоодын зохион байгуулалт, операторын талаар энэ ийм гуравхан зүйл дээр төвлөрнө гэдэг юу гэсэн үг вэ? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт, үзэл баримтлал дотор энэ хууль орж ирэхэд нэг тодорхой нэг бүтэц байдаг санагдах юм. Тэгээд үзэл баримтлалд нь тур операторын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй болох үндэслэлийг ерөөсөө тодорхойлоогүй байгаа. Чухам яагаад аялал жуулчлалын тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ байх ёстой вэ? Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны 01 сарын 01-нээс хэрэгжинэ. 2022 оны 6 сард батлагдсан.

Энэ нэмэлт, өөрчлөлт орж байж, 6 сар алсын хараагүй. Нэг ийм 6 сарын дотор л хууль хэрэгжээгүй байж өөрчлөгдөх болчихоод байгаа байхгүй юу.

Дараагийн асуулт. Хоёр дахь асуулт. Аялал жуулчлалын төслийн 6.8-д аялал жуулчлалын байгууллага аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан борлуулахдаа гадаадын болон дотоодын жуулчлалд ялгамжтай байдлаар үнэ тогтоож үйлчлэхийг хориглоно гэж заасан байгаа.

Үүнийг энэ олон аялал жуулчлалын компаниудтайгаа энэ холбоодуудтайгаа зөвлөлдсөн үү? Үндэслэл нь яг юу вэ? Би үүнийг эсэргүүцээгүй. Зүгээр үндэслэлийг нь би асууж байна. Энэ гадаадын жуулчдын орлого, дотоодын жуулчдын орлого, амьдралын өртөг, үнэлэмж маш ялгаатай. Энэ хориг дотоодын жуулчдад ямар нэгэн сөрөг нөлөөлөл болох уу? Дотоодын жуулчлал дээр бас хаасан, боомилсон үндэслэл бий болчих уу, үгүй гэдэг талаар судалгаа хийсэн юм байгаа юу?

Гуравдугаар асуулт. 6.9-д нь. Би яг энэ заалт заалтаар хариултаа авъя. Жуулчлалын үйл ажиллагаанд хориглох зүйл гээд дурдсан байна. Соёлын биет бусыг энэ дотор яагаад оруулаагүй юм бол оо. Бид чинь ер нь нарийн яривал тэр мал аж ахуйтай нүүдлийн соёлоо бид очиж үзэж, өөрсдөө ч гэсэн дээ тэгж л хотоос гардаг. Энэ соёлын биет бус энэ зүйлүүд алдагдахгүй байх баталгааг нь энэ хуулиар зохицуулалт, заалт яагаад ороогүй юм бэ?

Дөрөвдүгээр асуулт. Ядмаг байна. Хууль тогтоомж дээр. 6 удаа гадаад үг орсон. Менежмент, тур оператор, хог хаягдлын менежмент гээд.

Тэгэхээр энэ дотор бас тийм ээ. Жуулчны үйлчилгээ үзүүлэгч иргэн нь орон нутагтаа ингээд аялал жуулчлалын байгууллага бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх хүн байна гээд зачихсан байгаа. Хүн гээд. Энэ дараах ойлгомжгүй зүйл болж байна. Аялал жуулчлалын дагалдах бүтээгдэхүүн гэсэн нь яг хуулийн тодорхойлолт дээр алга. Дагалдах бүтээгдэхүүн гэж яг юуг яриад байна. Иргэн нь хүн байна гэдэг дээр нэг эргэж бодооч.

Би дараагийн нэг ноцтой гэмээр юм хэлье дээ. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийн дагалдах дээр явж байна лээ. 36.3.2-т Аялал жуулчлалын тухай хуулийн 12.2.4-т заасан тусгай зөвшөөрөл тухай бүр тур операторт 12 жилийн хугацаатайгаар газар олгоно гэж байгаа юм. Энэ 12.2.4 гэдэг заалт алга байна энд. Хуульд байхгүй. Эсвэл операторын алдаа юм уу, тур менежментийн алдаа юм уу. Тэрийг нь би мэдсэнгүй.

Тэгэхээр миний энэ асуултуудад. Би дараа нь.../минут дуусав/

Г.Занданшатар: 82.

С.Цогтгэрэл: С.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Хуулийн төслийн 12.2-т гурван ангилалтай байна гэж заасан байна. Зөвхөн гадаадын аялал жуулчлалын тухай заажээ. Дотоодын аялал жуулчлалыг зохицуулаагүй байна гэж асуулаа.

Хуулийн төсөл дээр дотоодын аялал жуулчлалыг бол аялал жуулчлалын компаниуд чөлөөтэй эрхлэх байдлаар зохицуулалтыг хэтэрхий бүх зүйлийг зохицуулах боломжгүй учраас чөлөөтэй байдлаар явуулахаар ингэж хуулийн төслөөр явж байгаа.

Тэгэхээр дутуу дотоодын аялал жуулчлалын асуудлаар нэмж тусгах шаардлагатай зүйлүүд байвал бид бас хэлэлцүүлгийн шатанд тусгах боломжтой байх гэж бодож байна.

Тур оператор яагаад тусгай зөвшөөрөлтэй байх ёстой вэ гэж. Заавал

тусгай зөвшөөрөлтэй байх ёстой вэ гэдэг асуудлаар дахиад бас хэлье. Түрүүн Б.Бат-Эрдэнэ сайд бас тайлбарласан байгаа. Одоо Аялал жуулчлалын холбоо энэ тур оператор компаниудад эрхийн гэрчилгээгээр зөвшөөрөл өгөөд явж байгаа. Аялал жуулчлалын холбооноос тэр эрхийн гэрчилгээ аваагүй тохиолдолд бол энэ төрлийн үйл ажиллагааг явуулах боломжгүй байгаа.

Тэгэхээр Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны 01 сарын 01-нээс эхлээд мөрдөгдөөд эхлэхээр зэрэг Зөвшөөрлийн тухай хуульд бид энэ тур операторын тусгай зөвшөөрлийг нэмэлтээр оруулж өгөхгүй бол энэ төрлийн тусгай зөвшөөрөл олгогдохгүй. Энэ тур операторын үйл ажиллагааг хэн дуртай хүмүүс нь чөлөөтэй эрхлэх ийм боломжтой болчих гээд байгаа.

Тэгэхээр энэ нь ямар сөрөг үр дагавар үүсэх вэ гэдгийг түрүүн Б.Бат-Эрдэнэ сайд бас тайлбарласан байгаа.

Төслийн 6.8-д гадаадын болон дотоодын жуулчдад ялгамжтай үнээр үйлчилж болохгүй гэдэг асуудлын үндэслэлийг асуулаа. Ер нь энэ тохиолдол бас өнөөдөр амьдрал дээр нэлээдгүй байгаа. Гадаадын иргэн нь тэдэн доллароор үйлчлүүлнэ, дотоодын иргэн тэдэн төгрөг гээд ялгамжтай байдлаар тогтоосон. Энэ нь бас Өрсөлдөөний тухай хууль ч гэдэг юм уу, холбогдох бас хууль тогтоомжууд хүнийг ялгаварлан гадуурхахтай холбоотой асуудалтай ч бас уялдаж байгаа.

Тэгэхээр нэг төрлийн үйлчилгээ, нэг төрлийн бүтээгдэхүүнийг гадаадын иргэн байна уу, дотоодын иргэн байна уу ялгамжгүйгээр нэг үнээр үйлчлэх

ёстой гэдэг ийм зарчмын байр суурьтай байгаа учраас хуулийн төсөлд ингэж оруулсан байгаа.

Хуулийн төслийн 6.9-д соёлын биет бус өвийг яагаад оруулаагүй вэ гэдэг асуудлыг хөндөж байна. Соёлын биет бус өвийг бас энд оруулах шаардлагатай гэж хууль тогтоогчийн зүгээс үзвэл бид бас хэлэлцүүлгийн шатанд үүнийг нэмэх боломжтой байх гэж үзэж байна.

Гадаад үг хэллэг их хэрэглэсэн байна. Тур оператор, менежмент гэдэг үгүүд бас нэлээн их гарсан байна гэж хэллээ. Ер нь энэ хуулийн төслийн хэлэлцүүлгийг салбарын мэргэжлийн байгууллагууд болон аж ахуйн нэгж, байгууллагуудтай холбоотой хамтарч хэлэлцүүлэг хийсэн. Боловсруулалтыг бас цуг хийсэн гэдгийг түрүүн хэлсэн. Тэгэхэд мэргэжлийн байгууллагуудын зүгээс энэ тур оператор, менежмент гэдэг үгүүд олон улсын түвшинд яг энэ чиглэлээрээ бүх улсад хэрэглэгдээд явдаг ийм нэр томьёо байгаа учраас энэ хуулийн төсөлд ороод явах нь зүйтэй гэж үзсэн.

Хууль тогтоомжийн тухай хуульд ч гэсэн бас энэ зүйл бол бас хориглогдоогүй байгаа учраас ингээд гадаад үг хэллэгийг бас зарим тохиолдолд хэрэглээд явсан байгаа.

Г.Занданшатар: 83.

Р.Лхагвабаяр: С.Ганбаатар гишүүн жуулчны үйлчилгээ үзүүлэгч иргэний зохицуулалтыг бас тухайлан асуусан. Энэ дээр хүн байна гэж томьёолсон байна. Үүнийг авч үзэх хэрэгцээ шаардлага өөрөөр томьёолж болох уу гэдэг дээр.

Энэ дээр ажлын хэсэг ярилцаад жуулчны үйлчилгээ үзүүлэгч иргэний цаад концепц нь бол нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал буюу орон нутгийн малчин иргэд аялал жуулчлалын үйл ажиллагаанд хэрхэн оролцох юм бэ? Өнөөдрийн хувьд эрх зүйн орчинд холбогдох хууль тогтоомж болон хэм хэмжээний актууд бол аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч иргэний зохицуулалт дутмаг байгаа.

Аялал жуулчлалын тухай хуульд 2022 онд орсон нэмэлт, өөрчлөлт бол жуулчны үйлчилгээ үзүүлэгч иргэн байна гэдэг заалт тусгагдсан. Харин энэ заалтыг бид хуулийн төсөл дээр 11 дүгээр зүйл буюу нэг бүтэн зүйл болгоод илүү тодорхойлж оруулж ирж байгаа.

Үүн дээр хүн байх буюу яг малчин иргэн байж болно. Цаашлаад хоршоо болон нөхөрлөлийн тухай хуулиараа хамтраад бас энэ нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалаа бүрэн хөгжүүлэх боломжтой гэж байгаа.

Аялал жуулчлалын тухай хууль дээр тусгагдсан гурван зүйл бол үзүүлж болох эрхийг нь нээж өгөөд цаашдаа энэ жуулчны үйлчилгээ үзүүлэгч иргэнийг төр болон нутгийн өөрөө удирдах байгууллагыг хэрхэн дэмжих юм бэ, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэхэд ямар журам баримтлах вэ, ямар шаардлагыг бас тавих юм бэ гэдэг ийм үндсэн гурван заалтыг оруулж ирсэн байгаа. Энэ дээр хүн томьёолол нь ажлын хэсэг ярилцаж эцэслээд хуулийн этгээд байхаас илүүтэйгээр малчин иргэд, малчин өрх байх учраас хүн гэдэг томьёоллоор нь явах нь зүйтэй гэж боловсруулаад өнөөдрийн төсөл боловсруулагдсан байгаа юм.

36.2.2 дээр Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт дээр. Энэ 12.2.4 нь та бас харж байгаа. Энэ дээр Монгол Улсаас гарах, Монгол Улс руу орох, олон улсын аялал жуулчлалын үйлчилгээ гээд дөрөв дэх заалт нь дотоодын аялал жуулчлалын үйлчилгээ гэж байсан.

Түрүүн хуулийн хэлтсийн СЦогтгэрэл даргын тодруулсанчлан бид дотоодын аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэх үйлчилгээгээ чөлөөтэй байлгах үүднээс хуулиар зөвшөөрөл хориглолтыг тавьж өгөөгүй. Харин энэ заалт нь өөрөө тухайн заалттай уялдаж байсан бөгөөд ажлын хэсгийн зүгээс хасах шаардлагатай байсан боловч хасаагүй алдаа гаргажээ.

Г.Занданшатар: Нэмж хариулах зүйлгүй бол тодруулж асууя гэж байна. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууя.

С.Ганбаатар: Төслийн 4.1.8 дээр ч гэсэн жуулчны хөтөч нь ийм ийм юмыг хангасан хүнийг гэж байна. Тэгээд энэ нь бол Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, ер нь ямар ч хамаагүй байсан хүн гэж ийм хууль арай ч байж болохгүй байх аа. Та нар эргэж бодвол буян болох байх даа.

Төслийн 16.4-т нэг заасан юм байна. Шаардлагатай бусад тохиолдолд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх бүхий л нөхцөл боломжийг бий болгосон байна гэж заасан байгаа. Энэ ер нь амьдрал дээр хэр хэрэгжих тухай судалгаа, тооцоо хийсэн үү? 16.4-ийг би асууж байна шүү.

Дараа нь төслийн 24.2-ыг та нар нэг томьёолыг нь унш даа. Энэ ийм юм биччихсэн байх юм. 24.2. Бас редакцын

алдаа юу. Энэ хуулийн 19.2.1-д заасан улсын аялал жуулчлалын бүсийн төлөвлөлтөд тусгагдаагүй газарт аймаг, нийслэлийн Засаг дарга газар эзэмших зөвшөөрөл олгохыг хориглоно гээд. Энэ чинь бүр Газрын хууль тэр чигээрээ явчихлаа шүү дээ. Энэ чинь. Би буруу ойлгоогүй бол. Үүнийг нэг тайлбарлаж өгөөч.

Г.Занданшатар: 24.2-ыг хэн тайлбарлах юм? 16.4.

Ер нь газрын хуулийн зохицуулалт, Зөвшөөрлийн хуулийн зохицуулалт, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн зохицуулалт. Олон хуулийн зохицуулалтыг зөрчиж байж байгаа заалт байна шүү дээ.

Техникийн алдаа юм уу, энэ улсын аялал жуулчлалын тусгагдаагүй газарт нийслэлийн Засаг дарга газар эзэмших зөвшөөрөл олгож болохгүй гэдэг чинь бүх газар орчихно шүү дээ. Энэ чинь.

83 хариул.

Р.Лхагвабаяр: Энэ 24.2 дахь зохицуулалт дээр бол хоригт тусгагдсан газарт гэдэг байдлаар томьёолсон боловч энэ дээр бас техникийн алдаа гарсан байна. Үүнийг засах нь зүйтэй байх гэж бодож байна.

16.9 буюу тэр эмнэлгийн тусламж үйлчилгээг бий болгосон байх, яаралтай тусламжийг үзүүлэх гээд. Энэ бол бас зайлшгүй хэрэгтэй заалт гэж үзэж байгаа. Яагаад үзэж байгаа вэ гэхээр бид олон улсын судалгаа явуулахад Казахстан, Киргизстан, Узбекистан зэрэг улсууд, Оросын Холбооны Улс бас нэмэгдээд жуулчны

аюулгүй байдлын харилцааг нэлээд нарийвчилж авч үздэг юм билээ.

Цаашлаад ямар ямар зохицуулалтууд нийтлэгээр тусгагдсан байна гэнгүүт нэгдүгээрт, зорчиход аюултай газар болон холбогдох бусад эрсдэл бүхий мэдээллийг тусгах.

Хоёрдугаарт, эрүүл мэндийн үйлчилгээ болон эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тухайн аяллыг зохион байгуулж байгаа тур операторын аяллын агент, жуулчны үйлчилгээний байгууллага нь заавал бий болгосон байх ёстой гээд.

Г.Занданшатар: Чанартай хууль оруулж ирж байх хэрэгтэй. Парламент бөөс хуурс түүх ёсгүй гэж хэлээд байгаа шүү.

Одоо Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ хуулийг дэмжиж байгаа. Хоёр гараа өргөөд дэмжиж байна гэсэн үг шүү.

Бид маш олон жил сая жуулчин гээд л ярилаа. Өнөөдөр 300, 400 мянгаас цаашаа гарч чадахгүй л байгаад байгаа юм.

Тэгэхээр Монгол Улсын Засгийн газраас энэ аялал жуулчлалыг хөгжүүлэх аялал жуулчлалын жил болгоод л ингээд хуульд өөрчлөлт оруулаад. Яаравчилсан горимоор байгаа байх аа. Оруулж ирж байгааг бас дэмжиж байгаа юм шүү. Нэг.

Засах зүйлүүд их байна. Нэн тэргүүнд хэрвээ бид одоо сая жуулчин авья гэсэн ийм зорилго тавьж байгаа бол жуулчин орж ирдэг хаалгаа нээх

хэрэгтэй. Энэ нэн тэргүүнд нөгөө МИАТ компанийн асуудал яригдана шүү.

Иргэний агаарын тээврээ лебералчлах асуудал яригдана шүү.

Тийзнийхээ үнийг доош нь буулгаж, тийзний үнийг хямдруулах асуудал ярьж ирнэ ээ.

Тэгэхээр тэр сан дотор байж байх шиг байна. Агаарын зорчигч тээвэрлэгчдэд зорчигч тээвэрлэхэд дэмжлэг үзүүлэх гээд байгаа юм. Ямар ч л байсан энд чинь үндэсний агаарын байна уу, ямар ч байсан Монголын агаарын тээврийн энэ системдээ либералчлал хийх, үнээ багасгах, аэро компаниудаа дэмжлэг үзүүлэх асуудал байж байгаа юм. Тэгээд үүнийг нэг жоохон тодруулаад ороод л ирэх хэрэгтэй байна.

Ер нь зүгээр миний бодлоор энэ салбарт байж байгаагийн хувьд энэ агаарын тээврийн компаниуд яг жишээ нь зорчигч урсгалтай үед, эсвэл жуулчин тээвэрлэх үед ер нь өөрсдийнхөө балансыг барьж байх ёстой л гэж ойлгож байгаа шүү дээ. Тэгж байж хаалгаа нээх ёстой. Монголоос илүү сайхан үйлчилгээ үзүүлдэг аялал жуулчлалын үзэх харах юмтай газруудад маш хямдханаар зорчигч тээвэрлэлт хийдэг аялал жуулчлал хөгжөөд байгаа шүү дээ.

Тэгэхээр хамгийн гол нь бид энэ МИАТ компанитай холбоотой, дотоодын агаарын тээвэрлэгчтэй холбоотой эд нарт дэмжлэг үзүүлэх асуудлуудыг бүр тодорхой болгох хэрэгтэй байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, жуулчны аюулгүй байдал гэдэг нэг ийм заалт орж ирсэн байх юм. Мэдээж жуулчны аюулгүй байдлыг бид нэн тэргүүнд тавих хэрэгтэй. Энэ бол зайлшгүй. Гэхдээ энэ заалтыг чинь ингээд харахаар монгол хүнийхээ аюулгүй байдлаас илүү дээр тавьчихсан юм шиг харагдаад байх юм. Наад жуулчид чинь үүнийг хараад баялаг биш, харин буруу ойлголт авна шүү.

Ер нь Монголд аюулгүй байдал нь алдагддаг юм байна. Үүнийг төрийн захиргаа нь ингэж зайлшгүй авахгүй болдоггүй юм байна гэсэн нэг ийм ойлголт жишээ нь надад төрөөд байна.

Тэгэхээр үүнийг аялал жуулчлалын байгууллагууд өөрсдөө жуулчныхаа аюулгүй байдалтай холбоотой энэ үйлчилгээгээ сайжруулах гэдэг юм уу, энэ утгаар нь оруулж ирэхгүй бол хүний эрхтэй холбоотой асуудал яригдаад монгол хүний аюулгүй байдлаас дээр тавьж байна гэсэн ойлголтоо тавих юм бол энэ буруу ойлголтыг жуулчиддаа өгөх асуудал болчихоод байна шүү.

Тэгэхээр энэ дээр анхаарах хэрэгтэй байна.

Тур операторын тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудал яригдаад байна. Нэлээн хэдэн гишүүдээс ярьж байна. Үнэхээр та бүхэн энэ дээрээ нэг хараач ээ. Та бүхний заалтан дотор орж ирж байгаа тусгай зөвшөөрлийн заалтууд гэдэг нөхцөл гэдэг чинь үнэхээр тусгай зөвшөөрөл байх ийм нөхцөл байдал биш байна шүү дээ. Мэргэжлийн хүнтэй байна. Англи хэлтэй байна гэж бараг бичих нь холгүй болчихож. Өөр энд чинь

айхтар зоогоод байгаа юм алга байна шүү дээ.

Ер нь энгийн зүйл энгийн байх тусмаа сайн гэдэг шиг бид бүх зүйлийг энгийн болгох хэрэгтэй. Энэ компаниуддаа бид улам том шаардлага тавиад байх юм бол энэ компаниуд чинь цаашаагаа тавьдаг шаардлага чинь ихэснэ. Монголчууддаа тавьдаг шаардлага чинь ихэснэ. Монгол хүн жуулчин хоёрын ялгаа ихэснэ. Дотоодын аялал жуулчлал чинь боогдоно. Аж ахуйн нэгжүүд чинь тодорхой хэмжээнд үйл ажиллагаагаа сайжруулах гэж байна гээд том том шаардлагууд тавьдаг болно.

Тэгэхээр эсрэг тал руу орчихно шүү. Тэгж байсанд орвол стандарт байдаг юм уу, ямар нэгэн байдлаар тэр аялал жуулчлалынх нь үйлчилгээ нь өөрөө стандартчлагдаагүй. Үйлчилгээ нь өөрсдөө тодорхой хэмжээний горим, дүрэм журамтай гэсэн ийм зүйлийг нь гаргаж ирж тавиад тэрэнд нь хэн таалагдаж, үйлчилгээгээ хангаж байна, хэн энэ болзлыг хангаж байна. Тэнд.../минут дуусав/

Г.Занданшатар: 81.

Б.Бат-Эрдэнэ: Ж.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Иргэний агаарын тээврийн хувьд, ялангуяа агаарын тээврийн либералчлалыг бид зайлшгүй хийх ёстой гээд явж байгаа. Энэ жилийн хувьд Бүгд Найрамдах Солонгос Улсаас Low-Cost 2 авиа компани Монгол Улсын чиглэлд ниссэн. Ингэснээрээ Бүгд Найрамдах Солонгос Улсаас 5 авиа компани Монгол Улс руу ниссэн ийм үе тохиосон.

Агаарын тээврийн либералчлал дээр Засгийн газрын барьж байгаа байр суурь агаарын тээврийг ерөөсөө хязгаарлахгүй байх ёстой л гэж байгаа юм. Энэ ядаж гурван жилийн хугацаанд агаарын тээврийг ямарваа нэг байдлаар битгий хязгаарла гэдгийг Монгол Улсын Ерөнхий сайдаас чиглэл өгсөн.

Тэгэхээр агаарын тээврийн либералчлал 100 хувь явагдана гэж харж байгаа. Жуулчны аюулгүй байдалтай холбоотой асуудал дээр санал хэллээ гэж ойлголоо. Тур операторын тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудал дээр бид өнөөдөр явагдаж байгаа ангиллын гэрчилгээ л үргэлжлэх процесс байгаа юм. Үүнийг ор зөвшөөрөлгүй болгочих юм бол тэгээд л бид нөгөө ширэнгийн хууль гэдэг шиг энэ хуулиараа л явна. Гадна, дотнын бүх компаниуд дураараа эрхэлдэг болно. Хариуцлагын асуудал байхгүй болно. Нэгдсэн мэдээллийн систем байхгүй болно. Үүнийгээ дагаад дуртай аялал, дуртай үйл ажиллагааг явуулж эхэлнэ. Ялангуяа өнөөдөр энэ дотоодын компаниудын маань хувьд гадаадын тур компаниудаас дотоодын зах зээлээ хамгаалъя гэдэг ийм зүйлийг маш их хэмжээтэй ярьж, хөндөж байгаа.

Дотоодын зах зээлээ хамгаалахгүй бол гадаадын, тухайлах юм бол Бүгд Найрамдах Солонгос Улс, Турк гэх мэтчилэнгийн орнуудаас гадаадын томоохон тур оператор компаниуд орж ирж үйлчилгээ явуулснаар Монгол Улс өөрөө хөтөч, гайд, маршрут ингээд бүх зүйлс дээрээ бид өөрсдөө дотоодын хяналтаа алдана гэдэг энэ зүйлийг бас дотоодын компаниудаас маань яриад байгаа учраас бид эрх зүйн зохицуулалтын хүрээнд Зөвшөөрлийн тухай хуулийн 2023 оны 01 сарын 01-ний өдрийн

хэрэгжилттэй холбогдуулж хуульд зааснаас бусад тохиолдолд зөвшөөрөл, лиценз, бүртгэл явуулахыг хориглоно гэдэг заалтын дагуу бид тусгай зөвшөөрөл байдлаар тусгаж оруулж ирж байгаа юм.

Тэгээд үүнийг бид хэрвээ жишээлбэл байхгүй бол түүх соёл, өвийг ашиглан аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах, мөн ямар ч татвар төлдөггүй байх энэ систем рүү орох. Эргээд үүсгэн байгуулагдсан этгээдтэй холбоо бүхий хууль эрх зүйн хүрээний хариуцлагын асуудлуудыг хөндөх гэх мэтчилэнгээр ингээд олон асуудлууд яваад эхэлж байгаа учраас л энэ тусгай зөвшөөрлийн асуудлыг хөндөж байгаа.

Тэгээд энэ бол шинээр гарч ирж байгаа зүйл гэж огт ойлгож болохгүй. Би түрүүн хэлсэн. Өнөөдөр Монголын аялал жуулчлалын холбоо 5 ангиллын зөвшөөрлийг олгож байгаа. Энэ нь гэрчилгээ нэртэй. Гэхдээ яг өнөөдрийн нөхцөл байдал дээр тусгай зөвшөөрөл байдалтай 175 аж ахуйн нэгжзөвшөөрөл аваад үйл ажиллагаа явуулж байгаа гэж ойлгож болно гэсэн үг. Баярлалаа.

Г.Занданшатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууна. 1 минут.

Ж.Бат-Эрдэнэ: Тэр иргэний агаарын тээврийн либералчлалтай холбоотой асуудал, тэр тусмаа Сөүлтэй холбоотой. Тэрний нислэгийн тоог нэмэгдүүлэх, авиа компани нэмэгдүүлэх асуудал чинь иргэний агаарын тээврийн либералчлал гээд л миний үед л анх санаачлаад хийсэн асуудал шүү дээ.

Энэ үр дүнгээ өгсөн. Билетийн үнэ 30-аас 35 хувь буусан шүү дээ. Энэ бол бодит тийм үү. Бодит. Яг үүнийг

цааш нь үргэлжлүүлэх хэрэгтэй. Гэхдээ тэр дэмжлэг. Билетийн үнээ буулгаад алдагдалгүй хэмжээнд нь аваачаад. Би тэрийг хүсээд байгаа байхгүй юу. Тэгээд цаагуураа дэмжлэг аваад компани нь өөрөө бас тодорхой хэмжээнд дэмжлэгтэй явах талын л юмыг яриад байгаа юм.

Энэ дээр бас тодорхой тийм саналуудыг оруулж ирээрэй гэж хүсээд байгаа шүү. Дараагийнхтай.

Тэр тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудал яах вэ, та бүхэн нэг үйл ажиллагаагаа ингээд сайжруулах гээд л ингээд л юу гэдэг юм, чичрээд л, гоё болгох гээд л явсаар байгаад л нэг мэдэхэд бүр хатуу юм руу оруулчихдаг нэг тал байдаг шүү. Энэ дээрээ анзаараарай.

Ер нь төрийн албан хаагчдыг бид.../минут дуусав/

Г.Занданшатар: Одоо хэн хариулах вэ? Санал юм уу даа. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ сайд хариулья.

Б.Бат-Эрдэнэ: Тийм. Ж.Бат-Эрдэнэ гишүүний хэлдэг бол үнэн.

Яалт ч байхгүй агаарын тээврийн либералчлалыг эхлүүлсэн. Тухайн үед тийзийн үнэ тариф тодорхой хэмжээнд бууж байсан. Энэ жилийн хувьд мөн адилхан **Low-Cost**_[хямд өртөгт тээвэрлэгч] 2 авиа компани орж ирснээр МИАТ компанид үүсэх эрсдэлийг хавар ярьж байсан. Гэхдээ энэ жил тухайлах юм бол Low-Cost 2 авиа компани орж ирснээр тухайн компани хоёр талдаа сая төгрөгөөр ниссэн байгаа юм. МИАТ компани нь өнөөдөр дампуураагүй. Харин ч өрсөлдөөн нэмэгдсэн гэдэг утгаар.

Дээрээс нь Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн Бүгд Найрамдах Солонгос Улсын жуулчдыг визгүй зорчих эрхийг нээж өгсөнтэй холбогдуулаад МИАТ компанийн хувьд бүр ашигтай ажилласан байгаа юм.

Тэгэхээр цаашдаа бид энэ агаарын тээврийн либералчлалыг үргэлжлүүлж хийх ёстой. Либералчлал хийгдэхдээ өөрөө өрсөлдөөний зарчмаар явах ёстой гэж таны тухайн үед ярьж байсан, хэлж байсан энэ заалт үргэлжлээд явж байгаа гэдгийг бас би танд хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Наянтайн Ганибал гишүүн асуулт асууна.

Н.Ганибал: Сайд сая танилцуулга хийгээд эхлэхээсээ эхлээд л нэг сонин болоод явчихлаа.

Ер нь ингээд Монгол Улсад энэ нэг социалист лоозогносон уриатай, тэгээд түүнийгээ дагасан хууль эрх зүйн орж ирж байдаг энэ асуудлаасаа хэдүүлээ салъя.

Монголд зочлох жил гээд нэр нэрлээд, тэгээд түүнийгээ дагуулаад аялал жуулчлалынхаа хуулийг яаралтай оруулж ирж байгаа л даа. Тэгээд ер нь бид нар өнөөдөр дэлхийн яг өрсөлдөөн дундаас бид яаж тэр аялал жуулчлалын салбараа хөгжүүлэх вэ, яаж гадаадын иргэдийг Монголд зочилдог болгох вэ гэдэг энэ л хуулиудыг бид хийх ёстой.

Түүнээс ямар нэгэн сүржин лоозон тавьчихаад түүндээ тааруулаад ядмагхан хууль оруулж ирж байгаа нь аягүй учир дутагдалтай байна. Хуулийг ингээд харахаар манай энэ Байгаль орчин, аялал жуулчлалын яамныхан

маань Монгол Улсын энэ аялал жуулчлалын зураглалаа олж хараагүй байна.

Өнөөдөр та бүхэн төсөв дээрээ Монгол Улсыг сурталчлах тэр зардлуудаа тавьсан уу? Яг юу үзүүлэх гээд байгаа юм? Улаанбаатарт хүрч ирж түгжрэл үзүүлэх гээд байгаа юм уу? Утаа үнэртүүлэх гээд байгаа юм. уу? Нэг эсвэл уул ус харуулах гээд байгаа юм уу? Зундаа аваачиж нууранд оруулах гээд байгаа юм уу? Морь унуулах гээд байгаа юм уу? Ямар ч бодлого алга байна шүү дээ.

Эхлээд аялал жуулчлалынхаа бүтээгдэхүүнүүдийг бий болгох тал дээр ажиллах ёстой шүү дээ. Танай салбар. Тэгээд тэрнийгээ эхлээд гаргачхаад тэгснийхээ дараа өнөөдөр Монголд ирж зочлооч ээ, та нар бид ингээд ийм сайхан юмнууд байна. Энэ болгоныг та нарт үзүүлэх гээд байна. Үзүүлэх гэсэн чинь бид тийзнийхээ үнийг буулгаж байна. Визээ бид амархан олгодог болголоо гээд. Ингэж байж энэ чинь бусдыг татна биз дээ.

Үгүй ээ, зүгээр энэ дээр нэг даатгалын заалт байна л даа. Энэ дотор ингээд гадаадын хуулиас ингээд хуулаад тавьчихсан. Ууланд авирах, далайд шумбах гээд ингээд тавьчихсан. Энэ хүмүүс даатгалтай гэнэ ээ.

Тэгээд нөгөө морь унах, морь унуулах тэр аялал жуулчлал гэж Монголд байгаа юм уу, байхгүй юм уу? Байлгах юм уу, байлгахгүй юм уу? Тэр нь яагаад даатгалынх нь энэ заалтад нь орохгүй байгаа юм?

Өвөлдөө тэр нохой чаргаар тэрийг хөгжүүлэх юм уу? Аялал жуулчлалын яам. Хөгжүүлэх юм бол тэр

нохой чарган дээрээс хүн унавал даатгуулбал даатгуулах ёстой юм уу, үгүй юм уу? Ингээд салбараа олж хар л даа. Тэгэхгүй зүгээр ингээд нэг хэдэн юм хуулаад тавьчихсан. Сүүлийн үед бас энэ Их Хурлын дарга маш тодорхой зөв шүүмжлэл хэлээд байгаа юм.

Энэ яамдууд чинь уялдаа холбоо алга аа. Газрын багц хууль дээр өнөөдрийн Байгаль орчны сайд байх л ёстой байсан. Хөдөө аж ахуйн сайд байх л ёстой. Ингээд нийлээд асуудлаа яриад орж ирэх болохоос бүгдээрээ нийлээд нэг янз бүрийн газрын асуудал нэг нэг хууль дээр оруулж ирчхээд ингээд яриад суугаад байх юм.

Тэр отгийн асуудал чинь зөв шүү дээ. Тэрийгээ тайлбарла л даа. Өнөөдөр Монгол Улсад зүүн аймагт аялал жуулчлалын гурван том нуур байдаг. Нэг нь эрүүл мэндийн аялал жуулчлал гээд Аварга тосон нуур маань байхгүй болсон. Бохирдсон. Дотоодын аялал жуулчлал эрхлэгч нар маань түүнийгээ байхгүй болгоод. Тэр дээр отог зайлшгүй байх шаардлагатай. Одоо Гүрмийн нуур гээд тэр нууран дээр яг энэ асуудал явж байна. Буйр нуурыг бас л энэ отгийн асуудлыг шийдээгүйгээс болоод бохирдолд орж байна.

Тэгээд тэр Хог хаягдлын тухай хуулиа энэ хуультайгаа сайн уяж холбоо. Тэр отгийн асуудал гэдэг чинь тэр нэг асуудлыг л яриад байна шүү дээ. Хураамж авах эрх зүй байдаггүй. Дархан цаазтай газар нутгийн газраас л авдаг. Түүнийгээ зарах эрх зүй бас байхгүй. Тэрийгээ зарж чаддаггүй шүү дээ. Хүнээс мөнгө авчхаад.../минут дуусав/

Г.Занданшатар: 81. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ сайд хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: Н.Ганибал гишүүний асуултад хариулъя.

Өрсөлдөөн дундаас аялал жуулчлалыг хөгжүүлэх ёстой гэдэгтэй зарчим дээр санал нэг байгаа учраас бид Аялал жуулчлалын тухай хуулиар менежментийг хэрэгжүүлэх, хувийн хэвшлийг дэмжих энэ асуудлуудыг оруулж ирж байгаа юм.

Тэгээд Монгол Улсыг сурталчлах зардлыг төсөвлөсөн үү гэж. Аялал жуулчлалыг хөгжүүлэх санг бид бий болгоно. Аялал жуулчлалыг хөгжүүлэх сантай холбоо бүхий заалтуудыг харах юм бол дотор нь Монгол Улсыг сурталчлах гэдэг энэ утга агуулга бүрэн дүүрэн орчихсон явж байгаа.

Аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүд байна уу гэж. Яг одоо **Mongolia Travel Guide** гээд хаягаар ороод үзэхэд ч гэсэн энэ Монгол Улсын аялал жуулчлалын тодорхой бүтээгдэхүүнүүд бэлэн байж байгаа.

“Хөх сувд” мөсний баяр бид 3 сард тэмдэглэдэг. “Бүргэдийн баяр”, “Түмэн тэмээний баяр”, “Цас, цааны баяр”, “Улаанбаатарын өвлийн наадам”, “Мөнгөн шагшуурга”, “Плейтайм”, Нүүдэлчин Монгол соёлын биет бус өвийн их наадам гэх мэтчилэнгээр ингээд **IT Mongolia International Travel Mart** гэх мэтчилэнгээр ингээд тодорхой аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүд маань байхгүй биш байгаа юм.

Тэгээд үүнийг бид олон улсад сурталчлах тодорхой жуулчдад, олон орны жуулчдад хүргэхийн тулд бид нарт төсөв хэрэгтэй. Төсөв нь өөрөө аялал жуулчлалыг хөгжүүлэх санд бид

төвлөрүүлэх байдлаар зохион байгуулалтыг хийж оруулсан байгаа.

Даатгалтай холбоо бүхий асуудал дээр хоёр янзын зүйл байгаа юм. Тухайн хуулийн 15 дугаар зүйл дээр даатгал гэж байгаа. Даатгалын 15.5 дээр, 15.4, 15.2, мөн 16 дугаар зүйл дээр жуулчны аюулгүй байдалтай холбоотой асуудлууд байгаа.

Үүнийг аль болох тухайн аялал жуулчлалыг эрхлэгч байгууллага нь өөрөө даатгалынхаа процессыг хийж явахаар ийм зохицуулалтуудыг хийж өгсөн байгаа.

Төр өнөөдөр даатгал хийж өгнө гэхээс илүүтэй бид нарын хэлээд байгаа энэ мэргэжлийн байгууллагууд, тур оператор, аяллын агентууд, хувийн хэвшил маань өөрсдөө энэ ажлаа хийж явах ёстой гэдэг энэ зохицуулалтуудыг бид оруулж өгчихөөд явж байгаа юм.

Дотоодын аялал жуулчлалын отог байх ёстой. Та сая хэллээ. Маш олон нууруудтай холбоотой, гол мөр нь булаг шандтай холбоотой асуудлууд бий. Одоо бодит байдал яг л ийм л байна.

Бид өнөөдөр аялал жуулчлалыг замбараагүй хөгжүүлснээс үүдэлтэй, аялал жуулчлалыг бид өнөөдөр 2000 оны хуулиар явж байгаагаас үүдэлтэй, тур оператор компаниудыг бид заавал одоо энэ тодорхой аялал жуулчлалын чиглэлийн тусгай зөвшөөрөлтэй байх ёстой, хөтчүүд маань тодорхой хэмжээний шаардлага хангасан байх ёстой. Ялангуяа хил дагасан, мөн улсын онцгой стратегийн ач холбогдол бүхий газруудад маршруттай байх ёстой гэдэг зүйл маань яг л үүнийг хэлж байгаа юм.

Бид үүнийг хийхгүйгээр байгаль орчноо сүйтгээд эргээд бид нөгөө мөнгө олдог буюу тухайн аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгодог энэ газруудаа бид Монгол Улс алдахад хүрч байгаа юм.

Тэгэхээр бид цаашдаа тухайн хуулиар зохицуулалт хийж өгч байгаа зарчмууд маань ерөөсөө л байгаль орчин өөрөө эзэнтэй байх ёстой. Аялал жуулчлал эзэнтэй байх ёстой. Аялал жуулчлалын маршрутууд эзэнтэй байх ёстой. Аялал жуулчлалын үйлчилгээ эрхэлж, эдийн засгийн хувьд өөрсдөө ашиг орлого олж байгаа компаниуд бүртгэлтэй байх ёстой. Хариуцлагатай байх ёстой. Төр өөрөө тодорхой хэмжээнд ард түмний тодорхой хяналтыг хүртэл тавихаар бид энэ хууль дээр заалтуудыг оруулж өгсөн байгаа.

Гэх мэтчилэнгээр ингээд төр болон хувийн хэвшлийн хүрээнд бид тодорхой хэмжээнд энэ хяналтыг тавих системийг хүртэл энэ аялал жуулчлалын хуульд оруулж өгснөөрөө энэ хууль бас тодорхой хэмжээнд ач холбогдолтой гэж үзэж байгаа юм.

Ялангуяа аялал жуулчлалын хуулийн 30 дугаар зүйл дээр аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих олон нийтийн хяналтыг бид оруулж өгсөн. Аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх талаар иргэн, хуулийн этгээдийн тодорхой эдлэх эрхүүдийг бид бас зааж өгч байгаа.

Энэ өөрөө ач холбогдлын хувьд юу вэ гэхээр бид аялал жуулчлалын хувьд, ялангуяа Монгол Улсын хувьд байгаль орчинд түшиглэсэн аялал жуулчлал гаднаас орж ирж байгаа жуулчдын санал хүсэлт аваад үзэхэд

Монгол орны байгаль орчныг үзэх гэж ирсэн.../минут дуусав/

Г.Занданшатар: Наянтайн Ганибал гишүүн.

Н.Ганибал: Тэгээд оруулж ирэхдээ том юм яриад буухтай жижиг юм ярьж байна шүү дээ. Энэ чинь зөв шүү дээ.

Эхлээд та хэд дэд бүтцээ сайн хий л дээ. Өнөөдрийнхөө байгаа бүх проблемуудыг шийдэх энэ асуудлуудыг нь хуульд оруулж ирснээ тайлбарла л даа. Том том юм ярьж ирээд л Зам тээврийн сайдын ярих ажлыг бараг асуултынхаа талд нь л ярих юм.

Тэртээ тэргүй тэр навигацын асуудал, агаарын тээврийн либералчлалыг тэнд хийгээд л явж байгаа юм шиг байна шүү дээ. Тэгээд миний хувьд бас яг энэ хог хаягдлын асуудал дээр энэ байгаль орчин, дотоодын аялал жуулчлал, гадаадын аялал жуулчлал энэ хог хаягдлын асуудлыг хэрхэн зохион байгуулах тал дээр хууль санаачлаад аймгуудаас 21 аймаг бүгдээс нь санал аваад Их Хурлын Тамгын газрын Их Хурлын даргад өргөн мэдүүлэхээр ингээд бэлэн болчихсон байгаа юм. Тэрийг та нар аваад харчхаарай.

Мөнгөө хурааж аваад зарж чаддаггүй юм. Тэрийг нь зардаг болгомоор байна. Тэгж байж энэ асуудлаа шийднэ шүү дээ. Тийм үү. Тэрийг та бүхэн бас аваад.../минут дуусав/

Г.Занданшатар: Тэр хуулийг судалчихаарай гээд зөвлөгөө өгч байна шүү.

Одоо эрхэм гишүүн Одонгийн Цогтгэрэл асуулт асууна.

О.Цогтгэрэл: Аялал жуулчлалын хууль гээд нэлээн тийм зөрчилдөөнтэй л хууль орж ирж байна. Өөрсдөө болохоор салбарын хөгжлийг дэмжиж байгаа гэх юм. Яг одоо энэ хуулийн агуулгуудыг ингээд харахаар гаднаас орж ирж байгаа нөхдүүд заавал тур оператороор дамжина. Тур оператор нь заавал тусгай зөвшөөрөл авна. Дотоодынх нь отоглох цэгээр заавал үйлчлүүлнэ. Эдгээрийг биелүүлбэл торгоно. Торгосон нэг санд орно. Дахиад үүнийг нэг Үндэсний хороо гэдэг байгууллага ахална. Нөгөө аялал жуулчлалын сайд нь ч хаачихсан юм.

Ерөөсөө нэг явж байгаа чиглэлийнхээ эсрэг. Дахиад л энэ засгийн чинь ярьж байгаа чиглэл чинь энэ дээр ирээд эсрэг болчихоод байх юм. Яг одоо Энэ хуулийн үзэл санааг ингээд харахаар Монголын аялал жуулчлал хөгжөөгүй байна. Хөгжихийн тулд ингээд чангалаад, бүртгээд, татвар аваад, торгоод байвал энэ салбар хөгжих юм байна. Энэ байхгүй учраас энэ салбар хөгжөөгүй юм байна гэдэг л зүйл энэний цаана нь харагдаж байх шиг байгаа юм.

Яг нөхцөл байдал дээр танилцуулгадаа ч бас харагдаж байсан. 600 мянган жуулчин оргил үедээ ирж байсан. 2019 онд гэсэн тоо байх шиг байна лээ.

Ер нь гадагшаагаа хэд дахин их мөнгө урсаж байгаа шүү дээ. Яг аялал жуулчлал дээр гэдэг чинь бид нарын нөхцөл байдал тийм их чангалж, торгоод байх хэмжээний. Асуудалд чинь нэг тоо ихдэхээр чанар луу

шилждэг. Манайд чинь аль нь ч байхгүй байгаад байна шүү дээ.

Тэгэхээр одоо тийм нэг яг ямар чөтгөр нь ингэж чангалаад торгоод бүртгээд явчихвал энэ салбар чинь гоё болчих гээд байна гээд яг ямар чөтгөр нь шивнэнэ гэдгээр юм болчихоод энэ хуулийн нөхцөл байдал ийм байдалтай гарчхаад байгаа юм. Одоо мэдэхгүй.

Тэгэхээр үүн дээрээ бас нэг хариулт хэлээч ээ? Яагаад энэ үзэл баримтлал чинь энэ тал руу явчихсан юм? Яагаад ийм үзэл баримтлал дээр энэ хуулийг бичих болчихсон юм? Үнэхээр тийм хэдэн сая хүн хахчихаад тэнд нь хэрэг зөрчил их гараад, одоо үүнийг цөөлөөд чанартай болгоё гэдэг ийм суурь үзэл баримтлал гарчхаад байгаа юм уу? Хүн ирэхгүй байхад чинь улам чангалаад байхаар чинь энэ салбарынхан чинь улам ч сөхөрчихдөггүй юм уу?

Одоо тэр ярьж байгаагаар зарим нэг мессеж ч ирчихсэн байна лээ. Энэ салбарынхан чинь баахан хүмүүс эсэргүүцээд яваад байх шиг байх юм. Дахиад энэ хуулийн энэ хавсралт материалуудыг харахаар Зөрчлийн хууль дээр оруулах өөрчлөлт гээд нэг 10-аад өөрчлөлт байна. Тусгай зөвшөөрөлгүйгээр явуулсан бол мянган нэгжээр торгоно. Бүртгэлтэй аяллын агентын үйл ажиллагааг эрхэлсэн. Ингээд хууль бус орлогыг нь хураана. 500 нэгжээр торгоно. Жуулчны хөтчийн үйл ажиллагаа гээд 10-аад зөрчлийн хууль дээр баахан торгоно шийтгэнэ, торгон шийтгэнэ гэсэн нэг баахан зүйл заалтууд.

Тэгэхээр энэ үзэл санаа чинь яг яагаад ийм юм бичих нөхцөл ба энэ хуулийн суурь фундамент чинь яагаад

ийм нөхцөл, хууль бичих ийм нөхцөл байдал үүсчихсэн гэдэг дээр нэг тайлбар өгөөч. Энэ хэлэлцэх эсэх явж байгаа болохоор бас үзэл баримтлал талаасаа асуух ёстой байх гэж бодож байна.

Хоёрдугаарт, нь энэ дэлхий чинь бас улам хавтгай болоод байна. Яг заавал тур оператор орж ирээд энэ бүх юм чинь бүртгэлтэй явна гэхээсээ энэ хүмүүс чинь нэг цахимаар сонирхоод магадгүй нэг жуулчны блог үзээд, үүгээрээ захиалаад **AirBNB**-гээр будлаа захиалаад. Ингээд л гэр бүлээрээ ч юм уу явчихдаг. Тэр улс орон нь аюулгүй болоод л явчихдаг. Тэр хандлага руу чинь. Энэ нэг ийм төвлөрсөн бус удирдлагын систем рүү чинь энэ дэлхийн улс орон чинь яваад байгаа юм биш үү.

Энд эсрэгээр нь бүх юмыг төвлөрүүлээд заавал зөвшөөрөл авна. Гаднын нэг нөхөр ирээд аялаад явбал торгуулах юм шиг байгаа юм. Дотоодын нөхөр очоод отоглох цэг дээр буухгүй бол бас торгуулах юм шиг байгаа юм.

Тэгэхээр энэ үзэл санаа чинь яагаад ингээд эсрэг тийшээгээ. Дахиад тэр энэ дэлхийн явж байгаа чиг хандлагын эсрэг явчхаад байгаа юм. Энэ дээр нэг бас нэг тодорхой тайлбар хэлээч.

Тэгээд өөр энэ аялал жуулчлалын холбоо, энэ мэргэжлийн байгууллагууд нь яг юу гэж үзэж байгаа юм? Энэ ажлын хэсгийн гишүүд дотор энэ холбооны төлөөлөл байгаа билүү? Тэр холбоогоо төлөөлөөд та нэг байр сууриа илэрхийлээч. Сая бас нэг л баахан энэ хажууд гарын үсэг цуглуулж байна. Ингэж байна, ингэж байна. Гишүүд үүнийг дэмжиж өгөөч гээд чат баахан юм ирчихсэн л байна лээ. Яг танай

холбооны гишүүд чинь энэ дээр эсрэг байр суурьтай байгаа юм биш үү. Тэгээд энэ нь гурван зүйлд нэг хариулт өгөөч.

Г.Занданшатар: 82.

С.Цогтгэрэл: О.Цогтгэрэл гишүүний асуултад хариулья.

Хуулийн төсөлд тэр гаднаас орж ирж байгаа жуулчид заавал тур оператороор дамжина гэсэн зохицуулалт байхгүй. Тэр ойлголт хаанаас яаж гарч ирээд байгаа нь бас сайн мэдэхгүй байна.

Ер нь тийм буруу ойлголт гадуур түгсэн юм шиг байгаа юм. Тэр дээр таны хэлж байгаагаар цахимаар гадаадаас жуулчид буудлаа захиалаад, үйлчилгээгээ захиалаад өөрөө үүргэвчээ үүрээд ирээд аялах боломж нь бол хуулиар нээлттэй байгаа.

Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар нийгмийн заавал хуулиар зохицуулах харилцааг л хуулиар зохицуулахаар хуульчлах ийм зохицуулалттай.

Тэгэхээр бүх зүйлийг бид бас хуулиар зохицуулах боломжгүй учраас зарим зүйлийг нь зохицуулаад, ихэнх зүйлийг чөлөөтэй байдлаар ингэж орхихоор хуулийн төслийг үзэл баримтлалыг гаргасан байгаа.

Тэр торгоно гээд зааж байгаа асуудлуудыг бол түрүүн хэлсэн. Хуулиар бид заавал тодорхой хэмжээний шаардлагуудыг тавьж байгаа бол тэр шаардлагууд зөрчигдсөн тохиолдолд яах вэ гэдэг энэ асуудал зүй ёсоор тавигддаг.

Тийм учраас хариуцлагын асуудал яригдаж байгаа. Тэгэхгүй бол одоо юу гэдэг юм, улсын аялал жуулчлалын бүсэд заавал отоглох цэгт буугаарай гэж хэлчхээд хариуцлагын асуудал байхгүй бол тэнд хэн ч буухгүй. Отоглох цэг маань ажиллаж өгөхгүй. Нөгөө отоглох цэгийг хувийн хэвшлийнхэн хөрөнгө оруулалт хийгээд менежментийг нь хариуцаад явъя гэхээр нөгөө хөрөнгө оруулалт нь эргэж үр ашгаа өгдөггүй. Ингээд ийм асуудлууд үүсэх учраас заавал тийм зохицуулалтууд орж ирээд байгаа юм.

Торгуулийн төлбөр, тэр аялал жуулчлалын хөгжүүлэх санд орно гэж та сая хэлэх шиг боллоо. Тийм зохицуулалт бол хуулийн төсөлд бас байхгүй байгаа. Торгууль бол ямар нэгэн байдлаар сан руу орохгүй. Ийм байна. Тэгээд та хариулах уу.

Г.Занданшатар: 80.

Ш.Нэргүй: Монголын аялал жуулчлалын холбоо. Энэ хуулийг эхнээс нь эхлээд боловсруулахад Монголын аялал жуулчлалын хувийн хэвшлийнхэн холбоод оролцож явсан байгаа.

Хуулийг батлахад Аялал жуулчлалын холбоо өөрийнхөө бодол, саналыг тусгасан. Гэхдээ өнөөдөр болж байгаа процессын хувьд бол олон ургальч үзлийн үүднээс янз янзын үзэл санаа байх шиг байна.

Хоёрдугаарт, аялал жуулчлалын хуулийн төслийг уншихад өнөөдөр бид хоорондоо харилцан ойлголцох, бас сайжруулах зарим зүйл дээр өөрчлөлт хийх асуудал гарч ирж байгаа юм.

Манайхны тавьж байгаа санал бол гол нь 7.2.2, 7.2.3, 12 дугаар зүйл, 25 дугаар зүйл гэсэн ийм 4 зүйл дээр голдуу ахин ярилцъя гэсэн ийм саналтай яригдаж байгаа.

Ойлголтын зөрүү нэлээн байх шиг байна. Өнөөдөр бид хэдийн ойлгосноор маргааш одоо ингээд хувийн хэвшлийн төлөөлөл өнөөдөр ажлын хэсэгтэйгээ уулзаад зарим нэгэн редакцын чанартай, зарим нэгэн өөрчлөлтийн чанартай зүйлүүд хоорондоо ярилцъя гэсэн асуудал байгаа.

Хуулийг зарчмын хувьд бүхэлд нь ингээд болохгүй, бүтэхгүй гэж байгаа зүйл байхгүй. Саяын 4 зүйл дээр ойлголцох юм бол цаашдаа хуульд бас бид хэдийн үйл ажиллагаанд дэмжлэг болно гэсэн ойлголттой байгаа.

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууна.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр аялал жуулчлалыг бид эдийн засгийн нэг тулгуур салбар гэж үзээд байгаа л даа.

Тийм учраас энэ салбар өөрөө эдийн засгийнхаа бусад салбаруудыг бас дэмжсэн тийм эрх зүйн зөв зохицуулалтын тухай асуудал яригдах гээд байх шиг байгаа юм.

Тэгээд энэ өнгөрсөн хоёр, гурван жилийн байдлыг хараад ирэхээр зэрэг гадаадын аялал жуулчлал тодорхой хязгаарлалтуудад ороод дотоодын аялал жуулчлал яваад ирэхээр зэрэг энэ орон нутгийн үйлчилгээний байгууллагууд нэлээн тийм жоохон сэргэх өнгө орж байгаа юм шиг байгаа юм. Ерөөсөө энэ хуулийн гол зорилго нь эдийн засгийг

идэвхжүүлэх, тэлэх тухай л ойлголт шүү дээ. Ер нь явж явж.

Тийм учраас энэ дотоодын аялал жуулчлалынхаа харилцааг нэлээн зөв бодож, тодорхой байдлаар гаргаж ирэх нь би зөв юм биш байгаа даа гэсэн нэг ийм санаа байгаад байгаа юм гэж. Энэ дээр та хэд ямар бодол байна вэ гэж.

Хоёр дахь зүйл. Одоо бидэнд аялал жуулчлалын бүсүүд байгаа. Байгаа.

Тэгэхээр тухайлсан тухайлсан бүсүүд дээр аялал жуулчлалын бүтээгдэхүүн буюу тэр эвентүүдийг яах юм бэ гэдэг асуудал байгаа юм. Тэгээд яаж хөгжүүлэх юм бэ гэдэг асуудал байгаад байгаа юм. Яг нарийндаа ирж байгаа улсуудад бид юу үзүүлэх юм гэдэг асуудал байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр нэгэн ижил хэлбэрийн агуулга, хэлбэртэй юмнуудыг бүх газраа байлгаад байх юм уу? Тодорхой тэр бүс нутгууд чинь тухайн иргэдийнх нь амьдрал, зан заншил юм нь бас хоорондоо давтагддаггүй өөр зүйлүүд бий. Газар, байгалийн унаган төрх, тэр бүх юм нь бас тийм.

Тэгэхээр түүн нь дээр нь тулгуурлаж тодорхой аялал жуулчлалын бүтээгдэхүүний чиглэлүүд, хөгжүүлэлтийн асуудлыг хэдүүлээ ер нь яаж авч үзэх юм гэдэг асуудал байна. Үүнийг онцгой анхаармаар байна гэж.

Дараагийн нэг асуудал дэд бүтцийн асуудал байгаад байгаа юм. Дан дамаа энэ улсын хэмжээний гол аялал жуулчлалын бүс нутгуудыг дэд бүтэцжүүлэх тухай асуудал нэлээн чухал байна. Энэ тал дээр ер нь ямархуу

байдлаар асуудалд хандах ёстой юм бэ? Яаж зохицуулах ёстой юм гэдэг зүйл байна. Энэ хуулийг дагуулаад тэр Ан агнуурын хуульд өөрчлөлт оруулах гээд ороод ирчихсэн юм билээ. Тэр тусгай зөвшөөрлийн агнууруудыг дуудлага худалдаагаар эрхийг нь олгох тухай асуудал яригдаад байна л даа.

Тэгэхээр тодорхой агнуурын нөөц нутгуудыг яаж хамгаалалтад авах вэ гэдэг асуудал. Түүн дээрээ тулгуурлаж энэ харилцаа өөрөө гарч ирэх тухай ойлголт байгаад байх шиг байгаа юм. Би бол тэгж хараад байгаа. Одоо бид тодорхой агнуурын бүс нутгуудыг энэ гадаадын анчдад тусгай зөвшөөрлийн ан агнуур хийлгэдэг тусгай зөвшөөрөлтэй компаниудад төслөөр хамгаалалтынх нь асуудлыг хариуцуулаад яваад байгаа шүү дээ. Үүнийг бол би нэг их ч буруу тогтолцоо гэж боддоггүй. Агнуурынхаа нөөцийг тогтвортой хамгаалах, түүн дээрээ тулгуурлаж тогтвортой энэ чиглэлийн орлого боломжоо бий болгох гэсэн ийм л бодлого яваад байсан. Тэгвэл хэрвээ үүнийг дуудлага худалдаагаар олгоод эхэлнэ гэвэл тэр агнуурын бүс нутгийн хамгаалалтын асуудлыг хэдүүлээ юу гэж үзэж, яаж томъёолж оруулж ирэх ёстой юм бэ? Үүнийгээ нэг тодорхой болгох ёстой болов уу гэсэн нэг ийм бодол байна.

Дараагийн нэг асуудал. Ер нь энэ хуулийн концепц Монгол үнэхээрийн л тэр байгаль, түүх, соёл, ахуй амьдралынхаа чиглэл дээр аялал жуулчлалынх нь гол чиглэл байна л гэж харцгаагаад байгаа юм бол нутгийн иргэд дээр түшиглэсэн аялал жуулчлал чинь өөрөө концепц нь байх юм. Түүнээс биш аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа улсуудад туслах хэлбэрээр.../минут дуусав/

Г.Занданшатар: Баярлалаа. 85.

Б.Болортуяа: Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр яг Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулга маань бол яг таны хэлсэнчлэн эдийн засгийг дэмжих гэдэг утгаараа энэ хууль маань явж байгаа юм.

Тийм учраас энэ хуульд орж байгаа оролцогч талууд маань тодорхой хэмжээгээр хязгаарлагдаж байгаа.

Тийм учраас таны сая хэлсэнчлэн яг ирж байгаа жуулчид, байгалийн болон түүх соёлын бүтээгдэхүүнийг үзэхийн тулд нийт ирж байгаа гадаадын жуулчдын 34 хувь нь Монгол орны байгаль татагдаж ирдэг. 24 хувь нь яг уламжлалт нүүдлийн соёл ахуйд татагдаж ирдэг. 12 хувь нь адал явдлыг сонирхож ирдэг. 11 хувь нь ан амьтан ажиглах. 10 хувь нь Монголын түүхийг сонирхож. 9 хувь нь бусад шалтгаанаар ирдэг.

Тэгэхээр бид нарт байгаа өнөөдрийн бодит аялал жуулчлалын нөөц маань өөрөө Монголын байгалийн үзэсгэлэнтэй газар маань нийт жуулчдынхаа 30 хувийг татаж байна. Үүн дээр нэмэгдүүлээд бид бүхэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээнийг үнэхээр илүү хөгжүүлэх шаардлагатай. Үүгээрээ дамжуулаад олон төрлийн бүтээгдэхүүнтэй байж эдийн засгийн эргэлт маань илүү сайн сайжрах учиртай.

Тийм учраас өнөөдөр хүртэл бодитой хөгжүүлэлт сайн хийгдэж чадаагүй боловчиг тухайн бүс нутаг, орон нутаг болгонд зохиогдож ирсэн

уламжлалт эвент арга хэмжээнүүд байна. Энэ хүрээндээ ирэх жилийг зочлох жилтэй холбогдуулан зарлаж байгаатай холбогдуулан онцлох 20 эвентийг. Мөн жилийн туршдаа байнга явуулах 67 эвентийг нийт Монгол Улсын 21 аймгийн нутаг дэвсгэр дээр өнгөрсөн хугацаанд хийгдэж ирсэн энэ уламжлалыг нь харгалзан үзээд цаашид хөгжүүлэхээр төлөвлөчихсөн явж байгаа. Энэ хөгжүүлэлтээ бид бүхэн орон нутгийн дэмжлэгтэйгээр явуулах биш аялал жуулчлалыг хөгжүүлэх сангаас тодорхой хэмжээний санхүүжилтийг гаргаж, энэ эвент арга хэмжээнүүдээ олон улсад сурталчлах, зарлах, жил болгоны 10 дугаар сарын 01-нээс өмнө энэ тухайн орон нутгийн эвентийг зарлах асуудлыг энэ хуулийнхаа орон нутгийн бүрэн эрх дээр тусгасан байгаа.

Мөн дээрээс нь энэ эвентийг зарлахтай холбогдуулаад бид бүхний бас нэг шийдэх ёстой ажил бол агаарын тээврийн нислэгийн асуудал байгаа. Тэгэхээр маш хямд үнэ, нислэгийн давтамж өндөртэй нислэгээр тийзийн хөнгөлөлттэй жуулчид ирээд тухайн бүс нутгуудад үе шаттайгаар календартчилсан төлөвлөгөөний дагуу аялалын хөтөлбөрүүдээ зоогоод тэр дээрээ бүтээгдэхүүн үйлчилгээгээ үзээд явах ийм боломж нээгдэхээр байгаа.

Г.Занданшатар: 84. Д.Цолмон. Хууль зүйн яам.

Д.Цолмон: Ж.Батжаргал гишүүний асуултад нэмэлтээр хариулья.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдан Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Энэ нь тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгын хүрээнд тусгай зориулалтын тодорхой амьтдыг агнах, барих зөвшөөрлийг дуудлага худалдааны журмаар олгох энэ зохицуулалтыг тусгасан юм.

Одоо яг ямар журмаар явж байгаа вэ гэхээр ерөнхийдөө энэ тусгай зориулалтын ховор амьтныг агнах барих зөвшөөрлийг Засгийн газрын тогтоосон квотод багтааж агнуурын бүс нутгаар хуваарилж яг энэ агнуурын бүс нутгийн менежмент хариуцагч буюу агнуур зохион байгуулдаг компаниудад олгож байгаа.

Тэгэхээр ерөнхийдөө энэ бол ан амьтан, ус ой төрийн нийтийн өмч, энэ ард түмний нийтийн мэдэлд, төрийн хамгаалалтад байх ёстой. Тэгэхээр энэ тодорхой ховор амьтдыг нутгийн менежментийн хариуцагч компаниуд гэрээний үндсэн дээр олгож байгаа нь бас зохимжгүй юм гэж үзээд үүнийг дуудлага худалдааны үндсэн дээр зохион байгуулья. Дуудлага хугадаанаас олсон орлогын ихэнх хувийг агнуурын бүс нутгийн аймаг, суманд 40, 40 хувиар, нийт 80 хувийг нь. Үлдсэн 20 хувийг нь агнуурын бүс нутгийн менежмент хариуцагчдад олгохоор нэмэлт хуулийн төсөл дээр орж ирсэн байгаа.

Ингэсээр агнуурын бүс нутгийн тэр менежмент хариуцагч маань тухайн бүс нутгийн байгалийн нөөц, хамгаалалт болон тэр амьтан өсгөж үржүүлэх, тэр зорилгынхоо хүрээнд ашиглаж болох санхүүжилтийн тогтвортой үүсвэрийг бий болгох ийм зохицуулалтыг оруулж ирсэн байгаа юм.

Г.Занданшатар: 82.

С.Цогтгэрэл: Ж.Батжаргал
гишүүний асуултад нэмэлтээр хариулъя.

Нутгийн иргэдэд түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх ёстой гэдэг таны саналтай санал нэг байгаа. Хуулийн төсөлд бас энэ талын зохицуулалтууд тусгагдсан. Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд жуулчны үйлчилгээ үзүүлэгч иргэний үйл ажиллагааны талаар зохицуулж өгсөн байгаа.

Тэгэхээр аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгч иргэн маань тухайн нутагтаа байдаг нутгийн иргэдэд түшиглэсэн ийм аялал жуулчлалыг хөгжүүлэх ийм зорилгыг тавьсан. Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч иргэн маань орон нутагтаа гэр түрээслэх, нүүдлийн соёл ахуй, зан заншлыг жуулчдад танилцуулан сурталчлах болон аялал жуулчлалын дагалдах бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэх ийм боломжийг хуулийн төслөөр олгож өгсөн.

Мөн ажлаар ирж байгаа хүмүүст юу үзүүлэх вэ гэдэг асуудал бас нэлээн хөндөгдөж байна. Та бас асуулаа. Ер нь сая хэлж байна. Эвэнт арга хэмжээнүүдийг бол улсын хэмжээнд төрийн бодлогоор салбарын яамнаас тодорхой хэмжээний эвэнт арга хэмжээнүүдийг зохион байгуулна гэж.

Нөгөө талаасаа энэ Аялал жуулчлалын тухай хуулийн төслийн зорилтыг бид хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1-д томьёолж өгсөн байгаа. Энэ хуулийн зорилт нь үндэсний онцлог бүхий байгаль, түүх, соёлын өвд тулгуурласан тогтвортой аялал жуулчлалын үйлдвэрлэлээр эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх,

дэмжихтэй холбогдсон болон аялал жуулчлалын үйл ажиллагаанд төр иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино гээд.

Өөрөөр хэлэх юм бол энэ түүх соёлтой холбоотой энэ хэсэг дээр нь төр бодлогоор тодорхой эвэнт арга хэмжээнүүдийг зохион байгуулах нь тэр байгалийн үзэсгэлэнт газруудыг үзүүлэх, байгалийн тогтолцоог харуулах энэ нь бүтээгдэхүүн үйлчилгээг тухайн аялал жуулчлалын компаниуд маань өөрсдийнхөө бүтээгдэхүүн, үйлчилгээг аяллыг хөтөлбөртөө шингээж өгөх боломжтой. Тэрийг бас хуулиар тодорхой ингэж хатуу зохицуулах бас боломжгүй гэж ингэж үзэж байгаа.

Та дэд аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх асуудлаар бас асуудлыг хөндлөө. Хуулийн төслийн 4.1.10-т аялал жуулчлалын дэд бүтэц гэж юу вэ гэдгийг томьёолсон байгаа. Аялал жуулчлалын жуулчлалын дэд бүтэц гэж аялал жуулчлалын зориулалттай байр сууц, зам тээвэр, усан хангамж, ариун цэврийн байгууламж, түр амрах цэг зэрэг байгууламж, харилцаа холбоо, мэдээлэл технологийн цахим дэд бүтцийг хэлнэ гэж ингэж томьёолсон.

Мөн хуулийн төслийн 17.1.4-т заасан байгаа. 17 дугаар зүйл бол аялал жуулчлалыг хөгжүүлэх сангийн харилцааг зохицуулсан байгаа. Энэ санд цугларсан хөрөнгөөр аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр энэ хөрөнгийг зарцуулна гэж хуулийн төслийн 17.1.4-т заасан байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Тодруулъя. Жигжидийн Батжаргал гишүүн. 1 минут.

Ж.Батжаргал: Тийм ээ. Тэр 11.2 дээр нутгийн иргэд дээр түшиглэсэн аялал жуулчлалын асуудал байгаа юм.

Тэгэхдээ туслан гүйцэтгэгч хэлбэрээр. Яг агуулгыг нь харвал. Уг нь ерөнхий гүйцэтгэгч нь энэ нутгийн иргэд дээр түшиглэсэн аялал жуулчлалын чинь үйл явц байхгүй юу. Тэрийг нь хөгжүүлэхэд энэ тур операторууд нэлээн том үүрэг гүйцэтгэж, тэндээс нь ашиг орлого олох боломжийг нь анхдагчаар нь авч үзэх л ийм л асуудал байна бидэнд л гэж би бол хараад байгаа хүн байгаа юм. Үүнийгээ л та нар бодох ёстой. Байрыг нь сольчихоод байгаа гэж яриад баймгүй л байна л даа.

Орон нутгийн эвентүүд байна. Гэтэл Монголын нөхцөл өөр юм. Үйл ажиллагаанууд дандаа хээр задгай явагдаж байгаа. Наад тур операторууд чинь нэг ч мөнгө төлөхгүй байгаа. Тэгээд хүний зохион байгуулчихсан юман дээр хэдэн жуулчнаа аваачихаад буцчихаад байгаа.

Цаашид үүнийг тогтвортой болгоё гэвэл бараг долоо хоногт нэг гэдэг юм уу, хоёр удаа заавал явуулдаг болгоод явах гэхээр зэрэг энэ наад тур операторууд чинь жуулчдаасаа тодорхой тэр зохион байгуулж байгаа арга.../минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах юм бэ? 81.

Б.Бат-Эрдэнэ: Ж.Батжаргал гишүүний асуултад нэмж хариулъя.

Өнгөрсөн 04 дүгээр сарын 11-ний өдөр Монголын аялал жуулчлалын холбоотой хамтарсан үндэсний

чуулганыг зохион байгуулсан байдаг. 04 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгуулсан Аялал жуулчлалын холбооны чуулганаар тухайн аймгийн аялал жуулчлалын холбоодтой хамтын ажиллагааны гэрээ, санамж бичгийг зурсан байдаг.

Энэ дээр бид нэг асуудлыг хөндсөн. Тэр нь юу байсан бэ гэхээр яг саяын таны ярьсан асуудал буюу яагаад монголчууд үнэгүй аялал жуулчлалыг явуулах ёстой вэ. Яагаад тухайн орон нутагт тодорхой хэмжээний орлогыг төвлөрүүлдэггүй вэ. Яагаад заавал жишээ нь Тайхар чулуу, Хоргын тогооноос авхуулаад үнэгүй үзэх ёстой вэ гэдэг ийм асуудлууд байсан.

Тэгээд үүнийг тухайн орон нутгийн аялал жуулчлалын байгууллага, холбоодоос зохион байгуулалт хийхээр тусгаад явж байгаа юм.

Г.Занданшатар: 83 гүйцээгээд хариулчихъя.

Р.Лхагвабаяр: Энэ нутгийн иргэдийг түшиглэсэн аялал жуулчлал буюу энэ малчин иргэд бол аялал жуулчлалын хуулийн үндсэн үйлчилгээ үзүүлэгч байх ёстой бөгөөд тур операторын аяллын агент, бусад этгээдүүд нь туслан гүйцэтгэгчээр байрыг нь сольсон байна гэдэг агуулгыг бол хэлж байна. Энэ бол бас нутгийн иргэд буюу малчин иргэдээ түшиглэсэн аялал жуулчлал өөрөө агуулга бол тусгагдсан. Манай ажлын хэсэгт бас Германы “Жи Ай Зэ” /Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ)/ төслийн зөвлөх байгаа. Тэр зөвлөх бас энэ саналыг хэлж байсан.

Тэгэхээр бид Байнгын хороон дээр ажлын хэсэг байгуулагдаад

ажиллах тохиолдолд жуулчны үйлчилгээ үзүүлэгч иргэний зохицуулалтаа илүү нарийвчлах, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын зохицуулалтыг урд аялал жуулчлалын байгууллагын ангилал дээр оруулах бас томьёоллыг оруулж болох уу гэж бодож байна.

Ажлын хэсэг бол суурь судалгааг энэ дээр сайжруулах судалгааг хийсэн байгаа. Илүү сайжруулах заалтуудаа бас ажлын хэсэг дээр ярилцаад явах бүрэн боломжтой байх гэж харж байгаа.

Г.Занданшатар: Ж.Батсуурь гишүүн алга байна. Тилеухан Аубакир гишүүн асуулт асууя.

Т.Аубакир: Баярлалаа. Аялал жуулчлалын тухай хууль манай улсын хувьд эдийн засгийн бас нэг тодорхой хэмжээний хөшүүрэг болсон ийм чухал хууль орж ирж байгаа.

Энэ хуулийг дэмжиж байгаа. Гадагшаагаа өгөх мессеж энэ тэр нь тодорхой. Визний хөнгөлөлттэй холбоотой, нөөцийн буцаан олголттой холбоотой гаднын аялагчдыг бас нэг татах тодорхой хэмжээний сегментүүд болж орж ирж байгаа.

Үүнийг дэмжиж байгаа. Тодруулах ганц нэг зүйл байна. Би сая сайдаас бас асуусан. Энэ ард иргэдийн дундаас маргаан дагуулаад байгаа энэ 8 дугаар заалт. Зөрчлийн тухай хуульд оруулах өөрчлөлт дотор энэ 8 дугаар заалт дээр улсын болон орон нутгийн аялал жуулчлалын бүсэд хээрийн отоглох цэгийн байршлаас бусад газарт жуулчин аялагч отоглосон бол торгуультай гэж. Тийм ээ. Үүнийг бид бас ингээд зөв тайлбарлаад явчихгүй бол.

Сая Ж.Батжаргал гишүүн ярьж байна лээ. Энэ жишээлбэл, Улаанбаатараас гарч давхиад л Төв аймгийн Лүнгийн наана хоноглоод явахыг бол хориглохгүй байгаа шүү дээ. Нэгдсэн зохион байгуулалтад оруулах, аялал жуулчлалын бүс нутагт дураараа отоглоод бохирдуулаад, мөн гэмт хэрэг гарах нөхцөлийг бүрдүүлээд хараа хяналтгүй, усны аюул, галын аюул зэргээс сэргийлэхийн тулд аялал жуулчлалын бүс дотор л дураараа отоглуулахгүй л гэсэн бодлого явж байгаа биз дээ. Тийм ээ. Сайд аа. Хэдүүлээ үүнийгээ яг тодорхой тайлбарлаад явахгүй бол ерөөсөө энэ өргөн уудам нутагтаа байж байж бид нэг майхан сав бариад хонохыг минь хориглолоо юу гээд л бас л нийгэмд асуудал дагуулаад байгаа юм.

Тийм учраас энэ хуулийнхаа бас үзэл санаа буюу цаад зорилгыг нь бид зөв тайлбарлаад явах ёстой гэж 8 дугаар зүйл дээр.

Бид гадаадын аялал жуулчлал гэхээсээ илүү дотоодын аялал жуулчлал руугаа чиглэсэн бодлогуудыг бас сая Ж.Батжаргал гишүүний хэлсэн хувийн хэвшлүүд дээр түшиглэсэн, ард иргэдтэйгээ хамтарч ажилласан аялал жуулчлалыг бид хөгжүүлэх ёстой. Яагаад гэх юм бол одоо Баян-Өлгий аймаг бол жишээлбэл, мөн дотоодын аялал жуулчлал ихээр очдог аймгуудын нэг. Тэнд одоо жишээлбэл нэг эсгий гэрээ бариад нэг бүргэдээ бас нэг гаднаа тавьчихсан ганц нэг хонь мал шөл юмаа гаргаад өгчихдөг. Хэдэн төгрөг олдог иргэдийнхээ бид орлого янз бүрийн юм нь чи ингэж жуулчдад хонь зарах эрхгүй, бүргэдээ чи харуулах эрхгүй гэж бас боомилж болохгүй юм.

Тийм учраас түрүүн Ж.Батжаргал гишүүний хэлсэн асуудлыг бид аягүй тодорхой болгох ёстой гэж.

Би аялал жуулчлалыг дэмжихэд жишээлбэл, Баян-Өлгий аймаг дээрээ л ярья л даа. Нэгэнт аялал жуулчлал хөгжсөн аймаг. Тэр аймгаас гарсан гишүүний хувьд би ярих ёстой.

Зуны улирлуудад аялал жуулчлалын сезонуудад орон нутгийн янз бүрийн эвент хийх асуудлыг энэ хуулиараа дэмжиж өгч байгаа юм. Долоо хоногтоо нэг байдаг юм уу, хоёр байдаг юм уу. Нэг ийм эвенттэй, одоо бүргэдийн баяртай, үндэсний онцлогийг харуулсан, морь уралдуулах, бөх барилдуулах зэрэг эвентийг орон нутгаас нь зохион байгуулж өгөөд. Гаднаас нэг жуулчны байгууллага хоёр, гурван онгоцоор жуулчдаа аваад очоод үзээд л буцаад явах юм уу? Тэр орон нутаг маань тэр аялал жуулчлалын компаниас яг ямар мөнгө авч үлдэх юм бэ? Орон нутагтаа ямар ашигтай юм бэ гэдгийг нь бид аягүй тодорхой болгож өгмөөр байгаа юм.

Тэгээд энэ дээр би бас нэг хариулт аваадахья. Эвент зохион байгуулахад орон нутагтаа ямар наалдацтай юм бэ гэж.

Хоёр дахь асуудал маань энэ тусгай зориулалтын ангийн асуудал байж байна л даа. Одоо бол тухайн сүргийн бүтэц, тоо толгойтой нь холбоотой яамнаас тоо толгойг нь тогтоож өгдөг. Ан агнуурын. Орон нутагтаа одоо бол тодорхой хэмжээний төсөв бүрдүүлэхэд тус дэм болоод явж байгаа нэг ийм орлого орж ирдэг нэг ийм зүйл байгаа юм.

Одоо энэ зохицуулалтаар дуудлага худалдааны хэлбэрээр өгөх нь л дээ. Энэнээс маань сая бүсгүйгийн тайлбарлаж байгаагаар 20 орчим хувь нь орон нутагтаа үлдэх юм гэж байна л даа.

Аймаг, орон нутгаас хүсэлтүүд ирж байгаа. Сум, орон нутгийн орлого бүрдүүлдэг ан агнуурыг маань ингээд дээшээ аваад явчхаж байгаа юм биш үү гэсэн асуулт ирээд байгаа юм. Энэ дээр нэг тодорхой хоёр дахь асуулт. Энэ ан агнуурын хувьд. Энэ дээр.../минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах юм? 82.

С.Цогтгэрэл: Т.Аубакир гишүүний асуултад хариулъя. Сүүлийн асуултаас эхлээд хариулъя.

Энэ ан агнуурыг тусгай зөвшөөрлийг дуудлага худалдаагаар олгох асуудал энэ Аялал жуулчлалын тухай хуулийн төсөлд орж ирж байгаа нь тодруулах зорилготой ийм зохицуулалт гэж ойлгож болно. Тэр нь юу гэсэн үг вэ гэхээр зэрэг 2022 оны 06 дугаар сард Зөвшөөрлийн тухай хууль батлагдсан. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 1.23-т заачихсан байгаа энэ тусгай зөвшөөрлийг.

1.1-д нь болохоор нэн ховор амьтныг амьдаар нь гадаад улсад гаргах зөвшөөрөл. 1.23 нь тусгай зориулалтын агнуурын амьтныг агнах, барих зөвшөөрөл гээд. Энэ зөвшөөрлийг дуудлага худалдаагаар олгохоор бараг мөн Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлд ингээд заачихсан байгаа юм.

Тэгэхээр энэ зохицуулалт нь Зөвшөөрлийн тухай хууль батлагдсанаараа хэдийнэ бий болчихсон ийм зохицуулалт. Одоо 2023 оны 01 сарын 01-нээс эхэлж хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ. Таны гол сая сонирхож ярьж байгаа зүйл бол энэ Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.23-т заасан тусгай зориулалтын агнуурын амьтныг агнах, барих зөвшөөрөл байгаа юм. Үүнийг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар байгаль орчин, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгодог. Одоо энэ Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны 01 дүгээр сарын 01-нээс эхэлж мөрдөгдөж эхлэхээр тухайн сум, дүүргийн Засаг дарга нь олгодог болох юм.

Тэгэхээр тухайн сум, дүүргийн Засаг дарга нь Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу дуудлага худалдаагаа зохион байгуулаад энэ зөвшөөрлийг олгодог ийм хууль эрх зүйн орчин хэдийнэ бүрдсэн байгаа.

Тэр нутгийн иргэдэд түшиглэж аялал жуулчлалыг хөгжүүлэх гэдэг дээр бас хэлж байна. Тэр нутгийн иргэд бас аялал жуулчлалаар явж байгаа жуулчдад үйлчилгээ үзүүлээд хонь, мал зараад ингээд явах зүйл энэ хуулийн төслөөр ямар нэгэн байдлаар хязгаарлагдаагүй байгаа.

Тэр орон нутагт эвент зохион байгуулж байгаа тохиолдолд тэр эвент зохион байгуулж байгаа орон нутаг юу авч үлдэх юм бэ, тур оператор компаниудаас төлбөр мөнгө авч болох юм уу гэдэг энэ асуудал байгаа. Энэ асуудлыг хуулиар тухайлан зохицуулах нийгмийн харилцаа биш гэж үзэж байгаа. Яагаад гэвэл тухайн орон нутаг

эвент арга хэмжээгээ зохион байгуулж байгаа бол тэр зохион байгуулалтын арга хэмжээгээ аваад тэрийг ирж үзэж байгаа зохион байгуулалттайгаар жуулчдыг авчирч байгаад тур оператортой хэрхэн харилцах вэ, төлбөр мөнгийг яаж авах вэ гэдэг асуудлыг орон нутаг өөрөө л шийдээд явах бүрэн боломжтой байх гэж үзэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо санал хураалт явуулна.

Санал хураалтын өмнө дэмжсэн, дэмжээгүй гишүүд үг хэлж болно. Лхагвын Мөнхбаатар гишүүнээр тасаллаа. Салдангийн Одонтуяа гишүүн үг хэлнэ. Дэмжсэн, дэмжээгүйгээ хэлээд явчихаарай.

С.Одонтуяа: Би хуулийн төслийг дэмжиж байна.

Тэгээд ер нь би бас өөрөө энэ манай Ардчилсан намын үзэл баримтлалд ч байдаг. Бизнесийн эрх чөлөө, эдийн засгийн эрх чөлөөг бол бид аль болохоор дэмжих ёстой.

Ер нь төр ингээд бүх юмыг өөрөө хийнэ гэхээсээ илүүтэй бизнесийг дэмжсэн бизнесийн байгууллагад энэ орон зайг нь гаргаж өгсөн, энэ зөвшөөрлийг нь, одоо ингээд бүх зүйлийг либералчилж өгч байгаа. Энэ бол хамгийн чухал.

Өнөөдөр холбогдсон улс орнууд л хөгжиж байгаа. Та нар мэдэж байгаа байх. **Параг Ханна** /Parag Khanna/ гэж хүний гол эдийн засгийн онол бол ерөөсөө л холбогдсон улс орнууд хөгжинө. Агаарын замаар, усан замаар, авто замаар, интернэтээр.

Тэгэхээр энэ агаарын орон зайг либералчилсан энэ асуудал бол хамгийн зөв өө. Бид бас энэ зоригтой ийм эдийн засгийн реформын чанартай хууль орж ирж байгаад баярлаж байна. Дэмжиж байна. Иймэрхүү л бизнесээ дэмжсэн, хилээ нээсэн ийм зүйл л орж ирж байх ёстой. Мэдээж сайн зүйлийг би бол дэмжээд л хэлдэг. Тийм учраас энэ бол болж байна.

Одоо ачааны онгоцууд нэмэгдлээ. Олон авиалинүүд бас ингээд нэмэгдэж байна. Эд нар бол маш зөв. Дээрээс нь визний асуудлыг хөнгөвчилж гэж байна. Бид чинь маш цөөхүүлээ. Тэгээд бид юу юу үйлдвэрлээд бас их томоохон амжилтад хүрч чадахгүй шүү дээ.

Тэгэхээр энэ сайхан байгаль дэлхийгээ үзүүлээд монголчууд бас түүхээрээ бахархаад энэ аялал жуулчлалыг бол хөгжүүлэх ёстой юм.

Ер нь аялал жуулчлал бол яг тэр тухайн орон нутгийнхаа иргэдэд хамгийн их орлого оруулдаг, ажлын байр нэмэгдүүлдэг салбар бол яах аргагүй л аялал жуулчлал байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг бол дэмжиж байгаа. Гэхдээ сая гишүүд маш олон зүйлийг хэллээ шүү дээ. Энэ хуулийн дотор олон болоогүй түүхий зүйлүүд байна. Бид одоо энэ хүнд суртлаасаа салъя гэж ядаж байхад дахиад л баахан зөвшөөрөл гарах вий. Энэ бүх зүйлүүдийг та нар сайн бодолцоорой. Хэлэлцэх явцад.

Энэ аялал жуулчлалын компаниудаар энэ Байнгын хороод хэлэлцүүлэг хийх ёстой. Яг энэ аялал жуулчлалын компаниудыг нь авчирч

байгаад энэ хэлэлцүүлгүүдээ маш сайн хийх ёстой. Ийм зүйл.

Дээрээс нь манайд ер нь бид энэ зөвшөөрлийн маш олон зүйлүүдийг халж байгаа шүү дээ. Хамгийн гол юм бол аялал жуулчлал дээр стандарт байдаг.

Тэгэхээр стандартыг сайн тавьж өгөөд, тэгээд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэхгүй бол манай аялал жуулчлалын байгууллагууд хэцүү шүү.

Монгол хүмүүс бол яах вэ тэгээд л очих газар луу дахин дахиад очиж болно. Гадаадын хүмүүс нэг ирээд л тэгээд л үйлчилгээ нь таалагдахгүй бол очоод л 10 хүн ярьдаг шүү дээ. Битгий очоорой ч гэдэг юм уу.

Дээрээс нь энэ аялал жуулчлалаа их сайн сегментлэх хэрэгтэй. Хүүхдүүд ирэхэд манайд аялал жуулчлалын ямар ч программ байдаггүй. Яах вэ, нэг хэсэг морь унаж болно. Тэгээд өөр хүүхдүүдэд зориулсан ийм аялал жуулчлал байдаггүй.

Дотоодын аялал жуулчлалыг бас сайн хөгжүүлэх хэрэгтэй. Онгоц нь болж байгаа юм байна. Авто зам нь болдог юм гэхэд галт тэрэг. Одоо энэ галт тэрэгний үйлчилгээ бол манай улсад энэ галт тэрэг 80 жил болсон гэхэд л ямар ч шинэчлэлгүй л хуучнаараа л байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ хэдэн вагонуудыг нь хувийн хэвшилтэйгээ яриад хэдэн гоё супер үйлчилгээ нээчих л дээ. Ардчилал гэдэг чинь өөрөө сонголтыг хэлдэг. Хямдхан нь байдаг, үнэтэй нь байдаг, VIP нь байдаг, люкс нь байдаг. Гэтэл одоо манайд бол ганцхан л люкс вагон байдаг. Замын даргын өөрийнх нь нэг л

вагон байдаг шүү дээ. Энэ чинь одоо 80 жил дотор юу гэсэн үг вэ.

Тэгэхээр би бол энэ Аялал жуулчлалын яамныхан, Зам тээврийн сайдад хүртэл тэр гадаадын гоё гоё вагоны юмнуудыг бол би явуулаад л байдаг юм. Санаа аваг гээд.

Тэгэхээр энэ чиглэлээр энэ галт тэрэгнийхээ үйлчилгээн дээр анхаараад өгөөч ээ. Тэгэх юм бол өнөөдөр гадаадынхан бол байна. Дотоодынхон галт тэргээр чинь аялах маш их хүн байна шүү дээ. Тэр дотор чинь казиногийн үйлчилгээ нээж болно. Тэр дотор янз бүрийн аялал жуулчлалын тэр 10 жилийн төгсөлт ч байдаг. юм уу. Ингээд янз бүрийн жуулчны. Эсвэл гэр бүлийн аялал гээд олон зүйлийг хийж болно.

Тэгэхээр энэ галт тэргүүд чинь үнэхээр хүн орохын аргагүй. Аль бүр 19 дүгээр зуунаараа байгаа шүү.

Үүнийг бас онцгой анхаарах хэрэгтэй. Тэгээд аль болохоор энэ олон хүн ирэхэд мэдээж бизнесийнхэн энэ дээр ажиллах байлгүй дээ. Өөрсдөө юм сэдээд ашигтай орлоготой юм байна гээд ажиллах байлгүй.

Тийм учраас энэ дээр би нэг их санаа зовохгүй байна. Гол нь стандарт дээр нь зөвлөн туслах үйлчилгээ гэдэг юмыг маш сайн хийж өгөх хэрэгтэй байх. Тэгээд ийм зоригтой, яг л бизнесийнхнийг дэмжсэн. Төр бол бодлогоо явуулсан, зохицуулалт хийсэн, агаарын замаа нээсэн, бүх замуудаа нээсэн ийм хуулиуд бол их олон орж ирээсэй гэж хүсэж байна.

Тэгээд түрүүнийг юмыг дахиад хэлэхэд мэргэжлийн байгууллагуудаас

хэлэлцүүлгийг сайн хийгээрэй. Алдаа гаргаж болохгүй ээ.

Г.Занданшатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Би бас дэмжиж үг хэлж байгаа юм.

Аль болгон бас уул уурхайгаа ухааж газар шороогоо ухааж мөнгө олох вэ. Эдийн засагт олох орлогоо нэг ч гэсэн салбараар төрөлжүүлж нэмэгдүүлж, мөнгө олох бололцоо боломжийг эрэлхийлж ажиллаж байгаа яамныхандаа, Засгийн газарт бас талархал илэрхийлэх нь зүйтэй.

Гэхдээ хууль батлагдах нэг хэрэг. Батлагдсан хууль амьдралд хэрэгжих бас нэг өөр асуудал. Та бүхэн гишүүдийн асуусан асуултад маш сайхан хариулж байна. Энд бас гишүүдийн асуултад хариулаад өнгөрөх нэг хэрэг. Яг энэ олон хүн ирсэн тохиолдолд тэр ирсэн иргэдийг аюулгүй байдлыг хангах, тав тухтай байх, чирэгдэл багатай байх, ойлгомжтой байх гээд ингээд олон асуудлууд нэгэн зэрэг үүсэх учраас энэ бүх эрсдэл үүсгэх байдлыг урьдчилан харж, тооцоолж. Ер нь аялал жуулчлалын салбар зөвхөн байгаль орчны салбарын яамны асуудал биш. Энд бүхий л салбар яамд хамаарах ёстой гэж ингэж ойлгож байна. Ингэж байж бид ард иргэдийг гэртээ урьж авчирч, ая тухтай байлгаж байж мөнгө олох энэ бололцоо боломж үүсэх байх гэж ингэж бодож байна.

Нөгөө талаар Байгаль орчны яаманд нэг асуудал хэлэх гэсэн юм. Аялал жуулчлалын асуудал ярихаар нэг нолийн асуудал маш чухал байдаг. Энэ Налайх дүүрэг, энэ Тэрэлжийн бүс газар, Хөвсгөл аймаг, Хөвсгөлийн нуур

тойрсон асуудал. Одоо шаардлага хангасан нольтой газар нэг ч байхгүй.

Та бүхэн Багануур дүүрэгт очоод Багануур дүүргийн баяр наадмын талбай дээр хийсэн Багануур дүүргийн цахилгаан механикийн үйлдвэрийн хийсэн 40 тонны контейнерийг яаж цэвэр боловсон ноль болгож болдог вэ гэдгийг харчхаарай. Б.Бат-Эрдэнэ сайд аа.

Дөрөв дөрөв, наймаг хүн зэрэг орох, хөгжлийн бэрхшээлтэй хүн орох, усаа бохироо байгаль орчинд ээлтэйгээр шийдчихсэн, соруулчихдаг ийм нолийн асуудлыг бас хийчихсэн жишээ байна. Үүнийг та бүхэн үзээд. Цаашдаа энэ байгаль орчны чиглэлээр, энэ аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудад ийм байдлаар хий гэдэг шаардлагыг тавьж ажиллавал бас болохгүй юм байхгүй юм билээ. Үүний зураг төсвүүд бид бүхэнд байгаа шүү. Хийчихсэн. Бэлэн байна.

Усыг нь аваачаад хийчихдэг. Бохирыг нь соруулчихдаг. Тэгээд ингээд орчин үеийн цэвэрхэн цэмцгэр ийм нойлууд л үгүйлэгдэх юм билээ. Ийм нойлуудыг эхлээд хийж чадахгүй бол энэ гаднын ирсэн хүмүүсийн чинь асуудал үнэхээр хүнд шүү дээ.

Тийм учраас энэ тал дээр та бүхнийг. Мөн Улаанбаатар хотод нэг тулгамдаад байгаа энэ хүйтэнд автобусны буудал. Мөн цахилгаан механикийн үйлдвэр энэ хүйтэнд халдаг, халуунд хөрдөг ийм битүү автобусны буудлыг бас Багануур дүүрэгт жишиг байдлаар хийчихсэн байгаа. 10-аад жилийн өмнө. Ийм хоёр асуудлыг та бүхэн нүдээр хараад үзчихээрэй. Энэ бас өнөөдөр тулгамдаад байгаа хоёр асуудлыг. Нэг жижигхэн

юм шиг боловч яг иргэдэд үйлчлэх үйлчилгээ талаасаа бол бас их нарийн асуудлууд юм байна лээ шүү гэдгийг бас давхар хэлчихье. Баярлалаа.

Г.Занданшатар: Одоо Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа.

Тэгэхээр энэ орон нутагт аялал жуулчлалын бүтээгдэхүүн гаргах гээд нэлээн их оролдоод байгаа юм. Тэгээд зарим нэг нь бас гайгүй явж байгаа ч юм уу гэж бодоод байгаа. Гэтэл яг энэ эвентийг түшиглэж аялал жуулчлалынхаа цар хүрээг тэлэх, яг тэр үйл ажиллагааны үр дүн дээр ашиг орлого нь орж явж байгаа энэ аялал жуулчлалын компаниуд чинь үүндээ оролцож байгаа оролцоо нь нэгдүгээрт тааруу байна.

Хоёрдугаарт, тэр улсуудад тодорхой хэмжээний төлбөр мөнгийг нь төлөхгүй байна.

Тэгэхээр үүнийг бид тодорхой эрх зүйн зөв зохицуулалт хийх ёстой. Яаж орон нутгуудтайгаа хамтарч ажиллах ёстой юм. Тэгж байж яаж энэ аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх юм. Жуулчдынхаа тоог нэмэх юм энэ тэр гэдэг юм чинь энэ тэгээд л уялдана шүү дээ. Орон нутгууд эвент хийхгүй бол наашаагаа чиглэдэг юм бас ховор. Яг үнэнийг хэлэхэд.

Тийм учраас үүнийг энэ талаас нь харж хиймээр байна. Дээр нь орон нутагт явагдаж байгаа энэ эвентүүдийг хэн нь үзэж, ийм байдлаар илүү хөгжүүлэлт хийвэл зөв юм байна гэдэг тэр зөвлөх үйлчилгээ үзүүлэх юм.

Дээр нь тэр зөвлөх үйлчилгээг үзүүлэхэд ч гэсэн тэр эвентүүдийг яг боловсронгуй болгох чиглэл дээр нь наад аялал жуулчлалын сан чинь, орон нутагт чинь, энэ тур операторууд чинь яаж хамтарч ажиллаж байж тов тодорхой хэдэн арга хэмжээтэй болох ёстой юм бэ. Энэ л бидний хамгийн гол зүйл байх ёстой болов уу гэж би ингэж бодоод байгаа юм.

Энэ Улаанбаатар төвийн бүсийн аялал жуулчлалыг нэлээн эрчимтэй хөгжүүлмээр байгаа юм. Цаг хугацааныхаа хувьд ч тэр, ирж байгаа жуулчдын зардал юуных нь хувьд ч тэр энэ бүс нутгийн аялал жуулчлалыг бид сайн хөгжүүлж чадах юм бол нэлээн ахиу орлого олох бололцоо боломжууд байгаа.

Тийм учраас энэ бүс нутгийн аялал жуулчлалын маршрут, эвентүүдийг их зөв гаргаж ирэх тухай асуудал байгаад байгаа юм болов уу гэж би бодоод байгаа юм. Энэ наадмыг үзье гэсэн сонирхолтой улсууд маш их захиалга өгдөг. Үздэг стадионных нь хэмжээ багатай. Билетнээсээ хамаараад болж өгөхгүй байгаа тухай яригдаад байгаа юм.

Тэгвэл тэр наадам цогцолбор гээд энэ баруун хойно нэг бүхэл бүтэн цогцолбор бий болгож байгаа биз дээ. Одоо тэнд долоо хоногт нэг өдөр ч гэдэг юм уу бэсрэг хэмжээний тийм арга хэмжээнүүдийг нээлттэй, тэр наадмын нээлтийн арга хэмжээтэй.

Тэгээд залгуулаад бөх, морь, суртай нь гэдэг юм уу ийм байдлаар нь долоо хоногт нэг хийгээд байдаг. Үүнд энэ Аялал жуулчлалын компаниуд чинь ямархуу байдлаар оролцож, тэр зардал мөнгийг нь босгож явах юм. Мэдээж

үүнийг төр даагаад явахгүй нь ойлгомжтой. Цэвэр бизнесийн үйл ажиллагаан дээрээ л тулгуурлагдаж явах ёстой байх гэж би ингэж бодоод байна.

Энэ мэтчилэнгээр энэ төвийн бүсийн аялал жуулчлалын хөгжлийн асуудлыг бодмоор байгаа юм. Улаанбаатар гэхэд одоо гаднаас ирсэн, хурал номонд ч ирсэн бай, уралдаан тэмцээнд ч ирсэн бай, аялал жуулчлалаар ч ирсэн бай энэ улсуудад үзүүлдэг тийм маршрут хөтөлбөр гэж байна уу. Аль аль газруудыг автобусанд суулгаад улсуудаа дагуулж явуулаад үзүүлдэг. Тэндээс ямар хэмжээний хураамж төлбөрүүд авдаг. Тэр нь буцаад тэр үзүүлж байгаа байгууллагуудаа бид тордож сайжруулах гэдэг юм уу, үзэж харах юмыг нь нэмэгдүүлэх хүрээнд чиглүүлэгдэх ёстой юм гэдэг юм уу, ийм юм байна уу.

Үүнийг бид нэлээн хийх ёстой юм шиг байгаа юм. Дэлхийн энэ улс орнууд хотуудыг хараад байхаар зэрэг хот доторх энэ үзэж хардаг юмаа нэмэгдүүлээд бас ирсэн улсуудыг дан ганц хурал номоор хангаад буцаачихдаггүй л бололтой юм байна.

Тийм учраас үүнийг нь зөв зохион байгуулж хийх тухай асуудал байх юм уу гэж.

Тэгээд би бодоод байгаа юм. Тэр энэ урлаг, спортын том фестивалиудыг гэдэг юм уу, наадмуудыг энэ улс орнууд өрсөлдөөд аваад байх юм байна даг.

Тэгэхээр зэрэг тэр нэг овоо жоохон орлого олдог улс орноо сурталчилдаг байлгүй. Тэгэхээр Монгол тэр тал руугаа энэ төвийн аялал жуулчлалынхаа чиглэлийн нэг гол зорилго болгож авч явах нь зөв юм биш

үү. Тодорхой тодорхой арга хэмжээнүүдийг зохион байгуулдаг. Мэдээж эхний юм дээр тодорхой байгууламж юмнууд шаардлагатай болох байх. Түүнийгээ зохион байгуулаад нэгэнт бий болгочихсон, одоо юу гэдэг юм спортын ордон гэдэг юм уу, тэрийг тойрсон зочид буудлууд гэдэг юм уу. Энэ бүх юмнуудаа хийгээд авчих юм бол түүн дээрээ түшиглэсэн мөнхийн орлоготой байх арга хэмжээнүүдийг тасралтгүй хийдэг зохион байгуулалтын арга хэмжээг л хийж байж л энэ тоо юмнууд одоо бас тогтвортой хангагдаж, нэлээн гайгүй үр дүнгүүд би гарч ирэх болов уу л гэсэн ийм л бодол санаа байгаад байх юм.

Дараагийн нэг хэлмээр байгаа зүйл нь. Тэр дан дамаа аялал жуулчлалын бүс нутаг дотор тэр отоглох цэгийг их тодорхой болгох ёстой. Тэр стандарт хангагдах ёстой. Гэхдээ отоглох цэг дээр майханаа бариад хонож болдог нэг хэсэг талбайг нь гаргаж өгөх хэрэгтэй. Хүн болгон заавал тэр жуулчин.../минут дуусав/

Г.Занданшатар: Лхагвын Мөнхбаатар.

Л.Мөнхбаатар: Эрхэм гишүүдийнхээ амрыг эрье.

Ер нь энэ аялал жуулчлалын эрх зүйн орчныг тодорхой болгох, аялал жуулчлалын салбар дахь үйл ажиллагаа явуулж байгаа хүмүүсийг нэг дээвэр доор нэгтгэж зохион байгуулах. Дээр нь төрөөс зарим зүйлийн зохицуулалт дээр бас тодорхой хэмжээнд зохицуулалт хийх, мэдээлэл эрсийн сантай болох гээд. Энэ агуулгаар нь энэ удаагийн оруулж ирсэн хуулийг бол дэмжиж байна. Дэмжиж байгаа юм.

Гэхдээ энэ дээр нь хэдүүлээ ажлын хэсэг байгуулаад хэлэлцэх эсэхийг нь шийдсэний дараа шийдэх маш олон асуудлууд байгаа шүү.

Сая хэлэлцүүлгийн явцыг харахад засаж сайжруулах маш олон зүйл байна. Мэдээж Их Хурлын тухайлсан Байнгын хороон дээр хийгээд явах байх гэж бодож байна.

Би энд хоёр, гурван зүйлийг тодорхойлж асууя гэж бодож байна. Б.Бат-Эрдэнэ сайдын хувьд би өмнө нь хоёр, гурван удаагийн чуулган дээр нэлээд шүүмжлэлтэй хандсан асуудал байгаа. Булнайн нуруу, Тэсийн голын тусгай хамгаалалтын газар нутгийн асуудал дээр та их хойрго хандаж байна. Энэ асуудал дээр өөрийгөө байр суурь бөгөөд байгууллагынхаа шийд гаргах ёстой гэсэн. Энэ дээр шийдвэр гаргасан байна лээ. Харин би үүнийг бол зүйтэй. Магадгүй энэ чиглэлээр мэдрэмжтэй ажиллаж байна гэж үзэж би энэ агуулгад Та бүгдийг явуулж байгаа үйл ажиллагааг дэмжиж байгаагаа хэлье.

Хоёрдугаарт, нийтлэг хэд хэдэн асуудал байна. Хөвсгөл аймаг. Бусад аймгуудад ч бас байгаа. Тусгай хамгаалалтын газар нутгийн тухай энэ хуулийнхаа асуудлыг та хэзээ оруулж ирэх вэ гэдэг асуулт байгаа юм.

Энэ дээр яаж байна вэ гэхээр Хөвсгөл аймгийн ихэнх газар нутаг нь тусгай хамгалалтай газар нутагт хамрагддаг. Тэр дотроо Цагаануур сум гээд бодъё. 98 хувь нь тусгай хамгаалалтай газар нутагт харагддаг. Улаан-Уул, Баянзүрх, Рэнчинлхүмбэ, Ханх гээд бүгдээрээ адилхан.

Энд ажиллаж амьдарч байгаа маш олон хүмүүсийн эрх ашиг яг энэ

тусгай хамгаалалтын газар нутагтай холбоотой. Энэ хуультай холбоотойгоор эрх ашиг нь хөндөгддөг юм.

Энэ хүмүүс ажиллаж амьдрах, хэвийн амьдрах нөхцөлийг нь бүрдүүлэхэд маш олон зүйл энэ хуулиар зөрчигдөөд байгаа юм. Зөрчил байгаа. Энэ талаар манай Байгаль орчин, аялал жуулчлалын яаман дээр нэлээн олон асуудал ирж байгаа байх. Энэ асуудлуудыг шийдэхийн тулд Аялал жуулчлалын тухай хууль орж ирж байгаатай холбогдуулаад хэлж байгаа юм л даа.

Ер нь цаашдаа энэ асуудлаа та нар маань нэг мөр болгож оруулж ирж, Тусгай хамгаалалттай газар нутгийн хуулиа оруулж ирэх нь зүйтэй.

Эдэлбэр газрын тухай байна. Хатгал сум гээд байна. Тосгон. Одоо ямар ч байсан хот юм уу, аль эсвэл сум болгохыг зохицуулалтыг нь хийх гээд хувьдаа оролдож байна.

Яг үүнтэй адилхан. 98 хувь нь газар нутаг нь, тусгай хамгаалалтад байгаа энэ хүмүүсийн асуудлыг одоо яаж шийдэх вэ. Энэ эдэлбэр газрын тухай асуудлыг яаж шийдэх вэ гээд энэ асуудал дээр манай Б.Бат-Эрдэнэ сайд маань жаахан санаачлагатай ажиллаад аялал жуулчлал тухайн орон нутагт амьдарч байгаа хүмүүсийн асуудлыг иж бүрэн авч үзэх хэрэгтэй. Байгалиа хамгаалах нь зөв. Зөв.

Тусгай хамгаалалтад газар нутгийг илүү их хэмжээгээр авч байж байгаль орчноо хамгаалах нь бодлого нь зөв. Гэхдээ тэнд ажиллаж, амьдарч байгаа хүмүүсийн асуудлыг хэрхэн шийдэх вэ гэдэг дээр та бас нэг

тодорхой чиглэлүүдийг яримаар байгаа юм.

Нөгөөтгүүр Ханх гээд сум байна. Ханхын олон улсын боомт болох асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Оросын Холбооны Улсад айлчлах үеэрээ энэ асуудлыг шийдсэн. Боомт болох асуудлыг шийдсэн. Гэхдээ дэд бүтцийн бусад асуудлаар нь Монголын тал бөгөөд Оросын Холбооны Улсын талаас асуудлуудыг шийдэж байгаад цаашаа явна.

Энд жилдээ 12-ос 17 мянган хүн жил болгон зорчиж байгаа юм. Цаана нь ямар боломж байна вэ гэхээр Байгаль нуур дээр 400 мянган жуулчин жил болгон ирж байгаа юм.

Гэтэл манай Орос, Монголын хмл нь хоёрхон улсын хил байдаг. Монгол, Орос гээд хоёрхон. Гуравдагч орныхон зорчих эрхтэй болох юм бол 300, 400 мянган жуулчин Монголд ирэх очих ийм боломжууд байгаа юм. Монголоос ч гэсэн ингээд явах боломж нь байна.

Энэ болгоныг хангах энэ асуудал дээр танай яам ямар бодлого барьж байна. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Боомтын сэргэлтийн бодлогын хүрээнд та нар маань энэ талаараа нилээн ажиллаж байгаа байх гэж би бодож байна.

Нөгөөтгүүр Мөрөн сумын нисэх буудлыг “4 Си”¹ гээд олон улсын

¹ ICAO-ийн дүрмийн дагуу 4С ангиллын хөөрөх буух зурвас нь 1800-1900 м ба түүнээс дээш урттай байх ёстой гэж заасан байдаг. Ийм зурвас нь А-320, В-737 гэх мэт нарийн биетэй онгоцнуудад зориулагдсан байна.

нисэх буудал болгох Засгийн газрын шийдвэр гарчихсан байгаа. Үүнийг олон улсын нисэх буудал болгох юм.../минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд дэмжсэн, дэмжээгүй үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Аялал жуулчлалын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Тэгэхдээ санал хураалт явуулахын өмнө энэ юу байна. Энэ хуулийг бүлгээр ер нь хэлэлцэх хэрэгтэй юм байна бас. Бүлэг дээр. Энэ бүлгүүдээр ярьж.

Ер нь нэрээсээ эхлээд аялал жуулчлалыг энэ Р.Лхагвабаяр,

С.Цогтгэрэл энэ тэр хууль боловсруулахдаа хэдэн улсын хууль уншиж судалсан. Аялах, жуулчлах тухай хууль нэг тусдаа. Аялал жуулчлалыг дэмжих тухай нэг. Хэчнээн улсыг судалсан. Солонгос, Вьетнам, энэ Азийн улсуудын хуулиуд чинь дандаа аялал жуулчлалыг дэмжих тухай хуулиуд байгаа шүү дээ. Тийм ээ. Нэрээс эхлээд энэ аялал жуулчлалыг.

Аялах, жуулчлах гэдэг бол жуулчдын эрхийг хамгаалахтай холбоотой. Ёстой даатгал энэ тэр гэсэн харилцаа.

Тэгээд энэ хольсон. Аялал жуулчлалын. Одоо ингээд аялал жуулчлалын цэг, аялал жуулчлалын Хөвсгөл аймаг, Баян-Өлгий аймаг гээд л ярьж байна. Аялал жуулчлалын бүс гээд зөвхөн хязгаарлачихсан. Бүснээс чинь гадна тэр дотор чинь аялал жуулчлалын одоо тэр очдог газар гээд байна шүү дээ.

Одоо “Эделман Korea” гэдэг компаниар Монгол Улсын брэнд нэрийн судалгаа хийлгэхэд “**Energetic Mongolia**” гэж нэрлэх нь зүйтэй юм байна. Энэ дэлхийн 50 гаруй улсад судалгаа хийж үзээд байна шүү дээ.

Тэгээд л Орос, Хятад хөрш орнуудаас авхуулаад Америк, олон улсад энэ улс Эрчим хүчний эх орон гэж үздэг. Тэгээд бид нүүдэлчин гэдэг чинь цыганууд гэсэн гаралтай үг байна гээд ингээд зөвлөгөө өгч байсан байх жишээтэй. Тэгээд энэ бүхнийг чинь боловсруулж бодлого болгож хууль гаргах хэрэгтэй.

Энэ зөвхөн хөрш орнуудын жуулчлалаас гадна зөвхөн Турк Улсаас гэхэд чинь сая Ерөнхийлөгчөөсөө авхуулаад таксины жолооч нь хүртэл

Монгол Улсыг мэддэг. Бид Орхоны хөндийгөөс гаралтай. Очиж үзэхийг хүсэж байгаа 20 сая хүн байна гэж бичдэг.

Тэр perspective ирээдүйгээ өнөөдөр тэдэн хүн тэндээс ирдэг. Тийм ан амьтны аялал жуулчлал хийдэг энэ тэр гээд сууж байх юм. Тийм ээ.

Дэлхийн хөгжил, ногоон хөгжлийн зорилго чинь юу байгаа билээ. Ан амьтны дуудлага худалдааг хуулийнхаа нэг голыг болгочихсон. Энэ ногоон хөгжлийн зорилго, чиглэл юу болж байна. Дэлхийд юу гэж харагдах вэ.

Тэгээд нэр томъёоноос авхуулаад ингээд боловсронгуй болгох шаардлагууд маш их байна. Энэ аялал жуулчлалыг дэмжих асуудал.

Тийм учраас бас энэ дээр холбогдох аялал жуулчлалын зам гэж байна. Аялал жуулчлалын цэг, спот, туризм спот гэж байна. Туризм бизнес гэдгээ тодорхойлох хэрэгтэй.

Казиногийн хууль тусдаа яваад байгаа юм. Туризм бизнесийн нэг хэлбэр чинь казино нь байна уу, тэр энтертейнмент, түүхэн, археологийн.

Хуралдаан 7 цаг 34 минут үргэлжилж, 18 цаг 24 минутад өндөрлөв.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Аялал жуулчлалын бизнесээ хүртэл ялгах хэрэгтэй. Хуульдаа.

Зөвхөн бүтээгдэхүүн гээд орхичихож байгаа юм. Package гэж бүтээгдэхүүнүүд байна. **Package tourism** гэж байна. Аялал жуулчлалыг дэмжих гэдэг үндсэн агуулга нь явах юм уу. Зөвхөн аялал жуулчлалын хуучин харилцаагаа улам боловсронгуй болгох юм уу. Шинэ юм хийх гэж байгаа юм уу. Шинэ сэргэлт хийх гэж байгаа юм уу.

Ийм учраас энэ асуудлуудаа гишүүд асуугаад яриад та нараас хангалттай хариулт авч чадахгүй байна гэж үзэж байна.

Ийм учраас нэг дэх өдөр бүлгийн хурлаар хэлэлцэнэ. Одоо санал хураалт явуулахгүй. Асуудлыг хойшлууллаа.

Хууль санаачлагчид бүтэн байхгүй байгаа учраас. Сайд нар бүрэн бүрэлдэхүүнээрээ байж байж санал хураалт явуулах ёстой.

Ингээд 18.00 цаг өнгөрсөн байна. Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Ц.АЛТАН-ОД